МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

# НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР
2003 ОН

ГАРЧИГ

Оршил 1

Нэг. Төрөөс нэн ядуу иргэдийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний хүртээмж 3

Хоёр: Орон нутгаас нэн ядуу иргэдийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний хүртээмж 7

Гурав. Төрийн бус байгууллагуудын оролцоо 8

Дөрөв. Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал 9

Дүгнэлт 14

Санал, Зөвлөмж 15

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Оршил

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 21 аймгийн 60 гаруй сум, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн 9 хорооны нутаг дэвсгэрт нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлын талаар судалгаа хийсэн. Тандалтын түүвэр судалгаанд хот хөдөөгийн нийт **1265** нэн ядуу иргэд хамрагдсан. Мөн төрийн болон төрийн бус нийт 30 орчим байгууллагын албан хаагчидтай уулзаж, ярилцсан бөгөөд энэ чиглэлээр гарсан хууль тогтоомж, эрх зүйн акт болон хийгдсэн судалгааны материалуудыг үзэж танилцсан юм. Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлыг Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенци, Үндсэн хуулиар баталгаажсан эрхийн хүрээнд харьцуулан судалж үзлээ.

1998 оны байдлаар монголын нийт хүн амын 35.6 хувь нь ядуу, үүнээс 19.7 хувь нь нэн ядуу ("Хүн амын амьжиргааны түвшний судалгаа", 1998), 2000 оны байдлаар нийт хүн амын 36.3 хувь нь ядуу, үүнээс 16.3 хувь нь нэн ядуу ("Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн" 2001) гэсэн судалгааны дүгнэлтүүд байна.

Нэн ядуу хүн амын тархалт (2000)[1]

| Аймаг нийслэлийн нэр | Нэн ядуу | | |
|---|---|---|---|
| | Хүн амын тоо | Нийт хүн амд эзлэх хувь | Байр |
| Архангай | 19624 | 20,2 | 9 |
| Баян-Өлгий | 20071 | 22,0 | 6 |
| Баянхонгор | 16916 | 19,9 | 10 |
| Булган | 15486 | 25,1 | 2 |
| Говь-Алтай | 9995 | 15,7 | 14 |
| Дорноговь | 4468 | 8,8 | 21 |
| Дорнод | 18736 | 24,8 | 3 |
| Дундговь | 11385 | 22,1 | 5 |
| Завхан | 29332 | 32,6 | 1 |
| Өвөрхангай | 28028 | 25,1 | 2 |
| Өмнөговь | 4598 | 9,8 | 19 |
| Сүхбаатар | 10834 | 19,3 | 12 |
| Сэлэнгэ | 10539 | 10,5 | 18 |
| Төв | 14129 | 14,2 | 16 |
| Увс | 21212 | 23,5 | 4 |
| Ховд | 18031 | 20,8 | 7 |
| Хөвсгөл | 24328 | 20,4 | 8 |
| Хэнтий | 9802 | 13,8 | 17 |

[1] *Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн, 2001*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| Дархан-Уул | 12267 | 14,7 | 15 |
| Орхон | 14106 | 19,7 | 11 |
| Говьсүмбэр | 2218 | 18,1 | 13 |
| Улаанбаатар | 69848 | 9,2 | 20 |
| Дүн | 385953 | 16,3 | |

Өнөөдөр Монгол улсад ядуурал бодит үзэгдэл болжээ. 1990-ээд оноос эхэлсэн зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой ажилгүйдэл, бодит орлогын бууралт, нийгмийн хамгааллын системийн өөрчлөлт зэргийн улмаас хүн амын амьжиргааны түвшин буурч байсан. Эхэндээ энэ ядуурал нь орлогын ядуурал байсан бөгөөд түр зуурын ядуурал байсан. Учир нь тэдний хуучин нийгмээс өвөлж авсан боловсрол, эрүүл мэнд гэх мэт чадавхийн хүчин зүйлүүд нь хадгалагдаж байсан. Гэтэл сүүлийн жилүүдэд энэ нь чадавхийн ядуурал руу шилжиж байна. Үүнд дараах шалтгаанууд байна. Нэгдүгээрт, ядуу зүдүү байдалд амьдарч байгаа иргэд аажимдаа чадавхиа алдаж байна. Тухайлбал, хоол хүнсний хомсдол, амьдрах ахуй нөхцөл муу зэргээс болж өвчинд нэрвэгдэх, эмчилгээний зардлыг дийлэхгүйн улмаас өвчин нь газар авах зэрэг нь чадавхийг нь бууруулж байна. Хоёрдугаарт, ядуу өрхийн хүүхдүүд ядуу иргэн болж өсөн удам дамжсан ядуурал бий болж байна. Ийм ядуу иргэд чадавхийн ядууралд орох магадлал маш өндөр байна. Тухайлбал, нэн ядуу иргэдийн 47.6 хувийг хүүхэд эзэлж байгаа (Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн, 2001) бөгөөдтандалтын судалгааны дүнгээс харахад нэн ядуу өрхийн сургуулийн насны хүүхдүүдийн 19 хувь нь сургууль завсардсан байна. Тэд ихэвчлэн хувцас, сурах бичиг худалдан авах боломжгүй болон ажил хийж эцэг эхдээ туслах зэрэг шалтгаанаар сургууль завсарддаг байна.

Судалгааны явцад ядуурал гүнзгийрч, нэн ядуу иргэдийн тоо өсч байгаа хэд хэдэн хүчин зүйл байна. Үүнд, нэгдүгээрт, Ажилгүйдэл /*Нэн ядуу бүлгийн ажилгүйдлийн түвшин 1998 онд 50.8 хувь (Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгаа, 1998), 2000 онд 52,6 хувь (Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн, 2001) байжээ Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлын тандалтын судалгаанд хамрагдагсдын 80 гаруй хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй гэж хариулсан. Улаанбаатар хотын захын хороод болон аймаг, сумын төвд ажлын байр хомс, байгаа ажил нь эмч, багш гэх мэт өндөр мэргэжил шаарддаг тул нэн ядуусын дунд ажилгүйдэл их байдаг байна. Судалгааны явцад нэн ядуу иргэдийн ажилгүй болсон шалтгаануудын нэгэнд үйлдвэр аж ахуйн газрын цомхотгол орж байсан.*/, хоёрдугаарт, Хөдөө орон нутагтядуурал, нэн ядууралд нөлөөлж буй гол хүчин зүйл нь жил дараалан нүүрлэж буй ган, зудын гамшиг юм. */Үндэсний Статистикийн Газрын мэдээлснээр 1999-2001 оны ган зуданд нийт 12 сая орчим толгой мал хорогдсон. Монголын Улаан Загалмайн нийгэмлэгийн тайланд 2000 оны байдлаар хөдөөгийн 450,000 хүн зудын гамшигт өртсөн гэжээ./*, гуравдугаарт, Боловсролын хүртээмж, чанар буурсан явдал /*Боловсролын түвшин буурах тусам ядууралд өртөх явдал ихэсч байгаа нь*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*судалгаанаас харагдлаа.Тандалтын судалгаанд оролцсон нэн ядуу иргэдийн 60 орчимхувь нь бага болон бүрэн бус дунд боловсролтой, 10 орчим хувь нь боловсролгүй гэж хариулсан./*

**Нэг. Төрөөс нэн ядуу иргэдийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний хүртээмж**

Нийгмийн халамжийн тухай хуулиар нэн ядуу иргэдэд төрөөс үзүүлэх тусламж, үйлчилгээг зохицуулж өгсөн байна. Нийгмийн халамжийн тухайхуулийн 3.1.3 -т нэн ядуу иргэн гэж хэн болох талаар "тухайн хүнд ногдох орлогын хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшингийн 40%-иас доогуур, тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй хүнийг хэлнэ" хэмээн тодорхойлж нэн ядуу амьдралтай хүнийг нийгмийн эмзэг хэсэгт багтаан улмаар нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулахаар заажээ. Хэдийгээр хуулиар тодорхойлсон хэдий ч нэн ядуу хэмээх тодорхойлолт бүрхэг байгаань судалгааны явцад харагдаж байсан. Үүнээс үүдэж зарим газар нэн ядуу хэмээн тодорхойлогдох иргэд өөр газар ядуу эсвэл бага орлоготой иргэнээр тодорхойлогдох гэх мэт зөрчил байна. Энэ талаар холбогдох мэргэжилтнүүдээс асуухад нэн ядуу хэмээх тодорхойлолтыг гаргах нь төвөгтэй, хуучин аргаар тодорхойлох нь олон улсын стандартад нийцдэггүйгэх мэт хариулт өгч байсан. Гэтэл энэхүү тодорхойгүй байдлаас болж иргэд хохирч байна. Хязгаарлагдмал хэрэглээтэй боловч орлого нь амьжиргааны доод түвшингийн 40 хувиас илүү гарч байвал тухайн хүнийг нэн ядуу гэж тодорхойлж болдоггүй ажээ. Мөн тухайн өрхийн үндсэн хөрөнгийн тухай заалт байхгүйгээс өөрийн гэрт амьдарч байгаа болон орон гэргүй айлын сууц хөлсөлдөг өрхүүд нэг ижил түвшний амьдралтай гэж үнэлэгддэг. Мөн түүнчлэн хөдөө малтай айлуудыг хэрхэн ангилах талаар нэгдсэн заалт байдаггүй байна. Өрхөд ноогдох малын тоогоор голдуу зааж өгдөг. Гэтэл ам бүлийн тооноос хамаараад нэг хүнд ноогдох ашиг шим өөр байгааг харгалзаж үздэггүй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

***Шигтгээ 1.** … Хотод нэг үнээтэй өрх нэн ядуу бүлэгт орохгүй …*

*Улсын Нийгмийн Халамжийн газрын ажилтны ярианаас…*

Нийгмийн халамжийн шугамаар үзүүлж байгаа тусламж дэмжлэгийн талаар тавих хяналт сул байдгаас зарим иргэд орлогоо нуун дарагдуулах замаар завших, тусламжийг давхардуулан авах гэх мэт сөрөг үзэгдэл газар авах болжээ. Үүнээс болоод нийгмийн халамжийн үйлчилгээ шударга бус хуваарилагдах тохиолдол гарч байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд дараах нэн ядуу иргэд тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэйг заасан.

-Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй, дараах иргэн халамжийн тэтгэвэр авах эрхтэй. Үүнд:

а. Нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй

б. Нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 насанд хүрсэн эх (50 насанд хүрсэн эцэг)

- Нэн ядуу өрхийн эх хүүхдээ төрүүлснээс хойш 1 удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү, нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж авах эрхтэй.

Гэхдээ нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн заалтууд нь ихэвчлэн нэн ядуу тахир дутуу иргэн, түүнийг асрамжлагч, нэн ядуу ахмад настан эсвэл өрх толгойлсон олон хүүхэдтэй нэн ядуу эхэд хамааралтай байна. Иймээс эдгээрт хамааралгүй олон тооны нэн ядуу иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй хоцорч байна. Тухайлбал, олон хүүхэдтэй 45-аас доош насныөрх толгойлсон эх /50-аас доош насны эцэг/ тэтгэвэр, тэтгэмж авах эрхгүй байна.

Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний нэг төрөл бол нэн ядуу иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ бөгөөд хуулийн 3.1.7-д нийгмийн халамжийн үйлчилгээг “иргэнийг түр хугацаагаар хооллох, эсвэл түүнд наад захын хувцас, хүнс болон ахуй, соёлын зарим зүйл олгох, хөнгөлөлт үзүүлэх, мэргэжил эзэмшүүлэх зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээ” хэмээн тодорхойлжээ. Нэн ядуу иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн арга хэмжээ нь халамжийн тэтгэвэр тэтгэмж болон орон байртай болгох, малжуулах, түлээ нүүрсээр туслах, үнэгүй сургалтанд хамруулах зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээнээс бүрдэж байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд тусгагдсан заалтуудаас дүгнэлт хийхэд нэн ядуу иргэнд мэргэжил эзэмшүүлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр олгох зэргээс бусад нь тогтвортой бус, нэг удаагийн шинжтэй байна. Нэг удаагийн тусламжийг үзүүлэхээс илүүтэйгээр тэднийг нэн ядуу байдлаас гаргах чиглэлээр ажиллах шаардлагатай байна. Нэн ядуу иргэдтэй уулзаж ярилцаж явахад тэд ч мөн ийнхүү ярьж байна.

Нийгмийн халамжийн хуулийн нэн ядуу иргэнд хүртээхээр заасан зарим үйлчилгээнээс үнэн хэрэгтээ тэд хүртэх ямар ч боломжгүй байна. Жишээлбэл: Нийгмийн халамжийн тухайхуулийн 24.2 -т нэн ядуу амьдралтай ахмад настныг эх орны рашаан сувилалд явах унааны 1 талын зардал, зар бичгийн үнийн 50%-ийг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

жилд нэг удаа нөхөн олгохоор заажээ. Гэтэл үнэхээр тус хуульд заасан АБДТ-ийн 40%-иас доогуур орлоготой[2] нэн ядуу ахмад настны хувьд үндсэн зардлыг өөрөө даагаад явна гэдэг нь бүтэшгүй зүйл юм. Ийнхүү хальт харахад их боломж олгосон мэт, бодит амьдралд хэрэгжих бололцоогүй заалтыг хууль тогтоогч нар эргэж харж, залруулах нь зүйтэй юм.

2001 оны 5 сард Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолоор "Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийг баталсан байна[3]. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн Газар нь нийслэл, аймаг, дүүрэг, суманд өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөлүүдээр дамжуулан бодлогоо хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн нэг нь хууль тогтоомжийн талаарх сурталчилгааг тогтмолжуулж, байгууллага иргэдийг хэрэгцээт гарын авлага, материалаар хангах явдал ажээ. Өвөрхангай аймагт хийсэ н тандалтын судалгаанд хамрагдагсдын 30 гаруй хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээний талаар мэдэхгүй буюу сонссон ч хэрхэн хөөцөлдөхөө мэдэхгүй гэж хариулсан бөгөөд бусад аймгуудын хувьд ч энэ байдал нийтлэг байгаагаас дүгнэж үзэхэд тэдэнд шаардлагатай мэдээлэл дутагдалтай байсаар байна. Мөн түүнчлэн тус хөтөлбөрийн хүрээнд үл хөдлөх хөрөнгийн барьцаа авч зээл олгож байгаагаас нэн ядуу иргэд хамрагдах боломжгүй болжээ.Хөтөлбөрийн орон нутгийн зөвлөл энэ чиглэлийн үйл ажиллагаандаа нэн ядуу иргэдийг илүүтэй хамруулах ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Засгийн газраас эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх үүднээс Санхүү Эдийн Засгийн Яамны дэргэд Ядуурлын Судалгааны Нэгжийг байгуулж 2001 оны 11 сараас ажиллуулжэхэлсэн байн а. Энэ нэгж нь төрийн эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах бодлогыг судалгааны үндэслэлтэй боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой ажээ. Энэхүү арга хэмжээ нь ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулахад зайлшгүй чухал арга хэмжээ билээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа зарим нэг ижил үйлчилгээ, хөнгөлөлтийг хүртэх өрхийн шалгуур үзүүлэлт нь хот хөдөөд харилцан адилгүй байна. Тухайлбал, Засгийн газраас дээд сургуульд суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журамд зааснаар нийт малыг нь богод шилжүүлснээр 500 хүртэл толгой мал бүхий зөвхөн малчин өрх болон амьжиргааны доод түвшингийн 60 хувиас

[2] Улсын дундаж 8200 төгрөг
[3] "Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр", 2001.

доогуур орлоготой (тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй) ядуу өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төр хариуцна гэж заажээ. Эндээс үзвэл хотод амьдардаг иргэдийн хувьд энэ үйлчилгээг хүртэх босго нилээн өндөр байна[4]. Мөн түүнчлэнСЭЗЯ -наас нэн ядуу, АБДТ-ийн 60%-иас доогуур орлоготой ядуу иргэдийн хувьд сургалтын төлбөрийн зөрүү мөнгийг өгөх бодит боломжгүй байдлыг харгалзан үзэлгүйгээр хувийн болон төрийн сургуулиудад нэг ижил жишиг тогтоодог ажээ. Тухайлбал 2002-2003 оны хичээлийн жилд тус буцалтгүй тусламжийн хэмжээг хувийн их дээд сургуульд 240000, төрийн их, дээд сургууль д 195000-282000 байхаар тогтоосон нь бодит амьдралд нийцээгүй шийдвэр болсон. Одоогийн байдлаар нэн ядуу гэсэн тодорхойлолтоор 6000 оюутан буцалтгүй тусламж авч байна. Гэтэл энэ оюутнууд үнэхээр нэн ядуу, ядуу өрхийн суралцагч мөн эсэхийг эргэж хянадаг механизм байдаггүй юм байна. Хэрвээ хяналтын механизм хүчтэй байх аваас энэ ангилалд ийм олон суралцагч суралцах бодит боломжгүй болох нь харагдах биз ээ.

> ***Шигтгээ 2.*** *Манай гэр хөдөө байдаг. Манайх нэн ядуу өрх учраас сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж авдаг. Дүү маань хотод ирж суралцаад, 6 сар болох хугацаанд бид нийт 300000 орчим төгрөгийг дүүгийнхээ дотуур байр, хоол, унаа, хичээлийн хэрэглэлд зарцуулсан.*
>
> *Сургалтын төрийн сангаас буцалтгүй тусламж авдаг оюутны эгчийн ярианаас*

Мөн түүнчлэн ЕБС-д суралцаж байгаа эмзэг бүлгийн хүүхдийн сурах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өрхийн нэг хүүхдийн хичээлийн хэрэглэлийг үнэ төлбөргүй олгох журмыг СЭЗЯ, БСШУЯ-ны сайдын хамтарсан тушаалаар батлан гаргажээ.

2002 оны 12 сард Засгийн газрын 248 дугаар тогтоолын дагуу 50.0 сая төгрөгийн зардал гаргаж орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийн талаар нэгдсэн арга хэмжээ авчээ. Энэ арга хэмжээ нь орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийн нэгдсэн тоо бүртгэлийг гаргаж, хойшид авах арга хэмжээгээ тодорхойлох зорилготой чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Бутцийн өөрчлөлт сүүлийн арван жилд олон гарч байгаатаас төрийн залгамж холбоо алдагдаж, иргэд хохирч байгаа тал судалгаа хийх явцад ажиглагдсан. Тэр ч байтугай өмнөх хүнийхээ хариуцаж байсан материалыг хүлээж аваагүй гэх тохиолдол ч гарч байсан.

---

[4] Монгол улсын Засгийн газрын 2000, 2001 оны 158, 195 дугаар тогтоол.

**Хоёр. Орон нутгаас нэн ядуу иргэдийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний хүртээмж**

Судалгаанаас үзвэл нийслэл,орон нутгийнтөсөвт нэн ядуу иргэдэд зориулсан хөрөнгө, мөнгө төсөвлөгддөггүй учир орон нутагт нэн ядуу иргэдэд тусгайлан чиглэсэн цогц арга хэмжээ байхгүй байдаг бөгөөд төрөөс явуулж буй нийгмийн эмзэг хэсэгт чиглэсэн нийгмийн халамжийн арга хэмжээнүүдэд нэн ядуу иргэн хамрагддаг гэсэн байдлаар ханддаг нь туйлийн учир дутагдалтай байна. Нийслэл болон орон нутагт үзүүлж байгаа нийгмийн халамжийн үйлчилгээнд орон байртай болгох, түлээ нүүрс олгох, сургалтын хэрэгслээр хангах, хоол хүнс тараах, мэргэжил олгох, түр орлого олох үйл ажиллагаанд (цас цэвэрлэх, мод тарих, хог цэвэрлэх гэх мэт) хамруулах зэрэг арга хэмжээнүүд багтаж байна. Орон байртай болгох үйл ажиллагааны хүрээнд гэржүүлэх төсөл хэрэгжиж байгаа ньорон нутгаас үзүүлж буй нийгмийн халамжийн арга хэмжээний хамгийн дорвитой ньГэм. н ийгмийн үйлчилгээг үзүүлэхдээ чанарыг орхигдуулан тоогоор хөөцөлдөх явдал элбэг байгаа бөгөөд, үүний улмаас тухайн үйлчилгээний үр дүн буурах явдал түгээмэл байна. Тухайлбал, Нийслэлийн Хан-уул дүүргээс дүүргийнхээ орон гэргүй нэн ядуу иргэдэд олгож буй гэр шалгүй, дан бүрээстэй байсан. Энэ нь манай орон шиг цаг агаарын эрс тэс уур амьсгалтай орны хувьд өвөл хэрэглэх боломжгүй юм. Түүнээс гадна судалгааны үед гэр авсан айлууд нүүгээд явчихсан тохиолдол цөөнгүй гарсан бөгөөд энэ тохиолдолд хороодын дарга нарт хариуцлага ноогдуулах механизм байхгүй, хяналт сул байна. Гэрийг хороодод хуваарилахдаа нэн ядуу иргэдийн эзлэх хувьд анхаардаггүй байна. Жишээлбэл, Сонгинохайрхан дүүрэг нийт 81 гэр олгосон боловч хамгийн их ядууралтай 4-р хороонд нэг ч гэр олгоогүй байна. Ер нь гэр олгосноор асуудал шийдэгддэггүй байна. Ялангуяа тэнэмэл амьдралтай иргэдэд гэр олгосноор дотор нь тавих тавилгагүй, гэр авангуут ус, цахилгаан, түлшний асуудал үүсдэг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

> ***Шигтгээ 3.*** *Үнэхээр нэн ядуу иргэдийн амьжиргааг дээшлүүлэх гэж байгаа бол гэр өгөхдөө тэдний нийгмийн асуудлыг давхар шийдэж өгч баймаар байна гэж БЗД-ийн зарим хорооны засаг дарга нар ярьж байлаа.*

Орон нутгаас байнгын болон түр ажлын байр гаргах ажлыг зохион байгуулж, ядуу, нэн ядуу хүмүүсийг хамруулж байгаа зарим жишээ байна. Энэ нь тэднийг ядуурлаас гаргах хамгийн тогтвортой арга хэмжээ билээ. Гэвч хөдөө, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх явдал туйлын хангалтгүй байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний нэг төрөл нь нэн ядуу иргэдийг нүүрс, түлээгээр хангах арга хэмжээ юм. Гэвч энэхүү тусламжийг иргэдэд хүргэхдээ шуудайгаар тооцдогоос ямар чанартай нүүрсийг хичнээн хэмжээгээр өгөх нь тухайн газрын үзэмжээр шийдэгддэг дутагдал байсаар байна.

Орон нутгийн засаг захиргаанаас авч хэрэгжүүлж байгаа нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээнд нэн ядуу өрхийн хүүхдүүдэд зориулсан халамжийн цэцэрлэг ажиллуулж байгаа нь сайшаалтай юм. Гэвч төсөв мөнгөний байдлаас шалтгаалж хамруулах хүүхдийн тоо хангалтгүй байдаг юм байна.

Зарим аймаг орон нутагт ядуурлын асуудалд хувийн хэвшлийн анхаарлыг хандуулж, тэднээс туслалцаа авч байгаа сайн тал ажиглагдаж байна. Тухайлбал Говьсүмбэр аймгийн хувьд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын анхаарлыг эмзэг бүлэгт хандуулах арга хэмжээ авсны үр дүнд 1996-2000 онуудад нийт 14 сая төгрөгийг хуримтлуулж, давхардсан тоогоор 4500 гаруй иргэдэд тусламж үзүүлсэн байна.

**Гурав. Төрийн бус байгууллагуудын оролцоо**

Улсын хэмжээнд халамжийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд нилээд олон байдаг бөгөөд дийлэнх нь гадаадын байгууллага эсвэл гадаадын санхүүжилттэй байгууллагууд байна. Судалгаа хийх явцад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим байгууллагуудтай уулзаж ярилцсан юм. Үүнд: Улаан загалмай нийгэмлэг, Дэлхийн зөн, “Тэмүжиний андуудын номын өргөө”, АДРА, Бадамлянхуа-хүүхдийн халамжийн төв, Тереза эхийн халамжийн төв, Энэрэл эмнэлэг.

Судалгааны явцад Дэлхийн зөн байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагаа нь нилээд тогтвортой, зохих эзэндээ хүрдэг болох нь харагдаж байсан. Эдгээр халамжийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг хамарсан улсын нэгдсэн зохицуулалт байхгүй ажээ. Төрийн бус байгууллагууд өөр хоорондоо холбоогүй нэгдсэн хяналтгүйгээс зарим овсгоотой нэн ядуу иргэд нийгмийн халамжийн олон төрлийн арга хэмжээнд дахин дахин хамрагддаг байхад мэдээллээс хол, эрхээ мэддэггүй иргэд ямар ч тусламж дэмжлэггүй хоцорч байна. Төрөөс эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн хяналтанд оруулаагүйгээс төрийн ачааллыг багасгах, үйлчилгээний үр дүнг олонд хүртээмжтэй болгох боломжийг алдаж байна.

UIH.MN
СНОЛАЛГААНЫ САН

Судалгаа хийх явцад ихэвчлэн гадны төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан бөгөөд дотоодын төрийн бус байгууллагуудыг төдийлөн хамруулж чадаагүй. Учир нь нийгмийн эмзэг хэсэгт тусламж үзүүлэх зорилгоор байгуулагдсан олон ТББ байдаг боловч үйл ажиллагаа нь тогтвортой биш байдаг ажээ. Өмнө нь Ядуурлыг Бууруулах Үндэсний хөтөлбөр хэрэгжиж байх үед нилээд төрийн бус байгууллагууд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан ч одоо эдгээр байгууллагууд нэн ядуу иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулахаа зогсоосон ажээ.

> ***Шигтгээ 4.*** *Бид өмнө нь нэн ядуу хүмүүст өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд нь зориулсан жижиг зээл өгч байсан. Гэсэн ч үнэхээр ямар ч орлогогүй өрхөд ийм зээл өгөх нь цоорхой уутанд гурил хийхтэй адил гэж хэлж болно. Тиймээс тэдэнд туслахыг хүсч байгаа бол арай өөр арга хайх хэрэгтэй болов уу. Бидний хувьд ийм айл, хүнд зээл өгчихөөр буцаад зээлийн эргэн төлөлт байхгүй болж, улмаар манай байгууллагад ч бэрхшээлтэй байдаг.*
>
> *ТББ-ын ажилтны ярианаас…*

**Дөрөв. Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал**

Хуулиар тодорхойлсон АБДТ-ийн 40%-иас доогуур орлого гэдэг нь улсын дунджаар 8200 төгрөг бөгөөд энэ нь нэн ядуу хүний анхдагч суурь хэрэгцээгээ хангах шаардлагатай зардлын талд ч хүрдэггүй тул энэ хирээр түүний эдийн засаг, нийгэм, соёлын болоод улс төр, иргэний эрхийн хэрэгжилт хязгаарлагдаж байна.

Монгол улс 1974 онд соёрхон баталсан “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт”-ын 11-р зүйлийн 2-р хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн өлсөхгүйгээр аж төрөх үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, тодорхой программ хэрэгжүүлэхийг оролцуулан, дангаараа буюу олон улсын хамтын ажиллагааны хэлбэрээр шаардлагатай арга хэмжээг дараах зорилгоор авна. . .” хэмээн заажээ.

Судалгаанаас үзвэл тэд өлмөн зөлмөн амьдралтай байдаг байна. Үүнээс болж хоол тэжээлийн дутагдалд орон ухаан санаа нь орж гарч байгаа хүмүүс ч судалгааны явцад тааралдаж байлаа.

> ***Шигтгээ 5.*** *СХД-ийн халамжийн төвийн байшинд 56 настай “ Г” хоол тэжээлийн байнгын дутагдлаас болж ухаан санаа нь самуурсан байдалтай байсан бөгөөд хэзээ хамгийн сүүлд хоол идсэнээ санахгүй байлаа.*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Судалгаагаар нэн ядуу өрхийн сарын зардал, орлогын талаар асуухад ихэнх нь хэлж мэдэхгүй байсан ба өдөртөө олдог хэдэн төгрөг нь хоол хүнсээ дөнгөж данган авахад л хүрдэг гэж байлаа. Иймээс хувцас авахад ч мөнгө хүрэлцдэггүй гэж байв.

Ядуурлын улсын үзлэгийн дүнгээс үзвэл бүтэн өнчин хүүхдийн 48.1 хувь, хагас өнчин хүүхдийн 65.6 хувь нь нэн ядуу өрхөд амьдарч байна. Нийгмийн даатгалын сангаас эхчүүдэд нярай хүүхэд асарсны тэтгэмж болох 9000 төгрөг өгдөг. Гэтэл нэн ядуу өрхийн хувьд энэ мөнгө нярай хүүхдийн асаргаанд бус харин тухайн өрхийн нийт ам бүлийн амьжиргаанд зарцуулагдсанаар нярай хүүхэд тэжээлийн дутагдалд орох нь элбэг тохиолдож байна. Тэр ч байтугай энэхүү тэтгэмжийг авахын тулд төлөвлөлтгүйгээр жирэмсэлж, хүүхэд төрүүлэх явдал элбэг байгааг төрөх тасгийн зарим ажилтан хэлж байсан. Аймгуудаас ирүүлсэн судалгааны материалд нярай хүүхэд хоол тэжээлийн байнгын дутагдалд орж байгаа, тэр ч байтугай тураалаар 6 сартай хүүхэд эндсэн талаар жишээ баримтууд байна.

Нэн ядуу иргэд хүүхдээ гадны тусламж, дэмжлэггүйгээр (хувцас, бичгийн хэрэгслээр хангах, үнэгүй хооллох гэх мэт) цэцэрлэг, сургуульд хамруулахад маш хүнд байдаг бөгөөд нэн ядуу өрхийн хүүхдүүд сургууль завсардах нь хэвийн үзэгдэл болжээ.

**Зураг 2. Нэн ядуу иргэдийн боловсролын байдал**[5]




UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Судалгаанаас үзэхэд нэн ядуу өрхийн сургуулийн насны хүүхдүүдийн 19 хувь нь ЕБС-д хамрагдаагүй ба тэдний 70 гаруй хувь нь ном дэвтэр, хувцас худалдан авах боломжгүйгээс сургууль завсарджээ. Мөн түүнчлэн нэн ядуу өрхөд амьдарч байгаа хүүхдүүд гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртөх болон гэмт хэрэгт уруу татагдах, гэмт хэрэг үйлдэх гэх мэтээр сөрөг зүйл байсаар байна. Тэр ч байтугай хуулийн

байгууллагын зарим ажилтнууд нэн ядуу зарим иргэд, хүүхдийг гэмт хэрэгт үндэслэлгүйгээр сэжиглэж, шалгах явдал гарах болсон нь зарим аймаг орон нутгийн судалгааны дүнгээс харагдлаа.

> ***Шигтгээ 6.** ...Манай хүүхдийг хулгайн хэрэгт 2 ч удаа сэжиглэн байцааж байсан бөгөөд ямар холбогдолгүй болох нь тогтоогдсон, гол нь ядуу зүдүү амьдралтай болохоор хэрэгт хардаж, сэрдэх шалтгаан болдог болов уу...*
> *... 26 настай эмэгтэйн ярианаас: Манайх 7 ам бүлтэй, өрхийн орлого байхгүй, ажил эрхэлдэг хүнгүй, байнга дутагдаж гачигдан, өлөн зэлмүүн байдгаас том хүү маань гадуур тэнэж, хулгайн хэрэгт холбогдон 2003 оны 2-р сарын 13-нд 2 жил 5 сарын хорих ял авсан...*
>
> *Говь-Алтай аймгийн судалгааны тайлангаас*

Судалгаа хийж байх явцад Улаанбаатар хотын нэн ядуу иргэдийн дунд хог түүж амьжиргаагаа залгуулдаг, хотын цооногт амьдардаг хүмүүс нилээд таарaлдаж байсан юм. Мөн түүнчлэн зарим аймагт уул уурхай, тэр дундаа алт, нүүрс олборлох ажил хувиараа, хууль бусаар эрхэлдэг хүмүүс олширсон байна. Эдгээр хүмүүсийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь ноцтойгоор зөрчигдөж байна. Тэр ч байтугай шороонд дарагдах, химийн бодист хордох зэргээр амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал газар авчээ.

> ***Шигтгээ 7.** ...Уянга сумын шороон дээр 6 сартай жирэмсэн эмэгтэй алт угаахаар бүтэн өдөржингөө голын усан дотор зогсох ажлыг хийж байна...*
> *...13 настай хүү гэр бүлээ тэжээхийн тулд энэ газар ажил хийдэг бөгөөд, элэг нь байнга унжиж өвддөг эмгэгтэй болжээ...*
>
> *Өвөрхангай аймгийн судалгааны тайлангаас*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Үндсэн хуулинд зааснаар хүн ажил хөдөлмөр эрхлэх эрхтэй бөгөөд үүрэгтэй. Гэтэл энэ эрхийн хэрэгжилт нэн ядуу хүмүүсийн хувьд туйлын хангалтгүй байна. Тэр дундаа ажил эрхэлсэн хэдий ч нэн ядуу байдалд амьдарч байгаа хүмүүс нилээд хувийг эзэлж байна. Ялангуяа төрийн үйлчилгээний албанд ажилдаг хүмүүс энэ байдалд их өртөх болжээ. Хэдийгээр Монгол улс нэгдэн орсон олон улсын Пактад дурьдсанаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн өөрийн болоод гэр бүлийн гишүүдийн хүрэлцээтэй амьжиргааг хангахуйц цалин хөлс авна хэмээн заасан байдаг хэдий ч дээрх хүмүүсийн хувьд өлөн зэлмүүн байдалд өдөр хоногийг өнгөрүүлж байна. Мөн түүнчлэн ган зудад малаа алдаж, хот суурин бараадан амьдрах болсон хүмүүсийн хувьд мэргэжил, боловсрол, ажлын арга туршлага байхгүй зэргээс үүдэж хөдөлмөр эрхлэхэд бэрхшээл гарч ирдэг байна.

---

[5] Нэн ядуу иргэдийн тандалтын түүвэр судалгааны дүнгээс

Судалгаанаас үзвэл нэн ядуу иргэдийн дотор бичиг баримтгүй хүмүүс маш олон байна. Бидний хийсэн тандалтын судалгаагаар нэн ядуу иргэдийн 30 гаруй хувь нь иргэний үнэмлэхгүй байна.

**Зураг 3. Бичиг баримтгүй байгаагийн шалтгаан**[6]




Судалгаанаас үзвэл иргэний үнэмлэхгүй байгаагийн гол шалтгаан нь мөнгөний боломжгүй байдал болон бичиг баримтын бүрдэлт гэж хариулсан. Гэтэл бичиг баримтгүй иргэд нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх, ажил хийх, сургуульд сурах, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх зэрэг олон эрхээ эдэлж чадахгүй хүрч байна. Цаашилбал үндсэн хуулиар баталгаажсан сонгох, сонгогдох эрхээ ч эдэлж чадахгүй болж байна.

> ***Шигтгээ 8.*** *Тэнэмэл хүмүүст авсан арга хэмжээний дагуу СХД-ийн халамжийн төвд ирсэн. Бичиг баримт олгох байх гээд эндээ байдаг. Иргэний үнэмлэхтэй болохоороо орцны жижүүр хийж мөнгө хураагаад тэрүүгээрээ жолооч болж такси барина гэж 24 настай иргэн "У" ярьж байлаа.*

Зарим дүүрэгт олон хүүхэдтэй өрхийн эхнэр, хүүхдийг нь шилжүүлж баримт бичиг бүрдүүлж өгчээ. Ингэснээр эхнэр нь ядаж ажилд орж нөхөр хүүхдээ тэжээдэг байна. Энэ нь дэвшилттэй хэрэг боловч эмэгтэйчүүдэд дангаар нь гэр бүлийн ачааг үүрүүлж байна. Яагаад нэг гэрийнхнийг бүгдийг нь шилжүүлэхгүй байгаа нь ойлгомжгүй юм.

[6] Нэн ядуу иргэдийн тандалтын түүвэр судалгааны дүнгээс

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Өнгөц харахад энэ шийдвэр нь эмэгтэйчүүдийн эрхийг давуутай авч үзсэн мэт боловч ЭЯГБХУТК болон бусад олон улсын гэрээ конвенцид заасан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд гэр бүлийнхээ өмнө эрх тэгш хариуцлага хүлээнэ гэсэн зарчимд нийцэхгүй байна.

Судалгааны явцад нэн ядуу иргэд мэдээллээс маш их хоцрогддог нь харагдаж байлаа. Энэ нь ч аргагүй. Ихэнх нь гэртээ зурагт, радиогүй бөгөөд сонин захиалах тухай ярих ч хэрэггүй юм. Хороо болон нийгмийн ажилтнууд нэн ядуу иргэдэд мэдээллийг хүртээх тал дээр дутагдалтай ажиллаж байна. Хөдөөнөөс шилжиж ирсэн иргэдийн зарим нь түр оршин суух зөвшөөрлийн талаар мэдэхгүйгээс эмнэлгийн үйлчилгээ хүртэж чадахгүй байх, хүүхэд нь сургууль завсардах гэх мэтээр хохирдог. Мөн нилээд хэсэг нь халамжийн үйлчилгээ хүртэх эрхээ мэдэхгүйгээс болж хохирч байна.

Нэн ядуу иргэдийн хувьд үүнчлэн маш хүнд нөхцөлд амьдардагаас амьсгалын замын өвчин (ханиад, сүрьеэ, астма гэх мэт) болон бусад өвчин тусах, түлэгдэх, хөлдөх зэрэг гэмтэл авах явдал элбэг тохиолддог байна.

**Зураг 1. Нэн ядуу иргэдийн архаг хууч өвчний байдал**




Гэвч эрүүл мэндийн даатгалын хураамж төлөөгүйн улмаас эрүүл мэндээрээ хохироход хүрдэг. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд эмзэг бүлгийн зарим иргэдийн даатгалыг төр хариуцахаар заасан. Гэвч НХТХ[7]-д заасны нэг адил олон тооны нэн ядуу иргэд төрийн үйлчилгээний гадна үлдэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[7] Нийгмийн халамжийн тухай хууль

*Шигтгээ 8. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум, 34 настай эмэгтэйн ярианаас: Уушиг их өвддөг, байнга ханиалгадаг. Нарийн шинжилгээ өгөхийг хүсэвч эрүүл мэндийн даатгалын хураамжаа төлөөгүй учир чадахгүй байна.*

*Говь-Алтай аймгийн судалгааны тайлангаас*

Нэн ядуу байдлаас гарахад хамгийн нөлөөтэй хүчин зүйл юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогсдын дийлэнх олонх нь ажилтай болох болон зээл авах гэж хариулж байсан юм. Эндээс үзвэл нийгмийн халамжийн нэг удаагийн тусламж нь нэн ядуугаас гарах хүчин зүйл гэж үзэхгүй байна. Хөдөлмөрийн чадвартай нэн ядуу иргэд өөрөө өөрсдийнхөө амьжиргааг дээшлүүлэх хүсэл тэмүүлэлтэй байгаа нь үнэхээр тэмдэглүүштэй юм. Жижиг зээлийн хөтөлбөрүүд нь үл хөдлөх хөрөнгө барьцаалдаг бөгөөд ийм хөрөнгөгүй нэн ядуучууд жижиг зээлийн хөтөлбөрт хамрагдах боломжгүй байна. Мал болон гэр хашааг барьцаанд авдаггүйгээс зээл авах боломж нь шууд хаагддаг байна. Газар хувьчилж авснаар амьдрал маань сайжирна гэсэн өөдрөг бодолтой нэн ядуу иргэд нилээд тааралдаж байлаа. Гэвч тэд газар хувьчлана гэж сонссоноос биш Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг мэдэхгүй байна. Энэ нь мэдээллээс хол байдгийн бас нэг баталгаа юм. Тэдний заримаас газар хувьчлалын тухай хэнээс сонссон болохыг асуухад Бат-үүлийн цуглаан дээрээс сонссон гэж хариулсан юм.

***Шигтгээ 10.** Намайг осолд ороод эмнэлэгт удаан хугацаагаар хэвтэж байгаад гарч ирэхэд бичиг баримт бүх зүйл маань алга болсон. Би гутал засаж чадна. Газар хувьчилж аваад юугаар ч хамаагүй хашаа, гутал засдаг ТҮЦ бариад амьдарна гэж иргэн "А" ярьлаа.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Дүгнэлт

Хүний эрхийн Үндэсний Комиссоос нэн ядуу иргэдийн эрхийн чиглэлээр хийсэн судалгааны дүнгээс харахад ядуурал, тэр дундаа нэн ядуу иргэдийн эрхийн хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Ядуурлыг бууруулах, ядуу, нэн ядуу иргэдэд үзүүлэх төрийн тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлыг зөвхөн нэг, хоёр яам, агентлагийн ажил мэтээр хаяж орхигдуулах явдал өнөөг хүртэл явж иржээ. Гэтэл хүн амын 3 хүн тутмын нэг ядуу, 5 хүн тутмын нэг нь нэн ядуу байдалд амьдарч байгаа өнөө үед энэ зохицуулалт нь хангалтгүй юм. Ядуурлыг бууруулах ажлыг дорвитой зохион байгуулахгүй, нэгдсэн зохицуулалт байхгүй байгаа нь ядуурал улам гүнзгийрэхэд хүргэж байна. Ядуурлын асуудал нь өөрөө эргээд эдийн засгийн хөгжлийг сааруулах, байгаль орчныг зүй зохисгүй ашиглахад хүргэх, гэмт хэргийг

өсгөх, тэгш бус байдлыг нийгэмд бий болгох, хүн амын зүй зохистой хөгжлийг бууруулах гэх мэт олон сөрөг зүйлийг дагуулж байна.

Мөн түүнчлэн ядуурлыг бууруулах чиглэлээр улсын төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламжаар багагүй хөрөнгийг зарцуулж байгаа хэдий ч зарцуулалтын байдалд тавих хяналт сул, үр дүнг нь эргэж тооцдоггүй зэргээс үүдээд танил тал харах, авилгалд автагдах гэх мэт сөрөг үзэгдлийг өөгшүүлэхэд хүргэж байна. Төрийн аль ч байгууллагын түвшинд байгаа нийтлэг дутагдал бол мэдээлэл нь хаалттай, ил тод биш байгаа, хүнд суртал ихтэй байгаа явдал юм. Эндээс бий болж байгаа сөрөг үр дагавар нь нийгэмд тэгш бус байдлыг бий болгож, танил талтай хүн мэдээлэлтэй, тэр хирээрээ нийгмээс илүү ашиг тус хүртэх боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү байдлаас гарахад төрийн нэгдсэн бодлого боловсруулах, бусад хөтөлбөр, төслийн уялдаа холбоог сайжруулах явдал зайлшгүй чухал билээ. Мөн түүнчлэн зарим хууль тогтоомжийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага зайлшгүй гарч ирж байна. Ядуурлыг бууруулах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажилд орон нутгийн байгууллагын хүч оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай ажээ. Ингэснээр орон нутаг бүрийн онцлогийг тусгасан хөтөлбөр боловсруулж, орон нутгийн байгууллагууд нь өөрсдөө энэхүү арга хэмжээгээ авч хэрэгжүүлэх нь төвлөрлийг сааруулах, ядуурлыг бууруулахад чухал түлхэц болох арга хэмжээ юм. Түүгээр ч барахгүй хот суурин газар луу тэмүүлэх шилжилт хөдөлгөөнийг бууруулах, хөдөө орон нутгийг хөгжүүлэх оновчтой арга хэмжээ болох боломжтой билээ.

Түүнээс гадна иргэний нийгэм, тэр дундаа төрийн бус олон улсын болон үндэсний байгууллагуудын хүч оролцоог энэ асуудалд татан оролцуулах уян хатан зохицуулалтыг бий болгох нь төрийн ачааг хөнгөлөх нэг чухал арга зам юм. Төр, төрийн бус байгууллагууд нь энэ чиглэлээр харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах явдал нь хөрөнгийг зүй зохистой хуваарилах, үргүй зарцуулахгүй байх болон нийгмийн хангамжийн үйлчилгээний хүртээмж, тэгш байдлыг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр болох ажил юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Санал, Зөвлөмж**

1. *Нийгмийн Халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

- Уг хуулийн нэн ядуу ахмад настны рашаанд сувилалын зардалд тусламж үзүүлэх тухай 24.2 заалтыг хэрэгжих бодит боломжтой байдлаар өөрчлөн найруулах
- Нэн ядуу иргэний тодорхойлолтыг буруу хийсэн, тусламж хүртэх ёстой нэн ядуу иргэнийг тусламж авах боложийг хязгаарласан гэх мэт зөрчил гаргасан тухайн шатны Засаг даргатай хариуцлага тооцох механизмыг чангатгах

2. *Аливаа бүтцийн өөрчлөлтийг хийхдээ төрийн залгамж холбоог алдагдуулахгүй байхад анхаарах:* Тухайн алба, ажил үйлчилгээтэй холбоотой бичиг баримт, мэдээлэл зэргийг дараагийн ажилтандаа бүрэн бүтэн хүлээлгэж өгөх, хэрэв хүлээлгэж өгөөгүй бол тухайн ажилтантай хариуцлага тооцдог системийг бий болгох хэрэгтэй. Мөн Төрийн аливаа албаны бичиг баримтын бүртгэлийг чангатгаж, үүнд тавих хяналтын систем бий болгох нь төрийн залгамж холбоог алдагдуулахгүй байхад чухал ач холбогдолтой юм. Мөн түүнчлэн тухайн ажлыг хариуцан ажиллах чадвартай, туршлагатай боловсон хүчинг сонгож ажиллуулах

3. *Нийгмийн халамжийн үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах:* Гэр олгох, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж өгөх гэх мэт нэн ядуу иргэдэд үзүүлэх тусламжийн зарцуулалтад тавих хөндлөнгийн хяналтыг хүчтэй болгох хэрэгтэй.

4. *Нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах* Аль болох олон хүнд дутуу дулимаг тусламж үзүүлдэг одоогийн хандлагыг өөрчлөх шаардлагатай байна. Нэг ч гэсэн хүн нэн ядуугаас гарч байх нь бүгдээрээ нэн ядуу байдалдаа байж байнга тусламж авч байснаас илүү үр дүнтэй юм. Иймд зарим төрлийн тусламжийг өгсөн шиг өгч баймаар байна. Тухайлбал, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг нэн ядуу өрхийн нэг суралцагчид тухайн сургуулийн сургалтын төлбөртэй тэнцүү өгөх төдийгүй суралцах хугацаанд нь тэтгэмж олгох шаардлагатай. Мөн түүнчлэн гэр олгохдоо өвөл зуны аль ч улиралд барьж болохуйц чанартай байлгах, авч байгаа айлыг гэртээ амьдрах нөхцлийг судалж шаардлагатай үед өөр бусад арга хэмжээтэй (өрхийн ядаж нэг хүнийг ажилд оруулах, сургалтанд хамруулах, тавилга авч өгөх гэх мэт) хослуулах хэрэгтэй. Мөн нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэх ёстой эзэнд нь хүргэхийн тулд нэн ядуу өрхийн талаар нарийн судалгаатай хандах нь зүйтэй юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5. *Нэн ядуу иргэдийг ажлын байр, амьжиргааны эх үүсвэрээр хангах:* Засгийн газраас нэн ядуу, хөдөлмөрийн насны иргэдэд ажлын байр бий болгоход татварын урамшуулал, хөнгөлөлттэй зээл өгөх замаар хувийн секторыг татан оролцуулах боломжтой юм. Нэн ядуу иргэдэд хөдөлмөрийн биржийн тухай мэдээлэл өгч, хөдөлмөрийн зах зээлд зуучилж өгч байх нь үр ашигтай юм. Мөн нэн ядуу иргэдээс үнэхээр амьдралын төлөө тэмцэж буй чадавхитай иргэдийг судалж тэдэнд хөнгөлөлттэй зээл өгөх замаар амьжиргааны эх үүсвэртэй болгож болно. Мөн хөдөө орон нутагт малжуулах төслийн хамрах хүрээг өргөтгөснөөр малчдын төв суурин газар луу шилжих шилжилтийг бууруулах.

6. *Нийгмийн ажилтныг сургах* Нэн ядуу иргэдтэй тулж ажилладаг гол хүн нь нийгмийн ажилтан юм. Нийгмийн ажилтныг сургалтанд хамруулж, идэвх санаачлагатай ажиллах хөшүүрэг бий болгох хэрэгтэй.

7. *Нэн ядуу иргэнийг тодорхойлох арга зүйг боловсронгуй болгох* Нэн ядуу иргэний тодорхойлолтонд байгаа хязгаарлагдмал хэрэглээ гэсэн ойлголтонд тодотгол хийх, нэн ядууг тодорхойлохдоо түүний хөрөнгийн байдлыг нэмж оруулах шаардлагатай. Мөн түүнчлэн нэн ядуу иргэнийг тодорхойлж буй арга зүйн талаар хороодын засаг дарга нарын дунд сургалт семинар зохион байгуулж нэгдсэн ойлголт, арга зүйтэй болгох шаардлагатай.

8. *Бичиг баримтжуулах* Нэн ядуу өрхүүдийн нилээд хэсэг нь холбогдох зардлыг нь гаргаж чадахгүй болон мэдлэг, мэдээлэл хомс зэрэг шалтгаанаар бичиг баримтгүй байдаг. Улмаар энэ нь нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх, ажил хийх, хүүхдээ сургуульд сургах, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх зэрэг олон эрхээ эдлэх боломжийг нь хаадаг байна. Иймд эдгээр иргэдэд ямар нэгэн төлбөр, хураамжгүйгээр бичиг баримт олгох нь зүйтэй юм. Зөвхөн бичиг баримт олгосноор тодорхой хэсгийнх нь амьдралд нааштай нөлөө үзүүлэх боломжтой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

9. *Нэн ядуу иргэдийг мэдээллээр хангах* Нэн ядуу иргэдийг хууль, нийгмийн халамжийн үйлчилгээ, хөдөлмөрийн бирж зэрэг гол хэрэгцээтэй мэдээллээр хангах арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх шаардлагатай. Дээрх мэдээллүүдийг агуулсан жижиг тараах материалууд, сурталчилгааны

самбаруудыг хорооны захиргаа, эмнэлэг, сургууль зэрэг төвлөрсөн газруудад байрлуулах, нийгмийн ажилтан нэн ядуу өрхүүдэд ухуулан таниулах ажил хийх, шинэ гарсан хууль тогтоомжийг гадаа өдөрлөг, цуглаан зохион байгуулах замаар хүргэх гэх мэт арга хэмжээнүүдийг авч болно.

10. *Гадны санхүүжилттэй төрийн бус байгууллагуудтай ажиллах* Нэн ядуу иргэдэд халамжийн үйлчилгээ үзүүлдэг гадны байгууллагуудыг нэгдсэн бүртгэлд оруулж, халамжийн үйлчилгээний сүлжээ байгуулан, харилцан уялдаатай ажилласнаар нийгмийн халамжийн үйлчилгээг олонд хүртээмжтэй болгох төдийгүй тэдний тухай мэдээллийг нэн ядуу иргэдэд хүргэх боломжтой.

11. *Нийгмийн халамжинд хамруулах хүрээг өөрчлөх* Нийгмийн халамжийн тухай хуулийг харвал нийгмийн халамжинд нэн ядуу иргэд нилээд олон зүйл, заалтаар хамрагдаж байна. Гэтэл эдгээр заалтууд нь өндөр босготой байдгаас нэн ядуусын ихэнх нь нийгмийн халамжийн үйлчилгээний гадна хоцорч байна. Иймд зарим заалтыг өөрчилж, хамрах хүрээг өргөжүүлэх нь зүйтэй. Тухайлбал, олон хүүхэдтэй өрх толгойлсон нэн ядуу эмэгтэйг нийгмийн халамжийн тэтгэмжинд хамруулах шаардлагатай.

12. *Нийгмийн халамжийн зарим үйлчилгээнд ялгавартай хамруулах* Сүүлийн жилүүдэд ядуу, нэн ядуу иргэдийн талаар бэлэнчлэх сэтгэлгээтэй, арчаагүй гэх мэт сэтгэлгээ нийгэмд газар авснаас зарим үйлчилгээг үзүүлэхээ хавтгайруулан болих байдал ажиглагдаж байна. Гэтэл нэн ядуу бүлгийн зарим гишүүнийг тусгайлан авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Тухайлбал нэн ядуу өрхийн жирэмсэн эмэгтэйчүүд хоол тэжээлийн дутагдалд байнга байснаас өөрөө болон хүүхэд нь эндэх, төрөлхийн туралтай хүүхэд төрөх гэх мэт сөрөг үзэгдэл гарч ирсэн. Тиймээс тэднийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулж, үнэ төлбөргүй хооллох нь эх, хүүхдийн эндэгдлийг бууруулахад дорвитой хувь нэмэр болох боломжтой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


1. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийн төсөл, 2001 он
2. Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн, 2001 он
3. Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998 он
4. Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгаа, 1998 он
5. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний Хөтөлбөр, 2002 он
6. Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн арга хэмжээнд зайлшгүй хамрагдвал зохих иргэдийн судалгаа, 2002 он
7. Нийгмийн халамжийн сангийн 2002 оны IV улирлын орлого, зарлагын тайлан, 2003 он
8. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн тайлан, 2000 он
9. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн буюу хэрэгжүүлэхээр зэхэж буй төслийн тойм жагсаалт, 2002 он
10. Ядуурлын талаар 2002 онд хийгдэх судалгаа, дүн шинжилгээний жагсаалт, 2002 он
11. Улаанбаатар хотын инженерийн байгууламжийн хонгил, цооногт тэнүүчлэн амьдарч буй хүмүүсийн бүртгэл, 2002 он
12. Аймаг, нийслэлийн нэн ядуу иргэдийн тандалтын түүвэр судалгаа, 2003 он
13. Poverty Assessment, B. Suvd, B. Altantsetseg, Ulaanbaatar, 2000

*Хууль тогтоомж, дүрэм, журам, зааврууд*

14. Монгол улсын Үндсэн хууль, 1992 он
15. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын Пакт, 1966 он
16. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 1979 он
17. Нийгмийн халамжийн тухай хууль, 1998 он
18. Нийгмийн даатгалын тухай хууль, 1994 он
19. Монгол улсын Засгийн газрын 248 тоот тогтоол, 2002 он
20. Монгол улсын Засгийн газрын 158 тоот тогтоол, 2000 он
21. Монгол улсын Засгийн газрын 195 тоот тогтоол, 2001 он
22. Үндэсний Статистикийн газрын даргын 128 тоот тушаал, 2002 он
23. Нийслэлийн Засаг даргын 519 тоот захирамж, 2002 он
24. Нийслэлийн Хан–Уул дүүргийн Засаг даргын 103 тоот захирамж, 2001 он
25. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 69 тоот захирамж, 1997 он


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# Баян-Өлгий аймгийн нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлын судалгааны тайлан.

Судалгааны төвийн багаас өгсөн удирдамжийн дагуу аймгийн төв Өлгий сум болон Алтанцөгц, Дэлүүн, Цэнгэл сумдыг сонгож судалгааг явуулав.
Судалгааны явцад холбогдох байгууллага, албан тушаалтантай уулзаж шаардлагатай материалуудтай танилцлаа.
Баян-Өлгий аймгийн хэмжээгээр хүн амын амьжиргааны түвшинг судалж бага орлоготой, ядуу, нэн ядуу амьдралтай айл өрх, иргэдийн тоо, нийгмийн халамжийн үйлчилгээний эрэлт, хэрэгцээ, шаардлага хамрах хүрээг тодорхойлж, ядуурлыг бий болгож байгаа шалтгааныг илрүүлэх, түүний үндсэн дээр нийгмийн халамж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, оновчтой болгох, хөтөлбөр, төсөлд хамруулах арга хэмжээ авч ажилласан байна.

2002 оны байдлаар аймгийн нийт хүн амын тоо 98000 байгаа ба үүнээс хөдөлмөрийн насны хүн 49488,. нийт хүн амын 13622 хүн буюу 13,9% бага орлоготой, 23422 хүн буюу 23,9% нь ядуу, 20874 хүн буюу 21,3% нь нэн ядуу амьдралтай байна.

Багийн Засаг нараас гаргасан судалгааг үндэслэн сум, багаар ядуу өрхүүдийн түүвэр гаргуулан жил бүрийн төсөв, ИТХ, ЗД-ын шийдвэрүүдэд тусгуулан ажилласан ба 2001 оныг дуустал ядуу болон нэн ядуу иргэдийг ЯБҮХ-ийн хүрээнд явагдсан ЯБС-ийн үйл ажиллагаанд ихээр хамруулж байснаас гадна ядуурлыг бууруулах, дэмжин туслах, ажлын байр бий болгоход ихээхэн анхаарал тавьж байсан нь харагдаж байна. Нэн ядуу иргэдийн талаар 2001 - 2002 онуудад аймгийн Засаг дарга 17 удаа 29 хүнд 1005,0 мян. төгрөгийн тусламж олгож, 7 хүнийг асрамжинд авахуулж, 2 удаа ажлын байр бий болгох зорилгоор 8 суманд 40 сая төгрөгийн бага хүүтэй зээл олгож, 2 удаа тусламжийн бараа өгөх тухай нийтдээ 24 захирамж гаргасан байна.

Хүн амын амьжиргааны түвшинд сумдын газар зүйн байршил ихээхэн нөлөөлдөг нь судалгаанаас ажиглагдаж байна.

2000-2002 оны өвлийн цаг агаарын таагүй нөлөө зарим сумдын ард иргэд амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргээ ихээр хорогдуулсан нь ядуу өрхийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн байна.Газар тариалан эрхлэх боломжтой зарим сумдад газрын шимийг хүртэх замаар ядуурлаас гарах боломж хайж нилээд өрх “ Ногоон хувьсгал “ хөтөлбөрт хамрагдаж байгаа талаар судалгааны явцад харагдаж байна. Энэ ажил ялангуяа Ногооннуур, Алтанцөгц, Баяннуур, Толбо, Буянт, Сагсай сумдад ихээхэн далайцтай явагдаж байгаа юм.

Мөн ЯБС, Английн түнэшлэлийн Хөтөлбөрийн сан зэргээс зохион байгуулсан малжуулах төсөлд ядуу иргэдийг хамруулан ажилласнаар 50 өрх 1500-гаад толгой малтай болж төсөл үргэлжилж байна.Орон нутгийн нийтийг хамарсан ажлуудад ядуу иргэдийг олноор хамруулж амьжиргаа нь улам доройтохоос урьдчилан сэргийлэх орлогыг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмрээ үзүүлж байна.

2002 оноос Өрхийн амьжиргааг сайжруулах хөтөлбөрт нэн ядуу иргэдийг хамруулах бодлого явагдаж байна. Ядуурлыг бууруулах талаар Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр боловсруулан, ИТХ-аар батлуулж 2002 оноос хэрэгжүүлж эхлээд байгаа ба Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр Улсын хэмжээнд “Тогтвортой амьжиргаа” төслийг хэрэгжүүлэх эхний үе шатанд тус аймгаас Улаанхус, Дэлүүн сумдыг шалгаруулан авч хамруулсан байна.

Нэн ядуу иргэдийг ЯБҮХ, “Ногоон хувьсгал”, Малжуулах төсөл, ОУ-ын УЗН болон бусад донор орнуудын тусламжинд хамруулан ажилласан байна.Ядуурлыг бууруулахад ядуурлыг бууруулах сангаас 1999 онд 205,5 сая, 2000 онд 139,5 сая 2001 онд 21,6 сая төгрөг, Малжуулах төсөлд 2000 онд 5,6 сая, 2001 онд 6,7 сая , 2001 онд Швейцарь, Голланд, Хятадын Засгийн Газар, Олон улсын УЗН-ийн чиглэлээр 127,0 сая төг 2002 онд Казахстанаас эргэж ирсэн иргэдээс гэр оронгүй нэн ядуу 902 хүнд СЭЗЯамнаас 180,4 сая төгрөг тус-тус олгож, Ногоон хувьсгал

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хөтөлбөрийн хүрээнд 115 кг төрөл бүрийн ногооны үр тарааж, Нийтийг хамарсан ажилд 2001-2002 онд 537 хүн хамруулан ажиллуулсан байна.

2002 онд Францын Засгийн газрын өлсгөлөнгийн эсрэг байгууллагатай хамтран хоол хүнсний төсөл хэрэгжүүлж 210 тн гурил, 40 тн ургамлын тосыг 240 өрхөд, Швейцарын Жей-Си-Эс байгууллагын төслийг Цагааннуур тосгонд хэрэгжүүлж 20 өрхөд хоол хүнсний тусламж үзүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга ,МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн даргатай хамтын ажиллагааны тухай байгуулсан гэрээний дагуу Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур, Дэлүүн, Сагсай, Буянт, Улаанхус зэрэг сумдын 385 өрхөд 35,0 сая төгрөгийн тусламж, Алтай,Цэнгэл, Улаанхус сумын 59 өрхөд 1,5 сая төгрөгийн хүнсний зүйл бүгд 36,5 сая төгрөгийн тусламж олгогдсон байна.

Шашны байгууллагаас 2000 онд 4,1 сая, 2001 онд 4,2 сая, 2002 онд 4,5 сая, 2003 онд 6,0 сая төгрөгийн мал / мах /-ыг нэн ядуу амьдралтай өрхүүдэд тусламж болгон өгч тусалсан байна.

Статистикийн мэдээгээр сүүлийн 2 жилийн байдлаар нэн ядуу өрхийн талаар мэдээлэл авахаа больсон байна.

**1998-2002 онд төсвөөс зарцуулсан хөрөнгийн судалгаа**

мян. төг

| | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Нэн ядуу өрх, хүнд | - | 209,0 | 456,0 | 841,0 | 1506,4 |

Нэн ядуу иргэдийг хөтөлбөрүүдэд хамруулсан байдлыг харуулбал:

**Нэн ядуу иргэдэд зориулсан хөтөлбөр** / сая. төг /

| Д/д | Үзүүлэлтүүд | онууд | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 |
| 1 | Ядуурлыг бууруулахад зарцуулсан хөрөнгө | 205,5 | 139,5 | 21,,6 | | |
| 2 | Малжуулахад зарцуулсан | 15,0 | 5,6 | 6,7 | | |
| 3 | Ажлын байртай болгоход | | | 40,0 | 8,4 | |
| 4 | Орон байртай болгох | - | - | - | 180,4 | |
| 5 | Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөр | - | - | - | - | 8.5 |
| 6 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | | | 11.893 | 47,0 | |
| 7 | Нийтийг хамарсан ажилд | | 23,3 | 9,2 | 19,2 | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Аймгийн Улаан Загалмайн хорооноос олгосон тусламжийн судалгаа**
/ 2003 он/

| үзүүлэлтүүд \ онууд | | | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт үзүүлсэн тусламж / төг-өөр / | | | **564,720** | **8,348,0** | **9,107,5** | **2,215,0** |
| Тусламж авсан хүн | | | 534 | 1684 | 1800 | 589 |
| үүнээс | Хүүхэд | | 344 | 462 | 1050 | 315 |
| | Тахир дутуу иргэд | | 36 | 30 | 92 | 9 |
| | Нэн ядуу өрх | | 154 | 1192 | 658 | 265 |
| Төслөөр | Нийт дүн / сая.төг-өөр/ | | - | **16,532** | **52,1** | **28,8** |
| | Хамрагдсан сум | | | 11 | 3 | 7 |
| | Хамрагдсан өрх | | | 324 | 880 | 385 |
| | Тусламж авсан хүн | | | 1692 | 4520 | 1982 |
| | үүнээс | Хүүхэд | | | 2640 | 1071 |
| | | Тахир дутуу | | | 210 | 44 |
| | | Нэн явуу өрх | | | 415 | 425 |

*Нэн ядуу өрхийн ихэнх нь 1996 оноос хойш гэр бүл болсон бага боловсролтой, тодорхой мэргэжилгүй залуучууд, өрх толгойлсон ганц бие эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настай олон хүүхэдтэй хүмүүс, тахир дутуу иргэд байгаа нь судалгаанаас ажиглагдаж байна.*
*Дээрхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа боловч энэ бүгд түр зуурын бөгөөд ядуурлаас гарах амьдралын баталгааг хангах эх үүсвэр болж хараахан чадаагүй байна.*
*Нэн ядуу иргэдийн ихэнх нь боловсрол багатай, мэргэжилгүй байгаа нь ажил олоход бэрхшээл учруулж байна.*
*Хөдөлмөр эрхлэлтийн алба, сум, багийн Засаг дарга нарын ажлын уялдаа холбоог сайжруулж, мэргэжил олгох сургалтанд нэн ядуу иргэдийг зохион байгуулалттайгаар хамруулах нь зүйтэй байна.*
*Төвөөс алслагдсан сумуудад цахилгааны хомсдол ихээс жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлж ажлын байр бий болгох боломж дутмаг байна.*
*Дизель станцтай сумдад оройн цагаар 3-4 цаг цахилгаан өгч бусад хугацаанд сул зогсч байна.Энэ нь дизель түлшний үнэ өндөр, үйлдвэрлэх цахилгаан энергийн өртөг ихтэй холбоотой юм.*
*Үүнээс үүдэн хөдөө сумын төвийн нэнядуу өрхүүд цахилгаангэрлээр гачигдаж лаа, дэнгийн гэрлээр амьдарч байна.*
*Хөдөө сумдад түлээ, нүүрсний гачигдал маш их юм.Ялангуяа ой модгүй манай аймгийн хувьд бүр ч хэцүү нь ойлгомжтой.Зөвхөн нүүрсний үнэ Нүүрст хотгорын уурхайд 9000төг, бол аймгийн төвд 2,4 дахин аймгийн төвөөс150 км алслагдсан сумд 4 дахин илүү үнэтэй байна.Энэ нь тээврийн зардал ихтэй*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*холбоотой юм.Хөдөөд нүүрс авч чадах айл ховор, ихэнхдээ аргал, хөрзөн түлж амь зууж байна.Нэг тэвш аргал хол ойроосоо хамаарч 20,0-30,0мян. төг-ийн хооронд үнэ нь хэлбэлздэг байна.Нэн ядуу өрхийн хувьд үүнийг ч худалдан авах чадал байхгүй тул айл, ах дүүгээсээ шуудайгаар гуйлга гуйж түлээгээ олж, зөвхөн хоол хийх үедээ хэрэглэж буцад үед бараг галгүй сууж байна.*
*Аймгийн төвд ч ийм байдал судалгааны үед харагдаж байсан ба төвлөрсөн зуухны үнэснээс дутуу шатсан нүүрсний хэлтэрхийг өдөржин түүж түлшэндээ хэрэглэж байна.*

*Нэн ядуу өрхийн хүүхдүүд их, дээд сургуулиудад сурах боломж бүр ч алга байна.Төр нэг хүүхдийн нь сургалтын зардлыг хариуцдаг боловч сурах газраа хүрэх унааны , хоолны, хувцас хунарын, хичээлийн хэрэглэлийн зардлыг төлөөд байх чадвар ядуу өрх бүрт алга байна.Мөн нэн ядуу өрхийн хүүхдүүдэд нь ном, дэвтэр, сурах бичиг дутмаг байдгаас ЕБС-д ч сурах боломжгүй болж сургууль завсардах боломж бүрддэг байна. Аймгийн төвийн зарим нэн ядуу өрхүүдэд томоохон хүүхдээ боломжтой айлын хүүхэд харах, гэр орны ажил хийхэд нь туслуулахаар ажиллуулах, хөдөө төрөл төрөгсөддөө мал маллахад нь туслуулахаар явуулах, ингэснээр хүүхэд боловсролгүй болоход хүрч байна.*
*Нэн ядуу өрхүүдээр явж судалгаа хийхэд ямар ч орлогогүй зөвхөн тэтгэврийн ахмад настны тэтгэврээр амьдарч байгаа 7-8 ам бүлтэй өрхүүд аймгийн төвд тааралдаж байлаа.*

*Нэн ядуу амьдралтай өрхийн гишүүд хоол хүнсээр гачигдах явдал маш их байна.Энэ талаар тодорхой судалгаа явуулах шаардлагатай юм.*
*Хууль эрхийн мэдлэг сул учраас өөрийнхөө эрх үүргийг тодорхой мэдэхгүй явдал байна. Нэн ядуу иргэдийн талаар төр, засгаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ , эрх ашгийг хамгаалах талаар гарсан хуулиудыг сурталчлахад зохих байгууллагууд анхаарах шаардлагатай байна.*
*Нийгмийн даатгалын тухай, нийгмийн халамжийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын талаар огт мэдэхгүй хүн олон байлаа.*
*Нэн ядуу өрхүүдэд хийгдсэн тандалтын судалгаанд хамрагдсан 220 өрхөөс 104 нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, даатгалын ач холбогдлыг сайн ойлгодоггүй, иргэний үнэмлэх аваагүй 48 өрхийн гишүүд байгаа нь ажиглагдав.Иргэний үнэмлэх аваагүй байгаа шалтгааны талаар асуухад ихэнх нь мөнгөгүй учраас гэж хариулж байв.Ер нь боловсрол дорой мэдлэг муутай байгаа нь судалгааны асуултуудад өгч байгаа хариултуудаас харагдаж байв. Зарим хүмүүс юу ч гэж хариулахаа мэдэхгүй , хаана хэнд хандаж тусламж авахаа ч мэдэхгүй хүн тааралдаж байгаа нь хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгааг харуулж байна.*
*Тус аймагт бас нэг ажиглагдсан зүйл Казахстан улсад нүүхээр бүх материалаа бүрдүүлж өгөөд Монгол улсын харьяатаас гарсан боловч, нүүж чадаагүй аль ч улсын иргэн биш байгаа иргэд ч байна.*

Судалгааны явцад нэн ядуу иргэдтэй биечлэн уулзаж учир шалтгааны тодруулахад ихээхэн анхаарч ажиллаа.
Ядууралд орж байгаа шалтгаан:

1, Тус аймагт ажлын байр нэн ховор , авах цалин хөлс улсын хэмжээнд доогуур байгаа нь нөлөөлж байна.
Улсын хэмжээнд цалингийн доод түвшин ижилхэн байгаа нь төсвийн байгууллагын ажилтан, ажилчид , тэтгэвэр , тэтгэмж авагчид, хувийн хэвшлийн үйлдвэр, байгууллагад цалингийн доод хязгаарын жишиг болж бага цалинтай хүмүүс, тэтгэвэр тэтгэмж авагсадад амьдралын өртгийн өсөлтийг хангаж чадахгүй байна. Энэ нь алс хязгаарын аймагт амьдрагсадад нэн тэргүүнд мэдрэгдэж байна. Иймд цалингийн доод түвшинг бүсчлэн өөр өөр тогтоох шаардлагатай юм.

2, Мэргэжилгүй хүмүүст мэргэжил олгоход голлон анхаарч сургалтын хялбар арга хэлбэрийг сонгон зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохирсон байхаар зохион байгуулах нь зүйтэй юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3, Сүүлийн жилүүдэд болсон зууднаар малаа үрэгдүүлж малгүй бологсод нэн ядуурч амьдрахын эрхэнд хот, суурин газар бараадаж байна.
Гэвч хот суурин газарт тэдэнд өгөөд байх ажлын байргүй, байсан ч тохирох мэргэжилгүй тул амьдарлаа тэтгэх орлогогүй , амьдарч суух гэр оронгүй болох явдал ч гарч байна.

4, Нэн ядуу иргэдийн ихэнх нь Казахстан улсад хөдөлмөрийн гэрээгээр анх нүүж очсон иргэдээс тэнд ч ажилгүй болж амьдрал нь хүндэрч буцаад нүүж ирэгсэд энд ч ажилгүй, оршин суух гэр оронгүй, хөрөнгөгүй болсон иргэд байна.

5, Өрхийн ихэнх нь олон хүүхэдтэй , ам бүл олуулаа тул олсон орлого амьдралд нь хүрэлцдэггүйгээс ядуу зүдүү амьдрахад хүрч байна.

6, Ядуу иргэдийн ихэнх нь угаас залхуу хойрго хүмүүс байгаа нь ажиглагдаж байна.

7, Нэн ядуу иргэдийн амжиргааны түвшин хэт доогуур байгаагаас хүнсний хангамж, орон сууцны нөхцөл маш муу байна.
Энэ нь өвчин эмгэгт нэрвэгдэх, өвчин угжирч хүндэрэхэд хүргэдэг байна.

8, Нэн ядуу иргэдийн хүүхдүүд өмсөх хувцас, хичээлийн хэрэглэлээр байнга дутагдаж үе тэнгийнхнээсээ хөгжлөөр хоцорч байна.
Зарим нэг нь энэ байдлаасаа болж сургуульзавсардаж боловсрол, мэргэжилгүй болоход хүрч байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Нэн ядуу иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагын тэмдэглэл.

2003,02,19 өдөр. Өлгий сум.

Аймгийн хүний эрхийн мэргэжилтэн Е. Алмагул, Хүүхдийн төлөө төвийн ажилтан М. Озат, Өлгий сумын 6 дугаар багийн Засаг дарга Т.Муттахи нар 6 дугаар багийн нэн ядуу иргэдтэй уулзаж , ярилцлага зохион явуулав.

Уг ярилцлагад тус багийн 14 хүн оролцов.

Хүний эрхийн мэргэжилтэн Алмагүл ярилцлагын зорилго, хийгдэх гэж байгаа судалгааны талаар танилцуулж, Хүүхдийн төвийн ажилтан Озат хүүхдийн эрхийн талаар танилцуулга хийж, хүүхдийн эрхийн төлөв байдлын талаар санал бодлоо чөлөөтэй ярьж өгөхийг хүсэв.

Багийн Засаг дарга Муттахи танилцуулахдаа:
Энэ баг нэн ядуу өрхийн тооны талаар нилээн дээгүүр байранд ордог. Яагаад гэвэл дээр үеэд Цагааннуурын дажлага баазад олон хүн ажилтай байсан, сүүлийн үед уг баазын үйл ажиллагаа зогсож, удирдлага нь аймгийн төвд нүүж ирсэнээр олон арван залуучууд ажлын байргүй болж, Өлгий сумын тус багт төвлөрөөд байгаа. Ихэнх нь орон гэргүй, ажил хөдөлмөргүй залуу гэр бүл учир, улсаас авах тэтгэвэр тэтгэмж гэж үгүй, амьдрал нь хэцүү байгаа ба ихэнх өрхүүд түлээ авах боломжгүй учир хогийн цэгээс дутуу шатсан нүүсний хаягдалыг түүж түүэндээ хэрэглэдэг гэв.

Өлгий сумын ЗДТГ-аас энэ байдлыг харж үзэн орон гэргүй зарим хүмүүс 70 ш банз авч өгсөн.Уг банзыг ашиглан байшингийн дээвэр хийж, үнсэн блокоор байшин барьсан байна.

Иргэн Б. 40 настай Амбул 5. /хүүхэд 2,3,13 настай, эхнэр нь жирэмсэн /
Цагааннуураас нүүж ирээд 5 жил болж байна, ажил эрээд олдохгүй байна. Ямар ч орлогогүй, юм хийх мөнгө төгрөггүй. Арга барахдаа том охин айлуудаар явж гуйлга гуйдаг.Өөрөө өдөржин хсг ухаж, орй ирдэг. Эхнэр маань төрөх дөхөж байгаа гэв.

Асуулт: -Эхнэр чинь эрүүл мэндийн даатгалтай юу?
Хариулт :- Даатгалд өгч, саяханаас л материалыг нь бүрдүүлж байгаа.

А: Охин чинь сургуульд сурч байгаа юу, ямар бэрхшээл байна вэ?
Х: 5 дугаар ангид сурч байгаа. Хичээлийн ном, хэрэглэл байхгүй.Сургуулийн захиргаанаас асуухад, зөвхөн хагас өнчин юм уу, бүтэн өнчин хүүхдэд л өгөх боломжтой гэсэн гэв.

Иргэн Ш: Казахстанаас нүүж ирээд 9 жил болж байна. Хийх ажил олдохгүй байна. Сургуулийн насны 3 хүүхэдтэй. 2 нь сургуулиас гарсан. 6 дугаар ангид нэг хүүхэд сурдаг.Өрхийн ам бүл 6. Ээж өндөр настны тэтгэвэр авдаг. Сард / 18,0 мян.төг /. Ордог орлого ерөөс л энэ. Цаашид яаж амьдрахаа мэдэхгүй байна. Гэрлийн мөнгө төлөөгүй учир сарын өмнө тасалсан. Иргэний үнэмлэх авах иөнгөгүй тул гэр бүлээрээ авч чадаагүй. 2002 онд түлээ нүүрсний тусламж 40,0 мян. төг.авсан.

Иргэн Х. 36 нгастай. Эхнэр 2 хүүхэдтэй. Бүтэн өнчин 3 дүү нь хамт амьдардаг.Нэг дүү маань ТМС-д сурдаг.Бусад хоёр нь 5,8 дугаар анги.Хүүхдүүд сард 12,0мян.төг тэтгэмж авдаг.
Х өөрөө өрөөсөн гаргүй.Тахир дутуугийн тэтгэмж 14,8 мян. төг авдаг.Нэг л хүүхэдэд / дүүд нь / хичээлийн хэрэглэл өгсөн. Амьдрал доройн ч гэсэн хэдэн дүүгээ

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*сургууль завсардуулаагүй.Гэвч бүгдээрээ том хүмүүс болохлоор идэж уух юмны хүрэлцээ муу.Заримдаа хувцас хунар муу учраас гуталаа ээлжилж өмсөөд гадагшаа гарах явдал гардаг.*

*Иргэн С. 43 настай. Өрх толгойлсон эмэгтэй.Ам бүл 7.Сургуулийн насны 3 хүүхэд маань сургуулиас гарсан.Өмсөх хувцас хунаргүй.Цахилгааны өр 50,0мян төг. Төлж чадаагүй учир гэрлээ таслана гэсэн.Том хүү маань зуны цагт хааяа нэг хөлсний ажил олж хийдэг. Тэжээгчээ алдсаны тэтгэмж сард 22,6 мян. төгрөг авдаг.*

*Иргэн Б 37 настай . Ам бүл 11. 8 хүүхэдтэй.Том охин маань ахлах сургуульд. ССургуулийн насны 3-аас сургуульд байгаа нь энэ. Сумын Засаг даргын тусламжаар сургуулийн дотуур байранд оруулж, сургаж байгаа. Бусад 2 нь сургуулиас гарсан. Сургуульд явуулах боломжгүй. Нэг охиноо боломжийн айлын хүүхдийг харуулах, гэр орны ажилд нь туслуулахаар өгсөн. / 14 наэстай / Өөр арга алга байна. Багийн засаг дарга нар ирсэн тусламжаас өгдөг.Тэр юу ч болохгүй байна. Ажил олж хийх хэрэгтэй байна.*

*Иргэн И. 36 настай. Ам бүл 6. Том охин 15 настай . сургуулиас гарсан. / 6 дугаар ангиас / Амьдрал хэцүү болохоор 8 настай хүүгээ ах дүү руу хөдөө явуулсан. Нөхөр маань хулгайн хэргээр шоронд суугаад ирээд жил болж байгаа. Ирээд нэмэр болсон юм алга. Өнөөдөр бас хулгайн хэрэгт сэжиглэгдэж баривчлагдсан юм шиг байна. Түлээ мод, идэх хоол ч үгүй. Заримдаа үхмээр санагддаг. Өнөөдөр талхны мөнгө олох гэж /хуучин гутал оёдог байсан, гутлын колоткийг/ зарах гэсэн боловч авах хүн олдсонгүй гэж уйлж байв.*

Бидний ярилцсан эдгээр хүмүүсийн ихэнх нь хөдөлмөрийн насны залуу хүмүүс байв. /36-43 насны / Амьдрал нь үнэхээр хэцүү байгаа нь харагдаж байна. Ихэнх нь ажлын байр л байвал бидний амьдрал дээшилнэ гэж байв. Өвлийн 2 сар болж байхад хөл нүцгэн явж байгаа бага насны хүүхдүүд байна. Эдгээр хүүхдийн цаашдын амьдрал, эрүүл мэнд нь ямар болохыг мэдэхэд хэцүү байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Өлгий сумын 2 дугаар багийн нэн ядуу өрх 2 өрөө блокон байшин 11 хүн амьдардаг З. Муханбетийн гэрт очиж хийсэн судалгааны товч тэмдэглэл.**

1. С: -Танай өрхийн нэн ядуу байгаагийн гол шалтгаан нь юу вэ?

Муханбет: Манайх 9 хүүхэдтэй айл эхнэр бид хоёр хоёулаа эрхэлсэн ажилгүй.

Би зах зээл гарахаас өмнө 1992 он хүртэл Ахуй үйлчилгээний салбарт ажиллаж байгаад байгууллагамаань байхгүй болсноос хойш ямарч ажил эрхэлээгүй Улсаас авч байгаа тэтгэвэр тэтгэмж байхгүй нэг муу мотциклтэй тэрүүгээр такси хийж явдаг боловч бараг олох юм гүй. Том нэг охин маань нэг хувийн гуанзанд сардаа 10-15 мянган төгрөгний цалин авч ажиллаж байгаа. Нэг хүү маань захд тэрэг түүрч өдөрт 500-1000 төгрөг олдог тэр хэдийг нэмж амь зууж л суундаа.

С: -Танд Улсаас үзүүлж байгаа тусламж юу байна. Ойрын 5 жилд ямар нэгэн тусламжинд хамрагдсан уу.?

М: Би Улсаас тусламж гуйж нэг их явдгүй харин ажилтай болгож өгөөч, Миний ар гэрийн байдлыг очиж үзээч гэж 2000 оноос хойш Өлгий сумын Засаг даргад 2-3 удаа өргөдөл оруулсан боловч ямарч үр дүн гарсангүй. 2001 онд түлээ нүүрсний хөнгөлөлт болох 40 000 төг нэг удаа олгож өгсөн. Миний Улсаас авсан тусламж гэвэл энэ л байна.

С: Танай өрхийг ядууралаас гаргах арга зам бий юу, байвал юу вэ?.

М: Би өөрөө ажил хийвэл ямарч хамаагүй ажил хийх бүрэн боломжтой гэр бүлийн хүн маань одоохондоо нялх хүүхэдтэй . Хөдөлмөрийн насны 4 хүүхэдтэй энэ бүгд биш юмаа гэхэд 2 хүн ажилтай болвол арай нэн ядуугийн тооноос гарч болох байх гэж боддог. Ажил олдохгүй юмаа гэхэд Улсаас ядууралын замаар хүүгүй зээл ирвэл , авч ямар нэгэн юм хийж болох байх гэж боддог.

**Танд баярлаа**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Өлгий сумын 2 дугаар багийн оршин суугч З. Муханбетийн гэрт хийсэн судалгааны товч тэмдэглэл хөтөлсөн Судлаач /М. Роза/

**Өлгий сумын 3 дугаар багийн оршин суугч Б. Мерекегийн гэрт хийсэн судалгааны товч тэмдэглэл.**

**С: Танайх хэдэн ам бүлтэй яаж амьдарч байгаа тухай товч ярихгүй юу?**

**Миний бие Б. Мереке Өлгий сумын 3 дугаар багт эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг Эхнэр бид хоёр хоёулаа тахир дутуугийн тэтгэмж авдаг хоёулаа төрлөхийн тахир дутуу манай гэр бүлийн хүний нэг гар, нэг хөл нь төрлөхийн ажилгаагүй ,миний нэг гар төрлөхийн тахир дутуу .**
**С: Та хоёрт Улсаасс үзүүлж байгаа тусламж бий юу**
**Сар болгон авах 12000 төгрөгний тэтгэмжийг авч байгаа жилд нэг удаа түлээ нүүрсний хөнгөлөлт гэж нэг удаа 40000 төгрөг авдаг өөр юм байхгүй**

**С: -Таны одоо Улсаас хүсэх юм юу байна . тахир дутуу иргэдэд зориулан юу хийгээсэй гэж бодож байна.**

**Бидний амьдрлд дарга нар ирж танилцаасай байдлыг маань харж тахир дутуу хүмүүст үзүүлэх тусламжинд хамааруулж байгаасай л гэж хүсэх байна.**

**Танд баярлалаа.**

**Өлгий сумын 3 дугаар багийн оршин суугч эхнэр нөхөр нь хоёулаа төрлөхийн тахир дутуу Б.Мерекгийн гэрт хийсэн судалгааны товч тэмдэглэл хөтөлсөн /М. Роза/**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# Алтанцөгц суманд хийгдсэн нэн ядуу иргэдийн талаарх судалгаа.

Сумын хэмжээний ядуу иргэдийн судалгааг шинэчлэн гаргуулж, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн 94 өрхийг нэн ядуу өрхөөр тооцож Засаг даргын 2003 оны 2 сарын 24-ний өдрийн 04 тоот захирамж гаргуулав.Уг 94 өрхийг багаар авч үзвэл:
Хаш багт –24, Баянбулагт-19, Улаанхарганд – 20 өрх,сумын төвд- 32 өрх амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур байна.Уг 94 өрхийн мал, хөрөнгийн талаар авч үзвэл хонь 72, ямаа 41, үхэр 48, адуу 14 байгаа ба гэр, эсгий гэртэй 84 өрх, өрх толгойлсон эмэгтэй 14 байна.

Эдгээр өрхүүдэд сургуулийн насны 68 хүүхэд байгаа ба үүнээс хичээлийн хэрэглэл, хувцас хунаргүйгээс болоод сургууль завсардаж байгаа 24 хүүхэд байна. Эдгээр хүүхдүүд хичээл номоо чамдан суралцах эрмэлзлэлтэй байгаа боловч өмсөх хувцас, ном дэвтэр авах боломж ар гэрт нь байхгүй байгаа нь судалгааны үед харагдаж байна.

Сумын ЗДТГ-аас нэн ядуу өрхийн судалгааг жил бүр авч, ЗД-ын зөвлөлийн хурлаар авч хэлэлцээд баталгаажуулан тогтоож байгаа ба он дараалалаар авч үзвэл:
2000 онд- 78,
2001 онд- 80,
2002 онд- 94 өрх болж өссөн байна.
Эдний дундаас 72 өрхийг ямар нэгэн зээл тусламжинд хамааруулан нийт
7,9 сая төгрөгийн эд зүйл / гурил, цай, хувцас хунар / өгсөн байна.

Нийгэм халамжийн сангаас 6 хүнд түлээ, нүүрс өгч 150 мян.төг зарцуулжээ. Ганц бие нэн ядуу харж хандах хүнгүй 2 хүнд нэг хүнийг өвлийн цагт асран халамжлахад нь сар бүр 10000 төгрөг өгч байсан ба орон гэргүй хүнд ЗДТГ-ын төлөвлөгөөнд тусгажбайшин барьж өгөхөөр болсон байна.

10 жилийн дунд сургуулиас нэн ядуу өрхийн 68 хүүхдэд зориулан 442000 төгрөгийн ном дэвтэр, харандаа, цүнх өгсөн байна.

Мусулман шашины байгууллагаас нэн ядуу өрхөд 2001 онд 10 хонины мах, 2002 онд 14 хонины махыг олгосон байна.

Нэн ядуу өрхөд зориулсан төсөв хөрөнгө тус суманд байхгүй байгаа ба 31 хүнийг улирлын чанартай ажилд хамруулсан байна. Сумын нэн ядуу өрхийн насны бүтэцийг авч үзвэл:
25-35 насны 18,
32-62 насны 76 байгаа үүнээс өрх толгойлсон эмэгтэй 14, насны бүтэцээр бол 32-48 насных байна.

Нэн ядуу иргэдээс нийгмийн халамжийн үйлчилгээнд 21 өрх хамрагдаж байгаа ба 2001 онд 17 өрх, 2002 онд 21 өрхөд / ам бүл 84 / нийгэм халамжаас 210,0 төгрөг зарцуулжээ.

2001 онд нийгмийн халамжинд харуулах шийдвэр гарсан хүн 4,
2002 онд 6 хүнийг нийгмийн халамжинд харуулах шийдвэр гарсан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын нэн ядуу хүн амын судалгаа

**1998-2002 он**

| № | онууд | өрхийн тоо | Хүн амын тоо | өрхийн дундаж орлого | Огт орлогогүй | Насны бүтэц | | | Боловсролын байдал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 0-16 | Хөдөлмөрийн насны | Тэтгэврийн насны | Огт орлогогүй | бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Тусгай дунд | дээд |
| 1 | **1998** | 67 | 191 | 13,2 | 18 | 48 | 65 | 52 | 42 | 38 | 61 | 18 | 26 | 6 |
| 2 | **1999** | 74 | 229 | 15,0 | 9 | 72 | 78 | 79 | 49 | 51 | 56 | 49 | 16 | 8 |
| 3 | **2000** | 78 | 234 | 17,1 | 13 | 97 | 110 | 27 | 61 | 41 | 54 | 30 | 40 | 8 |
| 4 | **2001** | 80 | 249 | 18,8 | 8 | 106 | 92 | 51 | 58 | 39 | 45 | 52 | 45 | 10 |
| 5 | **2002** | 94 | 460 | 22,4 | 15 | 205 | 208 | 47 | 64 | 49 | 102 | 198 | 28 | 19 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Дэлүүн суманд хийгдсэн нэн ядуу иргэдийн төлөв байдлын судалгаа.

Нэн ядуу иргэдийн төлөв байдлын судалгааг сумын нэн ядуу иргэдийн зохих хэсгийг хамруулан 2003 оны 2 сарын 15-наас 28-ныг хүртэлх хугацаанд хийв.Судалгаа явуулахын тулд судлаачдын баг зохион байгуулж сумын хэмжээний нэн ядуу иргэдийн судалгааг гаргаж, түүний дотроос зохих иргэдийг сонгон авч хүн бүртэй ганцаарчилсан уулзалт ярилцлага хийж асуулт хариулалтын тэмдэглэл хөтлөж дүнг гаргаж ажиллав.

Нэн ядуу иргэдээс гадна сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар , 10 жилийн сургууль , эмнэлэг болон ТББ-аас нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай танилцав.Үүнд:

Тус сум нийтдээ 1839 өрх 8464 хүн амтай, түүний 49,3%нь эмэгтэйчүүд, 174 хүн тахир дутуу, 86 нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.Үүний 441 өрхийн 1864 хүн нэн ядуу амьдралтай байгаа нь өрхийн22%, хүн амын 23%-ийг эзлэж байна.Оны эхэнд нэн ядуу өрхийн гишүүдийн орлогыг тооцоолж сумын Засаг даргын зөвлөлийн хуралаар авч хэлэлцэн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын жилийн төлөвлөгөөнд нийгмийн салбарт баримтлахзорилтоо иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх , хүний хөгжлийгхангах орчныг бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах асуудалд чиглүүлэн 2002 онд 42 асуудал төлөвлөснөөс 36 асуудал биелэгдэж 6 асуудал хэрэгжих шатанд байна. Оны эхэнд батлагдсан нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх төрөл бүрийн халамж тусламжинд эхний ээлжинд хамааруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласаны үр дүнд 2002 онд Франц улсын хүмүүнлэг байгууллагын тусламжинд 216 өрх буюу 915 хүнийг, УЗН-ийн тусламжинд 70 өрх тус бүрт 84 мян.төг, Казахстан улсаас нүүж ирсэн иргэдэд хүүгүй зээл 76 өрхөд 7400,0 мян.төг-ийг, сумын шашины байгууллагаас 110 өрхөд тут-тус биет болон мөнгөн тусламж өгч, нийт 396 өрхийн 1935 хүнийг хамруулсан байна.

Оны дотор нэн ядуу мргэдээс 36 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлж 936 мян. төгрөгний ор хоног үнэ төлбөргүй эм хэрэглэсэн байна.

Нийгмийн халамжийн сангаас давхардсан тоогоор 1047 хүн хамрагдаж 81506 мян. төг-ийн халамж хүртсэн байна.

Шинээр орон гарсан төсөвт байгууллагад 12 хүн, ХЭАА-д улирлын чанартай түр ажлын байранд 120 хүн орж ажилласан байна.Дээрхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа боловчядууралаас бүрмөсөн гарах ахицтай өөрчлөлт гарч чадахгүй байгаа.

Судалгаанл хамрагдсан иргэдийн мэдээллээс харахад өрхийн доторх хүн амын амьжиргааны нэг хүнд ногдох дундач орлогын хэмжээ 2400 төгрөг, насны байдлаар үзэхэд 29% нь 0-7 насны хүүхэд, 21 хувь нь 8-18 насны хүүхдүүд эзлэж байна.

Боловсролын байдлаас үзэхэд 12 хувь нь бүрэн дунд, 22? Нь бүрэн бус дунд үлдсэн хэсэг нь бага боловсролтой хүмүүс байна.

Судалгаанд хамрагдагсадын 31% нь Францын хүмүүнлэгийн байгууллагын тусламжинд 2 өрх, 1999 малжуулах төсөлд 3 өрх, Казахстанаас нүүж ирсэн орон байргүй 3 өрхөд орон сууц барихад нь зориулж хүүгүй зээл олгосон байна. Судалгаанд хамрагдсан өрхүүд дотроос 3 өрхөөс бусад нь ямар нэгэн тусламжинд хамрагдсан байна.

UH.MN
СУДАЛГААНЫ САН

Дэлүүн сумын нэн ядуу хүн амын судалгаа

| онууд | өрхийн тоо | Хүн амын тоо | өрхийн дундаж орлого | Огт орлогогүй | Насны бүтэц | | | Боловсролын байдал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 0-16 | Хөдөлмөрийн насны | Тэтгэврийн насны | Огт орлогогүй | бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Тусгай дунд | дээд |
| **1998** | 135 | 692 | 8460 | 11 | 353 | 257 | 17 | 48 | 117 | 91 | | | |
| **1999** | 136 | 685 | 1177 | 11 | 396 | 270 | 19 | 39 | 145 | 86 | | | |
| **2000** | 182 | 820 | 12400 | 15 | 432 | 364 | 24 | 41 | 243 | 80 | | | |
| **2001** | 441 | 1935 | 20855 | 35 | 1180 | 730 | 25 | 32 | 320 | 272 | 17 | 3 | 1 |
| **2002** | 315 | 1656 | 21000 | 11 | 940 | 683 | 33 | 31 | 312 | 245 | 12 | 4 | 2 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# Цэнгэл суманд хийгдсэн нэн ядуу иргэдийн төлөв байдлын судалгаа

Тус сум нь хүн ам олонтой, эмзэг бүлэг ихтэй сумын тоонд ордог.Нэн ядуу өрхийн ам бүлийн дундаж тоо нь 4,7-5 хүн, сард нэг ам бүлд ноогдох орлого 11,6-19,4 мян.төг байна.Сумын нэн ядуу өрхийн судалгааг жил бүрийн эхэнд багуудын Засаг дарга болон сумын төрийн үйлчилгээний байгууллагаас хийж, ЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталж байна.

"Ядуурлыг бууруулах сумын хөтөлбөрийг"-ийг 2000 онд ЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж , мөн оны 12 дугаар сарын 25-ны өдрийн захирамжаар баталж, амьдралд хэрэгжүүлж байгаа юм байна.Нэн ядуу өрхүүдийг жил бүр тодорхойлж гадаадын зээл, тусламжинд эхний ээлжинд хамруулж байна.

Тухайлбал, 2001 онд ирсэн гурил тэжээлд, 2002 онд МУЗН-ийн шугамаар ирсэн гурил, эмийн сан, радио хүлээн авагч, 2002 оны сүүлчээр ирсэн Швейцарь улсын хүмүүнлэгийн тусламжинд нэн ядуу өрхүүдийг 100% хамруулсан байна.

Мөн 1999 онд малжуулах, өрхийн амьжиргааг дээшлүүлэх төслийг авч хэрэгжүүлсэнээр эхний ээлжинд арван өрхөд 300 толгой бог мал өгч, тэдэнд 2 жил ашиглуулсанаар мал нь төлөөр өсөж, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн болно.

Уг малыг 3 жилийн дараа дахиад 10 өрхөд шилжүүлсэнээр тэдний аж амьдралд тус дэм болж байгаа юм.Мөн ядуурлыг бууруулах төслөөр 3 жилд 9,0 сая төгрөг авч , нэн ядуу 20-30 өрхөд тараан өгч, тэдэнд тэр мөнгөөр туйпуу, блок барих, оёдол оёх, мод бэлтгэх, мал худалдан авч өсгөх зэргээр ашиглаж, амьжиргааг дээшлүүлсэн байна.

Нэн ядуу иргэдийг ажилтай болгох зорилгоор эргэж төлөх нөхцөлтэйгээр зээл авч, сумд хөрөө рам болон мужааны цех, хөх шийрийн жижэг үйлдвэр нээж ажиллуулсанаар тэнд 15-20 хүн ажилд орж ажиллаж байгаа баэнэ нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахад зохих хувь нэмэр болсон юм.

Ядуу өрхийг сумын ИТХ-ын тэргүүлэгчид , ЗД-ын зөвлөлөөр авч хэлэлцэж, 2001 онд 200 өрхийг өрх тус бүрт 12 уут гурил, 200 өрхөд эмийн сан, радио, хүлээн авагч, 125 өрхөд өрхийн гишүүн тус бүрт 50 кг гурил, 5кг тос зэрэг тусламжийн зүйл олгосон байна.

Мөн Казахстанаас нүүж ирсэн 34 өрхөд эргэж төлөх нөхцөлтэйгээр 6,8 сая төгрөгийн хүүгүй зээл өгсөн байна.Судалгаанаас үзэхэд нэн ядуучуудын 40% нь хөдөлмөрийн насны,56% нь хүүхэд,байгаа нь тус суманд ажлын байр дутагдалтай байгаагаас шалтгаалж байна.Мөн ядуучуудын 83% нь огт боловсролгүй , эсхүл бага боловсролтой байна.Ядуурālд ороход энэ байдал бас нөлөөлж байна гэж үзэхээр байна.

Нэн ядуу иргэдийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд аймгийн халамжийн байгууллагаас 1998 оноос эхлэн жил бүр нэн ядуу өрхийн доторх тахир дутуу, ахмад настанд зориулж өрх тус бүрт15-20,0мян. төг-ийн буцалтгүй тусламжийг олгож байсан байна.Сумын нэн ядуу өрхийн 60% буюу 81 өрхийн аль нэг гишүүн нь нийгмийн халамжийн сангаас тэтгэмж авч байгаа нь харагдаж байна.Тэтгэмж авагсадын ихэнх нь 18-45 насны хоорондын хүмүүс байна.Нэн ядуугийн зэрэглэлтэй тэтгэвэр авагсадын ихэнх нь төрөлхийн болон ҮОМШӨ-ний биш, бусад төрөл бүрийн шалтгаантай байна.

Хүмүүстэй ярилцахад ядуурлын шалтгааныг ихэнх нь ажлын байрны хомсдолоос үүсч байгаа талаар ярьж байв.Мөн нэн ядуугийн ихэнх нь 1991-1993 онуудад явагдсан хувьчлалын үеэс эхлэж ядуурālд орсон тухай ярьж , айл өрхүүд хөдөө нүүдлийн байдлаар амьдардаг, сумын төвд эрхлэх ажил олдоггүй талаар ярьж байв.

Дээрхи судалгааны дүнгээс үзэхэд Төр засгаас болон Олон нийтийн / ТББ-уудаас / хүртэж байгаа тусламж нь тухайн үеийн түр зуурын арга хэмжээ болж байна.

Цэнгэл сумын нэн ядуу хүн амын судалгаа

| онууд | өрхийн тоо | Хүн амын тоо | өрхийн дундаж орлого | Огт орлогогүй хүн | Насны бүтэц | | | Боловсролын байдал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 0-16 | Хөдөлмөрийн насны | Тэтгэврийн насны | Огт боловсролгүй | бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Тусгай дунд | дээд |
| **1998** | 196 | 979 | 11600 | 13 | - | 401 | 4 | 409 | - | 109 | 51 | 6 | - |
| **1999** | 204 | 1003 | 11900 | 26 | - | 429 | 8 | 393 | - | 124 | 54 | 3 | - |
| **2000** | 211 | 907 | 12400 | 24 | 512 | 389 | 6 | 314 | 424 | 111 | 49 | 8 | 1 |
| **2001** | 148 | 666 | 15500 | 13 | 430 | 224 | 12 | 200 | 341 | 89 | 31 | 4 | 1 |
| **2002** | 145 | 923 | 19400 | 12 | 516 | 392 | 15 | 295 | 496 | 100 | 24 | 7 | 1 |

Судалгааг гаргасан Табигат

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ СУДЛАХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ИЛТГЭХ ХУУДАС

2003. 03. 07 Өлгий сум

Сумын хэмжээний нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдалд тандалт судалгаа хийх ажлыг сумын ЗДТГ-ын холбогдох ажилтнууд багийн засаг дарга нар багийн иргэдтэй хамтран хийв.

Судалгааны явцад нэн ядуу өрхийн эзлэх хувийн жинг 1998- 2002 оны байдлаар авч үзвэл:

| Он: | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Нийт өрх | 4711 | 5079 | 5693 | 5995 | 6336 |
| Ядуу өрх | 2778 | 2889 | 2950 | 1553 | 1601 |
| Нэн ядуу өрх | 1421 | 1487 | 1612 | 996 | 1552 |

Ажил хөдөлмөр эрхэлэлтийн байдал:

| Ажиллагсад: | | | | | Ажил эрхэлээгүй: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
| 3786 | 3821 | 3840 | 3843 | 3849 | 2077 | 4770 | 6650 | 6789 | 6900 |

Өлгий сумд аймгийн нийт хүн амын 28.3% нь оршин суудаг сүүлийн 5 жилд ажилгүйдэл ядуурлыг бууруулах чиглэлээр110 төсөлд 24 сая төгрөгний зээл олгогджээ . нэн ядуу иргэдэд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд компанит ажил , төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний дүнд 2001 онд буцалтгүй зээл тусламж, хөнгөлтөд давхардсан тоогоор 1282 өрх хамрагдан 19049800 төгрөгний Швецарийнн ОУ-ын байгууллагын " Өвөл төсөлд 192 өрх хамрагдан 22 сая төгрөгний хөнгөлөлт тусламжинд 2002 онд Хятад Улсын Алтай аймгийн тусламжинд 820 өрх хамрагдан 10 сая төгрөгний , 518 өрх Засгийн газрын хөнгөлөлттэй зээлд хамрагдан 103.6 сая төгрөгний тусламжинд Францын ОУ-ын байгууллагын шугамаар хэрэгжих төсөлд 442 өрх 2228 хүн хамрагдаж 16.2 сая төгрөгний буцалтгүй тусламж ХЗА- тай хамтран нийтийг хамрах ажилд 138 хүн ажиллан 4.9 сая төгрөгний төсөлд тус тус хамрагджээ.

Сумын засаг даргын захирамжаар батлагдсан нэн ядуу өрхийн бүртгэлд 2001 онд 996 өрх 2002 онд 1552 өрх тус тус хамрагдан эмнэлгийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагджээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Сумын баг бүрт ядуу нэн ядуу өрхийн судалгааг нарийвчлан гаргаж хөнгөлөлт үйлчилгээнд ээлж дараатайгаар хамруулж иржээ.

Нэн ядуу иргэдэд зориулан1998- 2002 онд ЯБС – аас 17 сая төгрөгний зээлийг олгож ажлын байртай болгох, амжиргааг нь дээшлүүлэх чиглэлээр зээл олгож байсан байна.

Нэн ядуу өрхийн бүртгэлд хамрагдсан нэн ядуу тахир дутуу иргэнтэй өрх , нэн ядуу ахмад настантай өрхүүд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдаж иржээ. Өлгий сумын хэмжээнд нийт ядуу өрхийн 636 эх хүүхэд асарсаны тэтгэмжээ халамжийн сангаас авч байгаа ба жилд өлгодог түлээ нүүрсний хөнгөлөлтөнд нэн ядуу өрхийн 20% хамруулж иржээ.

Сумын нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдалтай холбогдсон асуулгын хуудсанд 100 өрхийг хамруулж саналыг авав.

Судалгаанаас үзэхэд төр засгаас болон олон нийтийн байгууллагуудаас хүртэж байгаа тусламж нь тухайн үеийн түр зуурын арга хэмжээ болж байгаа нь Ядуурлын хэмжээ нь буурахгүй, харин жилээс жилд нэмэгдэж. байгаа нь харагдлаа.

Иймд:

Тодорхой мэрэгжил эзэмшсэн мал хөрөнгөгүй залуучуудыг ажлын байраар хангах.

Банк санхүүгийн байгууллагаас удаан жилийн бага хүүтэй зээл олгох.

ОУ- ын төсөлд ядуучуудыг өргөнөөр хамааруулах.

Бүтээлч байгууллагын ажилд хүмүүсийг өргөнөөр хамааруулах.

Хөдөө аж ахуйн чиглэлээр малжуулах төслийг хэрэгжүүлэх .

Ядуурлыг багасгах талаар компанит ажлуудыг олнолор зохион байгуулах.

түүнд эмзэг бүлгийн хүмүүсийг өргөнөөр хамруулах шаардлагатай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Баян-Өлгий аймгийн Өлгий сумын**
**нэн ядуу хүн амын судалгаа**

**1998-2002 он**

| № | онууд | өрхийн тоо | Хүн амын тоо | өрхийн дундаж орлого | Огт орлогогүй | Насны бүтэц | | | Боловсролын байдал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 0-16 | Хөдөлмөрийн насны | Тэтгэврийн насны | Огт боловсролгүй | бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Тусгай дунд | дээ |
| 1 | **1998** | 1421 | 5786 | 12,0 | 1042 | 2651 | 2481 | 654 | 1732 | 727 | 2018 | 952 | 253 | 104 |
| 2 | **1999** | 1487 | 5936 | 12,0 | 968 | 2639 | 2453 | 794 | 1811 | 804 | 1980 | 962 | 264 | 115 |
| 3 | **2000** | 1612 | 6657 | 18,8 | 1094 | 3280 | 2597 | 780 | 1730 | 949 | 2266 | 1271 | 296 | 145 |
| 4 | **2001** | 996 | 9862 | 18,8 | 1430 | 5406 | 3760 | 696 | 2820 | 778 | 3695 | 1904 | 469 | 196 |
| 5 | **2002** | 1552 | 10138 | 22,6 | 1622 | 5759 | 3663 | 716 | 2744 | 761 | 3808 | 2121 | 526 | 178 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Нийт төсвийн хувиарлалт

(нийт төсөвт харцуулбал)

| Тэтгэмжийн төрөл | 1998 | | 1999 | | 2000 | | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл |
| *Нэн ядуучуудад зориулан төсвөөс хувиарласан зардал* | *335000,0* | *114295,9* | *423633,0* | *180395,3* | *528749,2* | *204461,7* | *713997,2* | *172503,4* | *941721,6* | *343807,4* |

## Тэтгэмжийн төсвийн хувиарлалт

| Тэтгэмжийн төрөл | 1998 | | 1999 | | 2000 | | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл | Баталсан төсөв | Гүйцэтгэл |
| *Нэн ядуучуудад зориулан төсвөөс хувиарласан зардал* | *98000,0* | *114295,9* | *164000,0* | *180395,3* | *195000,0* | *204461,7* | *160000,0* | *172503,4* | *320000,0* | *343807,4* |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## НЭН ЯДУУ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР АВАЛТ

| Тэтгэврийн төрөл | 1998 | | 1999 | | 2000 | | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| *Бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангүй эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, тахир дутуу бөгөөд дэмжлэг туслалцаа үзүүлэх болоцоогүй нь тогтоогдсон нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй* | 397 | 29892,7 | 182 | 21654,1 | 101 | 16010,0 | 122 | 13580,0 | 128 | 15670,0 |
| *Нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 нас хүрсэн эх /50 хүрсэн эцэг/* | 0 | 0,0 | 3 | 130,0 | 2 | 240,0 | 3 | 360,0 | 4 | 454,0 |
| Дүн | | 29892,7 | 185 | 21784,1 | 103 | 16250,0 | 125 | 13940,0 | 132 | 16124,0 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## НЭН ЯДУУ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖИНД ХАМРАГДАЖ БАЙГААС СУДАЛГАА

| Тэтгэмжийн төрөл | 1998 | | 1999 | | 2000 | | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| Хүүхэд асарсаны тэтгэмж | *1200* | *38262,5* | *1595* | *106962,8* | *1264* | *148983,9* | *1442* | *105200,0* | *3214* | *257572,6* |
| Нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж | *56* | *820,8* | *101* | *1212,0* | *38* | *456,0* | | | *40* | *990,0* |
| Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмж | | | *7* | *324,0* | *9* | *722,0* | *12* | *1044,0* | *13* | *2574,0* |
| Нэн ядуу ахмад настаны хөнгөлөлт | *630* | *28981,3* | *963* | *31015,8* | *734* | *22044,5* | *936* | *33108,9* | *1260* | *41033,3* |
| Нэн ядуу тахир дутуу иргэдийн хөнгөлөлт | *309* | *10250,4* | *432* | *15081,4* | *297* | *12984,5* | *304* | *12767,3* | *525* | *22998,5* |
| Нийгмийн халамж асрамжийн үйлчилгээ | *867* | *3044,1* | *353* | *2007,6* | *101* | *1510,4* | *283* | *3221,6* | *183* | *1307,5* |
| Дүн | *3062* | *81359,1* | *3451* | *156603,6* | *2443* | *186701,3* | *2977* | *155341,8* | *5235* | *326475,9* |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## НИЙГМИЙН ХАЛАМЖ БОЛОН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

| д/д | Халамж, асрамж үйлчилгээний төрөл | 1998 | | 1999 | | 2000 | | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | Нэн ядуу амьдралтай хүнд үзүүлэх халамжийн үйлчилгээ | *867* | *3044,1* | *346* | *1933,9* | *101* | *1510,4* | *165* | *2599,5* | *180* | *1287,5* |
| 2 | Амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлогтой бөгөөд олон хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-д үзүүлэх халамжийн үйлчилгээ | | | *7* | *73,7* | | | *22* | *254,5* | | |
| 3 | Ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ | | | | | | | *96* | *367,6* | | |
| 4 | Нийгмийн халамжийн гэрийн үйлчилгээ | | | | | | | | | *3* | *20,0* |
| | Дүн | *867* | *3044,1* | *353* | *2007,6* | *101* | *1510,4* | *283* | *3221,6* | *183* | *1307,5* |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3.2.2. Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо

| Д/д | Сумдын нэр | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Алтай | 288 | 462 | 378 | 460 | 439 |
| 2 | Алтан цөгц | 616 | 393 | 395 | 429 | |
| 3 | Баяннуур | 541 | 903 | 565 | 330 | |
| 4 | Бугат | 557 | 805 | 364 | 541 | |
| 5 | Булган | 604 | 991 | 549 | 823 | |
| 6 | Буянт | 509 | 515 | 88 | 212 | |
| 7 | Дэлүүн | 460 | 631 | 2157 | 1786 | |
| 8 | Ногооннуур | 1108 | 1923 | 667 | 1419 | |
| 9 | Сагсай | 468 | 1543 | 753 | 968 | |
| 10 | Толбо | 387 | 520 | 516 | 818 | |
| 11 | Улаанхус | 610 | 999 | 2497 | 2801 | |
| 12 | Цэнгэл | 937 | 1961 | 862 | 1943 | |
| 13 | Өлгий | 6663 | 6970 | 7287 | 4681 | |
| 14 | Цагааннуур | 700 | 1115 | 843 | 815 | |
| | Дүн | 14448 | 19731 | 17921 | 18026 | |

Тайлбар:

2002 оны мэдээ гүйцэт гараагүй ба нэн ядуу хүн амын судалгааг сүүлийн 2 жилийн байдлаар статистикийн төвлөрсөн мэдээгээр гаргахаа больсон байна. Иймээс хүн амын тоогоор гаргахад хүндрэлтэй байсан ба статистикийн тоо болон нийгмийн халамж, багийн засаг дарга нараас авсан тоонууд хоорондоо зөрөөтэй байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Нэн ядуу иргэдийн эрхийи төлөв байдал,**
**нийгмийн хамгааллыг судалсан тайлан**

**2003.03.10** **Баянхонгор**

Баянхонгор аймаг дахь Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгааллын байдлын судалгааг 2003 оны 2-р сарын 12- ноос 3-р сарын 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ. Судалгаанд Баянцагаан, Бууцагаан, Жаргалант, Галуут, Баянхонгор сумдын 23 багийн 104 өрхийг хамруулсан. Баянцагаан, Бууцагаан сумд нь Баянхонгор аймгийн говийн Жаргалант, Галуут сумд нь хангайн бүсийн сумд бөгөөд Баянцагаан (250 км), Бууцагаан (180 км), Жаргалант (170 км), Галуут (90 км) нь хамгийн олон хүн амтай, тийм ч учраас хамгийн олон нэн ядуу иргэдтэй сумд юм. Судалгаанд аль болох олон төлөөлөл оруулах үүднээс сумын төвийн болон нийгмийн эмзэг бүлгийн өрх олонтой багуудаас тухайн бүлгийн 5 хувь байхаар тооцож иргэдээс судалгаа авав. Үүнд : Галуут сумын 12 (нэн ядуу өрх 240), Жаргалант сумын 10 (нэн ядуу өрх 193), Баянцагаан сумын 8 (нэн ядуу өрх163), Бууцагаан сумын 24 (нэн ядуу өрх 471), Баянхонгор сумын 50 (нэн ядуу өрх1758) өрхийг хамруулсан болно.

**Орон нутагт нэн ядуу иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр баримталж байгаа бодлого хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар :**

- Нэн ядуу иргэдийн талаар авч хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагаа, өртөг

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт нэн ядуу иргэдтэй холбоотой 13 төрлийн заалт, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 7 заалт тусган хэрэгжүүлж байна.

- Нэн ядуу бүлгийн иргэдэд зориулсан төсөв болон холбогдох бусад зардлын бүтэц (улсын болон орон нутгийн, шашны, олон улсын, сангийн)

Баянхонгор аймгийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан нийтлэг гэрээнд 2003 онд :

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан ажил хайгчдыг (600 хүн) сул чөлөөтэй ажлын байранд Хөдөлмөр эрхлэлтийн албадаар дамжуулан зуучилж ажилд оруулахад 4568.0
- Дэд бүтэц, байгаль хамгаалал, экологийн чиглэлээр нийтийг хамарсан ажил зохион байгуулж ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг (310 хүн) ажлын түр байраар хангахад 8000.0
- Хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэд, аж ахуйн нэгжид (180 хүн) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан жижиг зээл олгож ажлын байр бий болгоход 15000.0
- Ажил олгогчдыг (40) дэмжихэд 3828.0
- Мэргэжил олгох болон давтан сургалтанд (250 хүн) хамруулахад 10815.0
- Орон нутгийн төсвийн орлогын 0.3-с доошгүй хувийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулах

UIH MN СУДАЛГААНЫ САН

- Тэтгэврийн нөхөн олговрыг цаг хугацаанд нь олгоход 142272.0
- Орон нутгийн Хөдөлмөр эрхлэлтийн албадын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 6081.7 мянган төгрөг тусгажээ.

Японы **Санкей** сонин 2000 оны 8-р сард Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал сумдын 141 өрхийг малжуулахаар 100.0 сая төгрөг, 9525 мал зээлээр олгосон нь одоо 9954 толгой болж 3568 төл бойжиж байна. Энэ зээл нь жилийн 6 хувийн хүүтэй 2003 оны 8 сараас эхлэн төлөгдөж, эх үүсвэрийг эргүүлэн авахаар гэрээ хийжээ.

Дэлхийн зөн байгууллагаас 2002 онд Баянхонгор аймагт нийт 4000 гаруй хүнд 200.0 сая гаруй төгрөгийг хүнсний тусламж, хувцас, өрхийн сургалтанд зориулан зарцуулсан байна.

Аймгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээс хийгдсэн Малын буян төслийн зээлийн эргэн төлөлт сүүлийн 2 жилд ган, зуд болж МАА-д гарсан хохирлын улмаас эргэн төлөгдөөгүй болно.

- Нэн ядуу иргэдийн талаар орон нутгийн ИТХ, Засаг даргаас гаргасан тогтоол, захирамж
  1. **Өрхийн амьжиргааны чадавх дэмжих** хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн дэргэд аймгийн Засаг даргын 2002 оны 150-р захирамжаар **Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийн удирдлага**, **Орон нутгийн санаачилгын сан** гэсэн мэргэжлийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
  2. **Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн тогтвортой амьжиргааг дээшлүүлье** аймгийн зөвлөгөөн хийж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим арга хэмжээний тухай** аймгийн Засаг даргын 2002 оны 126, 159-р захирамж гарган, ажилгүй иргэдийн төсөл, санаачилгыг дэмжих хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, мэргэжил олгох, давтан сургах, мэргэжлийн чиг баримжаа олгох, хоршоо нөхөрлөлийн хэлбэрээр хамтарч ажиллах өрх, иргэдийн хөдөлмөрийн харилцааг зохицуулах зэрэг асуудалд анхаарал хандуулж ажиллажээ.

- Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо оноор (1998-2002)

Аймгийн нийт өрхийн 45.3 хувьтай тэнцэх буюу 39265 ам бүл бүхий 9667 өрх Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой байгаагийн дотор 5653 өрх нэн ядуу түвшинд амьдарч байна.

| | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Нэн ядуу өрх (мян) | 3.1 | 2.5 | 3.4 | 3.7 | 5.6 |

- Нэн ядуучуудад зориулан төсвөөс хуваарилсан зардлын хэмжээ, төсөвт эзлэх хувийн жин (1998-2002)

Нийгмийн даатгал, халамжийн зардлаас өөр нэн ядуу иргэдэд зориулан орон нутгийн төсөвт хөрөнгө суудаггүй бөгөөд 2002 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд 4.2 сая төгрөг төсөвлөснөөс 1.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвлөрсөн сангаас ажил олгогчийг дэмжих, жижиг зээл олгох, мэргэжил олгох, давтан сургах, нийтийг хамарсан

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ажил зохион байгуулах зориулалт бүхий хуваарилагдсан 52.5 сая төгрөгөөс ирсэн 41.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Орон нутгийн төсвийн зарлага**

| | 1998 | | 1999 | | 2000 | | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сая төг | % | сая төг | % | сая төг | % | сая төг | % | сая төг | % |
| Нийтийн ерөнхий үйлчилгээ | 613.1 | 17.5 | 489.4 | 15.2 | 624.3 | 13.7 | 736.7 | 14.0 | 803.1 | 15.5 |
| Нийгмийн хэв журам | 165.6 | 4.7 | 164.2 | 5.1 | 257.0 | 5.6 | 275.5 | 5.2 | 284.5 | 5.5 |
| Боловсрол | 1448.1 | 41.5 | 1515.7 | 47.0 | 1922.1 | 42.2 | 2428.1 | 46.3 | 2182.2 | 42.1 |
| Эрүүл мэнд | 1012.7 | 29.0 | 863.6 | 26.8 | 1403.4 | 30.8 | 1298.2 | 24.7 | 1390.8 | 26.8 |
| **Нийгмийн даатгал, халамж** | **0.0** | **0.0** | **1.6** | **0.0** | **31.2** | **0.7** | **47.5** | **0.9** | **40.6** | **0.8** |
| Хот тохижуулах | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Амралт, соёл, спорт | 160.6 | 4.6 | 130.9 | 4.1 | 201.5 | 4.4 | 216.9 | 4.1 | 247.3 | 4.8 |
| ХАА, ой агнуур | 31.4 | 0.9 | 17.1 | 0.5 | 37.7 | 0.8 | 36.4 | 0.7 | 38.5 | 0.7 |
| Эдийн засгийн бусад | 62.0 | 1.8 | 43.0 | 1.3 | 81.6 | 1.8 | 139.7 | 2.7 | 155.9 | 3.0 |
| Ангилагдаагүй зардал | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 68.9 | 1.3 | 44.5 | 0.9 |
| | 3493.5 | 100 | 3225.5 | 100 | 4558.8 | 100 | 5247.9 | 100 | 5187.4 | 100 |

- Нэн ядуучуудад зориулсан хөтөлбөр, зохион байгуулсан үйл ажиллагаа, (ажлын байртай болгох, орон байртай болгох, малжуулах, бусад) (1998-2002)

Аймгийн өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих сангаас 1994-2002 оны хооронд 1800 төсөл хэрэгжүүлж, 260 ажлын байр шинээр бий болж, 405 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Үүнээс сүүлийн 2 жилд 195 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсний 120 сая төгрөгийг малжуулах төсөлд зарцуулжээ. Тус сангаас олгосон 195 сая төгрөг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр ашиглагдаж байна.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албаар дамжуулан 2002 оны 10-р сарын байдлаар 231 иргэн ажлын байранд зуучлагдан, 2913 ажлын байр шинээр бий боллоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор сургалтын **Шинэ эхлэл** хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор, Бууцагаан, Хүрээмарал, Бөмбөгөр, Баянлиг, Баянговь,Богд сумдын захиалгаар 474 хүнд хүнсний ногоо тарих, бизнес эрхлэх сургалт, Энх тайвны корпус, МСҮТөв, Хөдөлмөр эрхлэлтийн алба хамтран 155 хүнд гахай, тахиа маллах арга зүй, хүнсний ногоо тариалах, аж ахуй эрхлэх сургалтыг зохион байгуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хас банкаар дамжуулан 2 жижиг зээлд 2.0 сая төгрөг олгосноор 8 хүн ажлын байртай болсон.

- Аймгийн нийгмийн халамжийн байгууллага нэн ядуу иргэний халамжийн үйлчилгээний зардалд ямар хэмжээний зардал төсөвлөсөн, батлагдсан төсөв, зарцуулалтын байдал (1998-2002)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Аймгийн нийгмийн халамжийн байгууллага нэн ядуу иргэний халамжийн үйлчилгээнд зарцуулсан төсөв (мянган төгрөг)**

| 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|
| 313.5 | 654.4 | 1728.1 | 763.4 | 4678.5 |

Нэн ядуу иргэдийг халамжийн 6 төрлийн тэтгэвэр, 8 төрлийн тэтгэмж, 5 төрлийн хөнгөлөлт үйлчилгээнд хамруулж байна.

2002 онд халамжийн төвлөрсөн сангаас халамжийн тэтгэвэр 1740 хүнд 219.3 сая, жирэмсэн болон амаржсан 2233 эхэд 212.9 сая, хүүхэд асарсны тэтгэмж 2400 хүнд 216.0 сая, олон хүүхэдтэй 913 хүнд 47.3 сая, нярайн арчилгаанд 120 хүнд 3.0 сая, 11 ихэр хүүхдэд 0.4 сая, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсөн 16 хүнд 3.2 сая төгрөгийн тэтгэмж, бүгд 7433 хүний тэтгэвэр, тэтгэмжинд 702.3 сая төгрөг олгожээ.

Өмнөх онуудад халамж, үйлчилгээний сангаас өндөр настны тэтгэвэр, жирэмсний, амаржсаны, олон хүүхэдтэйн, бүтэн өнчин хүүхдийн, ихэр, нярайн арчилгаа, хүүхэд асаргааны тэтгэмж, ахмад настан, тахир дутуу хүмүүст түлшний хөнгөлөлт үзүүлдэг байсан бол 2002 оны 10 сарын байдлаар халамж үйлчилгээг 13 төрлөөр нэмэгдүүлсэн. Үүнд : олон хүүхэдтэй өрх толгойлсон 40 эхийг эх үрсийн, АБТД орлоготой 195 ахмадыг сар шинийн баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулан, нэн ядуу амьдралтай өрхийн 190 хүүхдийг 1 удаа хооллож, хэвтэрт байгаа 10 ахмад настан, 16 тахир дутуу иргэдэд түлш, 20 хүнд тэргэнцэр, 327 хүнд сонсголын аппарат, 280 хүнд таяг, малгүй болсон нярай хүүхэдтэй 35 эхэд нярайн арчилгааны тэтгэмж, Богд сумын хөгжлийн бэрхшээлтэй болон нэн ядуу өрхийн 35 хүүхдэд буцалтгүй тусламж, хэлгүй дүлий 1, хараагүй 1 хүүхдийг Улаанбаатар хотын 29-р тусгай сургуульд хүргэж өгөх зардал, 3 хүнд хөлний протез, 1 хүнд нүдний болор суулгасны төлбөр, 2 хүнд иж бүрэн гэр олгон, нийт 10.5 сая төгрөг зарцуулсан байна.

Дүгнэлт

Олон жил үргэлжилсэн зудны улмаас өрхүүдийн хүнсний нөөц хомсдож, тоо төрөл нь улам хязгаарлагдмал болж тэжээлийн доройтол архаг хэлбэртэй болжээ. Хүн амын эмзэг бүлэг хоол тэжээлийн дутагдалд байж, эх, хүүхдийн дунд хоол тэжээлтэй холбоотой өвчлөл нилээд байна. Дундаж орлоготой өрхийн 1 гишүүн 2651.18 ккал, доогуур орлоготой өрхийн 1 гишүүн 1587.42 ккал илчлэг бүхий хоол хүнс хэрэглэж байгаа ба АБТД орлоготой өрхийн 1 гишүүн хоногийн хэрэгцээт илчлэгийнхээ дөнгөж 58.1-68.5 хувийг авч байна. Сумдад **Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл**, **Эмэгтэйчүүд** зэрэг болон эрүүл мэндийн дэд хөтөлбөрүүдийг ИТХ-ын хуралдаанаар батлуулах боловч төсвийн хүрэлцээгүйгээс хөрөнгийн асуудал шийдэгддэггүй тул хэрэгжихгүй зөвхөн цаасан дээр үлдэж байна. Баянцагаан сумын нийгмийн хөгжлийн бодлогын ажилтан Х. Одончимэг нэн ядуу өрхийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгөний хөнгөлөлтийг нийгмийн халамжийн сангаас олгож байгаад хуулинд заалт байхгүйн улмаас 2002 оноос эхлэн зогсоосон гэв. Сумдын удирдлагууд хоолгүй хоножк буй өрхүүд олон байгаа талаар ярьцгааж байлаа.

Нэн ядуу иргэдээс авсан асуулгад оролцогсдын өрхийн гишүүдийн 21 хувь буюу 22 хүн ажил эрхэлдэг, 50.9 хувь нь группын мөнгө, тэтгэвэр, тэтгэмж, цалин зэрэг орлоготой байв. Үлдсэн хэсэг нь алт ухах, хог ачих, дээл оёх, аргал түүх, түүхий эд зарж борлуулах, айлын гэр цэвэрлэх зэрэг тогтмол бус орлоготой байна. Дээл оёх зэрэг нь улирлын чанартай орлого байдаг бол алтыг жилийн ямар ч улиралд ухаж байна. Өвөл газар хөлдүү тул нурах аюул бага юм. Судалгаа хийж явахад Баянцагаан сумаас 30 гаруй хүн Зил 130 машинаар алтанд явж байлаа.

Эдгээр өрхүүдийн сургууль завсардсан 32 хүүхдийн 14 нь буюу 43.7 хувь нь ядуу амьдралын улмаас сургуулиа орхисон бол мал маллах зорилгоор мөн тооны хүүхэд сургууль завсардсан байна. Эдгээр мал дээр гарсан хүүхдүүдийн өрх малаа зуданд алдсан тул өнөөдөр сурах сургуульгүй, маллах малгүй болжээ.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн дундаж зарлага сард 15.0 – 40.0 мянган төгрөг бөгөөд хуурай хэрэглэл (гурил, будаа), лаа чүдэнз, цай давс, саван угаалгын нунтаг зэрэгт ихэвчлэн зарцуулдаг байна. Хөдөөгийн өрхүүдийн хувьд өдөрт нь явж хоногийн түлэх аргалаа түүж, цас мөсний усаа базаан ус түлшинд зарлага гаргахгүй амьдарч байхад аймгийн төвийн айлуудын хувьд ус, түлшний асуудал бэрхшээлтэй байдаг.

Говийн сумдын өрхүүдийн хувьд ямааны ноолуур үнэтэй, мал ихтэй байхад боломжийн амьжиргаатай байсан хүмүүс сүүлийн 2 жилийн зуданд амьжиргааны эх үүсвэрээсээ салаад сэтгэл зүйн дарамтанд орсон нь ажиглагдаж байлаа.

Хөдөлмөрийн чадваргүй нийгмийн халамжийн ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмжинд хамрагддаг байнгын орлоготой хүмүүсээс хөдөлмөрийн насныхны байдал илүү хүнд байна. Хөдөө орон нутагт ажлын байр хомс тул тэтгэвэрт гарах насанд хүрээгүй, нөхөн олговор авах шалгуурт тохирохгүй иргэд болон хувьчлалаар авсан малаа дуусан залуучуудыг ажилтай болгох талаар маш их зүйл хийх шаардлагатай байна. Аливаа төрлийн мэдээллийг бага авдаг, барьцаалах хөрөнгөгүй зэргээс шалтгаалан эдгээр хүмүүст зээл олддоггүй аж.

Төрийн байгууллага албан тушаалтанд 64 хүн буюу 61.5 хувь нь зээл, тусламж, ажилд оруулж өгөхийг хүсэх, ХЭАА байгуулахад туслах, хүүхдээ сургуульд явуулах, хүний эрхийн зөрчлийн талаар гомдол гаргах зэрэг ямар нэгэн асуудлаар хандаж байсан ба 12.5 хувь буюу 13 хүний хүсэлтийг биелүүлж, 27.8 хувь буюу 29 хүнд зохистой хандаж хүлээж авсан гэж хариулав.

Бууцагаан сумын цагдаа Амаржаргал иргэдээс орох хориотой тэмдгийн заалт зөрчсөн иргэдээс 5.0 мянган төгрөг хураадаг, мөнгөгүй бол машин мотоциклийн аккумляторыг хураах буюу өөрөө унадаг, согтуу хүнийг шонгийн модонд хүлдэг, халаалтын радиотороос гавладаг талаар иргэд гомдол мэдүүлэв.

Судалгаанд хамрагдагсдын 89.4 хувь нь 1996 оноос өмнө буюу зах зээлийн шилжилтийн үе эхэлсэнтэй холбоотойгоор болон сүүлийн 3 жил зуд болсноос үүдэн нэн ядуу ангилалд орох болсон байлаа.

Мөн аймаг, сумдад хэрэгжиж байгаа тусламжийн хөтөлбөр төслүүд эзнээ олдоггүй, олон хүн хамруулах үүднээс тэгшитгэн хуваарилдаг, гишүүнчлэлээр ялгаварладаг (Улаан загалмай), талаар иргэд ярьж байв.

Баянхонгор аймгийн 20 суманд ЯБСангийн жижиг зээлийн эргэлтийн санд 75.0 сая төгрөгийн зээлийн хөрөнгө эргэлтэнд орж, эргэн төлөлт

UILMN СУДАЛГААНЫ САН

Баацагаан, Галуут сумдад 95.0-100.0, Гурванбулаг, Хүрээмарал, Баянлиг, Баянговь, Баянхонгор сумдад 61.9-66.7 хувьтай байхад Заг 12.5, Шинэжинст 5.9 хувьтай хамгийн доогуур байв. Аймгийн дүнгээр зээлийн эргэн төлөлт 51.6 хувьтай байна. Аймгийн зөвлөлөөс 358 төсөлд мониторинг үнэлгээ хийхэд 41.8 хувь буюу 150 төсөл идэвхтэй үйл ажиллагаа явуулж, 12.5 хувь буюу 14 төслийн үйл ажиллагаа бүрмөсөн зогссон байна. Эндээс зээл олгохдоо зээлдэгчийн хариуцлага хүлээх чадвар, бизнесийн үйл ажиллагааны төлөвлөлт, зээлээ эргэн төлөх чадварыг харгалзан үзэлгүй танил талдаа өгөх зэргээр хариуцлагагүй ханддагтай холбоотой гэсэн дүгнэлт хийж болно.

Галуут сумын захиргаанаас 150 кг гурил, 5 кг ургамлын тос, хувцас хунарыг отор нүүдэл хийж яваа айлуудад өгнө гэсэн атлаа сумын төвийн айлуудад (тухайлбал, Гаваабалжир, Лханаажав) олгосон, малжуулах төсөлд төсвийн байгууллагад ажилладаг хүмүүс (багш, ИТХ-ын ажилтан) хамрагдсан, Архангайн Тамир сумын захиргаатай Галуут сумын удирдлагын зүгээс гэрээ, хэлцэл хийгээгүй тул отор хийж явсан өрхүүд төлбөр (хашааны болон түлэх модны гоожин) төлсөн зэрэг баримтуудыг ярив.

Бууцагаан сумд Дэлхийн зөнгийн төлөөлөгч нар ажиллаж төсөлд хамрагдагсадтай уулзахдаа шинэ хувцас олгохоор мэдэгдсэн боловч сумын удирдлагууд комиссын хуучин хувцас олгосон байна. Мөн Дэлхийн зөнгөөс төсөлд хамруулахдаа иргэд ямар нэгэн байдлаар ажил (субботник) хийж байж, хүнсний тусламж авах ёстой, хэрвээ ажил хийгээгүй бол тусламжийн зүйлсээ олгохгүй гэсэн бодлого барьсан юм байна.

Нэн ядуу иргэдэд амьдралын бололцоогүйгээс сургууль завсардах, эд зүйлсээр (хувцас, хичээлийн хэрэгсэл) гачигдах, өлсөх, ялгаварлагдах, өвдөх, амьдралд гутрах, гуйлга гуйх зэрэг бэрхшээл учирдаг.

Асуулганд хамрагдагсдын 74 хувь буюу 77 хүн өөрт тохиолдсон бэрхшээлийг арилгахын тулд сум, аймгийн удирдлагад хандана гэж хариулжээ. Нэн ядуу байдлаас гаргахын тулд төрийн зүгээс :

- залуучууд, хүүхдүүдэд боловсрол олгох
- ажлын байр бий болгож ажлаар хангах
- хувиараа аж ахуй эрхлэх боломж бүрдүүлэх, урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох, барьцаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх
- тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх
- малжуулах, хүнсний ногоо тарих төсөлд хамруулах зэргээр дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэсэн саналуудыг тавьсан юм.

Судалгаа гаргасан ХЭҮК-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч,
Хүний эрхийн мэргэжилтэн.......................... Ж. Ариунаа

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# БУЛГАН АЙМГИЙН НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2003-03-14 Булган

Аймгийн хүний эрхийн мэргэжилтэн Д. Баяраа, ЗДТГ-ын НХБХ-ийн түшмэл С. Цагаан, НХҮТ-ийн дарга Г. Ганбаатар нарын бүрэлдхүүнтэй судалгааны баг 2003 оны 2-р сарын 07-оос 3-р сарын 15 хүртэл ХҮЭК-ын удирдамжийн дагуу нэн ядуу иргэдийн эдийн засаг, нийгэм соёлын болон улс төр, иргэний эрхийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор түүвэр судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, нийгмийн үйлчилгээний газрууд, иргэдийн хүрээнд хийж, нийт 5 сум, 250 орчим хүнийг хамрууллаа. Судалгааны хүрээнд холбогдох байгууллагуудын мэдээ тайлан баримт бичгийг судлах, нэн ядуу иргэдээс анкетын судалгаа авах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх аргуудыг хэрэглэлээ.

Холбогдох байгууллагуудын тайлан илтгэл, мэдээ судалгаанаас үзэхэд 1995 оны ядуурлын үзлэгээр аймгийн хүн амын 9,3% нь ядуу \ ядуу+нэн ядуу гэсэн ойлголтоор \, байсан бол 1997 онд 35,5%, 2001 онд 51,4% болсон байна. Үүнээс 25,8%-ядуу, 25,6% нь нэн ядуу байна. Аймгийн статистикийн газраас авдаг мэдээ улсын ядуурлын үзлэгийн дүнтэй зөрдөг тул 2001 оноос сумдаас мэдээ авахаа больсон байна. Иймд 2001 оны ядуурлын үзлэгийн дүн нь аймгийн барьж байгаа албан ёсны тоо бөгөөд аймгуудаас ядуурлын түвшингээрээ эхний 3-т орж ядуурал аймгийн тулгамдсан асуудал болж байна.

Аймгийн хэмжээгээр нэн ядуу 2237 өрхийн 15486 хүн байгаа бөгөөд үүнээс ганц бие 122, 8-аас дээш ам бүлтэй 125 өрх амьдарч байна. Огт малгүй 1613 өрх байна. Энэ жил мал их хорогдож энэ тоо улам нэмэгдэх хандлагатай байна. Огт сууцгүй 146, айлын гэр байр хөлсөлдөг 65 өрх улсын үзлэгээр бүртгэгджээ. Ажилгүй 4018, ял эдэлж байгаа 48, өндөр насны тэтгэвэрт байгаа 458, халамжийн тэтгэвэрт 137 нэн ядуу хамрагдаж байна. Ажилгүйчүүдээс 2891 нь ажил идэвхитэй хайж ХЗА-д бүртгэлтэй байна. Нэн ядуу оюуны хомсдолтой 74, хараагүй 11, хэлгүй дүлий 31, бусад эрхтний гажигтай 105 хүн байдаг байна. Хог түүж амьдардаг 13 хүн бүртгэгдсэн бөгөөд нэнэ тоо булган суманд сүүлийн үед өсч байна. Өнгөрсөн жилд давхардсан тоогоор 7000 орчим хүн ямар нэг зээл , буцалтгүй тусламжинд хамрагдсан бөгөөд 2018 хүн огт хамрагдаагүй байна. 2503 хүн ажилд орох, 2430хүн малтай болох, 1328 хүн ногоо тарих, 824 хүн зээл авах хүсэлтэй байдаг байна.

Аймгийн төр захиргааны байгууллагаас ядуурлыг бууруулахад дараах чиглэлийг баримтлан ажиллаж байна. Үүнд: Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зээл тусламжийн механизмыг бүрдүүлэх, мэргэжлийн ур чадвар

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

эзэмшүүлэх, ажлын чиг баримжаатай болгох, наад захын хэрэгцээг нь хангах халамж асрамжийн үйлчилгээг өргөтгөх. Аймгийн засаг даргын нөөцийн хөрөнгөнөөс сүүлийн 3 жилийн хугацаанд 15 сая төгрөгийг ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд зарцуулсан байна. Жил бүр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар ядуурлын байдлыг хэлэлцэж дүгнэлт өгч ажиллаж байна.

Нэн ядуу иргэд, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор аймгаас олон улсын байгууллага , төсөл хөтөлбөрүүдтэй хамтран олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал тус аймагт үйл ажиллагаагаа 1997 оноос эхэлсэн олон улсын Дэлхийн Зөн байгууллагын шугамаар Малжуулах, Булган- үр тариа, Булган ногоожуулалт, Булган- төмсний үр, Булган бог будаа, Нийтийн эзэмшлийн ой, Хүнд нөхцөл дэх хүүхэд Булган нутгийн хөгжлийн хөтөлбөр, Малчдад хүргэх яаралтай тусламж зэрэг 20-иод төсөлд 300 сая орчим төгрөгний , Герман, Австраль, Итали, Канадын элчин сайдын яамны тусламжаар малжуулах, эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг 10-аад төсөлд 30 сая, Дэлхийн банкны 360,9 сая төгрөгний хөрөнгөөр Ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлжээ. Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 2000-2003 онд Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн хүрээнд нэн ядуу айлын 3800 орчим хүүхдэд нийтдээ 159553,000 долларын эд зүйлсийн болон мөнгөн тусламж үзүүлж, тэдний эрхийг хангахыг тулд бүхий л арга хэмжээг авч байна.

Түүнчлэн Засгийн газрын үндэсний хөтөлбөрүүд хэрэгжүүлж энэ хүрээнд нэн ядуусыг тэтгэх, дэмжин туслах арга хэмжээнүүд авч байна. Цагаан хувьсгал, Ногоон хувьсгал Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах, Булган залуучууд , Ядуурлыг бууруулах, Ажилгүйдлийг бууруулах , Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах Ахмад насны аж байдлыг сайжруулах зэрэг 10-аад үндэсний хөтөлбөрт сүүлийн 5 жилийн хугацаанд 260 орчим сая төгрөгний хөрөнгө аймаг орон нутгаас зарцуулаад байна.

Хүн амын ядуурлыг бууруулах, ядуурлаас хамгаалах зорилгоор “Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх” аймгийн дэд хөтөлбөр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2001 оны 13 дугаар тогтоолоор хэрэгжиж хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, өрхийн амьдралын чадавхийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, олон улсын төсөл, орон нутгийн төсөв зэрэг санхүүгийн эх үүсвэрээр жижиг зээл олгож ажлын байртай болгох, малжуулах, орон байртай болгох, халамж дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч байна.

Ядуурлыг бууруулах сангаас нийтийг хамарсан ажилд 1416 хүнийг хамруулж 61,1 сая төгрөг, эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр 580 хүнийг хамруулж 55,1 сая төгрөг, эрүүл мэндийн чиглэлээр 43,5 сая төгрөг, боловсролын салбарт 109,7 сая төгрөг зарцуулжээ. Ядуурлыг бууруулах сангийн зээлийн эргэн төлөлтийн

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

сангаас 394 хүн буюу 197 өрхөд 38.2 сая төг-ний зээл олгож үйлдвэрлэл үйлчилгээ эрхлүүлсний дүнд 1208 хүн ашиг хүртлээ. Баягт-Агт, Баяннуур, Дашинчилэн, Могод, Рашаант, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-өндөр сумын 234 өрхийг малжуулах төсөлд хамруулаад байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд нийгмийн эмзэг бүлгийнхэнд зориулж 518,6 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгож, 983 ахмадад 58,9 сая төгрөгийн, тахир дутуу иргэдэд 10,8 сая төгрөгийн хөнгөлөлт үйлчилгээ үзүүлж, харж хандах хүнгүй ганц бие 9 ахмадыг асрамжийн үйлчилгээнд хамруулж, өөрийн гэр оронгүй 10 ахмадад гэр олгож, ахмадын өвөл зуны сувилалын газрыг нээн ажиллуулж 136 ахмадыг амраагаад байна.

Тус аймгийн хувьд Аймгийн төвөөс алслагдсан Тэшиг,Хутаг,Баян-Агт, Могод, Баяннуур,Рашаант ,Сэлэнгэ сумд орж байна.Аймгаас эдгээр сумдын түргэн тусламжийн машиныг бүрэн шинэчилж, зарим сум багийг /Могод, Баян-Агт/ богино долгионы холбооны хөдөлгөөнт станцтай болгов.

2002 онд жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 6 хүнд 10.0 сая төгрөгийн зээл олгож ажлын байртай болгож, орон нутгийн төсөв, Дэлхийн зөн олон улсын байгууллагын хөрөнгөөр 21 өрхийг орон байртай болгож 234 өрхийг малжуулжээ. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих сангаас 435 хүнд 40.4 сая төгрөгийн зээл олгож 1320 хүн ашиг хүртэж зээл эргэн төлөлт 78.6 хувьтай байна. Өөрийн орон гэргүй, хүнд нөхцөлд амьдарч байгаа 20 хүнийг иргэний үнэмлэхтэй болгосон байна.

Нэн ядуусыг хүнсний ногоо нөөшлөх, модон эдлэл зөөлөн оёдол хийх, , талхны цех,спиртийн үйлдвэрийн өргөтгөл зэрэг обьектуудад ажиллуулснаар нийтдээ 317 ажлын байнгын, 2324 түр байр шинээр бий болгов. Мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд 450 хүнийг хамруулаад байна. Тухайлбал **Х**ялганат тосгонд "Ой цэвэрлэгээ", Булган суманд "Тохилог орчин" , "Цэцэгжүүлэлт", "Орон сууц" зэрэг 9 төслөөр нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж 282 хүнийг хамруулж 11.3 сая төгрөгийг зарцууллаа. Хялганат тосгонд ажилгүй иргэдийн саналыг үндэслэн мэргэжлийн сургалтуудыг зохион байгууллаа.

Нийгмийн салбарт 471 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийснээр нэн ядуу иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж дээшиллээ. Нийгмийн хэрэглээг эрчим хүчээр үр ашигтай хангах /МОН-97-301/ төслөөс Хишиг-Өндөрийн эмнэлэгийн их засварт 20.0 сая төгрөг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас Хишиг-Өндөрийн эмнэлэгийн их засварт 10.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлэг болон Сайхан сумын эмнэлэгт оношлогооны компьютер суурилуулсан 3.0 сая, ЭМСХХ-ийн албанаас Хишиг-өндөрийн эмнэлэгт 9.7 сая төгрөгний тоног төхөөрөмж , Хутаг сумын эмнэлэгт ДЭМБ-аас 0.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Амрах байрны зардалд Дэлхийн зөн байгууллага 700.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хийсэн байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Нэн ядуу иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар Баян-Агт,Хутаг өндөр, Хишигөндөр зэрэг сумд сайн зохион байгуулж зохих хөрөнгийг төсөвтөө тусган зарцуулсан байна.

Амьдрал хүнд эхчүүдийн төлөө аймгаас онцгой анхаарч ажилласнаар эхийн нас баралт 2001.2002 онуудад гараагүй байна. Эмзэг бүлгийн өрх тэргүүлсэн эмэгтэйчүүдийг зээл тусламж, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулж ажлын байртай болгоход онцгойлон анхаарч байна. Ядуурлын үзлэгийн дүнгээр эмэгтэй тэргүүлэгчтэй 1355 өрх байгаагийн 228 нь бага орлоготой, 413 нь ядуу, 498 нь нэн ядуу өрх байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй байгаа ажилгүйчүүдийн 58.0 хувь нь эмэгтэйчүүд байгаад анхаарч мэргэжил олгох сургалтанд хамрагдагсдын 76 хувьд нь ажил мэргэжилгүй эмэгтэйчүүдийг хамруулж жижиг зээл олгож орлогын эх үүсвэртэй болгож байна.

Нийт хүн амын 8.8 хувь нь 55 ба 60 –аас дээш насны ахмадууд байдаг. 6242 ахмадаас 568 нь эмзэг бүлэгт хамрагдаж байна. Үүнээс 221 нь халамжийн тэтгэвэр авч байна. 30 ахмадыг хөнгөлөлт үйлчилгээнд хамруулж банйа. НХҮТ-ийн дэргэд "Ахмадын цогцолбор" -ыг ажиллуулж ахмадуудад эмнэлгийн уламжлалт эмчилгээ, хэвлэл мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах үйлчилгээ үзүүлж байна.

Нийгмийн даатгал, халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг цагт нь олгож , иргэд хүсвэл урьдчилж өгч хэвшлээ. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, асрамж үйлчилгээнд нийт 6193 хүнийг хамруулаад байна. Нэн ядуу иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, ажлын түр байр бий болгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулахад 3,28 сая төгрөг зарцуулжээ.

Эмзэг бүлгийн хөдөлмөрийн чадваргүй хүнд нөхцөлд амьдарч байгаа иргэдэд аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөнөөс дэмжлэг туслалцаа байнга үзүүлж , өөрийн орон гэргүй 4 хүнийг улсын асрамжинд явуулж, Булган суманд "ядуучуудын байр" хэмээн нэрлэгдсэн 25 айлын орон сууцыг нурааж, түүнд амьдарч байсан 21 өрхийг гэр хороололд хашаа байшинтай болгож, 6.9 сая төгрөг зарцуулжээ.

"Дэлхийн зөн" олон улсын Булган дахь салбар байгуулага, Италын Засгийн газрын бус байгууллага, хөдөөгийн ядуурлыг бууруулах сан" хөтөлбөр төсөлд хамрагдан 64 хүнд хөнгөлөлттэй зээл олгож, сумдын ядуурлыг бууруулах зээлийн эргэлтийн сангаас нэн ядуу иргэдэд зээл олгож эргэн төлөлт 74 % -тай байна.

Төр засаг, аймаг орон нутгаас арга хэмжээ авч байгаа хэдий ч нэн ядуу иргэдийн амьдрал ахуй байнгын дутагдал гачигдалтай байж, нийгмийн үйлчилгээг тэр бүр хүртэж чадахгүй байгаа нь энэ удаагийн тандалт судалгааны дүн, нэн ядуустай болон холбогдох бусад хүмүүстэй хийсэн уулзалт ярилцлагын тэмдэглэл, мөн өмнө нь авсан зарим нэг судалгааны дүн, илтгэл тайлангын материалаас харагдаж байна.

UILMN
СУДАЛГААНЫ САН

Судалгаанд оролцсон иргэдийн 42,5% нь 1990-1994 онд, 41,8% нь 1995-2000 онд, 15,7% нь 2000 оноос хойш ажиллаж байсан байгууллага нь татан буугдаж ажилгүй болсон, мэргэжилгүйгээс ажил олдохгүй байгаа зэрэг шалтгаанаар нэн ядуу ангилалд орсон гэж үзэж байна. Тухайлбал мал хувьчлахдаа буруу бодлого барьснаас Орхон, Сэлэнгийнхэн, Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Хялганатын том аж ахуйнууд болон Өлзийт тосгон татан буугдсанаас тэндэхийн оршин суугчид орлогогүй болсон. Өмнөх нийгмийн үед газар тариалан, жимсний аж ахуй дээр тулгуурлан хөгжиж байсан Хутаг Өндөр, Хишиг Өндөр, Баяннуур сум, модны аж ахуй эрхэлж байсан Хялганат тосгон, орос цэргийн анги байсан Өлзийт тосгонд нэн ядуу амьдралтай нийгмийн эмзэг давхраа бий болж аймгийн төр захиргааны байгууллагаас анхаарлаа хандуулан ажиллаж байна. 2002 онд бүртгэгдсэн байдлаар тус аймагт 109 өрх, 81том хүн, 175 хүүхэд шилжин ирээд байна. Шилжин ирсэн өрхийн 42,0 % нь ядуу байна. Шилжиж ирсэн ядуу иргэд бүртгэлийн бэрхшээл болон баримт бичгийн бүрдэлгүйгээс шалтгаалж нийгмийн халамж үйлчилгээнд бүрэн хамрагдахгүй байна.

Мөнгөгүйгээс шаардлагатай зарим баримт бичгээ, тухайлбал иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтрээ авч чадахгүйд хүрч нийгмийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна. Судалгаанд оролцогчдын 28 % нь иргэний үнэмлэхгүй, 68,4 % нь эрүүл мэндийн дэвтэргүй буюу хураамжаа төлөөгүй байна.. Ингэснээр эрүүл мэндийн тусламж авах эрхээ бүрэн эдлэж чадахгүйд хүрч байна.Нөгөөтэйгүүр нэн ядуу иргэд өвчин тусахаас аргагүй нөхцөлд амьдарч байдаг гэж сумдын эмч нартай хийсэн уулзалтанд ярьж байна. Дуудлагаар очиход хүн тогтохын аргагүй хүйтэн гэрт туйлын хүнд нөхцөлд амьдарч байдаг. Хоол хүнс гэхээр юм байхгүй, Олдож л байвал юу ч хамаагүй иддэг болж. Хүнсний аюулгүй байдал гэж ярихын ч илүүц болсон. Эм бичээд өгнө.. Ихэнхи нь авах мөнгөгүй. Гэрээр нь эмчлэх гэхээр нөхцөл муу. Эмнэлэгт хэвтүүлэх болохоор эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй эсвэл хураамжаа цагт нь төлөөгүй байдаг. Хөнгөллөлтэй эм бичихийг бодно л доо. Бас л дээрх шалтгаанаар яаж ч чаддаггүй. Аргалж чаргалаад заримыг нь ямар 1 аргаар эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ. Орны 10 %-аа олж авч чаддаггүй. Тэгээд ч эмчилгээний үр дүн гардаггүй. Учир нь гараад хоол хүнсгүй хүйтэн гэрт өвчин дахидаг. Нэн ядуучууд ихэнх нь боловсрол муутай байдаг. Зөвлөгөө өгнө, биелүүлнэ гэж байхгүй. Сургалтанд оролцуулах гэнэ. Ирэхгүй. Дэлхийн Зөн байгууллагаас авсан судалгаагаар халдварт шар, сүрьеэ зэрэг өвчний ямар хэлбэрүүдийг мэдэх вэ гэсэн асуултанд дийлэнхи олонхи нь мэдэхгүй гэсэн бөгөөд өвчилвөл хамгийн түрүүнд хэнд хандах вэ? гэхэд ихэнх нь лам бариачид хандана гэж хариулсан байна.

Эрүүл мэнддээ анхаарал тавьдаггүйгээс өвчнөө бүр тартагт нь тулгаж байж ирдэг. Тэгээд эмнэлгээс илүү их зардал гарах болдог. Хэцүү амьдралтайд нь эмийн

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

зээл өгдөг. Эргэж олж авч чадахгүйгээс багийн эмч эргэлтийн эмийн санд өртэй болдог. Дээд шатны эмнэлэгт явах шаардлагатай нь тэр бүр явж чадахгүй. Зардал мөнгөгүй байдаг. Үүнээс гадна эрүүл мэндийн даатгалын хуулиар иргэн хүн эмнэлгийн тусламжийг газар зүйн байрлалаас үл шалтгаалан эмнэлгийн яаралтай тусламж авах эрхтэй гэж заасан боловч энэ нь амьдрал дээр зөрчигддөг. Жишээ нь Хангал, Сэлэнгэ, Бугат, Орхон сум, Хялганат тосгоны иргэд Эрдэнэт хотод олгойн хүндрэл зэрэг яаралтай тусламжийг урьдын адил авч чадахгүй байна. Улаанбаатар болон бусад хотод хөдөө орон нутгийнхныг үзүүлэхэд заавал аймгийн нэгдсэн эмнэлгийн 36-р маягтыг шаарддаг нь иргэдэд, ялангуяа ядууст хүндрэл учруулсаар байна. Өрхийн ам бүлийн түүвэр судалгаанд хамрагдагсдын 1,8 % нь мөнгөгүйгээс, 0,8 % нь эмчилгээ сайн бусаас эмчид үзүүлээгүй байна. Нийт өвчилсөн хүмүүсийн 17,6 % нь түргэн тусламж дуудсан бөгөөд 10,0 орчим хувьд нь дуудлага ирээгүй байна.Судалгаанд хамрагдсан ядуу иргэдийн 68,4 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй бөгөөд энэ нь даатгуулах ойлголт мэдлэггүй, шимтгэл төлөх төлбөрийн чадваргүй, баримт бичиг бүрдүүлж чаддаггүй зэргээс шалтгаалж байна. Хөдөөгийн малчид эмнэлгээс хол тул тэр болгон эмнэлэгт очиж чаддаггүй. Хөрөнгө мөнгөнөөс шалтгаалж эмч нар хөдөөгийн малчдын сууриар явж чадахгүй байна. Сумын эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгсдийн 40-50 хувь нь нэн ядуу, өвчнөө хүндрүүлж ирсэн иргэд байдаг байна. Судалгаанд хамрагдагсдын 88,0 % нь байнга өвчилдөг байна. Эмчтэйгээ илэн далангүй ярьж, зовиураа илэрхийлж мэдэхгүй. Амьдралдаа гутарч сэтгэцийн өөрчлөлттэй болсон хүн цөөнгүй байдаг. Тусалж дэмжих ах дүү бараг байдаггүй. Хоол тэжээлийн дутагдлаас элэгний өвчин, амьдралын хэцүү байдлаас сэтгэцийн өвчин ихсэх хандлагтай банйа. Мөн осол гэмтэлд өртөгсдийн ихэнх нь хөдөлмөрийн аюулгүй байдалд ажилладаг нэн ядуучууд байна. Хоол хүнс залгуулахын тулд амь насанд аюултай ажил хийдэг гэж судалгаанд оролцогчдын 40,0 % нь үзсэн бөгөөд энэ нь Сэлэнгэ , Бугат суманд бусдаасаа өндөр үзүүлэлттэй байв.

Судалгаанд оролцогчдын 75,0% нь ямар нэг хөдөлмөр эрхэлдэггүй байна. Ажлын байр байхгүйгээс хөдөлмөр эрхэлдэггүй гэж 68,0% нь хариулсан байна. Нэн ядуус ямар ч орлогогүйгээс эсвэл орлого багатайгаас өдөр тутмын хоол хүнсээр байнга гачигдаж байна. Судалгаанд оролцогчдын өрхийн сарын орлого 10 хүртэл мянган төгрөгтэй 61,0 %, 10-20 мянгатай 7,6%, 20-30 мянга 3,3 % байна. Огт орлогогүй нэн ядуус 27,9% тай байна. Мөн орлогыг цаг хугацааны хувьд авч үзэхэд Дэлхийн Зөнгийн судалгаагаар тогтмол орлоготой 15,9%, тогтмол бус орлоготой 60,8%, огт орлогогүй 23,1% гарсан байна. 71,8% нь байнга өлсдөг, 61% нь хоолгүй хоносон өдөр олон тохиолдож байсан гэж судалгаанд хариулжээ . Мөнгө олохын тулд өөр газар нүүж амь насанд эрсдэлтэй алт ухах, мод чулуу бэлтгэх зэрэг ажил хийх, эд

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

зүйлс дутагдсанаас хэд 3 мал ахуйгаа, эд хогшлоо , хөдөлмөрийн багаж хэрэгслээ, байшин хашаа зэрэг үл хөдлөх хөрөнгөө зардаг гэж 36,0%- 60,0% нь үздэг байна. Нэн ядуучууд Заамарын алт руу маш их явдаг болсон. Олохоосоо илүү баахан архидаж ирдэг . Янз бүрийн сйахан сэтгэлтэй хүмүүс, байгууллагаас юм авсаар байгаад бэлэнчилдэг хүмүүс л болж хувираад байна. Бэлэн юм өгсөөр байгаад сүүлдээ өгсөн хувцас гутлыг маань голоод авдаггүй. Өөрсдийн арчаагүй байдлаас болоод ядуу явж байгаа. Мөнгө зээл авч амьдрал ахуйгаа авч яваа иргэд ч байна. Тэд танил талаасаа мөнгө хоол зээлддэг / 42,0%/ , банкнаас , ломбарднаас мөнгө зээлддэг / 36,0%/ байна. Мөн ямар 1 үнэгүй хоол хүнс хайх хэрэгцээ олон тохиолддог гэж Булган сумынхан хариулжээ. Нас барагсдын буяны ажлыг байнга эрэлхийлж явдаг, хог ухдаг хүмүүс олширсон гэж Булган сумын төр, төрийн бус байгууллагынхны уулзалзалтанд оролцогчид тэмдэглэж байв.

Эд зүйлс дутагдсанаас, эсвэл ажил хийхээр сургуулиас гардаг / 17,9%/, хоолны нь мөнгийг төлж чадахгүйгээс, хувцас муутайгаас сургуулийн өмнөх насныханыг цэцэрлэгт хамруулж чаддагүй / 44,0% / байна. Үүнээс гадна завсардсан шалтгааныг үе тэнгийнхэн дарамталдаг, Оюун ухаан хэвийн биш гэж Сэлэнгийнхэн их хариулсан байхад хувцас хичээлийн хэрэгсэл байхгүй, мал маллах хүнгүй гэж Орхон, Хишиг-Өндөрийнхэн их / 34,0% / хариулжээ

Төр засгийн анхаарал халамжийг хэр хүртэж байгаа байдлыг сонирхож үзэхэд бидний хийсэн судалгаагаар нэн ядуу иргэдийн 71,0% нь ямар 1 халамж хүртдэггүй гэж үзсэн бол 2001 оны хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлох Өрхийн судалгаагаар судалгаанд хамрагсадын 64,6% нь нийгмийн халамжийн тэтгэлэг тэтгэмж авч чаддаггүй бөгөөд 51,7% нь мэдлэггүйгээс, 31,0% нь хөөцөлдөж авч чаддаггүйгээс, 3,5% нь бичиг баримтаа бүрдүүлж чаддаггүйгээс, 5,7% хүнд сурталталтнаас, 1.6% нь төлөх мөнгөгүйгээс тус тус шалтгаалдаг байна. Эндээс харахад хувь хүний хууль эрхийн мэдлэг, төрийн ажилтнуудын үйл ажиллагаа тааруу байгаагаас хуулиуд бүрэн хэрэгжихгүй байна гэж үзэх үндэслэл байна. Нэн ядуу, эмзэг бүлгийн хөдөлмөрийн насныхан нийгмийн даатгал, нийгмийн халамжийн байгууллагын хооронд хаягдаж байна. Нийгмийн даатгалын сангаас төлж эхчүүдэд тэтгэлэг 9000 төгрөг өгч байгаагаас сүүлийн жилүүдэд эмзэг бүлгийн эхчүүд мөнгөний төлөө хүсээгүй хүүхэд төрүүлж , нийт төрж буй эхчүүдийн 46 хувь нь хүндрэлтэй төрж байна. Ирж байгаа тусламж, халамжийг ядуучуудад ээлжилж олгох, зөвхөн ямар нэг төслөөс сонгосон өрх буюу урьд нь олгож байсан хүмүүстээ дахин дахин өгдөг нь буруу, бэлэн юм өгөхийг зогсоое. Ямар нэгэн ажил хийлгээд дараа нь өгч байя, мөн сургалтанд хамруулж мэргэжилтэй болгох нь зүйтэй, барьцаалах хөрөнгөгүй учир зээл авч чадахгүй байна, Энэ өвлөөс хэд 3 малтай малчид хоосорч эхэлж байна. Ялангуяа тал бүрийн ашигтай үхэр их үхэж байгаа нь

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ядуучуудыг бүр сөхрүүлж байна. Өрөм ааруул сүүгээр зундаа болоод байдаг айл олон байсан. Одоо хөг нь өнгөрлөө. Удирдлага санхүүжилтийн хууль гарснаар төр төсвийн байгууллагад ажиллаж байсан ядуучуудыг нэн ядуу руу түлхлээ. Ядуурлын талаар авч байгаа судалгаануудаа эргэж харах буюу цөөлмөөр юм. Хүмүүс ядуу болохын бөөн сонирхол болж. Яахав, юм өгдөг болохоор. Багийн хуралтай гэж зарлахад хэд 3 хан ирдэг. Гэтэл тусламжийн юм өгөх гэнээ гэвэл сум тэр аяараа цугларна. Ийм л болчихоод байна.

Судалгаанд тооны зөрүү их гардаг болж. Жишээлбэл : Ажилгүйчүүд гэхэд аймгийн статисикийн хэлтэс дээр нэг тоо байхад Хөдөлмөр зохицуулалтын албанд өөр байх жишээтэй. Сумдын нийгмийн ажилтнууд гэж ачаа нь хүндэдсэн хүмүүс байна. Хариуцахгүй ч юм байхгүй байна. Тийм болохоороо тодорхой үр дүн гарахгүй байх шиг. Өрхийн орлого нэмэгдүүлэх жижиг зээл ядуust өгч үзсэн. Гэтэл эргэж төлөгдөхгүй байна. Өнгөрсөн 4 жилд 14 сая төгрөг зээлээр олгосноос дөнгөж 3 сая нь орж ирээд байна. Төлж чадахгүй шалтгааныг JSS байгууллагаас судлахад зээл авсан иргэдийн 33,5% нь зээлээ өрөнд өгсөн, 18,9% нь хийсэн бүтээгдхүүнээ борлуулж чадаагүй шатсан гэж хариулсан байна. Зээл яагаад авдаггүй вэ? гэсэн асуултанд хөөцөлдөх гэж төвөгтэй, шат дамжлагатай / 31,6, %/, барьцааны хөрөнгө байхгүй бидэнд зээл өгдөггүй / 18,4% / гэж хариулсан байна. Дэлхийн Зөнгөөс сумдын өрхөд ногооны зээл өгч тусалсан. Өрөө ихэнх нь барагдуулаагүй байна.

Нэн ядуусын сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт зарим тохиолдолд тааруу байдаг. Нэн ядуусын 8,6% нь сонгуульд оролцож чаддаггүй бөгөөд үнийгээ иргэний үнэмлэх байхгүй / 72,0%/, орон нутагтаа бүртгүүлээгүйгээр / 28,0% / тайлбарлаж байна. Сүүлийн жилүүдэд болсон 2-3 удаагийн сонгуульд аймгийн суурин хүн амын 10 орчим хувь бүртгэгдээгүй бөгөөд , бүртгэгдсэнээс нь 28 хувь нь оролцоогүй дүн, мэдээ гарчээ. Орхон суманд 2002 оны УИХ-ын нөхөн сонгуулийн үеэр сонгогчийн үнэмлэх дээр шилжүүлэг хийгээгүйгээс 20 гаруй сонгогч, паспорт иргэний үнэмлэхний шилжүүлэггүйгээс 10 гаруй иргэн эрхээ эдэлж чадаагүй гэж тухайн үед гарсан “Хүний эрхийн толь” мэдээллийн хуудсаар мэдээлж байсан байна.

Иргэд эрхээ хамгаалуулах арга хэмжээний нэг хэсгийг төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл илэрхийлж байдаг юм. 1998-2002 он хүртэл 600 гаруй асуудал хөндсөн 570 орчим өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд 1998 онд жилдээ 136 өргөдөл хүлээн авч байсан бол 2002 онд 262 болж бараг 2 дахин өсчээ. Өргөдлийн зонхилох хэсэг нь тэтгэмж туслалцаа хүссэн санхүүгийн чиглэлийн асуудал байдаг. Өнгөрсөн оны эхний хагас жилд дээрх чиглэлээр 28-32 өргөдөл ирсэн нь нийт өргөдлийн 50 гаруй хувийг нь эзэлж байна. Өргөдөл өгсөн хүмүүстэй биечлэн уулзах, орон гэрээр нь очих үзлэг шалгалт хийлгэх, мэргэжлийн байгууллага хүмүүсээр дүгнэлт гаргуулах зэргээр нөхцөл байдлыг нь тодруулаад,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

мөнгө эд материалын дэмжлэг үзүүлэх, харъяа байгууллагад нь асуудлыг шилжүүлэх, халамж буяны байгууллагатай холбож өгөх зэрэг арга хэмжээ авч байна.

Ядуусын өмгөөлүүлэх болон халдашгүй эрхийн байдал бусад иргэдийг бодвол муу байна. Цагдаагийн байгууллагын ажилтан болон төрийн албан хаагчийн зүгээс таны эрхэнд халдсан тохиолдол бий юу? гэсэн асуултанд тийм гэж 23,7% нь хариулсан байхад 2002 онд 55 эмзэг бүлгийн хүн оролцсон судалгаагаар өмгөөлүүлэх эрхийн талаар бага мэдэх буюу огт мэдэхгүй гэж 47 нь, хэнд ямар байгууллагад хандахаа мэдэхгүй гэж 33 нь, өөрийгөө өмгөөлж чадахгүй гэж 50% нь хариулсан байна. Гэмт хэрэгт өртсөн өмгөөллийн хөлс төлөх чадваргүй хүмүүсийн төсвийг төрөөс даах хуулийн заалттай боловч тус аймгийн цагдаагийн хэлтэст жилдээ 200 гаруй гэмт хэрэгт холбогдсон этгээд өмгөөллийн хөлсөө төлж чадахгүйн улмаас эрх нь зөрчигдөж хуулийн заалт хэрэгжихгүйд хүрч байна.

Нэн ядуус юу хүсч байна вэ? Ажлын байртай болох / 84,5%/, Зээл авах / 65,1% /, Сургалтанд хамарч ажилтай болох / 27,1% / гэж үзсдэг байна. Урьд нь зээл авсан хүмүүс зээлээ төлдөггүй. Зээлийн нөхөн төлөлт муу байна. Нөгөөтэйгүүр зээл тусламжийг ядуучуудад биш хөрөнгө мөнгөтэй хүнд өгдөг. Халамж тусламж хүртэх ёстой хүндээ ирэхгүй байна. Сум орон нутгийн удирдлагаас гаргаж буй шийдвэр нь иргэдэд хүрдэггүй. Жишээ нь: ядуурлыг бууруулах сан, сум хөгжүүлэх сангаас зээл тусламж яаж авах , зарцуулалт нь ямар байна гэх мэт мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй бус байдгаас жинхэнэ авах ёстой хүн нь авч чаддаггүй тохиолдол олонтоо гарч байна.

Ядуустай ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд тэднийг материаллаг төдийгүй оюуны , сэтгэлийн хоосролд орж байгаа талаар ярьж байна. Нэн ядууст гурил авчирч өгдөг. Сар идэх юмыг 3-4 хоногт л ядуус нийлж идээд дуусгачихдаг. Хэмнэдэг хямгаддаг юм мэдэхгүй. Мал өгсөн . Идээд үхүүлээд дууссан. Дэндүү арчаагүй залхуу байна. Идэж уух, өмсөх зүүх юм янз бүрийн чиглэлээр өгөөд болж л байна. Гэтэл эрүүл мэндийн даатгалын хураамж мэтийн бэлэн мөнгө шаардагдах зүйл дээр нойл заачих юм. Тэгээд л өнөөх эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, өмгөөлүүлэх эрхнүүд нь илт зөрчигдөөд ирж байна. Бид нэн ядуу руу хэт их анхаарч жаахан дэм өгөхөд өөрсдийгөө аваад явчихмаар хүмүүсийг орхичихоод байна гэж шүүмжилж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## БУЛГАН АЙМГИЙН НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ-ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

2003-03-14 Булган

1. Орхон сум

- Нэн ядууст гурил авчирч өгдөг. Сар идэх юмыг 3-4 хоногт л ядуус нийлж идээд дуусгачихдаг. Хэмнэдэг хямгаддаг юм мэдэхгүй. Мал өгсөн . Идээд үхүүлээд дууссан. Толгой нь оюун ухаан нь ядуу байна. Дэндүү арчаагүй байна. Идэж уух, өмсөх зүүх юм янз бүрээр өгөөд болж л байна. Гэтэл эрүүл мэндийн даатгалын хураамж, гэх мэтчилэн бэлэн мөнгө шаардагдлах зүйл дээр нойл заачих юм. Тэгээд л өнөөх эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, өмгөөлүүлэх эрхнүүд нь илт зөрчигдөөд ирж байна. Бид нэн ядуу руу хэт их анхаарч жаахан дэм өгөхөд өөрсдийгөө аваад явчихмаар хүмүүсийг орхичихоод байна.
- Нэн ядуу, эмзэг бүлгийн хүмүүст халамжийн тэтгэвэр тэтгэмж хүрэлцэхгүй байа. Хуулийн заалтын дагуу олгох ёстой хүмүүст олгогдоод хөдөлмөрийн насны ядуучууд хоосон хоцордог.
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байна. Тийм учраас эмнэлгийн үзлэг үйлчилгээг авч чаддаггүй. Сүүлийн 5 жил эм, тариа хэрэглээгүй, өрхийн эмчээс ямар нэгэн үнэгүй эм тариа авдаггүй. Тэд ч өгдөггүй.
- Нэг сартай хүүхэдтэй Нинагийн Алтанцэцэг дикретний мөнгө аваагүй л байна. Мөнгөгүй гэх юм. -Ирж байгаа тусламж, халамжийг ядуучуудад ээлжилж олгож байвал зүгээр байна. Зөвхөн төслүүдээс сонгосон өрх буюу урьд нь олгож байсан хүмүүстээ дахин дахин өгдөг. Энэ нь буруу, бид ч бас тэр тусламжаас хүртмээр байна.
- Орхонд ядуурал их байгаагийн гол шалтгаан нь мал хувьчлахдаа буруу бодлого барьснаас , Өлзийт тосгон татан буугдсанаас тэндэхийн оршин суугчид орлогогүй болж сумын төв рүү шилжин ирж суурьшсантай холбоотой.
- Бэлэн юм өгөхийг зогсоое. Ямар нэгэн ажил хийлгээд дараа нь өгч байя. Мөн сургалтанд хамруулж мэргэжилтэй болгох нь зүйтэй. Бүх төрлийн тусламж дэмжлэгт хүмүүс яаж ийгээд хамрагддаг. Бодит байдал үнэхээр төвөгтэй байгаа. Зарим нэг аваагүй, хүртээгүй хүмүүс хэл ам их гаргадаг. Эмэгтэйчүүдийн эмч, эм тариа бусад хэрэглэлийг өгөхгүй байна. Барьцаалах хөрөнгөгүй учир зээл авч чадахгүй байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2. **Хишиг-Өндөр сум 27 хүн оролцов.**

- Нэн ядуучууд Заамарын алт руу маш их явдаг болсон. Олохоосоо илүү баахан архидаж ирдэг . 60 өрхөд Дэлхийн Зөнгөөс ногооны зээл өгч тусалсан. Өрөө ихэнх нь барагдуулаагүй байна. Янз бүрийн сйахан сэтгэлтэй хүмүүс, байгууллагаас юм авсаар байгаад бэлэнчилдэг хүмүүс л болж хувираад байна. Олдож л байвал юу ч хамаагүй иддэг болж. Хүнсний аюулгүй байдал гэж ярихын ч илүүц болсон. Удирдлага санхүүжилтийн хууль гарснаар төр төсвийн байгууллагад ажиллаж байсан ядуучуудыг нэн ядуу руу түлхлээ.
- Ядуурлын талаар авч байгаа судалгаануудаа эргэж харах буюу цөөлмөөр юм. Хүмүүс ядуу болохын бөөн сонирхол болж. Яахав, юм өгдөг болохоор. Багийн хуралтай гэж зарлахад хэд 3 хан ирдэг. Гэтэл тусламжийн юм өгөх гэнээ гэвэл сум тэр аяараа цугларна. Ийм л болчихоод байна. Тусламжийн байгууллагууд ямар нэг нийтийг хамарсан ажил нийлгэж байгаад юмаа өгдөг байвал зүгээр. Манай суманд том том аж ахуй олон байсан. Тэд дууссан. Ажилгү ядуучууд маш олон болсон. Энэ өвлөөс хэд 3 малтай малчид нурж эхэлж байна. Нэн ядуучууд улам ихсэнэ. Ялангуяа тал бүрийн ашигтай үхэр их үхэж байгаа нь ядуучуудыг бүр сөхрүүлж байна. Өрөм ааруул сүүгээр зундаа болоод байдаг айл олон байсан. Одоо хөг нь өнгөрлөө.
- Манай суманд халамжийн болон бусад тэтгэмж тусламжинд ихэнх ядуучууд хамрагддаг сайн талтай. Дэлхийн зөн байгууллага 350 хүүхдэд үнэгүй янз бүрийн бэлэг, хувцас, хичээлийн хэрэглэл өгдөг. Үүнд маш их баярлаж явдаг. Хамгийн гол нь тэтгэмж тусламж аваад байхдаа биш. Байнгын ажлын байртай болж хөдөлмөр эрхлэх шаардлагатай байна. Залуучуудыг ажилтай болгомоор байна. ЭМД- гүй учраас эмнэлгийн үзлэг үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна. Мөнгөний боломжгүйгээс зарим сургууль завсардсан хүүхдүүд зайны сургалтанд хамрагдаж байна.
- Нэн ядуу эмзэг бүлгийн хүүхдүүдийг халамжийн цэцэрлэгт хамруулах шаардлагатай байна. Тэдэнд зориулсан бүлэг шинээр нээх хэрэгтэй. Батцэцэгийн Энхтуяа хэлгүй, дүлий тэтгэмж авч чадахгүй байна. 5 сартай Ганчимэгт нярайн тэтгэмж олгогдоогүй. Ирагийн Батцэцэг 19 настай, хөлгүй, группэд орох гэхлээр Олзмөнх эмч хассан. Зээл авах гэхлээр Засаг дарга өгдөггүй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ирсэн мөнгө эзнээ олдоггүй.

3. Хялганат тосгон. 24 хүн хамрагдав.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Хүнсний ногооны үрээр хангаж туславал бид ажиллана.
- Ноднин авсан төмсний үрний мөнгийг өгч чадаагүй. Буцаагаад төмс авдаггүй, заавал мөнгийг авна гэдэг.
- Цагдаагийн ажилтнууд сайн ажилладаг. Эмнэлгийн үйлчилгээ таарууухан байдаг. ЭМД-ийн хураамж өгч чаддаггүй. Ажилтай болмоор байна.
- Гахай үржүүлэх санал тавиад орсон боловч дэмжээгүй.

Багийн 3 Засаг дарга, дэлхийн зөнгийн 2 ажилтан:

- Бид аль болох хүртээхийг эрмэлздэг. Бэлэн юм өгсөөр байгаад сүүлдээ өгсөн хувцас гутлыг маань голоод авдаггүй. Өөрсдийн арчаагүй байдлаас болоод ядуу явж байгаа.
- Дэлхийн зөнгөөс ирсэн тусламжийн бүх барааг зөвлөлийн хурлаар хэлэлцээд хуваарилаж хүртээдэг. Өнгөрсөн жил 27800 төгрөгийг төмс ногооны үр тарааж өгөөд ногоо тариулсан боловч одоо хүртэл үнийг нь төлөөгүй байгаа. Анх гэрээ байгуулахдаа үнийг нь мөнгөөр төлнө гэж тохирсон байдаг.

5. Булган сум.

- Судалгаанд тооны зөрүү их гардаг болж. Жишээлбэл : Ажилгүйчүүд гэхэд аймгийн статисикийн хэлтэс дээр нэг тоо байхад Хөдөлмөр зохицуулалтын албанд өөр байх жишээтэй. Сумдын нийгмийн ажилтнууд гэж ачаа нь хүндэдсэн хүмүүс байна. Хариуцахгүй ч юм байхгүй байна. Тийм болохоороо тодорхой үр дүн гарагүй байх шиг. Өрхийн орлого нэмэгдүүлэх жижиг зээл ядууст өгч үзсэн. Гэтэл эргэж төлөгдөхгүй байна. Өнгөрсөн 4 жилд 14 сая төгрөг зээлээр олгосноос дөнгөж 3 сая нь орж ирээд байна. Нас барагсдын буяны хоолыг хайж явдаг групп үүсчихээд байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**6. Сумдын хүний их эмч нартай хийсэн уулзалтын тэмдэглэл**

- Дуудлагаар очиход нэн ядуу иргэд туйлын хүнд нөхцөлд амьдарч байдаг. Хоол байхгүй, хүн тогтохын аргагүй хүйтэн гэрт өвчин тусахаас аргагүй нөхцөлд амьдарч байдаг. Эм бичээд өгнө.. Авах мөнгөгүй нь ихэнхи нь. Гэрээр нь эмчлэх гэхээр нөхцөл муу. Эмнэлэгт хэвтүүлэх болохоор эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй эсвэл хураамжаа цагт нь төлөөгүй байдаг. Хөнгөллөлтэй эм бичихийг бодно л доо. Бас л энэ шалтгаанаар яаж ч

чаддаггүй. Аргалж чаргалаад заримыг нь ямар 1 аргаар эмчилнэ. Эмчилгээний үр дүн гардаггүй. Учир нь хоол хүнсгүй буюу муугаас хоол тэжээлийн хомсдолтой, хүйтэн гэрт даарна. / Гурванбулаг, Рашаант сум /

- Нэн ядуучууд ихэнх нь боловсрол муутай байдаг. Зөвлөгөө өгнө өө. Биелүүлнэ гэж байхгүй. Сургалтанд оролцуулах гэнэ. Ирэхгүй. Эрүүл мэнддээ анхаарал тавьдаггүйгээс өвчнөө бүр тартагт нь тулгаж байж ирдэг. Тэгээд эмнэлгээс илүү их зардал гарах болдог. Хэцүү амьдралтайд нь эмийн зээл өгдөг. Эргэж олж авч чадахгүйгээс багийн эмч эргэлтийн эмийн санд өртэй болдог. Заримыг нь эмнэлэгт хэвтүүлнэ. Орны 10 хувийг барагтай бол өгөхгүй явчихдаг. Дээд шатны эмнэлэгт явах шаардлагатай нь тэр бүр явж чадахгүй. Зардал мөнгөгүй байдаг. Сумын эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгсдийн 40-50 хувь нь нэн ядуу, өвчнөө хүндрүүлж ирсэн иргэд байдаг. / Могод, Баяннуур, Бугат сум, /
- Зарим нэн ядуучууд нийгэмтэйгээ харицаанд орж чаддаггүй. Зовиураа илэрхийлж мэдэхгүй. Дуугарахгүй. Амьдралдаа гутарч сэтгэцийн өөрчлөлттэй болсон хүн цөөнгүй байдаг. Тусалж дэмжих ах дүү бараг байдаггүй. / Сайхан сум, Хялганат тосгон /
- Хоол тэжээлийн дутагдлаас элэгний өвчин, амьдралын хэцүү байдлаас сэтгэцийн өвчин ихсэх хандлагтай банйа. Мөн осол гэмтэлд өртөгсдийн ихэнх нь хөдөлмөрийн аюулгүй байдал ажилладаг нэн ядуучууд байна. / Орхон сум

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭН ЯДУУ ИРГЭДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ДҮН

2003-03-14 Булган

1.Оршин суугаа газар

Сэлэнгэ 25.8%

Хялганат 25.8%

Орхон 19.3%

Хишиг өндөр 29.0%

2. Нас

18 хүртэл хүүхэд -5.45%

хөдөлмөрийн насны –86.0%

өндөр настан -8.55%

3. хүйс

эр-9.7.%

Эм-90.3%

4. Боловсрол

дээд-0%

тусгай дунд-12.9%

бүрэн дунд-34.4%

бүрэн бус дунд-36.5%

бага-11.8%

боловсролгүй-4.3%

5. Гэрлэлтийн байдал

гэрлэсэн 50.5 %

салсан 19.4%

ганц бие 18.3%

бэлэвсэн 11.8%

6. Иргэний үнэмлэхтэй эсэх

тийм 72.%

үгүй 28%

7. Иргэний үнэмлэхгүй бол яагаад

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

мөнгө байхгүй12%

зураг авахуулаагүй-7%

8. Хөдөлмөр эрхэлдэг эсэх

тийм 24.7%

үгүй 75.3%

9.хөдөлмөр эрхэлдэг бол хаана ажилладаг вэ

хувиараа 23 хүн 24.7%

төр төсвийн байгууллагад

хөлсний ажил 75.3%

10. Ажил эрхэлдэггүй бол ажилгүй байгаа шалтгаанаа хэлнэ үү

ажлын байр байхгүй 68.5%

мэргэжил байхгүй 21.1%

мөнгөгүйгээс болоод 10.4%

11. өрхийн ам бүлийн тоо

1-5хүнтэй 34 өрх 36.5%

5-10хүнтэй 45 48.3%

10 дээш 14 өрх 15.2%

12. өрхийн гишүүдийн нас

13. өрхийн ажил эрхэлдэг хүмүүсийн тоо ажил эрхэлдэг хүн

байгаа 23 өрх 24.7%

байхгүй 70өрх 75.3%

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

14. өрхийн ажил эрхэлдэггүй боловч орлого олдог гишүүдийн тоо

байгаа 51.6

байхгүй 48.3

15. өрхөд байгаа сургуулийн өмнөх насны хүүхдийн тоо

байгаа 53 56.9%

байхгүй 40 43%

16.. Өрхөд байгаа сургуулийн өмнөх насны хүүхэд цэцэрлэгт хамрагдсан эсэх

тийм 29

үгүй 44.1

17. Өрхөд байгаа сургуулийн насны хүүхдийн тоо

байгаа 83.8%

байхгүй 16.1%

18. Сургуульд суралцдаг эсэх

тийм 71

үгүй 7.5

19. Сургууль завсардсан хүүхдийн тоо

байгаа 6.4%

байхгүй 93.6%

20 . Өрхийн сарын дундаж зарлага

| | |
|---|---|
| 10.0-50.0мян | 39.8 |
| 51.0-100.0мян | 35.1 |
| 100.0-150.0 | 17.2 |
| 150.0-200.0 | 7.1 |
| 200.0-дээш | 0.8 |

21. Өрхийн сарын мөнгөн орлого

| | |
|---|---|
| орлогогүй | 27.9% |
| 0-10.0 мян | 61.2% |
| 10-20.0мян | 7.6% |
| 20-30.0мян | 3.3% |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

22. Орон байр

гэрт 29%

хувийн байшинд-42%

орон сууцанд-12%

бусад-6.5%

23. Усан хангамж

төвийн систем-2.2%

гүний худаг-44%

уурхайн худаг-4.3%

гол мөрөн нуур цөөрөм-24.7

бусад-25%

24. Утсан холбоо

утасгүй –97.8

утастай – 2.2

25. Цахилгаан хангамж

цахилгаан гэрэлтэй –82.8

гэрэлгүй – 17.2

26. хөрөнгийн бүртгэл

27. Та ЭМД-д хамрагдсан уу

тийм –34.4

үгүй –62.4

мэдэхгүй-3.2

28. Та хамгийн сүүлд хэзээ эрүүл мэндийн үйлчилгээ хүртсэн бэ

2000 оноос өмнө 59.6%

2000 –2002онд 40.4%

29. Архаг хууч өвчтэй эсэх

тийм – 37%

үгүй –44.1%

мэдэхгүй –19.4%

30. Тахир дутуу эсэх

тийм –1.1.

үгүй –98.9

31. Төрийн нийгмийн халамжаас хүртдэг эсэх

тийм - 29

үгүй –71

32. Ямар байдлаар хүртдэг вэ

халамжийн тэтгэвэр авдаг –10.8

тэтгэмж авдаг – 17.2

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

33. Та өөр хаанаас нийгмийн халамж тусламж хүртдэг вэ?

Хүртдэггүй 83.1%

Дэлхийн зөн ОУХБайгууллагаас 16.9

34. Та сонгуульд оролцдог уу

тийм –92.5

үгүй –8.6

35. Сонгуульд оролцож чаддаггүй бол яагаад

иргэний үнэмлэх байхгүй 72%

орон нутагтаа бүртгүүлээгүй 28%

36. Танд болон таны ойр төрлийн хүнд цагдаагийн байгууллагын ажилтан болон төрийн албан хаагчийн зүгээс таны эрхэнд халдсан тохиолдол бий юу

тийм –23.7

үгүй – 76.3

37. Тийм бол тайлбарлаж хэлнэ үү

38. Та гэмт хэрэгт холбогдож байсан уу

тийм –2.6

үгүй --97.4

39. Холбогдож байсан бол өмгөөлөгч авч байсан уу? Тэр талаараа дэлгэрэнгүй хариулна уу

авч байсан 2.6%

авч байгаагүй 0

40. Та ямар нэгэн хүсэлт тавьж төрийн байгууллага албан тушаалтанд хандаж байсан уу

тийм –48.4

үгүй- 51.6

41..Хандаж байсан бол ямар асуудлаар

зээл хүсч 69.6

ажилтай болгож өгөх 48.1

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

янз бүрийн халамж үйлчилгээнд хамруулахыг хүсч 27.8

42. Та хэзээнээс нэн ядуу ангилалд орох болсон бэ

1990-1994онд -42.5%

1995-2000 -41.8%

2000-хойш -15.7%

43. Та яагаад нэн ядуу ангилалд орох болсон бэ

44. Таны өнөөгийн нөхцөл байдалтай холбоотойгоор ямар бэрхшээл учирч байна вэ

гадуурхах

өлсөх -71.8

өвдөх -88.0

сурч чадахгүй байх -17.9%

45. Та өөрт тохиолдож байгаа бэрхшээлийг арилгахын тулд хэнд хандах ёстой гэж бодож байна?

сумын засаг захиргааны ажилтнуудад 100.0

аймгийн халамжийн байгууллагад 95.0

баг хорооны даргад 72.8

46.Нэн ядуу байдлаас гарахад төрөөс ямар байдлаар дэмжлэг үзүүлбэл зохимжтой вэ

ажлын байртай болгох –84.5%

Зээл олгох -65.1%

Сургалтанд хамруулж мэргэжилтэй болгох -27.1%

47. Таны бодлоор нэн ядуу байдлаас гарахад хамгийн чухал нөлөөтэй хүчин зүйл юу вэ

ажилтай болох 100.0%

цалинтай болох 96.8%

зээл авах 86.5%

мөнгө 24.9%

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# Нэн ядуу өрхийн судалгаа.

Аймгийн нэр: Хүснэгт 4

| № | Сумын нэр | Ам бүл-ийн тоо | Нийт ам бүл-н тоогоор | | | | Өрхийн малын тоогоор | | | | Орон сууцны байдал | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ганц бие | 2-5 ам бүл тэй | 6-8 ам бүл-тэй | 8-аас дээш ам бүл-тэй | Огт мал-гүй | 2хүр-тэлх бод-той | 2-4 бод-той | 4-өөс дээш бод той | Огт сууц гүй | Гэрт болон ердийн галлагаа-тай | Тохи лог суу-цанд | Эцэг эхийн хамт амьдар даг | Айлын байр гэр хөлсөл дөг |
| | А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Баянагт | 590 | 4 | 105 | 21 | 1 | 0 | 30 | 47 | 54 | 2 | 129 | 0 | 0 | 0 |
| 2 | Баяннуур | 775 | 4 | 167 | 15 | 0 | 24 | 2 | 4 | 156 | 0 | 185 | 0 | 0 | 1 |
| 3 | Бугат | 565 | 6 | 76 | 37 | 4 | 55 | 23 | 5 | 40 | 0 | 123 | 0 | 0 | 0 |
| 4 | Булган | 3187 | 20 | 540 | 146 | 34 | 634 | 32 | 42 | 32 | 40 | 536 | 78 | 50 | 36 |
| 5 | Бүрэгхангай | 280 | 2 | 41 | 14 | 2 | 33 | 3 | 1 | 22 | 4 | 55 | 0 | 0 | 0 |
| 6 | Гурванбулаг | 875 | 7 | 141 | 45 | 6 | 54 | 9 | 6 | 130 | 1 | 194 | 0 | 4 | 0 |
| 7 | Дашинчилэн | 421 | 9 | 82 | 16 | 1 | 85 | 6 | 8 | 9 | 9 | 82 | 0 | 10 | 7 |
| 8 | Могод | 529 | 7 | 94 | 24 | 0 | 10 | 7 | 17 | 91 | 6 | 107 | 7 | 4 | 1 |
| 9 | Орхон | 491 | 7 | 66 | 21 | 10 | 65 | 2 | 8 | 29 | 27 | 71 | 1 | 3 | 2 |
| 10 | Рашаант | 1620 | 8 | 224 | 95 | 11 | 115 | 43 | 76 | 104 | 10 | 312 | 0 | 15 | 1 |
| 11 | Тэшиг | 471 | 4 | 53 | 37 | 7 | 30 | 5 | 18 | 48 | 7 | 87 | 0 | 3 | 4 |
| 12 | Сайхан | 582 | 10 | 73 | 54 | 17 | 31 | 4 | 21 | 98 | 8 | 135 | 1 | 6 | 4 |
| 13 | Сэлэнгэ | 885 | 7 | 102 | 66 | 4 | 108 | 12 | 9 | 50 | 4 | 165 | 0 | 10 | 0 |
| 14 | Хангал | 287 | 1 | 39 | 15 | 4 | 17 | 13 | 18 | 11 | 0 | 57 | 0 | 1 | 1 |
| 15 | Хишиг-Өндөр | 1669 | 4 | 292 | 81 | 2 | 96 | 11 | 57 | 215 | 0 | 364 | 0 | 14 | 1 |
| 16 | Хутаг-Өндөр | 1566 | 22 | 266 | 65 | 10 | 158 | 16 | 4 | 185 | 26 | 328 | 0 | 6 | 3 |
| 17 | *Хялганат тосгон* | *693* | *0* | *85* | *39* | *12* | *98* | *16* | *17* | *5* | *2* | *121* | *0* | *9* | *4* |
| 18 | **Дүн** | **15486** | **122** | **2446** | **791** | **125** | **1613** | **234** | **358** | **1279** | **146** | **3051** | **87** | **135** | **65** |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Нэн ядуу өрхийн хүн амын судалгаа.**

**Аймгийн нэр:** **Булган аймаг**

Хүснэгт 5

| № | Сумын нэр | Нэн ядуу хүн амын тоо | Насны бүлгээр | | | | | | | Хөдөлмөрийн насны | | | | | | Тэтгэврийн насны | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 0-3 насны | | 4-7 насны | | | 8-16 насны | | | | | | | | | | | |
| | | | Гэрт | Ясли | Цэцэрлэгт | Халамжийн цэцэрлэгт | Гэрт | ЕБС | Сургууль завсардсан | Суралцдаг | Ажилтай | Ажилгүй | Цэрэгт | Ял эдэлж байгаа | Хөдөлмөрийн чадваргүй | Өндөр насны тэтгэвэрт | Халамжийн тэтгэвэрт | Ажил эрхэлдэггүй | Огт орлогогүй |
| | А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 1 | Баянагт | 590 | 77 | 0 | 8 | 0 | 98 | 139 | 17 | 0 | 159 | 47 | 4 | 3 | 4 | 22 | 12 | 0 | 0 |
| 2 | Баяннуур | 775 | 54 | 0 | 3 | 0 | 158 | 183 | 23 | 1 | 201 | 139 | 1 | 1 | 1 | 6 | 2 | 0 | 2 |
| 3 | Бугат | 565 | 64 | 0 | 5 | 0 | 61 | 134 | 14 | 1 | 176 | 88 | 1 | 1 | 6 | 12 | 2 | 0 | 0 |
| 4 | Булган | 3187 | 129 | 39 | 60 | 30 | 147 | 836 | 61 | 114 | 603 | 773 | 27 | 11 | 54 | 211 | 70 | 0 | 22 |
| 5 | Бүрэгхангай | 280 | 25 | 0 | 1 | 0 | 23 | 70 | 8 | 2 | 48 | 89 | 3 | 1 | 1 | 6 | 3 | 0 | 0 |
| 6 | Гурванбулаг | 875 | 132 | 0 | 11 | 0 | 60 | 211 | 28 | 8 | 130 | 274 | 1 | 5 | 0 | 13 | 2 | 0 | 0 |
| 7 | Дашинчилэн | 421 | 35 | 0 | 4 | 2 | 49 | 107 | 3 | 6 | 32 | 167 | 1 | 3 | 2 | 5 | 5 | 0 | 0 |
| 8 | Могод | 529 | 45 | 0 | 1 | 0 | 62 | 117 | 7 | 8 | 153 | 108 | 3 | 2 | 8 | 15 | 0 | 0 | 0 |
| 9 | Орхон | 491 | 42 | 0 | 7 | 4 | 41 | 110 | 36 | 13 | 72 | 144 | 0 | 4 | 6 | 11 | 1 | 0 | 0 |
| 10 | Рашаант | 1620 | 156 | 0 | 19 | 0 | 228 | 367 | 62 | 18 | 416 | 315 | 10 | 2 | 0 | 26 | 1 | 0 | 0 |
| 11 | Тэшиг | 471 | 39 | 0 | 1 | 0 | 71 | 99 | 32 | 5 | 83 | 114 | 1 | 1 | 2 | 7 | 4 | 2 | 10 |
| 12 | Сайхан | 582 | 89 | 0 | 0 | 0 | 63 | 88 | 30 | 28 | 124 | 108 | 1 | 8 | 21 | 11 | 7 | 2 | 2 |
| 13 | Сэлэнгэ | 885 | 140 | 0 | 12 | 14 | 36 | 239 | 20 | 12 | 74 | 315 | 1 | 1 | 9 | 12 | 0 | 0 | 0 |
| 14 | Хангал | 287 | 13 | 0 | 0 | 9 | 27 | 94 | 1 | 1 | 7 | 119 | 3 | 1 | 0 | 12 | 0 | 0 | 0 |
| 15 | Хишиг-Өндөр | 1669 | 144 | 0 | 36 | 0 | 140 | 403 | 20 | 30 | 539 | 281 | 16 | 0 | 13 | 36 | 11 | 0 | 0 |
| 16 | Хутаг-Өндөр | 1566 | 152 | 0 | 2 | 0 | 161 | 332 | 64 | 13 | 151 | 634 | 8 | 2 | 7 | 26 | 10 | 1 | 3 |
| 17 | Хялганат тосгон | 693 | 75 | 0 | 9 | 10 | 25 | 164 | 24 | 7 | 21 | 303 | 9 | 2 | 10 | 27 | 7 | 0 | 0 |
| 18 | **Дүн** | **15486** | **1411** | **39** | **179** | **69** | **1450** | **3693** | **450** | **267** | **2989** | **4018** | **90** | **48** | **144** | **458** | **137** | **5** | **39** |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5-ын үргэлжлэл

| № | Хөдөлмөр эрхэлдэг хүний тоо | | | | | | | Ажил эрхэлдэггүй хүн | | | | | | Эрүүл мэндийн байдлаар | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Мэргэжлээр | | | | | | | |
| | Төсөвт байгууллагад | Төрийн өмчийн бусад байгууллагад | Хувийн хэвшилд | ХАА компани | Ардын аж ахуйтан | Хувиараа хөдөлмөр эрхэлдэг | Бусад | Ажил идэвхитэй эрж байгаа | Ажил эрж хайхгүй байгаа | Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж авдаг | Мэргэжилтэй | Мэргэжилгүй | Ажиллах сонирхолтой | Оюуны хомсдолтой | Хараагүй | Хэлгүй, Дүлий | Бусад эрхтэний гажигтай | Хэвтрийн өвчтэй |
| | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 |
| 1 | 8 | 0 | 0 | 0 | 149 | 2 | 0 | 47 | 0 | 0 | 30 | 17 | 0 | 0 | 0 | 0 | 16 | 0 |
| 2 | 1 | 1 | 0 | 0 | 198 | 1 | 0 | 60 | 79 | 0 | 32 | 107 | 23 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| 3 | 0 | 0 | 0 | 0 | 176 | 0 | 0 | 20 | 68 | 0 | 10 | 78 | 20 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | 36 | 19 | 36 | 0 | 37 | 374 | 101 | 630 | 143 | 0 | 215 | 558 | 796 | 36 | 7 | 13 | 42 | 4 |
| 5 | 2 | 0 | 0 | 0 | 46 | 0 | 0 | 4 | 85 | 0 | 2 | 87 | 0 | 8 | 0 | 0 | 6 | 0 |
| 6 | 7 | 0 | 3 | 0 | 108 | 0 | 12 | 219 | 55 | 0 | 48 | 226 | 193 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | 4 | 0 | 6 | 0 | 6 | 14 | 2 | 160 | 7 | 0 | 72 | 95 | 137 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | 13 | 4 | 0 | 0 | 136 | 0 | 0 | 102 | 6 | 0 | 6 | 102 | 0 | 0 | 0 | 0 | 8 | 0 |
| 9 | 1 | 0 | 3 | 5 | 26 | 37 | 0 | 112 | 32 | 0 | 20 | 124 | 2 | 0 | 0 | 6 | 1 | 0 |
| 10 | 11 | 1 | 20 | 2 | 369 | 13 | 0 | 288 | 27 | 0 | 205 | 110 | 288 | 3 | 0 | 1 | 6 | 1 |
| 11 | 4 | 1 | 8 | 9 | 60 | 1 | 0 | 78 | 36 | 0 | 16 | 98 | 0 | 4 | 0 | 2 | 3 | 0 |
| 12 | 2 | 0 | 8 | 0 | 111 | 3 | 0 | 105 | 3 | 0 | 73 | 35 | 31 | 4 | 2 | 0 | 1 | 1 |
| 13 | 0 | 0 | 18 | 40 | 0 | 15 | 1 | 166 | 149 | 0 | 70 | 245 | 164 | 3 | 1 | 1 | 7 | 0 |
| 14 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 0 | 36 | 83 | 0 | 9 | 110 | 27 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | 2 | 1 | 14 | 10 | 503 | 4 | 5 | 241 | 40 | 0 | 132 | 149 | 125 | 0 | 0 | 3 | 8 | 0 |
| 16 | 11 | 3 | 8 | 21 | 94 | 0 | 14 | 335 | 297 | 2 | 117 | 517 | 210 | 6 | 1 | 4 | 4 | 1 |
| 17 | 12 | 2 | 7 | 0 | 0 | 0 | 0 | 288 | 15 | 0 | 142 | 161 | 288 | 4 | 0 | 1 | 3 | 2 |
| 18 | **117** | **32** | **131** | **87** | **2019** | **468** | **135** | **2891** | **1125** | **2** | **1199** | **2819** | **2304** | **74** | **11** | **31** | **105** | **9** |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5-ын үргэлжлэл

| № | Бүтэн өнчин хүүхэд | Хагас өнчин хүүхэд | Хог түүж амьдардаг | | | Зээл тусламж авсан хүн | | | | | | | Шаардагдах тусламж дэмжлэг /хүний тоогоор/ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЯБ сангаас | | Бусад төрлийн тусламж | | Хоол,хувцас авсан | | Зээл тусламж огт аваагүй хүний тоо | | | | | | |
| | | | Ганц бие | Гэр бүлтэй | Орон гэргүй | Хүний тоо | Мөнгөний хэмжээ | Хүний тоо | Мөнгөний хэмжээ | Хүний тоо | Мөнгөний хэмжээ | | Ажилд орох | Малтай болох | Ногоо тарих | Зээл авах | Асрамжид явах | Бусад |
| | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 |
| 1 | 4 | 27 | 0 | 0 | 0 | 6 | 42.0 | 116 | 1622.0 | 94 | 49.0 | 16 | 78 | 136 | 16 | 42 | 0 | 7 |
| 2 | 0 | 33 | 0 | 0 | 0 | 23 | 0.0 | 0 | 0.0 | 157 | 100.0 | 95 | 43 | 28 | 0 | 15 | 0 | 0 |
| 3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 565 | 20 | 445 | 100 | 0 | 0 | 0 |
| 4 | 23 | 141 | 1 | 2 | 1 | 15 | 900.0 | 274 | 908.0 | 337 | 250.8 | 89 | 722 | 106 | 223 | 163 | 4 | 3 |
| 5 | 3 | 6 | 0 | 0 | 0 | 4 | 400.0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 69 | 20 | 11 | 9 | 0 | 0 |
| 6 | 1 | 21 | 7 | 0 | 0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 160 | 199 | 31 | 0 | 0 | 0 |
| 7 | 0 | 3 | 1 | 5 | 0 | 8 | 850.0 | 16 | 1218.0 | 269 | 3100.0 | 126 | 60 | 149 | 10 | 0 | 0 | 68 |
| 8 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 25 | 1500.0 | 61 | 94.5 | 344 | 977.0 | 99 | 108 | 254 | 216 | 0 | 0 | 0 |
| 9 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0.0 | 29 | 413.4 | 149 | 1051.2 | 0 | 65 | 81 | 40 | 60 | 0 | 0 |
| 10 | 2 | 7 | 1 | 0 | 0 | 15 | 1500.0 | 1224 | 2145.0 | 63 | 29.0 | 85 | 201 | 129 | 54 | 79 | 0 | 0 |
| 11 | 0 | 13 | 3 | 22 | 1 | 12 | 0.0 | 162 | 0.0 | 0 | 0.0 | 55 | 74 | 80 | 46 | 26 | 0 | 0 |
| 12 | 0 | 16 | 0 | 0 | 0 | 0 | 0.0 | 195 | 321.4 | 22 | 132.3 | 101 | 56 | 121 | 46 | 114 | 1 | 1 |
| 13 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 13 | 1400.0 | 0 | 0.0 | 97 | 860.0 | 0 | 164 | 124 | 166 | 87 | 0 | 0 |
| 14 | 4 | 8 | 0 | 0 | 1 | 18 | 1500.0 | 135 | 135.0 | 205 | 205.0 | 19 | 37 | 47 | 56 | 43 | 0 | 0 |
| 15 | 2 | 12 | 0 | 0 | 0 | 230 | 23000.0 | 282 | 627.0 | 760 | 1313.7 | 208 | 176 | 193 | 51 | 81 | 0 | 0 |
| 16 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 97 | 7320.0 | 366 | 3840.6 | 512 | 1437.9 | 334 | 273 | 240 | 172 | 83 | 3 | 13 |
| 17 | 2 | 43 | 0 | 0 | 0 | 11 | 1150.0 | 36 | 126.0 | 142 | 1150.0 | 226 | 197 | 78 | 90 | 22 | 1 | 11 |
| 18 | **46** | **330** | **13** | **29** | **3** | **477** | **39562.0** | **2896** | **11450.9** | **3151** | **10655.9** | **2018** | **2503** | **2430** | **1328** | **824** | **9** | **103** |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлын судалгаа

## Нэг. Судалгааны зорилго, хамрах хүрээ, хийх хугацаа

1.1. Нэн ядуу иргэдийн эдийн засаг, нийгэм соёлын болон улс төр , иргэний эрхийн төлөв байдлыг микро болон макро түвшний судалгаанд түшиглэн тодорхойлох зорилготой.

1.2. Судалгааг ядуурал болон иргэдийн эрхийн чиглэлийн хоёрдогч эх үүсвэр материалууд болон тандалтын судалгааны үр дүнг ашиглан явууллаа.

1.2.1. Хоёрдогч эх үүсвэр материалыг холбогдох яам, агентлагууд, төрийн бус байгууллагаас авч үзэж судаллаа.

1.2.2. Микро түвшний судалгаа буюу тандалтын судалгаанд аймгийн төвийн Сүмбэр суманд 115 өрхийн 115 хүнээс, Шивээговь суманд 40 өрхийн 40 хүнээс , Баянтал суманд 20 өрхийн 20 хүнийг хамрууллаа.

1.3 Судалгааг 2003 оны 2 дугаар сарын 10-наас 2003 оны 3 дугаар сарын 10 хүртэл хугацаанд зохион байгуулж явууллаа.

## Хоёр. Судалгаа явуулах баг , судалгааг хийх аргачлал.

2.1. Судалгааны багийг 2003 оны 2 дугаар сарын 12- ны өдөр аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоолоор 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

2.2. Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлын судалгааг баримт бичигт дүн шинжилгээ хийх, оролцооны аргыг ашиглан явуулсан.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## *Гурав. Макро түвшний судалгаа /. Баримт бичгийн судалгаа/*

### *3.1.1. Нэн ядуу иргэдийн талаарх тоо баримт , судалгаа шалгалтын тайлан, хурал , семинарын илтгэл , холбогдох бусад материал.*

*1991-2000 он / аймаг 1991 онд байгуулагдсан./ хүртэл статистикийн хэлтэс нэн ядуу иргэдийн талаар дэлгэрэнгүй судалгааг гаргаж байсан . 2001 оноос хойш статистикийн төв газраас үүрэг болгоны дагуу статистикийн хэлтэс ядуу, нэн ядуу иргэдийн судалгааг гаргахгүй болсон байна. Иймд 2001, 2002 онуудын нэн ядуу иргэдийн судалгааг сумдын багийн дарга нар гаргасан. Багийн дарга нар оны эцэст хүн ам, орон сууцны тооллогоор дээрх судалгааг хавсруулан хийжээ.*
*Мөн 1996 оноос эхлэн 2000он хүртэл аймгийн Ядуурлыг бууруулах зөвлөл нь ядуурал ажилгүйдлийн үзлэгийг аймгийн хэмжээнд 3 удаа зохион байгуулж, жилд 2 удаа ядуурлын судалгааг шинэчлэн гаргаж байсан 2001 оноос эхлэн ядуучуудын судалгааг гаргахаа больсон байна.*
*Иймд 2001 оноос эхлэн аймагт нэн ядуучуудын судалгааг нэгтгэж байгаа хэлтэс, албад байхгүй зөвхөн сумдууд гаргаж байна.*
*2001 оны 7-р сард Ядуурлын улсын үзлэг явагдсан .*
*1998-2002 он хүртэлх нэн ядуу иргэдийн тоо баримтыг хүснэгт 1-д үзүүлэв.*

*Хүснэгт-1*

| № | | | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нийт нэн ядуу өрх | | 341 | 384 | 423 | 377 | 356 |
| 2 | Нийт нэн ядуу хүн ам | | 1507 | 1846 | 1704 | 1627 | 1584 |
| 3 | Сүмбэр сум | Нэн ядуу өрх | 288 | 281 | 234 | 213 | 190 |
| | | Нэн ядуу хүн ам | 1284 | 1321 | 1065 | 980 | 949 |
| 4 | Шивээговь сум | Нэн ядуу өрх | 28 | 67 | 130 | 102 | 99 |
| | | Нэн ядуу хүн ам | 94 | 349 | 412 | 418 | 400 |
| 5 | Баянтал сум | Нэн ядуу өрх | 25 | 36 | 59 | 62 | 67 |
| | | Нэн ядуу хүн ам | 129 | 176 | 227 | 229 | 235 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*3.1.2. Нэн ядуу иргэдийн талаар авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөр , үйл ажиллагаа , өртөг.*

*Монгол улсын Засгийн газрын " Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг батлах тухай1994 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 105 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 1995.08.01-ний өдрийн 11/ 38 тоот захирамжаар аймгийн ядуурлыг бууруулах зөвлөлийг 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан " Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн ажлыг орон нутагт зохион байгуулах чиг үүрэгтэйгээр 1996-2000 он хүртэл ажилласан байна. Мөн Сум, багийн ЯБЗ- нь тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан байна.*
*1996-2000 онд ЯБҮХ-ийн Суурь боловсрол, Сургуулийн өмнөх боловсрол, НХА, Эрүүл мэнд , Эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх / ЭБОН/ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 100.4 сая төгрөгийн 193 төсөл хэрэгжүүлж Нэн ядуу иргэдэд туслах сангаас /НЯИТС/ болон бусад сайн санааны тусламжийг давхардсан тоогоор 880 өрхийн 1843 хүнд хүргэсэн байна.*

- *НХА-ын чиглэлээр 12,4 сая төгрөгийн өртөгтэй 10 төсөл хэрэгжсэн байна. Дээрх төслүүдээр аймгийн хэмжээнд 3 усан сан шинээр баригдаж 826 өрхийн 3088 хүн ундны усаар хангагдав, 12 км шороон замыг засварлан сайжруулж Сүмбэр сумын замын сүлжээг тэмдэгжүүлж, 40м$^2$ талбай бүхий зогсоол байгуулав. Шивээговь сумын эмнэлгийн цэвэр усны 800м шугам, Баянтал сумын халуун усны засвар, сумын төвийн тохижилтийг сайжруулж хүүхдийн болон спорт тоглоомын талбай барих, зүлэг мод тарих ажлыг хийв.Төслүүдэд 302 хүн түр, 4 хүн байнгын ажлын байраар хангагдаж , нэг хүн дунджаар 18,0 мянган төгрөгийн цалин авчээ. 192 өрхийн 684 хүн ашиг хүртэв.*
- *Эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр 141 төсөл хэрэгжүүлж 33.5 сая төгрөгийн жижиг зээл олгож нэн ядуу, ядуу иргэдийг жижиг зээлд хамруулж эхэлснээр Баянтал сум 6.4 сая төгрөгийн, Сүмбэр сум 19.6 сая төгрөгийн , Шивээговь сум 7.5 сая төгрөгийн эргэлтийн сантай болж өнөөдрийг хүртэл ажиллаж сангийн хөрөнгийн ашиглалт жилээс жилд сайжирч ирлээ.*
- *ЭМ /Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл/ -ийн хүрээнд 3 сумандэмнэлгийн түргэн тусламжийн автомашин, 2 сумын эмнэлгийн халаалт, дээвэр, барилгын засварыг хийж, Сүмбэр суманд төрөхийн өмнөх байрыг тохижуулав. Аймгийн хэмжээнд эмнэлгийн 40 сайн дурын туслагч бэлтгэгдэв. СДТ нар 3 сумын 508 өрхийн 1640 хүнд үйлчилж байна. Бүгд 4 төсөлд 8,1 сая төгрөг, машинд 14,3 сая төгрөг бүгд 22,9 сая төгрөгийн санхүүжилт хийгдэв. Төслийн хүрээнд 4 хүн байнгын, 106 хүн түр ажлын байраар хангагдав.*
- *СБ /Суурь боловсролыг дэмжих төсөл/ -ийн хүрээнд : 4 төсөлд 9,3 сая төгрөгийн санхүүжилт хийгджээ.*
- *СӨБ-ыг дэмжих төсөл : 5 төсөлд 7,0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.*
- *НЯИТС/Нэн ядуу иргэдэд туслах сан/ :*
  *Нэн ядуу иргэдэд туслах сангаас 1,3 сая төгрөгийн халамжийн үйлчилгээг 3 сумын 8 багийн 77 өрхийн 308 хүнд үзүүлэв.*
  *Мөн аймаг, сумдын санд иргэд байгууллагаас хандивласан 859,5 сая төгрөгийн халамж үйлчилгээг 171 өрхийн 342 хүнд үзүүлэв.*
  *Олон улсын байгууллагаас ирүүлсэн тусламжийн хувцасыг давхардсан тоогоор 803 өрхийн 1535 хүнд олгосон байна.*
  *Мөн хүнсний ногооны 4134 багц үрийг 300ш зөвлөмжийн хамт ядуу өрхүүдэд тарааж хүнсний хэрэгцээгээ нэмэгдүүлэхэд нь тусласан*

UIL.MN
СУДАЛГААНЫ САН

*байна.*

*"Талын гэгээ" сонинд аргачлал зөвлөгөө нийтлүүлж, " Ногоон хувьсал" хөтөлбөрийн ажлын албатай хамтран орон нутгийн телевизээр сургалт явуулсан байна.*

- *ТББ-д 10998,1 төгрөгийн өртөгтэй 25 эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх төслийг идэвхжүүлэн дэмжиж ажиллав. Төсөлд нэн ядуу өрхийн 125 эмэгтэй хамрагдсаны 55 буюу 45 хувь нь өрх толгойлсон эмэгтэй байв. Төслөөс 116 өрхийн 577 хүн ашиг хүртсэн байна.*
- *Орон нутгийн төсвөөс сургалт , сурталчилгаа, тусламжийн чиглэлээр 1,7 сая төгрөг оруулсан. Малжуулах чиглэлээр орон нутгийн төсвөөс 3,0 сая төгрөгийн өртөгтэй төсөл хэрэгжүүлж малгүй нэн ядуу 10 өрхөд зээл олгосон байна.*

*Монгол улсын Засгийн газрын " Өрхийн амжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр" –ийг батлах тухай 2000 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 93 дугаар тогтоолын 2-р заалтыг үндэслэн аймгийн ИТХТ-ийн 2001 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор аймгийн ЯБЗ-ийг ӨАЧДЗ болгон өөрчилж " Өрхийн амжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн ажлыг орон нутагт зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.*

*2001 онд хийсэн ажил :*
*Сүмбэр , Шивээговь сумдын ЭБОНСангаас 68 төсөлд 19 сая төгрөгийн , ХЭХ-ны салбар хорооны идэвхжүүлэгч төсөлд 1.5 сая төгрөгийн , АСЗХ-ны идэвхжүүлэгч 3 төсөлд 1.5 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийсэн байна.*
*Жижиг зээлд 164 хүн хамрагдан ажлын байртай болсны 104 нь эмэгтэй, 18 нь тахир дутуу иргэд байна.*
*2002 онд хийсэн ажил :*
*Аймгийн ИТХТ-ийн 2002 оны 6 дугаар сарын 25 –ны өдрийн 40 дүгээр тогтоолоор " Өрхийн амжиргааны чадавхийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байна.*
*Аймгийн хэмжээнд " Эргэлийн сан"-гаас орлого нэмэгдүүлэх чиглэлээр 164 төсөлд 48.4 сая төгрөгийн санхүүжилт хийж , жижиг зээлд 340 хүн хамрагдан ажлын байртай болсны 7.3 хувь нь тахир дутуу иргэд, 57.6 хувь нь эмэгтэйчүүд байна..*

*3.1.3. Нэн ядуу бүлгийн иргэдэд зориулсан төсөв болон холбогдох бусад зардлын бүтэц. / Улсын болон орон нутгийн , шашны , олон улсын сангийн/*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*3.2.1. Нэн ядуу иргэдийн талаар орон нутгийн ИТХ, Засаг даргаас гаргасан тогтоол захирамж.*

| № | Захирамжийн утга | Он, сар, өдөр | Дугаар | Хэрхэн шийдвэрлэсэн |
|---|---|---|---|---|
| | Аймгийн Засаг даргын гаргасан захирамж | | | |
| 1 | Буцалтгүй тусламж олгох тухай | 2001.06.19 | 127 | Сүмбэр сумын 2-р багийн иргэн Б. Зээхүүд ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан 30,000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. |
| 2 | Буцалтгүй тусламж олгох тухай | 2001.08.17 | 167 | Сүмбэр сумын 2-р багийн иргэн Г. Рагчаад ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан 30,000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. |
| 3 | Буцалтгүй тусламж олгох тухай | 2001.08.31 | 173 | Ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан Сүмбэр сумын 2-р багийн иргэн Д. Баянмөнхөд 20,000 мянган төгрөг, 1-р багийн иргэн Л. Цогтбаатарт 30,000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. |
| 4 | Буцалтгүй тусламж олгох тухай | 2001.10.12 | 200 | 4- өнчин хүүхэдтэйгээ амьдардагэрхэлсэн ажилгүй нэн ядуу Сүмбэр сумын 1-р багийн иргэн Ж. Раднаагийн гачигдалтай бадлыг харгалзан 30,000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж. |
| 5 | Буцалтгүй тусламж олгох тухай | 2002.01.21 | 09 | Ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан Сүмбэр сумын 2-р багийн иргэн П. Оюунцэцэгт 50,000 мянган төгрөг, Шивээговь сумын 2-р багийн иргэн Б. Наранцэцэгт 20,000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. |
| 6 | Буцалтгүй тусламж олгох тухай | 2002.02.08 | 22 | Сүмбэр сумын 2-р багийн иргэн Агваандаржаагийн Гансүхт ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан 12,000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. |
| 7 | Буцалтгүй тусламж олгох тухай | 2002.02.21 | 29 | Сүмбэр сумын иргэн Ж. Даваагийн хүү нь элэгний хүнд өвчнөөр өвчилж удаан хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай байгаа тул 50,000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж. Олгосон. |
| 8 | Буцалтгүй | 2002.03.27 | 55 | Сүмбэр сумын 5-р багийн иргэн Д. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Аймгийн ИТХТ-ийн гаргасан тогтоол | | | |
| 1 | Шийдвэр хэрэгжүүлэх тухай | 2002.10.28 | 65 | |
| | Баянтал сумын ИТХ, ЗД-аас гаргасан тогтоол , захирамж | | | |
| 1 | ӨАЧДЗ байгуулах тухай | 2002.01.29 | 05 | |
| 2 | ӨАЧДЗ-ийг шинэчлэн байгуулах тухай. | 2002.02.01 | 12 | |
| 3 | “Хүнс- түлээ- гэр” үйл ажиллагааг зохион байгуулах комисс томилох. | 2002.11.5 | 21 | |

3.2.2. Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо оноор /1998-2002

1998-2002 он хүртэлх нэн ядуу иргэдийн тоо баримтыг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт-1

| № | | | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нийт нэн ядуу өрх | | 341 | 384 | 423 | 377 | 356 |
| 2 | Нийт нэн ядуу хүн ам | | 1507 | 1846 | 1704 | 1627 | 1584 |
| 3 | Сүмбэр сум | Нэн ядуу өрх | 288 | 281 | 234 | 213 | 190 |
| | | Нэн ядуу хүн ам | 1284 | 1321 | 1065 | 980 | 949 |
| 4 | Шивээговь сум | Нэн ядуу өрх | 28 | 67 | 130 | 102 | 99 |
| | | Нэн ядуу хүн ам | 94 | 349 | 412 | 418 | 400 |
| 5 | Баянтал сум | Нэн ядуу өрх | 25 | 36 | 59 | 62 | 67 |
| | | Нэн ядуу хүн ам | 129 | 176 | 227 | 229 | 235 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

### 3.2.2. Нийгмийн халамжийн тэтгэвэр авч байгаа нэн ядуу иргэдийн тоо.

| № | Он | Нийгмийн халамжийн тэтгэвэр авч байгаа ядуу өрхийн тоо | Насны ангиллаар | |
|---|---|---|---|---|
| | | | 50-60нас | 7-16 нас |
| 1 | 1998 | 64 | 38 | 26 |
| 2 | 1999 | 90 | 45 | 45 |
| 3 | 2000 | 86 | 45 | 41 |
| 4 | 2001 | 100 | 41 | 59 |
| 5 | 2002 | 95 | 38 | 57 |
| | Дүн | 435 | 207 | 228 |

### 3.2.4. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нэн ядуу иргэн

| № | | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өрх | 76 | 88 | 989 | 139 | 277 |
| 2 | Нэн ядуу хүн ам | 142 | 436 | 4207 | 232 | 926 |

### 3.2.5. Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл , хүртээмжийг тодруулах.

| № | халамж үйлчилгээний төрөл | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Халамжийн тэтгэвэр | 9.2 сая 140 хүнд | 13.8сая 1103 | 30.9сая 195 | 24.4сая 228 | 26.4сая 223 |
| 2 | Тэтгэмж | 29.9сая 2416 хүн | 40.2сая 2734 | 49.0сая | 47.5сая 772 | 46.9сая 3318 |
| 3 | Олон хүүхдийн тэтгэмж | 3.5 сая 372өрх | 10.5сая 304өрх | 4.9сая | | 4.2сая 97 |
| 4 | Халамжийн үйлчилгээнд | 2.3 сая | 1.5сая 422 | 3.9сая 1868 | 364.8мян 10 | 2.6сая 364 |
| 5 | Ахмадын хөнгөлөлтөнд | 5.0сая | 12.3сая 552 | 11.5сая 671 | 8027.8м 827 | 1.5сая 1695 |
| 6 | Тахир дутуу иргэдийн хөнгөлөлтөнд | 0.8сая | 1.7сая 34 | 895.9 мян 65 | 4008.0м 238 | 6.9сая 721 |
| 7 | Эхийн одонгийн шагналд | | 420.0 мян | 140.0мя н | 200.0мян 9 хүнд | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*3.2.3. Нэн ядуучуудад зориулан төсвөөс хуваарилсан зардлын хэмжээ, төсөвт эзлэх хувийн жин. / 1998-2002 /*

*1998- 2002 онд орон нутгаас Нэн ядуу иргэдэд зориулан төсөвлөсөн төсөв байхгүй харин гүйцэтгэл байна .*

1. *1998 онд :*

- *Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар 13 хүнд 188.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон.*
- *Аймгийн Засаг даргын захирамжаар 1 хүнд 20.0мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.*
- *Мөн орон нутгийн төсвөөс халамжийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 850.0 мянган төгрөг зарцуулсан.*

*Нийт 1.058.0 мянган төгрөг зарцуулжээ.*

2. *1999 онд :*

- *Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар 9 хүнд 125.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон.*
- *Аймгийн Засаг даргын захирамжаар 1 хүнд 40.0мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.*
- *Мөн орон нутгийн төсвөөс халамжийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 804.0 мянган төгрөг зарцуулсан*

*Нийт 969.0 мянган төгрөг зарцуулжээ.*

3. *2000 онд :*

- *Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар 7 хүнд 58.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон.*
- *Аймгийн Засаг даргын захирамжаар 4 хүнд 130.0мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.*
- *Мөн орон нутгийн төсвөөс халамжийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 960.0 мянган төгрөг зарцуулсан*

*Нийт 1.148.0 мянган төгрөг зарцуулжээ.*

4. *2001 онд :*

- *Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц сангаас 6 хүнд 75.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон.*
- *Аймгийн Засаг даргын захирамжаар 7 хүнд 340.0мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.*
- *Аймгийн Засаг даргын захирамжаар хүнд 300.0мянган төгрөгийн гэр олгосон.*
- *Шивээговь сумын Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц сангаас 9 хүнд 146.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон.*
- *Мөн орон нутгийн төсвөөс Баясал халамжийн цэцэрлэгийн 25 хүүхдийн хоолны зардалд 600.3 мянган төгрөг зарцуулсан.*

*Нийт 1.461.3 мянган төгрөг зарцуулжээ.*

5. *2002 онд :*

- *Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц сангаас 14 хүнд 199.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон.*
- *Аймгийн Засаг даргын захирамжаар 13 хүнд 462.0мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.*
- *Шивээговь сумын Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц сангаас 11 хүнд 160.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон.*
- *Мөн орон нутгийн төсвөөс Баясал халамжийн цэцэрлэгийн 25 хүүхдийн хоолны зардалд 832.9 мянган төгрөг зарцуулсан.*
- *Өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангаж чадаагүй 120 гаруй нэн ядуу өрхөд аймгийн Засаг даргын зүгээс 2 вагон нүүрс буюу 120тн нүүрс , 40 гаруй өрхөд хүнсний зүйл тус тус олгож 1200.0 мянган төгрөг зарцуулжээ.*

UIH.MN
ЧУУЛГАНЫ САН

- *Зээр агнаж ядуу, нэн ядуу хүмүүст олгосон. Бензины зардалд 60.0 мянган төгрөг зарцуулсан байна.*

*Нийт 2.913.9 мянган төгрөг зарцуулжээ.*

| № | | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн төсвийн зарлага /сая/ | 934.3 сая төг | 919.6 сая төг | 1.087.3 сая төг | 1.590.6 | 1.521.5 |
| 2 | Нэн ядуу иргэдэд зориулсан зардлын хэмжээ | 1.058.0 мян төг | 969.0 мян төг | 1.148.0 мян төг | 1.461.3 мян төг | 2.913.9 мян төг |
| 3 | Төсөвт эзлэх хувийн жин | 0.11% | 0.1% | 0.1% | 0.09% | 0.2% |

*3.2.3. Нэн ядуучуудад зориулсан хөтөлбөр, зохион байгуулсан үйл ажиллагаа /ажлын байртай болгох, орон байртай болгох, малжуулах бусад/ 1998-2002.*

*Нэн ядуучуудад зориулан ЯБҮХөтөлбөр, олон улсын " Жей-Си- Эс " байгууллагын зохион байгуулсан " Хүнс – гэр – түлээ " төслүүд хэрэгжсэн байна.*

1. *1998 онд*
   a. *ЯБҮХөтөлбөрийн хүрээнд :*
   - *ЭБОНСангийн 9 өрх 1490.0 мянган төгрөгийн зээл авч ажлын байртай болсон байна.*

2. *1999 онд*
   a. *ЯБҮХөтөлбөрийн хүрээнд :*
   - *ЭБОНСангийн 51 төсөл 12.3 сая төгрөгийн санхүүжилт хийж иргэн ажлын байртай болсон байна.*
   - *Аймгийн нэн ядуу иргэдэд туслах сангаас АБТДО-той өрхийн хэвтэр байгаа 10 өндөр настанд тус бүр 10 мянган төгрөгийн буцалтгүй тусламж., хөхний рактай 1 эмэгтэйд 50 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, хоол ,хүнс, мал худалдаж авахад нь тусламж болгож 47 өрхийн 217 хүнд 895340 мянган төгрөгийг зарцуулсан байна.*

3. *2000 онд*
   a. *ЯБҮХөтөлбөрийн хүрээнд:*
   - *Үндсэн болон эргэлтийн сангийн 72 төсөлд 216 хүнийг хамруулж ажлын байртай болгосон.*
   - *НЯИТСангаас 6 уут хүнсний ногооны үрийг сумдад хуваарилсан, аймгийн хэмжээнд нэн ядуу 14 өрхөд 475.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж , 92 хүүхдэд тусламжийн хувцас / 177.6 мян.төг /, эрүүл мэндийн үзлэгт 97 хүн , орон гэргүй 1 өрхөд гэр , 314 хүнд хоол, хүнс, хичээлийн хэрэглэл /371.0мян.төг/ , 15 өрхөд 7м мод, 19тн нүүрс олгов.*

4. *2001 онд*
   a. *ЯБҮХөтөлбөрийн хүрээнд :*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- *Сүмбэр , Шивээговь сумдын ЭБОНСангаас 68 төсөлд 19 сая төгрөгийн , ХЭХ-ны салбар хорооны идэвхжүүлэгч төсөлд 1.5 сая төгрөгийн , АСЗХ-ны идэвхжүүлэгч 3 төсөлд 1.5 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийсэн байна.*
- *Жижиг зээлд 164 хүн хамрагдан ажлын байртай болсны 104 нь эмэгтэй, 18 нь тахир дутуу иргэд байна.*

*б. " Хүнс – гэр – түлээ " төслийн хүрээнд :*

- *Аймгийн хэмжээнд нэн ядуу 3 өрхөд гэр 1.8 сая төгрөг, 110 өрхөд хүнс 2.8 сая төгрөг, 17 өрхөд түлээ 680.0 мянган төгрөг зарцуулжээ.*

5. *2002 онд*

*а. ЯБҮХөтөлбөрийн хүрээнд*

- *Аймгийн хэмжээнд " Эргэлтийн сан" –гаас орлого нэмэгдүүлэх чиглэлээр 164 төсөлд 48.4 сая төгрөгийн санхүүжилт хийж, жижиг зээлд 340 хүн хамрагдан ажлын байртай болсны 7.3 хувь нь тахир дутуу иргэд, 57.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт эмэгтэйчүүдийн 14.2 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.*

*Б. " Хүнс – гэр – түлээ " төслийн хүрээнд :*

- *160 нэн ядуу иргэдэд ногооны үр үнэгүй тараан хүнсний ногоо тариалах ажилд хамруулан түр ажлын байраар хангасан юм.*

*3.2.6. Нэн ядуу иргэдийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байдал.*

*Ядуурлыг арилгах олон улсын өдрүүдийг 1996 оноос хойш жил бүр тэмдэглэдэг уламжлал тогтсон байна.*

*Өмчийн болон хувийн хэвшлийн ААН болон нийт иргэдийн анхаарлыг нийгмийн эмзэг хэсгийнхэнд хандуулж туслах хөдөлгөөнийг өрнүүлснээр 1996-2000 онд аймгийн хэмжээнд 14.0 сая төгрөгийн төрөл бүрийн тусламжийг давхардсан тоогоор 4500 гаруй иргэдэд хүргэсэн байна.Дээрх хөрөнгийг 3 сум, 60 гаруй ААНБайгууллага, ажиллагсад, иргэдээс хуримтлуулсны 859.5 мянган төгрөгийг аймаг, сумын НЯИТСанд хандив, нэн ядуу иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулахад 270.0 мянган төгрөг, эм, үзвэр үйлчилгээнд 496.5 мянган төгрөг, гутал, хувцасны хангамжийг сайжруулахад 3.4 сая төг, хоол хүнсний хангамжийг сайжруулахад 3.3 саятөг, хичээлийн хэрэглэлд 356.3 мянган төг, тахир дутуу иргэдэд 150.0 мян төг, түлээ түлшний хэрэгцээг хангахад 3.9 сая төг , хүмүүст шууд олгосон бэлэн мөнгөний тусламж 1.0 сая төг зарцуулжээ.*

*Жил бүр нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргаж , ядуу иргэдэд сургалт, урлаг, уран сайхан, эмнэлэг , халуун ус зэрэг үйлчилгээг нэн ядуу иргэдэд үзүүлдэг.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*3.3.1 Аймгийн нийгмийн халамжийн байгууллага нэн ядуу иргэдийн халамж үйлчилгээний зардалд төсөвлөсөн , батлагдсан төсөв, зарцуулалтын байдал.*

*1998 он.*

*Орон нутгийн төсвөөс Нийгмийн халамж үйлчилгээний хэрэгжилтэнд 3.5 сая төгрөг батлаж өгснөөс 1.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн дутагдлаас болж үлдэгдэл төгрөгийг олгоогүй болно.*

*Төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс 320 гаруй хүнд 2.3 сая төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн орон нутгийн төсвөөс халамжийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 850гаруй мянган төгрөг зарцуулсан*

*байна. Ядуурлыг бууруулах сарын ажлын хүрээнд " Хариу нэхээгүй тус " уриан дор аймгийн ЯБЗөвлөлтэй хамтран нэн ядуу иргэдэд халамжийн туслалцаа үзүүлэх ажил зохион байгуулж аймгийн хэмжээнд 6354.2 мянган төгрөгийн төрөл бүрийн тусламжинд 2112 нэн ядуу иргэд хамрагдсан байна.*

*1999 он.*

*Орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардалд 3600.0 мянган төгрөг батлуулснаас 3001.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Нэн ядуу иргэдийн үйлчилгээнд 422 хүнд 1472.5 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүллээ.Аймгийн 2-р цэцэрлэгт халамжийн бүлэг ажиллуулж орон нутгийн төсвөөс хоолны зардалд 804.0 мянган төгрөг зарцуулсан байна. Аймгийн нэн ядуу иргэдийг туслах сангаас АБТДО-той өрхийн хэвтэрт байгаа 10 өндөр настанд тус бүр 10.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, хөхний рактай нэг эмэгтэйд 50.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, хоол, хүнс мах, будаа, гурил худалдах авахад нь тусламж болгож 47 өрхийн 217 хүнд 895.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.*

*2000 он.*

*Энэ онд орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардалд 3502.6 мянган төгрөг батлуулнаас 5210.2 төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Нэн ядуу иргэдийн халамжийн үйлчилгээнд 1868 хүнд 3954 .0 мянган төгрөг зарцуулснаас хүнсний зүйл 1800 хүнд 3400.0 мян/ төг, 68 хүнд мөнгөн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн байна.*

*Аймгийн 2-р цэцэрлэгт халамжийн бүлэг ажиллуулж орон нутгийн төсвөөс хоолны зардалд 960.0 мян/ төгрөгийг зарцуулсан байна.*

*Тахир дутуу иргэдийн судалгааг аймгийн хэмжээнд явуулж судалгаагаар 251 тахир дутуу иргэд байгаагаас 146 нь эмэгтэй иргэд байна.Тахир дутуугийн тэргэнцэр 5 хүнд олгож 750.0 мян/төг , рашаан сувилалын үйлчилгээнд 1 хүнд 22.9 мян/ төг эх үрсийн баярыг тохиолдуулан эхчүүд болон өнчин 50 хүүхдэд 75.0 мян/ төгрөгийн бэлэг гардуулж бүгд 65 хүнд 895.9 мян төгрөгийг зрцуулсан байна.*

*2001 онд:*

*2001 онд төвлөрсөн төсвөөс 93810.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1000.0 мян/ төг-ний санхүүжилт авч зарцуулав.*

*Нэн ядуу иргэдийн халамжийн үйлчилгээнд 10 хүнд 364.8 мян төгрөгийг зарцуулсан.Үүнд:*

*Нэн ядуу өрх толгойлсон 1 эмэгтэйд 160.0 мян/ төг-ний 2 өрөө байр авч өгсөн. Нэн ядуу амьдралтай 9 хүнд 204.8 мян/ төг-ийн мөнгөн тусламж олгов.Баясал цэцэрлэгийн халамжийн бүлгийн 25 хүүхдийн хоолны мөнгөнд 600.3 мян/ төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан.*

*2002 он:*

*2002 онд орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардалд 7647.4 мянган төгрөгийг зарцуулсан.*

*Халамжийн сангаас нэн ядуу иргэдэд үзүүлэх халамж үйлчилгээнд 182 хүнд 1656.4 мян/ төг , ахмад настанд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээнд 182 хүнд 960.6 мян/ төг-ийг тус тус зарцуулж, бүгд 364 хүнд 2617.1 мян/ төгрөгийн халамжийн үйлчилгээ хүргэсэн байна. Орон нутгийн төсвийн сангаас нэн ядуу 25 өрхийн 25 хүүхдийг цэцэрлэгт хамруулан хоолны үнэд 832.9 мян/ төгрөг зарцуулав.*

*Өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангаж чадаагүй 120 гаруй нэн ядуу өрхөд Аймгийн Засаг даргын зүгээс 2 вагон нүүрс буюу 120тн нүүрс, 40 гаруй өрхөд хүнсний зүйл тус тус олгож 1200.0мян. төгрөгийг зарцуулсан байна.*

UILMN
СУДАЛГААНЫ САН

# ДҮГНЭЛТ

ГовьсҮмбэр аймаг нь байгуулагдсанаасаа хойш буюу 1991 оноос хойш 2000 он хүртэл нэн ядуу иргэдийн дэлгэрэнгүй судалгааг Статистикийн хэлтсээс албан ёсоор гаргадаг байсан байна.

Харин 2001 оноос хойш гаргахаа больсон байна. Иймд 2001, 2002 онуудын судалгааг багийн дарга нараас авсан.

Энэхүү судалгаанд хамрагдсан нэн ядуу иргэдийг өрхөөр нь болон хүний тоогоор авч үзвэл дунджаар аймгийн хэмжээнд нэн ядуу нэг өрхөд нэн ядуу 4,4 хүн оногдож байна. Өөрөөр хэлбэл нэг өрх нь 4 хүнтэй байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн насны дундаж нь .... байна. Нэн ядуу өрх болон хүний тоо 1998-2002 оны хооронд бага зэргийн өөрчилөлт орсон болохоос огцом өөрчилөлт төдийлөн гарсангүй. Сумдын хувьд Сүмбэр суманд нэн ядуу иргэн болон өрхийн тоо /2000 оныг эс тооцвол/ буурсан үзүүлэлттэй байхад Шивээговь суманд 1998-2000 онд өсч түүнээс хойш буурсан байна. Харин Баянтал суманд жил дараалан өссөөр иржээ.

Хүмүүсийн ядууралд өртөж байгаагийн гол шалтгаан нь ган, зуд, мөн ажилгүйдэл ажлын байр байдаггүйтэй ихээхэн холбоотой байна. Жил дараалан болсон ган зудад нэрвэгдэж малаа барсан иргэд төв суурин газарт олноороо нүүн суурьшиж амьдрах болсон бөгөөд эдгээр хүмүүс нь мал маллахаас өөр ажил хийж байгаагүй эзэмшсэн мэргэжилгүй зэрэг нь ажилд ороход улам ч төвөг учруулж байна.

2002 оны байдлаар аймгийн нийт өрхийн 11,0% нь нэн ядуу, нийт хүн амын 12,2% нь нэн ядуу гэсэн ангилалд багтаж байна.

Энэхүү судалгаанд ашиглагдаж байгаа тоо баримтын хувьд 2 мэдээллийн эх үүсвэр авч ашигласан бөгөөд эдгээр эх сурвалжуудын хооронд зарим талаараа нилээд зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Тухайбал ЯБЗ-өөс нэн ядуу иргэд болон өрхийн судалгаа нь Сумдын Багийн Засаг дарга нарын гаргасан судалгааны тооноос нилээд зөрүүтэй байна. Үүнд: Ядуурлын улсын үзлэгээс гаргасан тоонд нийт 420 өрхийн 2218 хүн байхад Багийн засаг Дарга нарын гаргасан судалгаанд 377 өрхийн 1627 нэн ядуу хүн байна гэсэн тоо гарчээ.

Тус аймагт 1996-2000 онд ЯБҮХ хэрэгжсэн бөгөөд 2001 оноос ӨАЧДҮХ ажиллаж байна. ЯБҮХ-нь 1996-2000 оны хооронд Дэлхийн банк, СИДА, ГЗГ-зэрэг байгууллагын тусламжтайгаар 98452,4 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн байна. Эдгээр төсөл нь: сум орон нутгийн тохижилт, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролыг дэмжих, хандив зээл тусламж, малгүй болсон айл өрхийг малжуулах, зэрэгт зориулагджээ.

1998-2002 оны хооронд нэн ядуу иргэдэд буцалтгүй тусламж олгосон аймгийн Засаг даргын 21 захирамж гарсан бол

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Сүмбэр сумын Засаг даргын захирамж 49, Шивээговь сумын Засаг даргын захирамж 15 гарсан байна.

Орон нутгийн төсөвт нэн ядуу иргэдэд зориулсан хөрөнгө мөнгөний эзлэх хувь 1998 онд 0,11%, 1999 онд 0,1%, 2000 онд 0,1%, 2001 онд 0,09%, 2002 онд 0,2 болон өсжээ.

Ядуурлыг арилгах олон улсын өдрийн хүрээнд 1996-2000 онд аймгийн хэмжээнд 14,0 сая төгрөгийн тусламжийг давхардсан тоогоор 4500 гаруй иргэнд хүргэсэн байна. Дээрхи тусламжийн 859,5 мянган төгрөгийг аймаг, сумын НЯИТСанд хандив, 240,0 мянган төгрөгийг нэн ядуу иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулахад, 496,5 мянган төгрөгийг эм, үзвэр үйлчилгээнд, 3,4 сая төгрөгийг гутал хувцасны хангамжийг сайжруулахад, 3,3 сая төгрөгийг хоол хүсэнд, 356,3 мянган төгрөгийг хичээлийн хэрэглэлд , 150,0 төгрөгийг тахир дутуу иргэдэд, иргэдийн түлээ түлшний хангамжинд 3,9сая төгрөг олгосон бол хүмүүст шууд бэлнээр 1,0 сая төгрөг зарцуулжээ. Нэн ядуу иргэдэд нэг удаа өмсөөд урагдах хувцас юмуу нэг удаа идээд цадах хоолноос илүүтэй ажлын байр, ажил хийх арга барилд сургавал төслийн болон тусламжийн хөрөнгө илүү үр дүнтэй зарцуулагдаж магадгүй юм.

Анкетаар авсан судалгаанд 58%-нь эмэгтэй, харин 42%-нь эрэгтэй хамрагдлаа. Боловсролын хувьд зөвхөн нэг хувь буюу нэг л хүн дээд боловсролтой харин бусад хэсэг нь бага буюу дунд боловсролтой байгаа нь хүний амьжиргаанд боловсрол үлэмж нөлөөтэйг харуулж байна. Мөн гэр бүлийн хувьд 59%-нь гэрлэсэн үлдсэн хэсэг нь гэрлээгүй буюу салсан бэлбэсэн байгаа нь гэр бүлийн хувьд төдийлөн тогтворгүй мэт. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд дөнгөж 9% буюу 16 хүн л хөдөлмөр эрхэлж үлдсэн хэсэг нь вагонд хоол цай зарах, лааз, шил, хог түүх, вагоноос нүүрс буулгах, тоосго, кремзит ухах зэргээр амьжиргаагаа залгуулхын зэрэгцээ тэжээгчээ алдсаны , тахир дутуугийн нярайн, нийгмийн халамжийн, өндөр настны зэрэг тэтгэвэр, тэтгэмжийг орлогын гол эх үүсвэрээ болгодог байна. Эрүүл мэндийн даатгалд 75% нь хамрагдаж 25% нь хамрагдаагүй байна. Судалгаанд хамрагсдын 63 буюу 36% нь архаг хууч өвчтэй, 64% нь ямар нэгэн архаг хууч өвчингүй гэсэн бол 5% нь ямар нэгэн архаг хууч өвчтэй эсэхээ мэддэггүй байна. Энэ нь эрүүл мэндийн үзлэгт хамрагддаггүй зэрэгтэй холбоотой биз.

Судалгаанд хамрагдагсад нэн ядуу байдлаас гарахад хамгийн чухал хүчин зүйл юу вэ? төрөөс ямар дэмжлэг үзүүлбэл зохимжтой вэ гэсэн асуултанд дийлэнхи олонхи нь мэргэжил олгох сургалтанд хамрагдах, ажил хийх, шинээр ажлын байр бий болгох хэрэгтэй гэх зэргээр хариулсан байна.

UILMN СУДАЛГААНЫ САН

# Дархан-Уул аймгийн нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлын судалгааны тайлан

## 1. Нэн ядуу иргэдийн талаарх тоо баримт, бичиг баримт, холбогдох материалд судалгаа хийсэн байдал

Дархан-Уул аймгийн суурин хүн амын байдлыг нас, хүйс, сумдаар гаргасан статистик мэдээгээр үзүүлбэл:

| Насны бүлэг | Аймгийн дүн | | | Дархан сум | | | Хонгор сум | | | Орхон сум | | | Шарын гол сум | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Хүйсээр | | Бүгд | Хүйсээр | | Бүгд | Хүйсээр | | Бүгд | Хүйсээр | | Бүгд | Хүйсээр | |
| | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм |
| 0-19 | 35243 | 17905 | 17338 | 27254 | 13739 | 13515 | 2879 | 1460 | 1419 | 1584 | 837 | 747 | 3526 | 1872 | 1597 |
| 20-39 | 29853 | 14022 | 15831 | 24215 | 11249 | 12966 | 1700 | 847 | 833 | 1119 | 563 | 536 | 2859 | 1363 | 1496 |
| 40-59 | 18129 | 8802 | 9327 | 15024 | 7351 | 7673 | 863 | 427 | 436 | 556 | 254 | 302 | 1686 | 770 | 925 |
| 60-аас дээш | 5299 | 2519 | 2787 | 4302 | 2028 | 2274 | 311 | 151 | 160 | 250 | 138 | 112 | 445 | 203 | 242 |
| **Бүгд** | **88524** | **43248** | **45283** | **70795** | **34367** | **36428** | **5753** | **2885** | **2848** | **3509** | **1792** | **1697** | **8516** | **4208** | **4260** |

Үүнээс Дархан-Уул аймгийн хэмжээнд байгаа нэн ядуучуудын тоо, хүйсийн байдлыг сумдын хэмжээнд 1998-2002 оноор харуулбал:

***Дархан сумын хэмжээнд:***

| Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо | | 1998 он | 1999 он | 2000 он | 2001 он | 2002 он |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | | 2 941 | 3 076 | 4 749 | 6 871 | 6 401 |
| Хүйсийн байдал | Эр | 1 216 | 1 264 | 2 049 | 2 980 | 2 677 |
| | Эм | 1 725 | 1 812 | 2 700 | 3 891 | 3 724 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

***Шарын гол сумын хэмжээнд:***

| Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо | | 1998 он | 1999 он | 2000 он | 2001 он | 2002 он |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | | 1 014 | 1 120 | 1 073 | 1 131 | 1 118 |
| Хүйсийн байдал | Эр | 378 | 570 | 483 | 511 | 506 |
| | Эм | 636 | 550 | 590 | 620 | 612 |

***Орхон сумын хэмжээнд:***

| Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо | | 1998 он | 1999 он | 2000 он | 2001 он | 2002 он |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | | 852 | 749 | 614 | 461 | 419 |
| Хүйсийн байдал | Эр | 341 | 300 | 246 | 215 | 168 |
| | Эм | 511 | 449 | 368 | 276 | 251 |

***Хонгор сумын хэмжээнд:***

| Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо | | 1998 он | 1999 он | 2000 он | 2001 он | 2002 он |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | | 273 | 302 | 297 | 287 | 312 |
| Хүйсийн байдал | Эр | 106 | 121 | 117 | 111 | 123 |
| | Эм | 167 | 181 | 180 | 176 | 188 |

***Дархан –Уул аймгийн хэмжээнд:***

| Аймгийн хэмжээнд байгаа нэн ядуучуудын тоо | | 1998 он | 1999 он | 2000 он | 2001 он | 2002 он |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | | 5080 | 5247 | 6733 | 8750 | 8250 |
| Хүйсийн байдал | Эр | 2041 | 2255 | 2895 | 3817 | 3474 |
| | Эм | 3039 | 2992 | 3838 | 4963 | 4776 |

Дээрх аймгийн хэмжээний нийт хүн амын тоог 2002 онд бүртгэгдсэн нэн ядуу хүмүүсийн нийт хүн амд эзэлж буй хувийн жинг тодорхойлбол:

| Аймаг сумын хүн ам | Дархан-Уул аймаг | | | Дархан сум | | | Орхон сум | | | Хонгор сум | | | Шарын гол сум | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эр | Эм | Бүгд | Эр | Эм | Бүгд | Эр | Эм | Бүгд | Эр | Эм | Бүгд | Эр | Эм |
| | 88254 | 43248 | 45283 | 70795 | 34367 | 36428 | 3509 | 1792 | 1697 | 5753 | 2885 | 2848 | 8516 | 4208 | 4260 |
| Нэн ядуу хүмүүс | 5.7% | 8.0% | 10.5% | 7.2% | 6.1% | 8.2% | 11.9% | 9.3% | 14.7% | 5.5% | 4.2% | 6.6% | 13.1 % | 12.0% | 14.3 % |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Нэн ядуучуудад зориулан төсвөөс хуваарилсан зардлын хэмжээ, төсөвт эзлэх хувийн жин

| Нэн ядуучуудад зориулан төсвөөс хуваарилсан зардлын хэмжээ, төсөвт эзлэх хувийн жин | Дархан сум | Шарын гол сум | Орхон сум | Хонгор сум |
|---|---|---|---|---|
| 1998 он | 0.09% | 0.9 % | 18459.6 | 42.2<br>0.03% |
| 1999 он | 0.03% | 0.5% | 18459.6 | 62.0<br>0.1% |
| 2000 он | 0.04% | 0.4% | 23275.3 | 59.3<br>0.02% |
| 2001 он | 0.02% | 0.2% | 28736.0 | 1629.4<br>0.8% |
| 2002 он | 0.02% | 0.3% | 24784.9 | 815.0<br>0.2% |

Дархан-Уул аймгийн нэн ядуу иргэдийн өрхийн дундаж орлого /1998-2002 он/

| Өрхийн дундаж орлого | Дархан сум | Орхон | Хонгор | Шарын гол | Аймгийн хэмжээний дундаж |
|---|---|---|---|---|---|
| 1998 он | 11552 | 2200 | 19858 | 3980 | 7518 |
| 1999 он | 18455 | 3100 | 22030 | 5308 | 9778 |
| 2000 он | 18000 | 2900 | 21961 | 5320 | 9636 |
| 2001 он | 20000 | 4800 | 21950 | 5560 | 10462 |
| 2002 он | 24123 | 9000 | 22740 | 6720 | 12516 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Аймгийн хэмжээнд нэн ядуу иргэдийн боловсролын байдал /1998-2002 он/

***Дархан сум***

| Боловсрол | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Дээд | 39 | 58 | 92 | 156 | 120 |
| Тусгай дунд | 98 | 104 | 336 | 316 | 436 |
| Бүрэн дунд | 879 | 952 | 1398 | 2081 | 1581 |
| Бүрэн бус дунд | 1322 | 1325 | 1819 | 2589 | 2431 |
| Бага | 336 | 353 | 678 | 1353 | 1141 |
| Боловсролгүй | 267 | 284 | 426 | 381 | 692 |

*Орхон сум*

| Боловсрол | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Дээд | - | - | - | - | - |
| Тусгай дунд | 3 | 3 | 3 | 3 | - |
| Бүрэн дунд | 28 | 15 | 11 | 13 | 13 |
| Бүрэн бус дунд | 745 | 655 | 524 | 369 | 330 |
| Бага | 50 | 50 | 50 | 50 | 50 |
| Боловсролгүй | 26 | 26 | 26 | 26 | 26 |

*Хонгор сум*

| Боловсрол | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Дээд | - | - | - | - | - |
| Тусгай дунд | 2 | 3 | 5 | 8 | 7 |
| Бүрэн дунд | 116 | 107 | 101 | 113 | 103 |
| Бүрэн бус дунд | 103 | 130 | 122 | 106 | 121 |
| Бага | 40 | 48 | 55 | 49 | 66 |
| Боловсролгүй | 12 | 14 | 14 | 11 | 16 |

*Шарын гол сум*

| Боловсрол | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Дээд | - | 1 | 1 | 1 | 1 |
| Тусгай дунд | 8 | 10 | 5 | 8 | 6 |
| Бүрэн дунд | 61 | 75 | 67 | 68 | 73 |
| Бүрэн бус дунд | 399 | 318 | 289 | 304 | 299 |
| Бага | 333 | 340 | 373 | 346 | 357 |
| Боловсролгүй | 213 | 376 | 338 | 404 | 382 |

UIH MN
СУДАЛГААНЫ САН

*Дархан-Уул аймгийн хэмжээнд /1998-2002 оны байдлаар/*

| Боловсрол | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|
| Дээд | 39 | 59 | 93 | 157 | |
| Тусгай дунд | 111 | 120 | 349 | 335 | 449 |
| Бүрэн дунд | 1533 | 1149 | 1577 | 2275 | 1770 |
| Бүрэн бус дунд | 2569 | 2420 | 2754 | 3365 | 3181 |
| Бага | 759 | 791 | 1156 | 1798 | 1614 |
| Боловсролгүй | 518 | 700 | 804 | 822 | 1116 |

1998-2002 онуудад Дархан –Уул аймгийн ИТХ, ИТХТ-ийн хурлын тогтоол, хэлэлцсэн асуудлууд, аймгийн Засаг даргын гаргасан захирамж зэрэгт нэн ядуу, амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдтэй холбоотой асуудлуудыг судалж үзэхэд дээрх 5 жилийн байдлаар ИТХ-аар 3 удаа асуудал хэлэлцсэн байна. Үүнд:

1. Хүн амын эмзэг хэсгийг орон сууцаар хангах бодлогод шинэ хуулийн дагуу өөрчлөлт оруулах тухай хэлэлцээд "Орон сууцны талаар баримтлах бодлого батлах тухай 28-р тогтоол"-ыг 1999.1015-нд баталсан.
2. Аймгийн "Ядуурлыг бууруулах дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн талаар 2000.02.11 –нд хэлэлцсэн.
3. Өрхийн амьжиргааны дэд хөтөлбөр батлах тухай 19-р тогтоол 2002.03.06-нд баталсан байна.

Аймгийн "Ядуурлыг бууруулах дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэх хуралдаанд, ЯБЗ-ийн нарийн бичгийн даргын тавьсан тайланд: "Орон нутагт нийтийг хамарсан ажилд 55.1 сая төгрөг зарцуулж, нийт 445 ажилгүй хүнийг түр ажлын байраар хангасан....Өрх толгойлсон 163 эмэгтэйд болон тэдний цэцэрлэгийн насны 104 хүүхдэд 22.6 сая төгрөг зарцуулсан.....Нэн ядуу иргэдэд туслах чиглэлээр 9.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж, нийт 490 өрхөд хоол хүнс, дулаан хувцас, нарийн ногооны үр зэргийг тараасан" гэж дурьджээ. Мөн цаашид авах авч хэрэгжүүлэх бодлого чиглэлийн талаар: "...нэг удаагийн буцалтгүй тусламж нь ядуу иргэдэд бэлэнчлэх сэтгэлгээг төрүүлж байна, иймд нэг удаагийн хоол хувцсаар тэтгэх биш, *амьдрах ухаанд сургах, ажлын байр олноор бий болгох чиглэлд түлхүү анхаарах нь* зүйтэй" гэж дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2002 оны 01.31-ний 28 тоот захирамжаар Дархан сумын 5 дугаар багийн 54-р брак байранд гал гарсны улмаас гэр орон нь шатаж, хүнд гарз хохирол учирсан нэр бүхий 8 хүнд тус бүр 30.0 мянган төгрөг нийт 240.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгохоор, нэн ядуу амьдралын гачигдалтай 28 хүнд нийт 710 000 төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

Аймгийн хэмжээнд ядуурлын үзлэг зохион байгуулах комисс байгуулах тухай 2001.04.26 –нд, аймгийн хэмжээнд орц, хонгил, траншейгээр амьдардаг иргэдийн нэгдсэн судалгаа гаргаж ажил зохион байгуулах комиссыг батлах, тус комисст арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах тухай 2002.12.16-ны 390 тоот, "Ядуу эхийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах" төслийг дэмжиж, багийн бүрэлдхүүнийг батлах тухай, төсөлд дэмжлэг үзүүлж шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгох тухай 2002.05.14-ны 159 тоот, мөн нэн ядуу харах хүнгүй ганц бие ахмад настан 2 хүнийг улсын асрамжийн газарт явуулах тухай захирамжийг тус тус гаргажээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Аймгийн Засаг даргын 2002 оны 12 сарын 16-ны 390 тоот захирамжийн дагуу орц, хонгил, траншейгээр амьдардаг иргэдийн судалгаа гаргаж, тэдгээр хүмүүсийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Хүүхдийн төлөө төв, Дулааны шугам сүлжээний газар, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, багийн Засаг дарга нар, эмч нар зэрэг байгууллагууд хамтран 7 хэсэг болж, нийт 28 хүний бүрэлдхүүнтэй ажилласан байна.Тус арга хэмжээний үеэр орц, хонгил траншей, вокзалд тэнүүчлэн амьдардаг 22 бүртгэгдсэн байна.Үүнд:

| | Эрэгтэй | Эмэгтэй | Хүүхэд | |
|---|---|---|---|---|
| Бүгд 22 хүнээс | | | Эр | Эм |
| | 9 | 3 | 8 | 2 |

ТРАНШЕЙ арга хэмжээнд хамрагдсан хүмүүсийг хооллох, ариун цэврийн хэрэгслээр хангах, орон нутагт нь буцаах зэрэг зардалд Дархан сумын ЗДТГ-аас нийт 104 752 мянган төгрөг зарцуулжээ. Траншейд хөл нь гэмтсэний улмаас эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй удаж, улмаар удаан хэвсэнээсээ болж сүүж нь цоорч, доод мөч нь мэдээгүй болсон хүн ч байжээ. Бүртгэгдсэн хүмүүст эрүүл мэндийн үзлэг хийсэн их эмч Оюуны тайланд:

Үзлэгт хамрагдсан хүмүүсээс:

1. уушигны сүрьеэ өвчтэй 3
2. сэтгэцийн болон оюун ухааны хомсдолтой 4
3. тэмбүү өвчтэй 1
4. заг хүйтэн өвчтэй 1
5. хамуутай 2
6. доод мөч нь мэдээгүй болсон 1
7. элэгний архаг үрэвсэл /церрозтой/ 1

**Бүгд өвчтэй 13 хүн**

Тэдгээр хүмүүсийг хооллож, усанд оруулж, хувцас үнэгүй эм бэлгэвч тараасан төгөөд, зарим хүмүүсийг хамаатан садан, харгалзан дэмжигчдэд нь хүлээлгэн өгсөн. Холоос ирээд буцах зардалгүй байгаа хүмүүст нь буцах замын тасалбарыг худалдан авч өгөх гэх зэргээр нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна.Элэгний церроз өвчтэй, доод мөч нь мэдээгүй болсон 2 хүнийг эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэхээр шийдвэрлэжээ.

Дээрх хүмүүсийг бүртгэл судалгаанд хамруулж, нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулсан ч, уг ажлын талаарх тайлан мэдээнд дурьдсанаар: ямар нэгэн гэм зэмгүй “хүмүүсийг баривчлан” саатуулсан нь хүний эрхийг зөрчсөн үйлдэл болжээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст Сууц өмчлөгчдийн холбоодоос байрны орц, подвалд амьдардаг хүмүүсийн судалгааг ирүүлсэн байна. Дархан сумын 5-16-р багуудад 18 СӨХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд, нэн ядуу 154 хүн СӨХ-дын харъяа “жижүүрийн байр” гэх өргөөшөө 1.3м, уртаашаа 2.5м орцны хонгилд байгалийн гэрэл нэвтэрдэггүй, дулаалгагүй, ариун цэврийн хувьд тохиромжгүй нүх адил оромжинд амьдарч байна. Тухайн орцны айлуудаасаа жижүүрүүд орц цэвэрлэсний хөлс 400төг, орцонд жижүүр хийсний хөлс 1000 төг, сард 15 000-19 000 төгрөгний орлого олох ёстой боловч айлууд тэр бүр хөлс мөнгөө цаг тухайд нь өгдөггүй, мөнгөнийхөө оронд мах гурил, хуучин хувцас зэргээр төлбөрөө аргацаах тохиолдол элбэг байдаг тухай орцны жижүүрүүд ярьж байна.

СӨХ-доос Хууль зүйн хэлтэст ирүүлсэн судалгаагаар:

| Бүгд 154 хүн Үүнээс: | Эрэгтэй | Эмэгтэй | Хүүхэд | Бичиг баримтгүй |
|---|---|---|---|---|
| | 78 | 69 | 7 | 50 |

Аймгийн Засаг даргын 2002 оны 05 сарын 14-ний 159 тоот захирамжийн дагуу “Ядуу эхийн хоол тэжээлийг сайжруулах” төсөлд дэмжлэг үзүүлэх, багийн бүрэлдхүүнийг батлах, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг ЗД-ын орлогч Д.Батсүхэд үүрэг олгосон байна. Уг төслийг хэрэгжүүлэх багийн бүрэлдхүүнд аймгийн ЗДТГ-ын НХБХ-ийн ажилтан, Үйлдвэр худалдааны хэлтсийн ажилтан Дархан Гурил тэжээлийн үйлдвэрийн инженер зэрэг хүмүүсээс бүрджээ. Төслийн хэрэгжилтийн талаар аймгийн **Засаг даргын орлогч Д.Батсүхээс** тодруулахад:

- Өнгөрсөн оны 05 сард “Ядуу эхийн хоол тэжээлийн байдлыг” сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Дархан-Гурил тэжээлийн үйлдвэрт, гурилыг төмрийн бэлдмэлээр баяжуулан ядуу, цус багадалттай, тэжээлийн доройтолтой, жиоэмсэн эхчүүдэд өгөхөөр гадаадаас оруулж ирсэн тоног төхөөрөмжөө гурилын үйлдвэрт суурилуулсан боловч, одоо Гурилын үйлдвэр зогссон учир үр дүн нь тааруу байна" гэж ярилаа

Нийгмийн халамжийн төвөөс нэн ядуу иргэдэд үзүүлдэг ямар тэтгэмж, төрөл байгаа талаар **НХТ-ийн дарга Пүрэвдоржтой** ярилцлага хийхэд: "манай байгууллага ядуу хүмүүсийг дараахь төрлийн тэтгэмж үйлчилгээнд хамруулж байна. Үүнд:

- Хүүхэд асарсны тэтгэмж
- Нэн ядуу ахмадуудыг рашаан сувилалд амрахад замын зардлын хөнгөлөлт 50%
- Ажилгүй, орлогогүй ядуу иргэдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулах

Аймгийн НХТ-ийн амралт байдаг, тэнд ч мөн нэн ядуу иргэд амарч байна. Амралтын үйлчилгээний чанар, төлбөр хямд учраас ахмадуудаас гадна жирийн иргэд ч амрах дуртай байдаг. Нэн ядуу гэдгээр цөөн тооны хүмүүс амарсан, ядуу хүмүүсийн хувьд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тэр бүр очиж амрах сувилуулах боломж мөнгө тааруу байдаг шиг байна.Дархан-Уул аймгийн хувьд амьдралын баталгаажих түвшингийн доод хэмжээг 19 700 төгрөгөөр тогтоосон бөгөөд, үүнээсээ 40%-ийн доогуур орлоготой иргэдийг нэн ядуу хүн гэж тооцно гэж тодорхойлж байгаа, гэтэл тэр шалгуурт тэнцэх хүмүүс бараг үгүй юм. Ядуу гэсэн хүмүүсийн орлогыг сонирхоход өдөрт ядаж шил, лааз тушаагаад 500-1000 төгрөгийн орлоготойд тооцогддог. Гэхдээ бодит амьдрал дээр ядуурал нэлээд байнаа. Нэн ядуу хүмүүстээ бид дээрх үйлчилгээг олгодог. Бид жил бүр халамжийн үйлчилгээг жинхэнэ эзэнд нь олгох зорилгоор үзлэг явуулдаг, 2001 онд л гэхэд халамж хүртэх ёсгүй 136 хүний 7.2 сая гаруй төгрөгийн тэтгэмжийг зогсоосон. Үүнд хүүхэд асарсны тэтгэмж, түлээ нүүрсний хөнгөлөлт гэх мэт үйлчилгээг хуулинд заасан үзүүлэлтийн дагуу авах ёстой хүмүүс биш байсан" гэж ярилаа.

Нийгмийн халамжийн төвөөс нэн ядуу хүмүүс 2001-2002 оны байдлаар ямар тэтгэмж, үйлчилгээнд хамрагдсан талаарх тоон үзүүлэлтийг сонирхвол:

| Тэтгэмж, үйлчилгээний төрөл | 2002 онд | | 2002 онд | |
|---|---|---|---|---|
| | Хүний тоо | Мянган төгрөгөөр | Хүний тоо | Мянган төгрөгөөр |
| Нэн ядуу ахмад настны тэтгэвэр | 400 | 47.580.0 | 140 | 16.900.0 |
| Нэн ядуу эхчүүдийн хүүхэд асарсны тэтгэмж | 15 | 897.5 | 58 | 1.399.2 |
| Рашаан сувилалд амрахад хөнгөлөлт | 6 | 177.5 | 33 | 1.038.78 |
| Ядуу ахмадуудад түлээ нүүрсний хөнгөлөлт | 962 | 22.460.0 | 1355 | 59.396.0 |
| Д Ү Н | 1383 | 71.115.0 | 1586 | 78.733.98 |

Аймгийн халамж үйлчилгээний төв нь тэр бүр ядуу хүмүүст хүрэх үйлчилгээ нь хүртээмж муутай, гол төлөв ахмад настнууддаа дээрх үйлчилгээг хамруулахыг хичээдэг гэж ня-бо нь ярьснаас нийгмийн эмзэг хэсгийн бүлэг хүмүүст үйлчилгээ хүргэх ёстой байгууллага нь нийгмийн халамж үйлчилгээний гадна ядуусыг үлдээж байна.

Дархан-Уул аймгийн төвөөс зайдуу гэр хорооллын ядуу иргэдийн хувьд бас нэг тулгамдсан асуудал бол цэвэр усны хэрэглээний тухай юм. Дархан сумын 1-3-р багийн иргэд нийтийн ус түгээгүүрийн газраасаа илүү Хараа голоос усаа авч хэрэглэдэг. Энэ нь иргэдийн ядуу байдалтай холбоотой. Ус түгээгүүрийн газарт 1 л усыг 26 мөнгөөр худалддаг. Гэр хорооллын айлуудын хоногийн усны хэрэглээ нь аймгийн БОХА-ны мэдээнд сүүлийн 3 жилийн ямар байсныг судлахад:

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| 2000 он | 2001 он | 2002 он |
|---|---|---|
| 2.5-4.0 | 3.1-3.5 | 3.2-6.8 |

1 хүн хоногт 250 л ус хэрэглэх стандартын норм хэмжээнээсээ дээрх тоон үзүүлэлт нь 3.6-7.8 дахин бага байна гэж үзэж байна. Аймгийн БОХА-ны орчны эрүүл ахуйч Болормаа "Хараа голын ус нь химийн үзүүлэлтээр нитритийн бохирдолттой, нян судлалын үзүүлэлтээр аюулгүй шаардлагын хэмжээг хангаагүй, эмгэг төрөгч Е-соли ...эрсэн нь гадаргын усны цэврийн ангиллаар 4-р зэргийн бохирдолттой байна. Мөн Хараа голын эрэг ойр орчим нь нь сая үзлэг хийхэд үхсэн нохойн сэг, хатуу хог хаягдлаар бохирдсон байна" гэж ярилаа.Орон сууцанд амьдардаг, төвлөрсөн сисиемээс усаа хэрэглэдэг иргэдийн хоногийн усны хэрэглээ нь 230-430 л байдаг ажээ. Дээрх жишээн дээр иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрх зөрчигдөж байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд нэн ядуу өрхийн хүүхдүүдийг төрийн сангийн зээлээр их дээд сургуульд 2000-2002 онд нийт 1109 хүүхэд суралцуулсан тоо гарчээ.

| 2000 онд | 2001 онд | 2002 онд |
|---|---|---|
| 357 хүүхэд | 372 хүүхэд | 380 хүүхэд |

...г, сум, аймгийн засаг дарга нарын тодорхойлолт шийдвэрээр төрийн сангийн зээлд нэн ядуу өрхөөс суралцуулсан байдагч , бодит амьдралд нэн ядуу маш доогуур амьдралтай хүмүүсийн хувьд хүүхдээ их дээд сургуульд сургах нь байтугай хоногийн хоолоо арай ядан залгуулдаг хүмүүс байх юм.Тэгэхээр энд ядуувтар, нэн ядуу хоёр ойлголтын хооронд нэг их зөрүү гардаггүй бололтой.

**"Ертөнцийг өөрчилье" нийгэмлэг /олон улсын байгууллага/ хүмүүнлэгийн тусламж.** ЕӨН нь Дархан-Уул аймгийн эмзэг бүлгийн хараа хяналтгүй хүүхдүүд, өвчтэй ядуу хүмүүст чиглэсэн олон хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлдэг ОУ-ын буяны байгууллага бөгөөд 2001-2002 оны тухайн байгууллагын ирүүлсэн тайлангаар нийт **259 154 994** төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

- Дархан-Уул аймгийн ЗДТГ-тай хамтран 2001 онд нэн ядуу амьдралтай хүмүүст газар тариалан, мал аж ахуй, мужаан зэрэг хувийн жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор жижиг зээл олгоход **4 200 000** төгрөг зарцуулсан.
- Орхон суманд нэн ядуу өрхийн 26 хүүхдийг цэцэрлэгт хамруулж, тэдний хичээлийн хэрэглэл, бусад хувцас, эд материал, багш нарын цалин зэрэгт **2 457 900** төгрөг зарцуулсан.
- Ядуу болон шаардлага бүхий хүмүүст Дархан-Уул аймгийн ЗДТГ болон Зудын комисстой хамтран шинэ, хуучин хувцас хандивлах ажлыг зохион байгуулж, үүнд нийт 9 725 440 төгрөгийг зарцуулсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**"Дэлхийн зөн" олон улсын байгууллага.**

- 4 эмзэг бүлгийн ядуу өрхөд гэр авч өгсөн, бөгөөд үүнд 1 000 000 төгрөг зарцуулжээ.
- Дархан сумын 2 багийн Ширээ нурууны ойр орчмын хог цэвэрлэх ажлыг багийн Засаг даргатай хамтран зохион байгуулж, 416 хүнийг түр ажлаар хангасан байна.

Дархан-Уул аймагт үйл ажиллагаагаа явуулж буй дээрх 2 байгууллагуудын 2000 оноос хойш ядуучуудад зориулан зарцуулсан зардал нь аймгийн нийт төсөвтэй зарьцуулахад 3.9%-ийг эзэлж байна.

**Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн пастор Нямсүрэн**

"Манай сүмийн сүсэгтнүүдийн 60%-ийг ядуу хүмүүс эзэлдэг. Нийт 240 орчим сүсэттэн байдгаас 5-6 тахир дутуу хүн явдаг. Манай сүмийн хаалгаар тахир дутуу тэргэнцэртэй хүмүүс орох тусгай шат хаалга бий. Урьд жилүүдэд сүмийн ядуу хүмүүст туслах, эм тариа, дулаан хувцас авч өгөхөд зориулж сар бүр 200 000 төгрөг төвөөс ирдэг байлаа. Энэ жилээс салбар бие дааж тусламж үзүүлэх болсон. Сүсүэгтнүүд сард 1 удаа мацаг барьдаг, тэр мөнгөө ядуучуудад өгдөг."

**Христэд итгэгчдийн сүмийн ажилтан Шинэтулга**

"Манай сүмийн Христийн нөхөрлөлд 300 гаруй хүн хамрагддаг. Үүнээс 10 орчим тахир дутуу хүн, 30% нь ядуус, 60% нь хүүхэд залуучууд байна. Сард 30 айлд 7 хоногийн хоол хүнс өгөх маягаар туслалцаа үзүүлдэг. Манай тусламж "дэлхийн зөн" ОУБ-ын шугамаар голдуу айлуудад хүрдэг. Манай сүмд явсан ядуу хүмүүсийн хувьд дотоод сэтгэл нь буюу амьдралыг үзэх үзэл нь өөрчлөгдөж, үүгээрээ дамжин хүн төлөвшиж, ядуу залхуу, хойрго сэтгэлгээнээсээ салж байна" гэж бидэнд ярьсан юм.

**2. Нэн ядуу иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлага**

Байршил: Дархан сумын 15-р багийн Эрчим хүчний 13-р байр.

Энэ байр 1987 онд эрчим хүчний ТМС гэж байхад оюутны дотуур байр байсан. 1997 оноос сургууль нь татан буугдаж, айлуудыг оруулсан бөгөөд ашиглалтанд орсноосоо хойш нэг ч удаа засвар хийгдээгүй. Иргэдийн дунд "Канделярийн" байр гэж нэрлэгддэг, нийгмийн эмзэг давхаргын ядуу айлууд амьдардаг. 4 давхар барилга бөгөөд нийт 116 айл амьдардаг. Айл амьдрах зориулалтгүй нийтийн шүршүүрийн цонхгүй цементэн шалтай өрөөнд хүртэл айл амьдарна.Коридорын шалных нь банз хуучирч хэмхэрсэн, гэрэлгүй харанхуй хонгилоор судалгаа хийхээр явсан С.Алтанцэцэг бид 2 тэмтчиж явахдаа, хугархай шалных нь завсар хий гишгэж унав. Энд бид 3 хүнтэй уулзаж ярилцан, 3 өрхөөр анкетийн асуулга авсан.

***Ямар ажил төрөл эрхэлж, яаж амьдарч байна вэ?***

Тусгай хийсэн ажилгүй, бид шил лааз, яс, пиавар сав цуглуулж тушаадаг. Сүүлийн үед хог шил түүдэг хүмүүс олширч, бидний орлого муудаж байна.Баяр ёслолын дараа арай дээр байдаг.Сургуулийн  2 хүүхэд зах дээр гялгар тор зарж, бидэнд

нэмэр болдог юм. Том хүү маань хятадын шохойн олборлох үйлдвэрт ажилладаг. Тэр үйлдвэр нь байсхийгээд зогсчихдог, тогтмол ажиллахгүй.Амьдрал хүнд л байна, хоосон хонох ч энүүхэнд.Хүнд байна гээд хэндээ хэлэх вэ, хүний төлөө амьдарч байгаа биш.

**Өдөртөө хоол хүнсэндээ юу хэрэглэдэг вэ? Хоол хүнс хэр хүрэлцээтэй вэ?**

Өдөртөө тосгүй хуурай гамбираа л иддэг юм. Өдөрт шулсан яс авах мөнгө олж чадвал ясаа чанаад, шөлөнд нь бантангаа хутгаад иддэг. Цувдай толгой, хавар бас үнэтэй болчихдог, арай ядан хүргэж байна. Баяр ёслолын дараах өдрүүдэд хааяа нэг хямд төсөр мах авч иддэг. Тэр ч сардаа ганц хоёр л тохиолддог доо.

**Бичиг баримт бий юу ? Аваагүй бол ямар шалтгаанаар аваагүй вэ?**

2 хүнд нь иргэний үнэмлэхтэй, нэг нь Баянхонгор аймгаас ирээд 2 жил гаруй болж байна, шилжүүлэггүй учир үнэмлэхээ авч чадаагүй. Шилжин ирэхэд төлдөг 25 000 төгрөгийн хураамжаа төлж чаддаггүй. Эрүүл мэндийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр аль алинд ч байхгүй.

**Ямар нэгэн өвчин хуучтай юу?, Эмнэлгийн тусламж үйлчилгээ авдаг уу? Өрхийн эмчдээ үзүүлдэг үү?**

2 эмэгтэйн нэг нь шулуун гэдэсний шархлаатай, нөгөө нь сав, бөөр нуруу үргэлж өвддөг гэв. Эрэгтэйн хувьд зүрх муутай астамтай, сүүлийн үед тамхи их татсанаас уушиг муудсан байх, үе үе бүгшүүлж ханиалгаж цэр их гардаг гэлээ.

1 эмэгтэйн хувьд өнгөрсөн оны 9 сард эмчид үзүүлж, эм бичүүлж авсан, нөгөө 2 хүн эмнэлгээр ойрын 3 жилд ер үзүүлээгүй, өвдмөөр болохоороо өөрсдөө ойр зуурын эм хааяа авч уугаад аргалдаг гэв. Өрхийн эмч нар биднийг хайхардаггүй, түүгээр явъя гэхээр хувцас хунар муутай болохоор санаа зовоод, эмнэлэг домнолог хөөцөлдөж явж чаддаггүй.

**Амьдрал ядуугаас болж ямар зовлон бэрхшээл ихээхэн учирч байна вэ?**

Өвдөж зовох, өлсөж хоосон хонохоос авахуулаад юу эс мундах вэ?Хамгийн гол нь ядуугаасаа болоод хэдэн хүүхдээ ч олигтой сургуульд сургаж чадахгүй юм. Өдөр нь ирээд хичээл номыг нь давтуулах зав ч байхгүй, зах руу тор заруулах гээд л явуулдаг. Бас л мань шигээ юм болчих вий гэж их санаа зовдог. Сургуулийн 8 –р анги төгссөн том охин байна, түүнийг мэргэжилтэй болгоё, сургууль дамжаанд сургая гэхээр өдрийн лааз, шил цуглуулдаг ажил маань хоцроод хоосон хонох болчих гээд зовлон их байдаг. Бүгдээрээ л гадуур дотуур явж, хог түнхэж байж хоногийнхоо хоолны мөнгийг олохгүй бол, өөр орлогогүй бид хэцүүдэх болно.Тэгээд олны газар олигтой өмсөх хувцасгүй болохоороо сургууль соёлын газраар явахаас ичдэг бололтой юмаа.Албан газраар юм хөөцөлдөөд явахаар зарим ажилтнууд нь илт ялгаварлаж харьцдаг.

Өвчин туссан ч чанартай эмчилгээ хийлгэх мөнгөний чадваргүй болохоор би өнгөрсөн жил сайхан том болсон охиноо шарлахад нь хүндрүүлээд алдсан.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Саяхан би нэг хүнтэй суусан юм. Тэр хүн маань Шарын голд гал командад ажиллаж байхдаа түлэнхийгийн хүнд зэрэгтэй группт орсон. Шарын голын эмнэлэг хөдөлмөрийн чадвар алдалт 70%-тай гэж тогтоосон юм. Тэнд байхдаа мөнгөгүйн болоод группын дэвтрээ дэлгүүрт хоол хүнс зээлснийхээ барьцаанд тавиад авч чадаагүй юм билээ. Тэгээд энд группээ сунгуулах болтол дэвтэргүй учир 50%-ийн хөдөлмөрийн чадвар алдсан гээд тэтгэмж 18 000 төгрөгөөр тогтоогдсон.

**Та бүхэн хэдий үеэс, ямар шалтгаанаар ядуугийн ангилалд орох болов?**

Зах зээлд шилжих шилжилтийн үеэс үйлдвэр, байгууллагууд татан буугдаж, бүтцийн өөрчлөлт хийгдэхэд онц мэргэжил боловсролгүй, мал хуйгүй бид л хамгийн түрүүнд ядуугийн замд орцгоосон. 1 эрэгтэйн хувьд Керамзитэд нормын ажилчин байгаад 1995 оноос үйлдвэр зогсох үед, 1 эмэгтэй Орон сууцанд цэвэрлэгч байгаад 1997 оноос Орон сууцны байгууллага татан буугдахад, нөгөө эмэгтэй Хөдөө эмнэлгийн асрагч хийж байсан, 1996 онд цомхотголд орсон, эдгээрээс шалтгаанаас ядууралд орж эхэлсэн.

**Төр захиргааны байгууллагад хандан ямар нэгэн хүсэлт гаргаж байсан уу? Хүсэлтийг чинь хэрхэн хүлээн авч яаж шийдэж байсан бэ?**

Багийн засаг дарга өнгөрсөн оны 10 сарын үеэр нэг ирж зарим хүмүүстэй уулзсан. Ажил төрөл хийе, жижиг зээл байвал биднийг хамруулах боломж байна уу? гэхэд, бичиг баримтаа аваад хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүл гэсэн хариу өгсөн.Та нарт өгөх бэлэн зээл хаа байна, дандаа юм гуйж байдаг, та нарыг үргэлж тэжээж байх бэлэн хоол төрд хаана байна гэж загнасан. Түүнээс хойш очоогүй.
Малаа болохоор жил бүр тоолоод, им тамга тавиад вакцин тарилга хийгээд байдаг, манийгаа тоож харах бүртгэж судлах хүн цөөн бололтой юм билээ.

**Төр засгийн зүгээс та бүхэнд ямар дэмжлэг хэрэгтэй вэ? Ямар арга хэмжээ авбал ядуурлаас хурдан гарах боломжтой гэж та бүхэн бодож байна вэ?**

Ажлын байрны хэрэгцээ маш их байна. Ямар ч хамаагүй баталгаатай ажил олдвол хийнэ. Манай байранд өрх бүрт нэг нэг шуудай ноос ээрч бай гэдэг ч юмуу, нэг тийм нормтой хөлсөө цаг тухайд нь өгчихдөг ажил өгөөд байвал энд хийх хүн мөн олон байна. Даанч түүнийг зохион байгуулж, энэ олон ажиллах хүчийг ашиглах талын бодлого бодлого дутмаг байна.

Бидэнтэй ярилцсан 41 настай эмэгтэй өнгөрсөн жил баруун гарандаа хагалгаа хийлгэсэн, 3 жилийн өмнө савандаа мөн хагалгаа хийлгэсэн, гэхдээ одоо сав гадагш гарч унждаг, маш зовиуртай гэж байв. Эмчлүүлэх чадалгүй хойно ингээд л явж байна. Одоо 17 настай нэг охин 1-р ангийн хүүтэйгээ байдаг, тэр охин нь 15 настайдаа жирэмсэн болж үр хөндүүлсэн. Түүнээс хойш хүүхдүүдээс ичээд хичээлдээ явахаа больсон, би ч дахиад жирэмсэн болчих вий гээд хааш нь ч гаргахгүй гэртээ хорьдог болсон. Би өөрөө гадуур гарахдаа түгжээд явдаг, нэг ёсны гэрийн хорионд байдаг гэж бидэнд ярилаа. Үнэхээр намайг хааш нь ч гаргадаггүй

гэж охин нь бидэнд хэлсэн юм. Биднийг ороход том болсон охиноо хүний нүднээс илт нуудаг янзтай өрөөнийхөө нэг буланд хаалт маягийн даавууны цаана суулгаж байсан юм.

Тус нийтийн байрны жижиүүр, **зохицуулагчийн ажлыг хийдэг С..** гэдэг эмэгтэйтэй уулзаж ярилцлаа.

"Энэ байранд амьдардаг айлуудын ус, цахилгаан дулааны өр гэж маш их, 1997оноос айлууд орсон цагаасаа хойш дээрх цахилгаан дулааныхаа мөнгийг төлөхгүй явсаар байгаад ийм болчихсон, төлье гээд ч төлөх чадвартай 20 орчим айлаас бусад нь чадваргүй. Тус байрны зөвхөн цахилгааны өр гэхэд л 97 оноос хойш 30 сая төгрөг байгаа, айлууд нь тоолуургүй учраас цахилгааныг задгайгаар биччихдэг бололтой. Энэ байраар явдаг цахилгаан, дулааны байцаагч гэж байхгүй, цаагуураа л бичигдэж байдаг, юун дээр үндэслэж хэдэн төгрөг бичигдэж вэ? гэж хянаж, хайхардаг хүн байхгүй, бүх айлыг нь задгайгаар бичдэг. Энэ он гарсаар хөөцөлдөж байж, бүх айлыг тоолууртай болгосон, одоо 13 айл тоолуургүй байна. Одоо тоолууртай болсноос хойших төлбөрөө цаг, цагт нь хийгээд яв гэсэн шаардлага тавьж байхад, энүүхэн Голомт банкинд очоод мөнгөө тушаадаг хүн байхгүй, залхуу , нөгөөтэйгүүр хувцас хунараасаа ичдэг юм шиг байна лээ. Би л хамаг бичиг цаасны, хөөцөлдөх тушаах юмыг нь амжуулдаг. Намайг айлууд сар бүр 400 төгрөгөөр цалинжуулахаар болсон. Багийн Засаг даргад 30 гаруй айлыг тодорхойлж байж үнэгүй авахуулсан.2002 оны 09 сарын 01-нд сургууль завсардсан 18 хүүхдийг сургуульд явуулнаас одоо 7 нь суралцаж байна, "Энэрэл" цогцолборт багийн даргаар тодорхойлуулаад 13 хүүхэд явуулахад 3 хан хүүхэд Энэрэлд үлдсэн. Эндхийн хүүхдүүд бие биенийгээ уруу татаж, вагоноор их тэнэдэг, тэгж яваад сургуулиасаа гардаг зуршил их бий" гэж ярилаа.

/Нэн ядуу иргэдтэй хийсэн асуулгын анкетыг ард хавсарган явуулав./

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**Дорнод аймаг** **2003 .03.17**

Аймгийн Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөл нь Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр, аймгийн Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих дэд хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт ядуурлыг бууруулж, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар 2002 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан заалтуудыг биелүүлэх зорилттой ажилласан байна.

Энэ зорилтоо хэрэгжүүлэхийн тулд:

- ЯБҮХ-ийн хүрээнд сумдад бий болсон эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх зээлийн эргэн төлөлтийг аймгийн дүнгээр 80 хувьд хүргэх
- Сум бүрт бодит ядуурлын түвшинг 20- иос доошгүй хувиар бууруулах
- “ Тогтвортой амьжиргаа “ төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж , 2 суманд хэрэгжүүлж эхлэх
- Сумдын ӨАЧЗөвлөлийн үйл ажиллагааг иргэдийг бие даан амьдрах арга ухаанд сургах зэрэг асуудлууд орсон байна.

Зорилтыг хүрээнд 2 төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллжээ.

1. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрөөс энэ онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан мөрдөж ажилласан байна. Уг төлөвлөгөөнд 44 асуудал тусгаснаас 41 нь бүрэн, 1 заалт хагас биелж 2 заалт огт хэрэгжээгүй байна.

Хэрэгжээгүй 2 асуудал нь :

- Матад сумын төвийн хүн амыг хүнсний хэрэгцээний усны найдвартай эх үүсвэртэй болгох

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Баян –Уул, Матад сумдын эмнэлгийг халаалт, цахилгааны найдвартай эх үүсвэртэй болгон, байнга ашиглах гэсэн заалтууд тасарсан байна.

Бүх сумдын засаг дарга, эмнэлэг, багуудын дарга нар радио станцтай болсон байна.

2. Аймгийн өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөлийн 2002 оны ажлын төлөвлөгөөг зөвлөлийн хурлаар батлуулан ажиллаж, тайлант хугацаандаа 11 удаа хуралдаж 31 асуудал хэлэлцэн шийдвэр гаргасан байна. Мөн Зөвлөлийн хурлаар сумдын өрхийн амжиргааны чадавхийг дэмжих зөвлөлийн ажиллах журмыг баталжээ.

Аймгийн хэмжээний 14 суманд эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх зориулалтаар 159,5 сая төгрөгийн жижиг зээлийн сантай болон амьжиргаагаа тогтворжуулах боломжтой ядуу , ядуу бус бага орлоготой өрхөд төсөл хэрэгжүүлж байна.

2002 онд 14 суманд 253 өрх төмс , хүнсний ногоо тариалж , борлуулах, жижиг худалдаа эрхлэх , оёдол, талх нарийн боовны үйлдвэрлэл явуулах гэх мэт үйл ажиллагааны 12 чиглэлээр жижиг төсөл авч хэрэгжүүлэн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай 612 хүн өрхийн үйлдвэрлэлд ажиллан ажлын байртай болж, төсөл хэрэгжүүлэгчдийн 65 хувь буюу 165 өрх нь ядуу, 35 хувь ядуу бус бага орлоготой өрх хамрагдсан байна.

2002 онд эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх чиглэллээр хэрэгжсэн төслүүдийн 63,9 хувь нь жижиг худалдааны чиглэлээр, 36,1 хувь нь дархан мужаан, төмөр эдлэл, оёдол, талх нарийн боов, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрхэлж , бүтээгдэхүүнээ борлуулах чиглэлээр төсөл хэрэгжсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад зээлдэгч нар үйлдвэр эрхлэх тал руу илүү анхаарч байгаа нь харагдсан байна.

Эндээс дүгнэлт хийхэд жижиг зээлийн зориулалтаар нэг өрхөд олгож байгаа мөнгөний хэмжээ нь бага учраас өөртөө суурь мөнгөгүй ядуу хүмүүс авсан зээлээрээ жижиг худалдаа эрхлэх л цорын ганц боломжтой байдаг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Цаашдаа жижиг зээлийг үйлдвэрлэл биш дандаа худалдаа эрхлээд байвал тогтвортой үйл ажиллагаа эрхлэх боломж муутай болох нь худалдааны чиглэлийн төслүүд дээр түгээмэл байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэг өрхийн жилийн орлого 317400 төгрөгт хүрч тайлант хугацаанд 1102 өрхийн 4956 иргэн ядуурлаас гарлаа. / Энэ нь сумдын ӨАЧДЗөвлөлүүдээс ирсэн тайлангаас гарсан тоогоор /

Малжуулах төслийн эцсийн үнэлгээг төсөл хэрэгжүүлсэн 3 суманд 7,8 дугаар саруудад хийж зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн дүгнэлт гарган, дараагийн төсөл хэрэгжүүлэх сумдыг сонгосон байна. Малжуулах төслийг 6 сумын хөдөөгийн ядуу, малчин 85 өрхөд төсөл хэрэгжүүлж эхэлжээ. Уг төсөл нь бэлчээрийн даац ихтэй, мал цөөнтэй манай аймагт хамгийн үр өгөөж сайтай төсөл болох нь төсөлийн үнэлгээгээр тодорхой харагдсан тул аймгаас 6 сая төгрөг нэмж гарган шинээр 10 өрхийг малжуулсан байна.

Эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх зээлийн төлөлт аймгийн хэмжээнд үндсэн зээлийнх 68,0 эргэлтийн сангийн хөрөнгийнх 72,2 хувьтай байна. Үндсэн зээлийн эргэн төлөлт 3 дугаар улиралаас аймгийн дүнгээр 8 хувь буюу 12419,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн боловч Эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх зориулалтаар олгогдсон үндсэн зээлийн эргэн төлөлтийг 80 хувьд хүргэх зорилго биелэглээдээгүй байна.

Энэ нь Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжиж эхэлсэн эхний 2 жилд **нэн ядуу** хүмүүст олгогдсон 31900,0 мянган төгрөгийн зээлийн 82 хувь нь үндсэндээ эрсдэлд орсонтой холбоотой байна.

Йимд аймгийн хэмжээд ядуу иргэдийн өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хэрэгжиж буй төслүүдэд 2002 оноос эргэн төлөлтгүй, буцалтгүй тусламжаас татгалзаж нэн ядуу иргэдийг хамруулалгүй, халамжийн байгууллагуудад даалгасан байдалтай байна.

2001 оны 09 сарын 14нд хуралдсан аймгийн төвийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдаанаар " Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөр" ийг батлан хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Хөтөлбөр нь 6 жилийн хугацаатайгаар 2 үе шаттай хэрэгжих бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд

А/ Нийгмийн хүрээнд

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Б/ Боловсролыг хамрах хүрээг өргөжүүлэх талаар

В/ Тахир дутуу иргэдийг дэмжих зорилтын хүрээнд

Г/ Эдийн засгийн хүрээнд

Д/ Байгал орчны хүрээнд

Е/ Мэдээлэл, судалгаа сургалт сурталчилгааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн дэд хэсгүүдтэй байна.

Хэрлэн сумын нэн ядуу эмзэг бүлгийн иргэдэд төсвөөс хуваарилан олгосон зардлын хэмжээ нь :

1998 онд 863.4 мянган төг

1999 онд 1598.0 мянган төг

2000 онд 2894.0 мянган төг

2001 онд 2300.0 мянган төг

2002 онд 2651.4 мянган төг байна.

2002 онд Хэрлэн сумын Хэмжээнд Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих төслийн шугамаар 18 өрхийн 104 хүн , үүнээс хөдөлмөрийн чадвартай 37 хүн, малжуулах төслөөр 22 өрхийн 102 хүнийг ажлын байраар хангажээ. Нэн ядуу эмзэг бүлгийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд мэргэжил эзэмшүүлэх ажлын байрны төсөл боловсруулах чиглэллээр 2 удаа сургалт зохион байгуулж тус бүр 40 хүнийг хамруулсан байна.

2002 онд орон гэргүй 9 хүнийг орон байраар / гэр болон өвлийн пин/ хангаж, орц траншейд байгаа 54 хүний орон байртай болгох ах дүү төрөл төрөгсдөд нь шилжүүлэх ажлыг 2003,2004 онд шийдвэрлэх зорилттой байна.

Хөдөө сумдад нэн ядуу иргэдийг талаар хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг дурьдхад тухайлбал :

Дашбалбар суманд жилийн эцсийн хүн ам, мал хөрөнгийн тооллогын дүнд үндэслэн амьжиргааны түвшингийн тооцоог 790 өрхийн 3386 хүн амд хийгээд байна. Тооцоогоор хүн амын 722 буюу 21,3% ,өрхийн 152 буюу 19,2% нь нэн ядуу амьдралтай бөгөөд өнгөрсөн оныхоос 3хувиар буурсан өөрөөр хэлбэл 2003 онд нэн ядуу өрхийн тоо 30-аар, хүн амын тоо 149- өөр буурч ядуурал багассан гэж үзэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Нэн ядуу иргэдийн амьдралд дэм болох үүднээс тэднийг амьдрах арга ухаанд суралцуулах үүднээс сүүлийн 2 жилд 4 хүн үсчин, талх, нарийн боовны сургалтад хамрагдсан байна. Мөн олон малтай, хүн хүч дутагдалтай өрхөд түшиглүүлэн 13 хүнийг ажилын байраар хангасан байна.

УИХ –ын гишүүний тойрогтоо үйл ажиллагаа явуулахад зориулсан улсын төсвөөс олгодог 5 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай малжуулах төсөлд нэн ядуу 5 өрх хамрагдаж 50 толгой бог малыг 3 жилийн хугацаатайгаар маллуулахаар олгоод байна.

Нэн ядуу өрхийн дундаж орлого 2500-5400 төгрөг байна. Сумын нэн ядуу хүний дийлэнх хувийг залуу, дунд насныхан эзэлж энэ нь мэргэжил, боловсролгүйгээс ажлын байр олдохгүй байгаатай холбоотой байна.

2002 онд Халамжийн тухай хуулийн дагуу нэн ядуу амьдралтай 10 өрхөд 310000 төгрөгний түлээний хөнгөлөлт үзүүлсэн мөн өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулж төмсний үр 1,5 тн-ыг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдаж үрийн төмсөөр хангасан байна.

Эмзэг бүлгийн 10 өрхөд 6 төрлийн хүнсний ногооны үр үнэгүй олгож 180 пакет үрийг хямд үнээр худалдаж олгосон.

26 хүнд сумын ядуурлыг бууруулах сангаас 5,2 сая төгрөгийн жижиг зээл олгоод үр дүнтэй ажилласан байна.

Харин суманд хэрэгжиж байгаа Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх төслийн журамд 2002 онд өөрчлөлт орж нэн ядуу иргэд хамрагдах боломжгүй болсон байна.

Манай аймагт нэн ядуу 2-5 ам бүлтэй 2245 өрх, 6-8 ам бүлтэй 1167өрх байгаагаас 1400 гаруй нь өрх толгойлсон эмэгтэйчүүд эзэлж байна. Өрх толгойлсон ядуу эмэгтэйн гол орлого ологч насанд хүрээгүй хүүхэд байх нь цөөнгүй байна.

Эмчилгээний зардал нэмэгдсэн, эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй буюу боломжгүй байгаа зэрэг нь ядуу болон нэн ядуу иргэдийг эмнэлгийн үйлчилгээ, тусламж авах боломжгүй болгож байна. Нэн ядуу иргэдийн халдашгүй эрх , эрүүл мэндээ хамгаалуулах , нийгмийн хангамж хүртэх зэрэг эрхүүд зөрчигдсөөр байна.

Тайлан бичсэн : Ц. Нарантуяа

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Дорноговь аймгийн ХЭХС Зөвлөл*

# Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал

*Сайншанд*
*2003 он*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СЭДЭВ : * *Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал* *

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО : *Нэн ядуу иргэдийн эдийн засаг, нийгэм соёлын болон улс төр, иргэний эрхийн төлөв байдлыг микро болон макро түвшний судалгаанд түшиглэн тодорхойлох*

СУДЛАГДАХУУН: *а/ Аймаг, сумын ИТХурал, Засаг Даргын Тамгын Газар, орон нутгийн холбогдох албан газар, аж ахуйн нэгж байгууллагууд*

*б/ Сум : Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Замын- Үүд, Улаанбадрах, Зүүнбаян*

СУДАЛГААНЫ ОБЬЕКТ : *Нийгмийн эмзэг бүлгийн нэг хэсэг болох нэн ядуу өрх, иргэд.*

ХУГАЦАА : *2003 оны 02- р сарын 10- наас 03- р сарын 10- ныг хүртэл*

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ : *Шаардлагатай баримт бичигтэй танилцаж too мэдээлэл цуглуулах, холбогдох албан тушаалтантай уулзаж санал бодлыг сонсох, зохих газраар явж танилцаж баримтжуулах, анкет, асуулга, сурвалжлага, оролцооны арга,нэн ядуу иргэдтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Сайншанд 2003- 03- 05

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн удирдамжийн дагуу нэн ядуу иргэдийн эдийн засаг, нийгэм соёлын болон улс төр, иргэний эрхийн төлөв байдлыг микро болон макро түвшний судалгаанд түшиглэн тогтоох зорилгоор судалгааг 2003 оны 02- р сарын 10- наас 03-р сарын 10- ныг хүртэлх хугацаанд аймаг, сумын ИТХурал, төрийн захиргааны төв, орон нутгийн зарим аж ахуйн нэгж байгууллагууд, Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Замын- Үүд, Улаанбадрах, Зүүнбаян сумдыг хамруулж хийлээ.

Судалгааг ядуурал болон иргэдийн эрхийн чиглэлийн хоёрдогч эх үүсвэр материалууд болон тандалтын судалгааны үр дүнг ашиглан холбогдох албан тушаалтантай уулзаж тэдгээрийн санал бодлыг сонсох, шаардлагатай баримт материалтай танилцах, тухайн асуудлаар авсан арга хэмжээ, зохиосон ажил, үр дүнгийн талаарх холбогдох баримтыг үзэж, шаардлагатай мэдээллийг авах, нэн ядуу иргэдтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, тэдгээрийн санал бодлыг сонсох замаар хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажилд аймгийн хүний эрхийг хангах салбар зөвлөлийн гишүүд, сумдын нийгмийн бодлогын түшмэлүүд, туслан гүйцэтгэгчдийг татан оролцуулж тэдэнд судалгааны зорилго, чиглэлийг танилцуулан тус тусын хийх ажлын хүрээнд тодорхой чиглэл, аргачлал өгч судалгааны ажлыг эхлүүлсэн бөгөөд судлаачид тус тусын ажил үүргийн дагуу шаардлагатай обьектуудад судалгаа хийж, судалгааны ажилд шаардлагатай баримт материал, мэдээлэл, тоо баримтуудыг цуглуулах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, улмаар судалгааны үйл явцын тайлан, дүгнэлт бичиж өөр хоорондоо шүүн хэлэлцэх замаар судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дорноговь аймаг 109, 0 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, 11956 өрх, 50 гаруй мянган хүн амтай. Хүн амын 65,1 % нь төв суурин газарт, 34,9 % нь хөдөөд амьдарч байна. Нийт хүн амын 48,7 % нь эрэгтэй, 51,3 % нь эмэгтэйчүүд байдаг. Нийт хүн амын 75,0 %- ийг 0- 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлдэг. Тэтгэврийн насны 3209 хүн байгаа нь нийт хүн амын 6,5 % болдог бөгөөд тэдгээрийн 64, 2 % нь эмэгтэй, 35,8 % нь эрэгтэйчүүд байна.

Амьдралын түвшин доогуур, өндөр настангууд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, олон хүүхэдтэй өрх, тахир дутуу иргэд, сургууль завсардсан хүүхдүүд гээд нийгмийн эмзэг бүлэгт багтдаг 1200 өрхийн 9800 хүн өнөөдөр Дорноговь аймагт амьдарч байна.

Өнөөдөр Дорноговь аймагт нийт 11066 хүн ядуу буюу нэн ядуу амьдарч байгаа нь нийт хүн амын 22,4 % болж байгаагийн 12,2 % нь ядуу, 10,1 % нь нэн ядуу амьдарч байна. Үүнийг 1997 онтой харьцуулахад хүн амын ядуурал 7,6 %- иар буурсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Аймгийн хэмжээнд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх 1998 онд 2169 буюу 18,4%, 1999 онд 1499 буюу 12,6%, 2000 онд 1647 буюу 13,8%, 2001 онд 2318 буюу 19,0%, 2002 онд 2339 буюу 18%- ийг тус тус эзэлж байна.

Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөөс нэн ядуу өрх 1998 онд 791 буюу 36,5%, 1999 онд 642 буюу 42,8%, 2000 онд 663 буюу 40,3%, 2001 онд 1080 буюу 46,6%, 2002 онд 978 буюу 42% нь байсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр авч байгаа нэн ядуу иргэдийн тоо 1998 онд 675, 1999 онд 680, 2000 онд 602, 2001 онд 632, 2002 онд 663 байсан байна.

Нийгмийн халамжийн бусад тэтгэмж авч байгаа нэн ядуу иргэдийн тоо 1998 онд 668, 1999 онд 2874, 2000 онд 2031, 2001 онд 2157, 2002 онд 2316 байсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нэн ядуу иргэдийн тоо 1999 онд 179, 2000 онд 160, 2001 онд 191, 2002 онд 1025 байсан байна.

Нэн ядуу иргэдийн нийгмийн халамжийн үйлчилгээнд зориулж 1998 онд 49078,3 төг, 1999 онд 11679,2 төг, 2000 онд 10460,3 төг, 2001 онд 14978,6 төг, 2002 онд 17350,3 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй нэн ядуу амьдралтай иргэд, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой ахмад настан, тахир дутуу хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эхчүүдийг тухай бүрд нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулж ирсний зэрэгцээ бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан, тахир дутуу хүмүүсийг асрамжийн үйлчилгээнд хамруулж ирсэн байна.

1997 оноос хойш Ядуурлыг бууруулах хөтөлбөрөөс 297,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус аймагт хийгдэж, хүн амын ядуурлыг бууруулах, нийгмийн үйлчилгээний байгууллагуудын засвар тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд тодорхой хувь нэмэр оруулж, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 341 төсөлд 2416 хүн хамрагдаж ашиг хүртсэн байна.

2001- 2002 онд нийт 326 нэн ядуу тахир дутуу иргэдэд 26,2 сая төгрөгийн хөнгөлөлт үйлчилгээ үзүүлсэн байна. Нэн ядуу 15 айлыг гэр, орон сууцтай болгож өрх толгойлсон, олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрх, нэн ядуу ахмад настан 210 гаруй хүнд хоол хүнс, хувцас олгох ажлыг тогтмолжуулж ирсэн байна. Мөн түүнчлэн амьдралын хүнд нөхцөлд амьдарч байгаа, бие даан амьдрах чадваргүй, асран хамгаалж тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан, тахир дутуу 32 иргэн Нийгмийн Халамж Үйлчилгээний Төвийн дэргэдэх асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Аймгийн Засаг Даргын 2002 оны 261 дүгээр захирамжаар Сайншанд сумын хэмжээнд орон байргүй амьдарч байгаа 10 иргэнд 4 ханатай шинэ гэр олгосон бөгөөд үүнд 5,7 сая төгрөг зарцуулсан байна.

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, Санхүү эдийн засгийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан **Нийгмийн эмзэг бүлгийн болон дөров ба түүнээс дээш иэг хүүхэд нь ЕБС- д зэрэг суралцдаг өрхийн нэг хүүхдэд**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**хичээлийн хэрэглэлийг үнэ төлбөргүй олгох журам**- ын хэрэгжилтийг аймгийн ИТХ- ын дэргэдэх нийгмийн бодлого, хүн амын халамж үйлчилгээний байнгын зөвлөлөөс аймаг, сумдын бүх ерөнхий боловсролын сургууль бүр дээр үзэж шалгасан байна. Хичээлийн хэрэглэлийн гүгээлт нь журмын дагуу зохих эзэддээ хүрч чадсан гэж дүгнэсэн бөгөөд энэ арга хэмжээнд зориулж нийт 19,545,500 төгрөг зарцуулсан байна.

Аймгийн ИТХТ- дийн 2002 оны 3- р хуралдаанаар Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг батлуулан ажиллаж байна.

2002 оны 3 дугаар улирлын байдлаар 9 сумын ӨАЧДЗөвлөлөөс 66915,0 мянган төгрөгийн зээлийг 285 төсөлд олгосон. Эрсдэл фондыг аймгийн ӨАЧДЗөвлөлийн дансанд байрлуулж тус данснаас 4,8 сая төгрөгний ноос самнах 16 машин авч 32 хүнд зээлээр олгосон байна.

Хүүхдийн цэцэрлэгийн халамжийн бүлэгт нэн ядуу өрхийн 70 хүүхэд хамрагдаж байна. Нэн ядуу, тахир дутуу 70 иргэнийг аймгийн говийн албан газар, аж ахуйн нэгжүүдэд хуваарилан өгч нэг удаагийн буцалтгүй тусламж олгуулсан байна. 2002 онд нэн ядуу, тахир дутуу 100 гаруй өрхөд түлээ нүүрсний хөнгөлөлтийг бэлэн мөнгөөр олгосон байна. МУ- ын Засгийн Газрын шийдвэрээр **Орц хонгилд амьдардаг иргэдэд тусламж үзүүлэх** шийдвэрийн дагуу аймгаас комисс томилогдон ажиллаж энэ ажлын хүрээнд Халамж Үйлчилгээний төвөөс орон гэргүй 8 өрхийн 30 хүнийг усанд оруулах, хооллох, нэг удаа бүрэн хувцаслах, 20 өрхөд 1 сарын хүнсний зүйлийг тус тус олгосон байна.

Аймгийн халамж үйлчилгээний төв нь 2002 онд нийт 413941,2 төгрөгийн санхүүжилт авч тэтгэвэр, тэтгэмж, ахмад настан болон тахир дутуу иргэдийн хөнгөлөлт, нийгмийн халамжийн үйлчилгээнд 411471, 4 төгрөг зарцуулсан байна.

2001 онд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу иргэдтэй нэн ядуу өрхийн 134 хүнд 12692,9 төгрөгийн, 2002 онд 161 хүнд 11305,2 төгрөгийн хөнгөлөлт, үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

Малжуулах төслийн хүрээнд 15 өрхөд 1500 толгой мал олгож, мөн түүнчлэн зарим сумдад хоршоо, компани, олон малтай малчид малаа ядуу иргэдээр маллуулж, хөлсөнд нь мал олгох журмаар аймгийн хэмжээнд 2001 онд 146 өрхөд 4800 мал, 2002 онд 27 өрхөд 738 толгой малыг тус тус олгосон байна.

Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллага, иргэдийн санаачилга, сумдын хөдөө аж ахуйн хоршоо, Улаан загалмай, Эмэгтэйчүүдийн зөвлөл зэрэг байгууллагууд ядуу өрх иргэдийг дэмжиж эд материалын болон мөнгөн тусламж үзүүлэх, жижиг зээл олгох, малжуулах зэрэг ажлыг зохион байгуулж ирсэн байна.

Судалгаанд хамрагдагсан нэн ядуу айл өрхийн гишүүдийн дийлэнх ажлын байр байхгүйгээс орлогын эх үүсвэр олох ямар ч боломжгүй байгаа тухай, мөн түүнчлэн энэ байдлаас болж сургуулийн насны хүүхдүүд сургууль завсардах үзэгдэл ч хэвийн болсон тухай ярьж байлаа. Гэрэл, цахилгаанаар хангуулдаг боловч хэрэглэсэн цахилгааны үнийг олон сараар төлж

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

чаддаггүйгээс гэрлээ таслуулдаг. Орлогын эх үүсвэр нь хог түүх, нүүрсний хог ухаж зарах, дулааны улиралд ундаа зарах мэтээр хязгаарлагддаг байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
САЛБАР ЗӨВЛӨЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## НЭН ЯДУУ ИРГЭДИЙН СУДАЛГАА

Аймаг **Дорноговь** 2003.02.18.

| д/д | Агуулга | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нэн ядуу иргэдийн талаар орон нутгийн ИТХ-аас гаргасан тогтоол, захиармж | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2 | Нэн ядуу иргэдийн талаар Засаг даргаас гаргасан тогтоол, захиармж | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 3 | Засаг захиргааны нэгжид байгаа нэн ядуучуудын тоо | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | Нэн ядуучуудад зориулан төсвөөс хуваарилсан зардлын хэмжээ, төсөвт эзлэх хувийн жин | | | | | |
| 5 | Нэн ядуучуудад зориулсан хөтөлбөр, зохион байгуулсан үйл ажиллагаа /ажлын байртай болгох, орон байртай болгох, малжуулах, бусад / | | тахир дутуу 3 иргэнийг ажлын байртай болгосон | | ХДИ-ийн 10 гаруй хүнийг ажлын байртай , нэн ядуу амьдралтай тахир дутуу 4 өрхийг орон байртай | Халамжийн сангаас хөрөнгийг нь гарган ХДИ-ийн 10 айлд орон сууцны байр худалдан авч өгсөн |
| 6 | Нэн ядуу иргэдийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байдал | Хуулийн дагуу 49078,3 м.т, зар-цуулан үйлчил-гээнд хамруулсан | Хуулийн дагуу 11679,2 м.т, зар-цуулан үйлчил-гээнд хамруулсан | Хуулийн дагуу 10460,3 м.т, зар-цуулан үйлчил-гээнд хамруулсан | Хуулийн дагуу 14978,6 м.т, зарцуулан үйлчилгээнд хамруулсан | Хуулийн дагуу 17350,3 м.т, зар-цуулан үйлчилгээнд хамруулсан |
| 7 | Нийгмийн халамжийн тэтгэвэр авч байгаа нэн ядуу иргэдийн тоо /тэдний нас болон өрхийн хэмжээ/ | 675 | 680 | 602 | 632 | 663 |
| 8 | Нийгмийн халамжийн бусад тэтгэмж авч байгаа нэн ядуу иргэдийн тоо /тэдний нас болон өрхийн хэмжээ/ | 668 | 2874 | 2031 | 2157 | 2316 |
| 9 | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нэн ядуу иргэдийн тоо /тэдний нас болон өрхийн хэмжээ/ | | 179 | 160 | 191 | 1025 |
| 10 | Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хүртээмж/ | Халамжийн хуулийн дагуу | Халамжийн хуулийн дагуу | Халамжийн хуулийн дагуу | Халамжийн хуулийн дагуу | Халамжийн хуулийн дагуу |

Судалгаа гаргасан: , , , , , , , [signature]

Албан тушаал , , , , , , , , , , ,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хүснэгт - 2

Аймаг **Дорноговь**

Байгууллагын нэр **Нийгмийн Халамж Үйлчилгээний Төв,**

2003.02.18.

| Агуулга | Төсөвлөсөн зардал /төг/ | | | | | Батлагдсан төсөв /төг/ | | | | | Зарцуулалтын байдал /төг/ | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| оноор | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
| Аймгийн Нийгмийн Халамж үйлчилгээний төвөөс нэн ядуу иргэдийн халамж үйлчилгээнд зориулж гаргасан зардал | | | | | | | | | | | 49078,3 | 11679,2 | 10460,3 | 14978,6 | 17350,3 |

Судалгаа гаргасан: Цэрэн.

Албан тушаал , ахлах байцаагч

## ДУНДГОВЬ АЙМГИЙН НЭН ЯДУУ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2003.03.10 Мандалговь

Аймгийн хэмжээгээр 2001 онд явуулсан ядуурлын улсын үзлэгийн дүнгээс үзвэл нийт өрхийн 44,9 хувь буюу 5675 өрх , нийт хүн амын 50,4 хувь нь буюу 26053 хүн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нийт өрхийн 2424 буюу 19,2 хувь, нийт хүн амын 11722 хүн буюу 22,6 хувь нь нэн ядуу амьдарч байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт нэн ядуу амьдралтай айл өрхийн хоол тэжээлийн дутагдалд орсон сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулан хоолны сувилгаа хийх , эрүүлжүүлэх чийрэгжүүлэх эмчилгээнд хамруулах тухай 1 заалт орсон.

Мөн Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих дэд хөтөлбөрийг /2002-2006/ батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Нэн ядуу иргэдэд туслах сангийн журмыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан уг сангаас нэн ядуу иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

Ган зудаас хамгаалахад туслах аймгийн дэд хөтөлбөрийг 2001 онд батлан гаргасан.

Ядуу хүн амын тоо 1996 оны түвшингээс 6,9 дахин өссөн. Мал аж ахуйд учирсан хохирлын улмаас мал бүхий өрхийн 21 хувь буюу 213 өрхийн 1994 хүн малгүй болж амьжиргааны баталгаа алдагджээ. Аймгийн хэмжээнд амьжиргааны түвшний доройтолд орлогын баталгаат эх үүсвэргүй олон хүүхэдтэй өрх , өрх толгойлсон ганц бие эцэг , эх цөөн малтай залуу малчид ,тул түших хамаатан садангүй ядуу өрх, тэтгэмжийн багахан мөнгөөр амьдардаг өрх ажилгүйчүүд , хөдөлмөрлөх чадваргүй хүмүүс нэлээд өртөгдөж байгаа нь бодит амьдралаас харагдаж байна.

Ядуурлалд гол төлөв ам бүл олонтой өрх толгойлсон эмэгтэйчүүд өртжээ. Тухайлбал: эмэгтэй тэргүүлэгчтэй нийт1479 өрхийн 501 өрх нь нэн ядуу байна. Хөдөлмөрийн насны нэн ядуу 5474 хүний 1681 хүн ажилгүй байна. Хөдөлмөрийн насны нэн ядуучуудын 12,3 хувь нь амйгийн төвд, нэн ядуучуудын 47,6 хувь хөдөөд хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс үзвэл аймгийн төвд хөдлөмөр эрхлэлт бага, ажилгүйдэл газарт илүү төвлөрсөн нь харагдаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Нэн ядуу өрх, ам бүл /1998-2002 он/

| Он | Нэн ядуу өрх ам бүлийн тоо | |
|---|---|---|
| | Өрхийн тоо | Ам бүлийн тоо |
| 1998 | 714 | 3778 |
| 1999 | 1048 | 4688 |
| 2000 | 1658 | 6514 |
| 2001 | 2424 | 11772 ядуурлын улсын үздэгийн дүн |
| 2002 | 2135 | 9971 |

2000 он хүртэл нэн ядуу өрх ам бүлийн талаар статистик мэдээ байдаг ба 2001 оноос эхлэн уг бүлгийн талаарх мэдээ статистик үзүүлэлтэнд орохоо болсон байна.

| сум | он | Нэн ядуу хүн ам | Насны ангилал | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 хүр тэл | 1-4 | 5-7 | 8-10 | 11-15 | Тэт гэ вэр | Хөдөл мөр |
| Сайхан-Овоо | 1998 | 352 | 13 | 37 | 30 | 40 | 70 | 13 | 149 |
| | 1999 | 242 | 6 | 28 | 24 | 23 | 47 | 6 | 108 |
| | 2000 | 332 | 16 | 28 | 37 | 44 | 37 | 6 | 164 |
| | 2001 | 570 | 14 | 37 | 78 | 74 | 75 | 3 | 289 |
| | 2002 | 910 | | | | | | | |
| Эрдэнэдалай | 1998 | 120 | 2 | 18 | 17 | 21 | 41 | 7 | 14 |
| | 1999 | 629 | 20 | 60 | 102 | 84 | 94 | 31 | 238 |
| | 2000 | 546 | 0 | 43 | 60 | 70 | 95 | 13 | 265 |
| | 2001 | 2249 | 93 | 112 | 342 | 200 | 307 | 72 | 1123 |
| | 2002 | 371 | | | | | | | |
| Адаацаг | 1998 | 170 | 5 | 7 | 27 | 12 | 29 | 9 | 81 |
| | 1999 | 207 | 9 | 11 | 11 | 7 | 9 | 7 | 153 |
| | 2000 | 279 | 8 | 39 | 32 | 29 | 38 | 9 | 124 |
| | 2001 | 351 | 23 | 20 | 54 | 40 | 50 | 10 | 154 |
| | 2002 | 422 | | | | | | | |
| Сайнцагаан | 1998 | 1657 | 29 | 103 | 138 | 303 | 436 | 72 | 576 |
| | 1999 | 1824 | 41 | 126 | 156 | 204 | 466 | 86 | 745 |
| | 2000 | 2491 | 104 | 261 | 211 | 290 | 557 | 179 | 889 |
| | 2001 | 4323 | 126 | 210 | 444 | 500 | 750 | 202 | 2091 |
| | 2002 | 4621 | | | | | | | |

Нэн ядуу өрхийн нэг хүнд ногдох сарын орлого Эрдэнэдалай сумын хувьд 653 төгрөгөөс- 2124 төгрөг байна.

Тайлбар: 2002 оны нэн ядуу хүн амын талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаагүй байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Аймгийн Халамж үйлчилгээний төв нэн ядуу иргэдийн асрамж халамжийн үйлчилгээний зардал

| Он | Төсөвлөсөн | Хамрагдсан хүн | Зарцуулсан төсөв |
|---|---|---|---|
| 1998 | * | * | * |
| 1999 | Төсөвлөөгүй | 32 | 341,8 |
| 2000 | 290,0 | 139 | 1061,4 |
| 2001 | 840,0 | 136 | 1474,0 |
| 2002 | 4,0 сая | 75 | 1976,0 |

2002 онд 4,0 сая төгрөг төсөвлөсөн. 2.024.000 төгрөгийг засвар болон албан хэрэгцээний машин авахад зарцуулсан. Хүндээ хүрч зарцуулагдсан нь 1976,0 төгрөг байна. /75 хүн /

Тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дэргэд халамжийн зөвлөлийг засаг даргын захирамжаар байгуулан халамжийн чиглэлээр гарах шийдвэрүүдэд хамтын шийдвэр гаргаж ажиллахын зэрэгцээ тус зөвлөлийн захиран зарцуулах эрх бүхий "Нэн ядуу иргэдэд туслах" сангийн журмыг батлан ажиллаж байна. Гэхдээ ажил хариуцсан хүмүүс орон нутагтаа энэ хэлбэрийн ажил өрнүүлэх талаар тун дутагдалтай ажиллаж байна.

Нэн ядуу иргэдэд туслах сангийн зарцуулалтын байдал 2000-2003 он

| № | он | Төсөвлөсөн | Зарцуулсан хөрөнгө | Хүний тоо | Бусад тусламж |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1998 | 1 сая | 270.400 | 13 | 200 кг цагаан будаа 200 кг гурил |
| 2 | 1999 | 200,0 | 695.000 | 22 | 142 кг цагаан будаа 40 кг гурил |
| 3 | 2000 | 700,0 | 1.390.900 | 46 | 460 кг цагаан будаа 25 кг шар будаа 1240 кг гурил |
| 4 | 2001 | 1500,0 | 756,000 | 30 | 425 кг цагаан будаа 110 кг шар будаа 315 кг гурил |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *5* | *2002* | *1500,0* | *1.767.500* | *54* | *1290 кг цагаан будаа 75 кг гурил* |
| *6* | *2003* | *Төсөвлөөгүй* | | | |

*Нийгмийн халамжийн тухай хуулийн 7-р бүлгийн 8-ын 2-т нийгмийн халамж асрамжийн үйлчилгээний санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ жил бүр тусгайлан зааж батална гэсэн заалтын дагуу уг сангийн хөрөнгийг аймгийн жил бүрийн төсвөөс суулгаж өгдөг. Нэн ядуу иргэдэд зориулсан хөрөнгө хэтэрхий бага тул нэн ядуу хүн бүрт хүрч чадахгүй өөрөөр хэлбэл тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг өргөжүүлэхэд дэмжлэг муу байна гэсэн үг юм. .*

*Суманд нэн ядуу иргэдэд туслах зорилгоор жилд 150,0-200,0 төгрөгийг төсөвлөдөг зарим суманд нэг төгрөг ч төсөвлөхгүй байна.*

*Ногоон хувьсгал хөтөлбөрийн хүрээнд :*
*2001 онд 225 нэн ядуу өрхөд 1487,0 төгрөг*
*2002 онд 195 нэн ядуу 600,0 төгрөгийн үр олгожээ.*

*2000 оноос 10 сумын 537 өрхөд 410 сая төгрөгийн малжуулах төслийг хэрэгжүүлсэн ба Дэлхийн Зөн ОУБ-аас эмзэг бүлгийн иргэдэд туслах тэднийг ирээдүйд учрах эрсдлээс хамгаалах арга хэмжээнд 420,0 мянган америк долларын санхүүжилт хийгдсэн байна.*

*Аймгийн нийгмийн халамж үйлчилгээний төв нь нийгмийн халамж үйлчилгээг өргөжүүлэх чанартай болгох чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж байна.*

*Хүн амын эмзэг хэсэг нэн ядуу амьдралтай ахмад настан бүтэн өнчин хүүхэд, иргэдийг түр хугацаагаар хооллох асуудлын хүрээнд эдгээр хүмүүст хүнсний тусламжийг материалаар нь олгодог болсон байна. Асран хамгаалах хүнгүй, хэвтрийн ахмад настныг халамжлах гэрийн үйлчилгээг үзүүлж байна. Эдгээр халамжийн үйлчилгээг үзүүлдэгч хүртээмж муу, ганц нэг шуудай гурил будаагаар хязгаарлагдаж байна.*

*2000 оны 06 сард аймгийн ИТХ-аас орон гэргүй нэн ядуу иргэдийг орон байртай болгох зорилгоор ашиглагдаагүй байсан эмнэлгийн хуучин барилгыг ашиглуулж байна.*

*Судалгаа хийх явцад уг байранд амьдарч буй айл өрхөөр явж амьдрал байдалтай танилцсан. Энд амьдарч буй айл өрхийн ихэнх нь хоногийн хоолгүй, түлэх түлээгүй, 2 хоног юм идээгүй айл ч байлаа. Эдгээр өрхийн иргэд хоол хүнсний байнгын хомсдолд орж өлмөн зөлмөн байдалд аж төрж байна.*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Мах идээгүй удаж байна. Гэдсээр хоол хийдэг 1 гэдсийг хэмнээд идэхэд 7 хонодог . Өглөө хар цай уудаг өдөржин хоосон байж байгаад оройдоо гэдэснийхээ шөлөнд гурил бантагнаад иддэг энэ нь гуриланд арвин байдаг. Хаая шулсан яс авч /1кг-10 төг/ хоол хийж иддэг ингэхэд хөлс гараад сайхан болдог Хүүхдүүд маань өлсөөд уйлдаг байсан одоо сурчихсан Халамжийн 12000 төгрөг хаач хүрэхгүй юм гэж ярьж байлаа.

Чинээлэг өрхүүдтэй харьцуулахад эрүүл мэндийн салбарын үйлчилгээг ядуу өрхүүд бага хүртэж байгаагийн зэрэгцээ эмнэлэгт хандах давтамж нь буурсан. Нэн ядуу иргэд эрүүл мэндийн дэвтрээ сүүлийн 2-3 жилд бөглүүлээгүй иймд эмчид үзүүлэх хэрэгцээ байсан ч хандаж чадахгүй байна. ЭМД төлсөн хүн эмнэлэгт хэвтэхэд 10%-ийг өөрөө төлдөг энэ нь нэн ядуу иргэд эмнэлгийн үйлчилгээ авах боломжийг бүр хааж байна.

Эрдэнэдалай сумын ядуурлын ажилтантай уулзаж ярилцахад: Манай сумын хэмжээнд 110 гаруй хүн иргэний үнэмлэхээ аваагүй байна. Үүний 60 -аад нь тэмдэгтийн хураамжаа төлөх чадваргүй учраас авч чадахгүй байна. Одоо уг хураамжийн үнэ нэмэгдсэн бүр хүндрэлтэй болж байна.

Мөн хүүхэд шинээр бүртгэхэд 600 төгрөгийн хураамж авдаг Үүнийг төлж чадахгүйгээс хүүхдээ бүртгүүлж чаддаггүй. Манай сумын хувьд энэ мөнгийг эхэд олгох хүүхэд асарсны тэтгэмжээс нь суутгаад авдаг

2000 оны байдлаар нэн ядуу өрхийн сургуулийн насны 2925 хүүхдийн 568 хүүхэд сургууль завсардсан байна. Нэн ядуу өрхийн хүүхдийн сургууль завсардах гол шалтгаан нь хувцас хичээлийн хэрэгслэлээр хангаж чадахгүй байгаа явдал юм.

Өрх толгойлсон нэн ядуу эмэгтэйн яриа:

Дэвтэр авч өгч чадахгүй болохоор дэвтэр дээрээ зайгүй бичдэг Ингэж бичиж болохгүй гэж зарим багш нар нь дүнг дардаг. Саван , угаалгын нунтаг авах мөнгөгүй учир хаяа л нэг усанд орцгоодог хувцас хунар цэвэрлэх боломж маш бага зарим багш нар нь арчаагүй гэж загнана, зарим нь ч ойлгодог. Гэрэл цахилгаангүй болохоор хүүхдүүд минь телевиз үзэх ,хичээл номоо ч хийж чаддаггүй . Уг нь ногоо тариад мөнгөөр нь / 32000 / телевиз авсан юм. Хувцас хунар авах талаар яриад ч хэрэггүй хүний хуучин хувцас хаяа Дэлхийн зөнгийн тусламжийн хувцас өгдөг.

Нэн ядуу болон тахир дутуу иргэдийн уулзалтанд оролцсон иргэд орон нутгийн төрийн байгууллагын ажилтангууд санал хүсэлтийг шийдвэрлэхдээ хойрог, зүй бус харьцдаг. Бид өөрсдөө хууль дүрэм, хаана хэнд хандахаа мэдэхгүй учир арга

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*мухардаад буцдаг. Бид авах ёстой ч биш гэхдээ арга тасараад орон нутгийнхаа захиргаанд ханддаг.*

*Судалгааны явцад нэн ядуу иргэдтэй уулзаж байхад өргөдөл гомдол гаргах, үзэл бодлоо илэрхийлэх эрх туйлын хаалттай болсон байна.*

*Нийгмийн халамжийн тухай хуулиар нэн ядуу тахир дутуу, нэн ядуу ахмад настанд янз бүрийн хөнгөлөлт үзүүлдэг ч хөдөлмөрийн насны нэн ядуу иргэдэд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээ уг хуулинд байхгүй байна. Иймд эдгээр иргэдийн амьжиргааны өнөөгийн байдал нь ядуурал-өлсгөлөн-өвчин гэсэн гинжин холбоог үүсгэж байна.*

*ТАЙЛАН БИЧСЭН*
*ХҮНИЙ ЭРХИЙН АЖИЛТАН* *Д.ГАНТУЯА*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Нэн ядуу иргэдийн талаар хийсэн судалгаа

Нэн ядуу иргэдийн талаар судалгаа хийхдээ нэн ядуу иргэдийн талаар гарсан Засаг даргын захирамж, ИТХ – ын тогтоолуудыг үзэж танилцан тэмдэглэл хөтөлж, анкетийн аргаар асуулга авснаас гадна аймгийн төвийн 3 баг, 3-н сумын нэн ядуу 60 орчим өрхөөр багийн дарга нартай нь явж, анкетийн асуулга авч, 32 хүнтэй бүлгийн ярилцлага хийсэн болно.

Завхан аймаг 87,7 мянган суурин хүн амтай бөгөөд хүн амын амжиргааны түвшингээр нь нэн ядуу, ядуу, ядуу бус бага орлоготой, чинээлэг гэсэн 5 бүлэгт хуваах болохоор байна.

| | |
|---|---|
| 1. Нэн ядуу | 17,2 хувь |
| 2. Ядуу | 17,8 хувь |
| 3.Бага орлоготой | 14,9 хувь |
| 4.Дунд зэргийн орлоготой | 46,1 хувь |
| 5. Чинээлэг | 4 хувь |
| Дүн | 100 хувь |

Бага орлоготой өрхийн 11,9 хувь нь ганц бие, 66,1 хувь нь 2-5 ам бүлтэй, 20 хувь нь 6-8 ам бүлтэй, 4 хувь нь 8- аас дээш ам бүлтэй байна.

Ядуу өрхийн 4% нь ганц бие, 71 % нь 2-5 ам бүлтэй, 22 % нь 6-8 ам бүлтэй, 4 % нь 8-аас дээш ам бүлтэй байна.

Нэн ядуу өрхийн 4% нь ганц бие, 68 % нь 2-5 ам бүлтэй, 24% нь 6-8 ам бүлтэй, 4% нь 8- аас дээш ам бүлтэй байна.

Нэн ядуу амьдралтай эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх 933, ядуу өрх толгойлсон эмэгтэй өрх 793, бага орлоготой ӨТЭ өрх 580 байна. Энэ нь өрхийн байршлаас хамаарахгүйгээр ядуурлалд гол төлөв ам бүл олонтой болон өрхийн тэргүүлэгчид нь эмэгтэй өрхүүд илүү өртөж байгааг харуулж байна.

Манай аймаг төвөөс нэлээд алслагдсан , дэд бүтэц сул хөгжсөн, хөдөлмөр эрхлэх боломж хомс, орлогын түвшин доогуур байгаагаас орлогын ядуурал зонхилж байна. 2001 онд явуулсан Ажилгүйдэл, ядуурлын улсын үзлэгийн түвшингээр ядуу, нэн ядуу иргэдийн тоогоор улсын хэмжээнд хамгийн өндөр байгаа дүн гарсан байх бөгөөд энэ нь сүүлийн 2-3 жил дараалан ган, зуд болсны улмаас олон малчин өрх малгүй болсон, үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг дорвитой сэргээгүйтэй холбоотой юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Амжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн иргэд хоол хүнсний байнгын хомсдолд орж, өлмөн зэлмэн байдалд аж төрж байна.
Монгол хүний өдөрт хэрэглэх хоол тэжээлийн зохистой нормыг 2900 калори гэж тогтоосон байх бөгөөд ядуу өрхийн гишүүд дунджаар 1784 калори авч байгаа тухай судалгаа байна.

Ядуу амьдралтай өрхийн хүүхдэд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэхэд ихээхэн бэрхшээл учирч байна. Ядуу өрхийн сургууль завсардсан буюу , сургуулийн гаднах хүүхдийн 70 хувь нь амьдралын гачигдал, ажил эрхлэх шаардлагын улмаас сургуульд хамрагдаагүй байна.
Ядуурлын улмаас хүүхдийнхээ хувцас, хичээлийн хэрэглэлийг худалдан авч чадахгүй байгаа өрхийн тоо өсч, хөдөө орон нутагт хүүхдийнхээ байр, хоолны

зардлыг төлж чадахгүй болсон зэрэг нь сургууль завсардалт өсөхөд нөлөөлж байна.

**Завхан аймагт амжиргааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн**

**Тус** аймаг Ядуурлыг бууруулах дэд хөтөлбөрийг 1994- 2000 онд хэрэгжүүлсэн байна. Дэд хөтөлбөрийг удирдан зохион байгуулах Аймгийн ЯБЗ – ийг 7 хүний бүрэлдхүүнтэй Аймгийн Иргэдийн Хурлын тэргүүлэгчдийн 1997 оны 3-р сарын 7 ны хурлаар батлуулжээ.

Аймаг сумдын ЯБЗ – ийн гишүүдийг ЯБҮХ – ийг хэрэгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр 6 удаагийн сургалтанд хамруулсан байна. Ядуурлыг бууруулах Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг Аймгийн ИТХ –д 2 удаа, Ядуурлын бууруулах хөтөлбөрийн газарт 1 удаа тайлагнасан байна.

Дэд хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх сан, хөдөө орон нутагт дэд бүтцийг хэрэгжүүлэх замаар ажлын түр байр бий болгох чиглэлээр нийтийг хамарсан ажил, Сургуулийн өмнөх болон Суурь боловсролыг дэмжих, Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, Хөдөөгийн малчдыг малжуулах зэрэг 825 гаруй төсөлд 815,1 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлжээ.

Үүний үр дүнд Эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжсэн 139 төсөлд 157 өрхийн 615 ядуу, нэн ядуу иргэд хамрагдаж, 133 ажлын байнгын байртай болсон байна.
Нийтийг хамарсан ажлын хүрээнд 5 суманд бэлчээрийн болон төв суурин газрын усан хангамжийг сайжруулах чиглэлээр , 6 суманд зам гүүрийн засварын ажил, нийтийн хог цэвэрлэгээ, халуун усны барилга засвар зэрэг төслүүдэд 719 ядуу иргэдийг хамруулж, ажлын түр байраар хангасан байна.

Эмэгтэйчүүдийн орлого нэмэгдүүлэх сангийн 62 төсөлд 317 хүн, 81 өрх хамрагдаж 53 төсөл хэрэгжжээ.

**Хөдөөгийн хүн амын эрүүл мэнд, боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хийсэн ажил**

Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр нийт 81 төсөлд 172,0 сая төгрөгийн санхүүжилт хийж, 12 суманд эмнэлгийн түргэн тусламжийн машин, 13 сумыг багийн бага эмчийн унаагаар хангаж, 75 уналгын морь олгосон байна. Тосонцэнгэл суманд эрүүл мэндийн сайн дурын ажилтны сургалт явуулан, 15 сумын төрөхийн өмнөх байрыг иж бүрэн тохижуулж, 18 сумын эмнэлгийн халаалт, засвар, гэрэлтүүлгийн асуудлыг шийдвэрлэжээ.

Суурь боловсролыг бэхжүүлэх чиглэлийн 49 төсөлд 23 сум хамрагдаж, 88 сая төгрөгийн төсөл хэрэгжин 49 сургуулийн халаалт, засвар, гэрэлтүүлгийн асуудал шийдвэрлэгдэв.
Сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх чиглэлийн 51 төсөлд 66,0 төгрөгийн санхүүжилт хийгдэж, 14 цэцэрлэгийн засвар халаалт, 3 суманд гэр цэцэрлэг, 12 суманд ээлжийн бүлэг зохион байгуулж 521 хүүхэд хамрагдсан байна. Цэцэрлэгийн туслах аж ахуйн 14 төсөлд нийт 842 толгой малтай болж, СӨББ- н чиглэлийн төсөлд нийт 5670 хүүхэд хамрагдсанаас малчдын хүүхэд 2306, ядуу өрхийн хүүхэд 485, хагас өнчин хүүхэд 289, ажил эрхэлдэг хүнгүй эрхийн хүүхэд 1485 байна. Цэцэрлэгт хамрагдалтын хувь 22,4 болжээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Нэн ядуу иргэдэд үзүүлсэн тусламж, дэмжлэгийн талаар**

Нийт 24 сумын 589 иргэнд тусламж олгож, 6728 хүн төслөөс ашиг хүртсэн байна. 30,5 сая төгрөгийн буцалтгүй тусламж, хоол хүнс, түлш зэрэгт олгожээ.

Аймгийн нийт нэн ядуу хүн амын тоо, насны ангилал, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргийг хүснэгтээр үзүүлэн хавсаргав.

Улиастай сумын хэмжээн дэх нэн ядуу иргэдийн байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

| Он | Сумын нийт хүн ам | Нэн ядуу | | Нийт хүн амд эзлэх хувь | Өрхийн | |
|---|---|---|---|---|---|---|
| | | өрх | Хүн ам | | Насны бүтэц | Дундаж орлого / мян төг/ |
| 2000 | 21600 | 803 | 3452 | 15,9% | 0-45 | 6,0-8,0 |
| 2001 | 17887 | 961 | 4062 | 22,7% | 0-60 | 5,0-10,0 |
| 2002 | 16618 | 952 | 3998 | 24% | 0-55 | 5,0-12,0 |

Сумын нэн ядуу 10 өрхөд 1998 онд Чигэстэй багийн нутаг дэвсгэрт байрлах өвлийн сууц олгосон байна. 2000 онд зудын гамшигт малгүй болсон нэн ядуу 40 гаруй өрхийг 30 гаруй сая төгрөгийн малжуулах төсөлд хамруулж, 2002 онд орон байргүй хараагүй 1 иргэнд өвлийн бүрээстэй гэр өгсөн байна.

Нэн ядуу иргэдийн боловсролын түвшинг авч үзвэл бага, бүрэн бус дунд бүрэн дунд боловсролтой иргэд 60-80 %, тусгай дунд, дээд боловсролтой иргэд 5-10 %- ийг эзэлж байна.

Улиастай сумд 2002 онд нэн ядуу 162 иргэнийг халамжийн үйлчилгээнд хамруулж, 6480,0 төгрөгийн тусламж үзүүлсэн байна.

Улиастай сумын хэмжээгээр 273 хүн халамжийн тэтгэвэр авч байгаагаас 221 нь нэн ядуу, амьдралтай хүмүүс байна. 2002-2003 онд Улиастай сумын хэмжээгээр нэн ядуу 239 хүнийг төлбөргүйгээр тогооч, үсчин, зурагчин, оёдолчин, гэх мэтийн дамжаанд хамруулахад төрөөс 5975,0 төгрөгийн зардал гаргасан байна.

Нэн ядуу хүмүүсийн болон хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах чиглэлийн төслийн Төрөхийн өмнөх байрыг тохижуулах төслийн гүйцэтгэгчийг төрийн бус байгууллагуудын дунд тендер зарлаж, Аймгийн УЗН шалгарснаар 14 сумын төрөхийн өмнөх байрыг тохижуулах ажлыг үр дүнтэй хийжээ.

Нэн ядуу иргэдэд төслийн шугамаар зээл олгодг боловч эргэн төлөгддөг нь тун цөөхөн учир дараагийн төсөл орж ирхэ, бусад хүмүүст зээл өгөхөд хүндрэл учруулдаг ажээ. Судалгааны явцад анхаарахад говийн сумаасаа илүү хангайн сум ядуурлад их өртсөн байлаа. Тосонцэнгэл сумд ядуурал их байгаагийн шалтгааныг тодруулахад энд үйлдвэр олонтой, Мод боловсруулах үйлдвэр гэх мэт ажиллагсад олонтой байгаад тарж үгүй болсноор ажилгүй хүмүүс олширсонтой холбоотой гэж үзэж байна.

UIH.MN
ТУЛААН АНЫ САН

# Нэн ядуу өрхийн хүн амын судалгаа

| д\д | Сумдын нэр | Нэн ядуу хүн амын тоо | Насны бүлгээр | | | | | | | Хөдөлмөрийн насны | | | | | | Тэтгэврийн насны | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 0-3 насны | | 4-7 насны | | | 8-16 насны | | | | | | | | | | | |
| | | | гэрт | ясли | цэцэрлэгт | халамжийн цэцэрлэгт | гэрт | ЕБС | Сургууль завсардсан | Суралцдаг | Ажилтай | Ажилгүй | Цэрэгт | Ял эдлэж байгаа | хөдөлмөрийн чадваргүй | Өндөр насны тэтгэвэрт | Халамжийн тэтгэвэрт | Ажил эрхлэл дэггүй | Огт орлогогүй |
| | А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 1 | Тэлмэн | 1494 | 163 | | 3 | 7 | 226 | 276 | 32 | 19 | 463 | 261 | 2 | 1 | | 16 | 25 | 1 | |
| 2 | Баянтэс | 462 | 52 | | 5 | | 98 | 82 | 13 | | 145 | 61 | 4 | | | 2 | | | |
| 3 | Түдэвтэй | 1271 | 161 | | 12 | | 151 | 199 | 54 | 26 | 345 | 287 | 6 | | 7 | | 23 | 19 | |
| 4 | Шилүүстэй | 752 | 76 | | 8 | | 105 | 145 | 23 | 7 | 180 | 197 | [illegible] | | | 5 | 4 | | |
| 5 | Тэс | 794 | 71 | | 30 | | 72 | 128 | 10 | | 119 | 257 | | | 4 | 98 | 5 | | |
| 6 | Асгат | 687 | 50 | | | | 98 | 151 | 33 | 9 | 46 | 272 | 2 | 1 | 2 | 9 | 14 | | |
| 7 | Алдархаан | 1837 | 184 | | 10 | 2 | 270 | 301 | 72 | 19 | 128 | 799 | 4 | | 3 | 32 | 13 | 3 | 3 |
| 8 | Яруу | 2336 | 177 | | 40 | | 191 | 409 | 112 | 53 | 409 | 693 | 151 | 1 | 7 | 61 | 32 | | 2 |
| 9 | Сонгино | 633 | 62 | | 6 | | 105 | 124 | 17 | 7 | 152 | 133 | 8 | 1 | 4 | 9 | 5 | | |
| 10 | Их-Уул | 4443 | 603 | | 4 | | 845 | 544 | 206 | 23 | 545 | 1462 | 6 | 9 | 8 | 137 | 51 | 104 | 721 |
| 11 | Эрдэнэхайрхан | 94 | 5 | | 1 | | 7 | 31 | 4 | 1 | 16 | 22 | 1 | | 1 | 3 | 2 | | |
| 12 | Сантмаргац | 721 | 68 | | 4 | 6 | 128 | 154 | 7 | 12 | 32 | 299 | 4 | | | 4 | 3 | | |
| 13 | Нөмрөг | 731 | 91 | | | | 103 | 129 | 17 | 21 | 262 | 98 | 3 | 1 | 1 | 2 | 3 | | 1 |
| 14 | Завханмандал | 241 | 34 | | 6 | | 34 | 74 | 6 | 7 | 45 | 30 | 2 | | | 1 | 2 | | |
| 15 | Цагаанчулуут | 205 | 25 | | | | 29 | 52 | | 2 | 37 | 50 | 1 | | 2 | 2 | 5 | | |
| 16 | Баянхайрхан | 1377 | 113 | | 47 | | 233 | 253 | 60 | 9 | 172 | 455 | 2 | | | 23 | 10 | | |
| 17 | Ургамал | 296 | 40 | | 6 | | 21 | 70 | 6 | 6 | 45 | 81 | 4 | | | 9 | 8 | | |
| 18 | Отгон | 559 | 47 | | 7 | | 30 | 64 | 8 | 16 | 23 | 211 | 8 | 1 | 5 | 127 | 12 | 6 | 3 |
| 19 | Улиастай | 4062 | 260 | | 86 | 25 | 290 | 1283 | 58 | 141 | 134 | 1578 | 17 | 5 | 12 | 157 | 16 | 121 | 5 |
| 20 | Тосонцэнгэл | 3112 | 290 | | 9 | 3 | 400 | 650 | 79 | 38 | 120 | 1407 | 1 | 4 | 25 | 52 | 29 | | 5 |
| 21 | Идэр | 1678 | 175 | | | 3 | 296 | 283 | | 19 | 395 | 437 | 1 | | 5 | 17 | 11 | | |
| 22 | Дөрвөлжин | 241 | 13 | | 2 | | 30 | 71 | 7 | 5 | 88 | 16 | 3 | | 1 | 4 | 1 | | |
| 23 | Цагаанхайрхан | 371 | 43 | | 7 | 5 | 39 | 35 | 6 | | 122 | 94 | 2 | | 2 | 11 | 5 | | |
| 24 | Цэцэн-уул | 935 | 48 | | 31 | | | 73 | | 13 | 57 | 636 | 9 | | | 59 | 9 | | |
| | Нийт дүн | **29332** | **2851** | | **324** | **51** | **3801** | **5581** | **830** | **453** | **4080** | **9836** | **243** | **24** | **89** | **840** | **288** | **254** | **740** |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | | Ажил эрхэлдэггүй хүн | | | | | | Эрүүл мэндийн байдлаар | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Мэргэжлээр | | | | | | |
| Төсөвт байгууллагад | Төрийн өмчийн бусад байгууллагад | Хувийн хэвшилд | ХАА компани | Ардын аж ахуйтан | Хувиараа хөдөлмөр эрхэлдэг | Бусад | Ажил идэвхгэй эрж байгаа | Ажил эрж хайхгүй байгаа | АДТэт гэмж авдаг | мэргэжилтэй | мэргэжилгүй | ажиллах сонирхолтой | Оюуны хомсдолтой | Хараагүй | хэлгүй дүлий | Бусад эрхтний гажигтай |
| 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 |
| | 2 | 16 | | 396 | 36 | 13 | 121 | 86 | | 6 | 33 | 14 | | | 2 | |
| 2 | | 1 | | 142 | | | 47 | 14 | | 27 | 31 | 34 | 1 | | | 6 |
| 6 | 6 | 2 | | 329 | 2 | | 131 | 29 | 2 | 14 | 68 | 29 | 5 | 3 | 4 | 11 |
| 3 | | 2 | | 172 | 2 | 1 | 46 | 6 | | 22 | 107 | 14 | 1 | 1 | 2 | 1 |
| 15 | 28 | 18 | 2 | 56 | | | 21 | 41 | | 8 | 34 | 31 | 4 | | | 2 |
| 4 | | | 1 | 9 | 23 | 3 | 125 | 170 | | 48 | 169 | 12 | 2 | | | |
| 5 | 14 | | | 105 | 4 | | 211 | | | 11 | 3 | 164 | | | 1 | 1 |
| 18 | | | | 297 | 89 | 2 | 653 | 48 | | 58 | 166 | 385 | | 1 | 1 | 2 |
| | 2 | | | 150 | | | 85 | 48 | | 10 | 109 | 83 | 2 | 2 | | 2 |
| 22 | 5 | 4 | 1 | 498 | 9 | 6 | 579 | | | 68 | 82 | 14 | 3 | 1 | 1 | 5 |
| 1 | | 1 | 1 | 11 | | 2 | 9 | 22 | | | 22 | 9 | | | | |
| 9 | | | | 17 | 6 | | 4 | | | | | 20 | | | | |
| 1 | | 3 | | 256 | 2 | | 45 | 63 | 1 | 11 | 87 | 6 | | | 1 | 2 |
| 1 | | | 1 | 41 | 1 | 1 | 44 | 11 | | 2 | 2 | | | 2 | | |
| 2 | | 2 | | 23 | 10 | | 7 | 27 | | 1 | 32 | | | | | |
| 18 | | | | 87 | | 67 | 51 | | | | 117 | | | | 4 | |
| 1 | | | | 42 | 2 | | 40 | 41 | | 2 | 2 | 23 | | | | |
| 6 | 2 | 1 | - | 6 | 8 | | 123 | 88 | 2 | 77 | 134 | 10 | 3 | | 4 | 2 |
| 29 | 18 | 33 | | 28 | 26 | | 1538 | 40 | | 449 | 612 | 428 | 4 | | 6 | 10 |
| | | 20 | | 69 | 31 | | 1170 | 237 | | 70 | 767 | 534 | 20 | | 3 | 12 |
| 2 | | 1 | | 253 | | 139 | 331 | 90 | | 55 | 243 | 39 | 2 | | 2 | 5 |
| 1 | | 84 | | 1 | | 2 | 6 | 1 | | 4 | 37 | 3 | | | 1 | 1 |
| 2 | | | | 117 | 3 | | 5 | 90 | | 13 | 206 | 58 | 3 | | 2 | 1 |
| 13 | | | | 44 | | | 173 | | | 21 | 127 | | | | | 7 |
| **161** | **77** | **188** | **6** | **3149** | **254** | **236** | **5565** | **1152** | **5** | **977** | **3190** | **1910** | **50** | **10** | **39** | **70** |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| хэвтрийн өвчтэй | Бүтэн өнчин хүүхэд | Хагас өнчин хүүхэд | Хог түүж амьдардаг Ганц бие | Гэр бүлгэй | Орон гэргүй | Зээл тусламж авсан хүн: ЯБСангаас Хүний тоо | ЯБСангаас Мөнгөний хэмжээ | Бусад төрлийн туслам. Хүний тоо | Бусад төрлийн туслам. Мөнгөний хэмжээ | Хоол хувцас авсан Хүний тоо | Хоол хувцас авсан Мөнгөний хэмжээ | Зээл тусламж огт аваагүй хүний тоо | Шаардагдах тусламж дэмжлэг \хүний тоогоор \ Ажилд орох | малтай болох | ногоо тарих | зээл авах | асрамжид явах | бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 |
| 3 | | 13 | | | | 3 | 500000 | 1494 | 12699000 | | | | 119 | 362 | 75 | 111 | | |
| 1 | 1 | 19 | | | | 9 | 180000 | 203 | 1245000 | 280 | 1176000 | 49 | 29 | 146 | 2 | 22 | | |
| 1 | 2 | 16 | | | | 2 | 200000 | | | | | 228 | 98 | 362 | 20 | 38 | 27 | |
| | 3 | 4 | | | | 16 | 2690000 | 65 | 4184600 | 752 | 3846100 | 1 | 28 | 136 | | 66 | | 8 |
| | 6 | 65 | | | | 12 | 2000000 | | | | | 163 | | | | 2 | | |
| | 3 | 7 | | | | | | 347 | 1416000 | | | | 41 | 65 | 2 | 38 | | |
| | | 24 | | | | 48 | 1675000 | 1195 | 3573420 | 1408 | 3662170 | | 13 | 92 | 13 | 81 | | 38 |
| | 2 | 37 | | | | 5 | 1000000 | 11 | 6160000 | 46 | 3305000 | | 341 | 307 | 23 | 77 | | |
| | | 4 | | | | 18 | 1800000 | 206 | 7650000 | | | | 42 | 260 | 41 | 39 | | |
| | 17 | 71 | | | | 31 | 800000 | | | | | | 380 | 1097 | 137 | 235 | | |
| | 1 | 5 | | | | 10 | 1788000 | | | | | 2 | 21 | 8 | | 9 | | |
| | 11 | 4 | | | 4 | 119 | 12500000 | 10 | 30000 | 482 | 3245000 | | 70 | 87 | | 17 | 1 | |
| 4 | 3 | 6 | | | | 1 | 200000 | | | | | 220 | 18 | 274 | 5 | 31 | 1 | 21 |
| | 3 | 2 | | | | 12 | 432000 | 72 | 788400 | 268 | 2267900 | | 2 | 60 | | 22 | | |
| | | | | | | | | 56 | 4480000 | | | | 11 | 44 | 2 | 44 | | |
| | 12 | 2 | 8 | | | | | 38 | 2000000 | | | | 17 | 185 | 8 | 179 | | |
| | 2 | 2 | | | | 3 | 300000 | | | | | 8 | 31 | 58 | | | | |
| 1 | | 8 | | | | | | | | | | | 101 | 22 | | 6 | | |
| 4 | 4 | 156 | | | | | | 545 | 1230100 | 702 | 2114500 | 41782 | 814 | 117 | 277 | 504 | 2 | 129 |
| 5 | 14 | 100 | | | | 23 | 2300000 | 1078 | 6823000 | 303 | 1520000 | 1233 | 570 | 310 | 113 | 466 | | 52 |
| | 9 | 39 | | | | 8 | 1400000 | 966 | 7177000 | 701 | 3595950 | 36 | 57 | 583 | 7 | 75 | 1 | 124 |
| | | 15 | | | | | | 241 | 1753000 | 36 | 423 | | 3 | 144 | 1 | | 1 | 28 |
| 2 | 3 | 5 | | | | 43 | 1726400 | 183 | 116000 | 371 | 1128400 | | 5 | 119 | 14 | 8 | | |
| | | 4 | | | | 4 | 4000000 | 3 | 300000 | 214 | | 43 | 1511 | 139 | 31 | 9 | | |
| **21** | **96** | **608** | **8** | | **4** | **367** | **35491400** | **6713** | **61625520** | **5563** | **25861443** | **43765** | **4322** | **4977** | **771** | **2079** | **33** | **400** |

UH.MN СҮЛЖЭЭНИЙ САН

## Завхан аймагт Өрхийн амьжиргааны чадвахийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2001-2006 онд хэрэгжих төслийн жагсаалт

2001.11.15

(мян.төг)

| д/д | Сумдын нэр | СУРГУУЛЬ | | | ЭМНЭЛЭГ | | | | | | | | | Нийтийг хамарсан ажил | | | | ЭБОН | ЭХСан | Малжуу | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Халаалт,засвар | дотуур байрын засвар | Туслах аж ахуй | Засвар | ТӨБайр | ББЭУ(нажуу) | Сургалт | ТТ машин | Халаалт | засвар,гэр цэц | тоглоом,сургалт | ээлжийн бүлэг | худаг засвар | зам гүүр, засвар | хог цэвэрлэгээ | халуун ус | | | | |
| 1 | Алдархаан | 5000.0 | | | 3000 | 800 | | | | | | 1400 | | | | | | 3000.0 | 3000.0 | | 16200.0 |
| 2 | Асгат | | 2000 | 1000 | | | | | | | 2000 | 1400 | 1000 | | | | | | 3000.0 | | 10400 |
| 3 | Баянтэс | 8000 | | | 2000 | | | | | | 2000 | 1400 | | 3000 | | | | 3000 | 3000.0 | 40000 | 62400 |
| 4 | Баянхайрхан | 3000 | 2000 | 1000 | 4000 | | | | | 3000 | | 1400 | 1000 | | | | | 3000 | 3000 | 50000 | 71400 |
| 5 | Тосонцэнгэл | 16000 | | | 15000 | | | | 4000 | 8000 | 4000 | 2800 | | | | 2000 | 5000 | 12000 | 13000.0 | | 81800 |
| 6 | Дөрвөлжин | 4000 | 2000 | 1000 | 3000 | | | | | 3000 | 2000 | 1400 | | | | | | | 3000 | | 19400 |
| 7 | Завханмандал | 8000 | | | 3000 | | | | | 5000 | | 1400 | 1000 | | 5000 | | | | 3000.0 | | 26400 |
| 8 | Идэр | | 3000 | 1000 | 2000 | | | | | | 2000 | 1400 | | | 5000 | | | 3000 | 3000.0 | 40000 | 60400 |
| 9 | Их-уул | | | | 2000 | 800 | 800 | | | 4000 | | 1400 | | | | | | 3000 | 3000.0 | 50000 | 65000 |
| 10 | Нөмрөг | 5000 | 2000 | 1000 | 3000 | | | | | | 2000 | 1400 | 1000 | | | | 6000 | 3000 | 3000.0 | 40000 | 67400 |
| 11 | Отгон | 5000 | | | 3000 | 800 | | | | 5000 | | 1400 | | | 6000 | | | 3000 | 3000.0 | | 27200 |
| 12 | Сантмаргац | 3000 | 2000 | 1000 | 5000 | | 1000 | | | 4000 | 2000 | 1500 | | | | | | | 3000 | | 22500 |
| 13 | Сонгино | 3000 | | | | | | | 4000 | | 2000 | 1500 | 1000 | | | | | 3000 | 3000 | | 17500 |
| 14 | Түдэвтэй | 5000 | 2000 | 1000 | | | | | 4000 | | 2000 | 1400 | | | | | | 3000 | 3000 | 40000 | 61400 |
| 15 | Тэс | | | | 2000 | | 800 | | | 4000 | 2000 | 1400 | 1000 | | | 3000 | | 3000 | 3000 | | 20200 |
| 16 | Тэлмэн | 5000 | 3000 | 1500 | | 800 | 800 | | | | 2000 | 1400 | | | | | | 3000 | 3000 | 46000 | 66500 |
| 17 | Ургамал | 5000 | | | | | | | | 3000 | 2000 | 1500 | | 3000 | | | | | 3000.0 | | 17500 |
| 18 | Улиастай | | | | | | 6000 | 8000 | 4000 | | 10000 | 8000 | 1000 | | | 2000 | | 6000 | 21000 | | 66000 |
| 19 | Цагаанхайрхан | 6000 | 4000 | 1200 | 5000 | | | | | | | 1400 | | | 6000 | | 3000 | 3000 | 3000 | | 32600 |
| 20 | Цагаанчулуут | 8000 | 3000 | 1000 | 4000 | 800 | 1000 | | | 3000 | 2000 | 1800 | | | | | | | | | 24600 |
| 21 | Цэцэн-уул | 5000 | | | 3000 | | | | | | 2000 | 1800 | | | | | | 3000 | 3000.0 | | 17800 |
| 22 | Шилүүстэй | | | | 3000 | | 800 | | | 3000 | 2000 | 1400 | | | | | | 3000 | | | 13200 |
| 23 | Эрдэнэхайрхан | 8000 | 3000 | 1000 | 3000 | 800 | | | | 3000 | 2000 | 1400 | | | | | | 3000 | | | 25200 |
| 24 | Яруу | | | | 2000 | 800 | | | | 2000 | 2000 | 1400 | | | | | | 3000 | 3000.0 | | 14200 |
| | Дүн | 102000.0 | 28000 | 11700 | 67000 | 5600 | 11200 | 8000 | 16000 | 50000 | 46000 | 42700 | 7000 | 6000 | 22000 | 7000 | 14000 | 66000.0 | 91000.0 | 306000 | 907200.0 |

Тооцоо хийсэн ӨАЧДэмжих Аймгийн зөвлөлийн

| 54 | Отгонсүрэн Улаанаа | 80% | эр | Y баг | Иж 80070415 | Ахуйн осол |
| 55 | Бумаа Цагаанбаатар | 70% | эр | IY баг | Еа 75090210 | Ахуйн осол |
| 56 | Авирмэд Саранцэцэг | 70% | эм | II баг | Мю 62020407 | Ердийн |
| 57 | Ичинхорлоо Нарантуяа | 80% | эм | III баг | Мж 72060408 | Ердийн |
| 58 | Чулуунбат Хүрэлбаатар | 70% | эр | IY баг | Мь 73121619 | Төрөлхийн |
| 59 | Жаргалсайхан Эрдэмсоёл | 70% | эм | I баг | Мь 85042507 | Төрөлхийн |
| 60 | Нямсүрэн Мөнхзул | 70% | эр | II | Йф 64072511 | Ердийн |
| 61 | Батаа Оюун-Эрдэнэ | 70% | эм | IY баг | Мэ 78040700 | Ердийн |
| 62 | Даваахүү цэндсүрэн | 70% | эм | IY баг | Дк 65070508 | Ердийн |
| 63 | Дамдинсүрэн Түвшинжаргал | 70% | эр | III баг | Мю 86020511 | Төрөлхийн |
| 64 | Чимэд-Очир Янжинсүрэн | 70% | Эм | II баг | Хз 83072268 | Ердийн |
| 65 | Норов Цолмон | 70% | эр | Y баг | Мь 60101214 | Ердийн |
| 66 | Дамдин Өлзийбаяр | 70% | эм | IY баг | Дю 57060161 | Ердийн |
| 67 | Халтар Алтанхуяг | 70% | эр | III баг | мэ 85120731 | Ердийн |
| 68 | Пагмадулам Мэнджаргал | 80% | эр | IY баг | Ма 77031218 | Ахуйн осол |
| 69 | Жуков Соёлтөр | 70% | эр | II баг | Мн 80122073 | Ердийн |
| 70 | Монц Мөнхбаяр | 70% | эр | I баг | Мь 81020812 | Ердийн |
| 71 | Пэрэнлэй Отгонцэцэг | 70% | эм | I баг | | Ердийн |
| 72 | Даваадорж Баттунгалаг | 80% | эм | III баг | Мл 69051567 | Төрөлхийн |
| 73 | Нэргүй Түвшинжаргал | 70% | эр | IY баг | Мю 80050374 | Ердийн |
| 74 | буянхишиг Пүрэвхүү | 70% | эм | I баг | Мь 77042201 | Ердийн |
| 75 | цагаан Золбаатар | 70% | эр | IY баг | Мэ 72010518 | Ахуйн осол |
| 76 | Хэнмэдэх Мөнхтуяа | 70% | эм | IY баг | Мю 78112360 | Төрөлхийн |
| 77 | Дорж болормаа | 70% | эм | Y баг | Мь 73082802 | Ердийн |
| 78 | бямбажав Насан-Өлзий | 90% | эр | IY баг | Ит 84112718 | Ахуйн осол |
| 79 | Бадам Сарантуяа | 70% | эм | Y баг | Мэ 68050101 | Ердийн |
| 80 | Лувсансандаг Хишигжаргал | 70% | эм | II баг | Мю 76011961 | Ахуйн осол |
| 81 | Лхагва Чинбаяр | 70% | эр | IY баг | | Төрөлхийн |
| 82 | Дорж Ганбаатар | 70% | эр | III баг | Мю 74031211 | Ердийн |
| 83 | батжий Батмөнх | 80% | эм | I баг | Ря 60021103 | Төрөлхийн |
| 84 | Чагнаадорж баасандорж | 70% | эр | III баг | Мю 86050211 | Ахуйн осол |
| 85 | Түмэнжаргал Баяржаргал | 70% | эр | IY баг | Мь 86110312 | Ахуйн осол |
| 86 | Энхсайхан Болортуяа | -30% | эм | III баг | Мк 75091199 | Ердийн |
| 87 | Чилгэр Нямсүрэн | 70% | эм | III баг | Мю 74122901 | Ердийн |
| 88 | гүнгэрэгжав Сарангэрэл | 70% | эм | III баг | | Ердийн |
| 89 | Болд Энхбаатар | 70% | эр | I баг | | Төрөлхийн |
| 90 | Болд энхжаргал | 70% | эм | I баг | Мв 76050804 | Төрөлхийн |
| 91 | Даваа Хишигжаргал | 70% | эр | IY баг | Мь 75010518 | Ахуйн осол |
| 92 | Борис Наранцэцэг | 70% | эм | I баг | | Төрөлхийн |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 93 | Болд Батхуяг | 70% | эр | Y баг | | Төрөлхийн |
| 94 | Цагаан-Арслан Батбилэг | 70% | эр | IY баг | | Ердийн |
| 95 | Нямжав нармандах | 70% | эр | III баг | | Ердийн |
| 96 | Борис Оюун-Эрдэнэ | 70% | эм | I баг | | Төрөлхийн |
| 97 | Даваатөмөр Нямдорж | 70% | эр | III баг | | Төрөлхийн |
| 98 | Пүрэвдорж Уяахундага | 70% | эр | I баг | | Төрөлхийн |
| 99 | цэдэн"Очир Эрдэнэбат | 100% | эр | III баг | | Төрөлхийн |
| 100 | Валя Цолмон | 70% | эр | Y баг | | Ердийн |
| 101 | Нарангэрэл Болортуяа | 70% | эм | III баг | | Төрөлхийн |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Төв аймгийн хэмжээнд нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлыг шалган судалсан ажлын тайлан**

2002- 3- 10.

Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын батлагдсан удирдамжийн дагуу аймгийн нэн ядуу иргэдийн эдийн засаг,нийгэм соёлын болон улс төр, иргэний эрхийн төлөв байдлын судалгааг аймгийн төв , хөдөөгийн сум баг албан байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан зохион явууллаа.

1. **Судалгааг эрхлэн явуулсан баг, ажлын зохион байгуулалт**

2003 оны 2-р сарын 11-ны өдрийн аймгийн Засаг даргын 45-р захирамжаар аймгийн хүүхэд, тахир дутуу, нэн ядуу иргэдийн нийгмийн хамгаалал, эрхийн төлөв байдалд шалгалт судалгаа хийх ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын хууль зүйн хэлтсийн даргаар ахалуулан байгуулж хөдөө орон нутагт 2 групп гарган ажиллаа.Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Хууль зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга : ХЭҮК-ын төлөөлөгч
Гишүүдэд : Нийгмийн халамж үйлчилгээний төвийн дарга
Мэргэжлийн хяналтын албаны тасгийн дарга
Хүүхдийн төлөө төвийн дарга
НХБХ-ийн мэргэжилтэн
ӨАЧДТ-ийн нарийн бичгийн дарга
Нийгмийн эрүүл мэндийн албаны дарга
Зуунмод сумын ЗДТГ-ын дарга

Нэн ядуу болон тахир дутуу иргэдийн судалгааг 2-р сарын 10 наас 3-р сарын 10 хүртэл нэг сарын хугацаанд явуулж төв хөдөөгийн 7 сум, 26 баг, 50 гаруй өрх ,20 гаруй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, асрамж , халамжийн төв, шашны болон буяны байгууллагууд болон 10 гаруй компани , аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдсан байна.

Ажлын хэсгийн гишүүд 2 группт болж 6 хоногийн хугацаагаар баруун ба хойд чиглэлд тус бүр 3 суманд / Эрдэнэсант, Лүн, Аргалант, Борнуур,Жаргалант, Баянчандмань/ томилолтоор ажиллаж сумын ЗДТГ, багийн Засаг дарга нартай хамтран ажиллаа.

Судалгааны сумдыг амьжиргааны төвшин эдийн засгийн байдал , газар зүйн байршил хүн амын тоо , зэргийг харгалзан сонгон авсан болно.

Судалгааг -тоон болон баримт бичигт дүн шинжилгээ хийх арга
-ажиглалтын арга
-нэн ядуу иргэдтэй байгаа орчинд нь ганцаарчилан болон бүлгээр уулзаж ярилцлага хийх замаар анкетын асуулга авах оролцооны аргаар явууллаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## 1. Макро түвшний судалгаанд хамрагдсан байгууллага,нэгж

Нэн ядуу иргэдийн талаарх баримт бичгийн судалгааг
-Аймгийн ЗДТГ-ын НХБХ
-Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх төсөл
-Халамж үйлчилгээний төв
-Хөдөлмөр зохицуулалтын алба
-Сум, багийн Засаг дарга нар

./Холбогдох бичиг баримт материалуудыг хавсаргав./

### 1.1 Нэн ядуу иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр аймгийн Халамж үйлчилгээний төвөөс хэрэгжүүлсэн ажлын товч тайлан:

2002 онд аймгийн Халамжийн төв улсын төвлөрсөн төсвөөс 698,7 сая төгрөгийн санхүүжилт авч түүнээс халамжийн тэтгэвэрт 1766 хүнд 217,3 сая төгрөг, тэтгэмжинд 4004 хүнд 388,7 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлтөнд 135 хүнд 13,8 сая төгрөг, нийгмийн халамж асрамжийн үйлчилгээнд 94 хүнд 2,3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Батсүмбэр, Зуунмод, Баянчандмань зэрэг 10 гаруй сумын 159 нэн ядуу амьдралтай хүнд 840,0 мянган төгрөгийн хүнсний болон 600,0 мянган төгрөгийн хувцасны тусламж олгосон байна.

**Төв аймгийн нийгмийн халамжийн төвөөс үзүүлж байгаа халамж асрамжийн үйлчилгээний төрөл, хүртээмж**

| Үйлчилгээний төрөл | 1999 | | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хүний тоо | Мөнгөний тоо | Хүний тоо | Мөнгөний тоо | Хүний тоо | Мөнгөний тоо |
| Халамжийн тэтгэвэр | 1403 | 148,6 сая төг | 1605 | 192,6 сая төг | 1835 | 223,1 сая төг |
| Халамжийн тэтгэмж | 4488 | 205,8 | 3990 | 305 | 4004 | 388,7 |
| Ахмад настны хөнгөлөлт үйлчилгээ | 1021 | 96,8 | 1773 | 61,6 | 1977 | 79,1 |
| Тахир дутуу иргэдийн хөнгөлөлт үйлчилгээ | 20 | 0,7 | 392 | 15,6 | 351 | 15,8 |
| Халамж асрамжийн үйлчилгээнд | | | | | 94 | 2,3 |
| | | | | | 8170 | 698,7 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**1.2 Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 1995-2001 онд Төв аймагт зохион байгуулсан ажлын тайланд дараах асуудлууд тусгагдсан байна. Үүнд:**

- Тухайн орон нутагт ядуу , нэн ядуу өрхийн судалгааг бодит байдалд тулгуурлан сум өөрсдөө гаргаж амьжиргааг нь дээшлүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч байхаар шийдвэрлэсэн байна. Эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх зээлийг амьдралын бололцоогүй, зээлийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж хугацаанд төлөх чадвар бүхий ажилгүй иргэдэд олгож байх бодлогыг сүүлийн жилээс эхлэн баримталж ирсэн байна.

- Энэ зээлд хамрагдах боломжгүй хэсгийг нь чадалтай хүмүүсийг дагалдуулан төсөлд хамруулахын зэрэгцээ зарим хэсгийг нийтийг хамрасан ажлын хүрээнд ажлын байраар хангаж орлогын эх үүсвэртэй болгох , хөдөлмөрийн чадваргүй халамж шаардлагатай хэсгийг нь олон улсын хүмүүнлэгийн болон орон нутгийн төсвөөс үзүүлж буй тусламжид хамруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна

- ЯБНСанд гадаадын хандивлагчид болон ЯБХГазраар дамжуулан 400,7 сая, орон нутгийн төсвөөс 16,6 сая нийт 417,3 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлэн 27 сумыг хамруулж төсөл санхүүжүүлсэн.
- Орон нутгийн хөгжлийн сангаас нийтийг хамарсан ажилд 41 төсөлд

157,1 сая, эрүүл мэндийн 6 төсөлд 12 сая, суурь боловсролын 10 төсөлд 24 сая, сургуулийн өмнөх боловсролд 33 төсөлд 44,5 сая төгрөг, эмзэг бүлгийн орлого бий болгоход 400 гаруй төсөлд 97,8 сая төгрөг зарцуулжээ.

Энэ ажлын хүрээнд нэн ядуу өрхийн хөдөлмөрийн чадвар бүхий 980 хүнийг ажлын байнгын байраар, 6200 хүнийг ажлын түр байраар хангасан байна.

- Нэн ядуу иргэдэд туслах сангаас 23,3 сая төгрөгийн санхүүжилт авч цэцэрлэгийн хүүхдийн хоолны үнийн хөнгөлөлтөнд 3,38 сая, хоол хүнсний тусламжид 13 сая төгрөг, хувцас олголтонд 6,3 сая төгрөг, хичээлийн хэрэглэлд 1,5 сая төгрөг зарцуулж 1940 өрхийн 7960 хүнд тусламж үзүүлсэн байна.
- ЯБҮХ-ийн хүрээнд орон нутагт ажиллаж байсан ЯБЗөвлөлийн бүрэлдэхүүн 2002 оноос Өрхийн амьжиргааны чадварыг дээшлүүлэх шинэ хөтөлбөр хэрэгжиж эхлэхэд 74 хувь нь өөрчлөгдсөн байна. Орон нутагт хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэх ,зээл төлөлтийг хариуцан ажиллах ажилтныг орон тоогоор ажиллуулж эхний ээлжинд зээлийн хүүгийн урамшууллаар цалинжуулж туршихаар Зуунмод, Угтаалцайдам сумдад ажиллуулж эхэлжээ.
- Зээлийн эргэлтийн санд ЯБҮХ-ийн хүрээнд 125,4 сая төгрөг төвлөрүүлж 25 суманд хуваарилсан ба 2002 онд эргэлтийн сангаас Эрдэнэ, Архуст, Баянжаргалан ,Батсүмбэр, Угтаал, Зуунмод сумдад өрхөөр үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж зээлээр 15,3 сая төгрөгийн санхүүжилт олгосноор 44 өрхийг ажлын байраар хангаж орлогын эх үүсвэртэй болгосноор 179 хүн ашиг хүртэж байна.
- Зуунмод сумын театр киноны хүрээлэнгийн дээврийн засварын ажилд ажилгүй 6 хүнийг ажиллуулж 387,0 төгрөгийн цалин олгож ажлын түр байраар хангасан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**1.3 Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албаны 2002 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланд** тусгаснаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 899 байгаагийн 46,7 хувь нь эрэгтэйчүүд, 53,3 хувь нь эмэгтэйчүүд байна.2002 оны эцсийн байдлаар 1262 хүнийг ажлын байраар хангасан байна.

Нийтийг хамарсан , түр зохион байгуулалттай ажилд ажилгүй иргэдийг өргөн хамруулах бодлого баримтлан ажиллаж нийт 2638 иргэдийг ажлын түр байраар хангасан байна.

Хоршоолол мэдээлэл сургалтын төв, КОнрад Аденаурын сангаас хэрэгжүүлж буй *Ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд Зуунмод, Архуст, Баянжаргалан, Жаргалант сумдад Эсгийн гутал, Хоршооны үүсгэн байгуулах сургалт явуулан тухайн сумдад байгуулагдсан хоршоодод тоног төхөөрөмж, жижиг зээлд 4,5 сая төгрөгийн олгож ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.

Тогтвортой хөгжил хөтөлбөрийн хүрээнд Баянцогт сумын ажилгүй 2 иргэнд 1,0 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 20,0 сая төгрөгийг хувиараа үйлдвэрлэл эрхлэх,өрхийн үйлдвэрлэл хөгжүүлэх ажлын байр бий болгоход зориулан 162 хүнд жижиг зээлийг олгосон байна.

Сургалтын танхимдаа Зуунмод сумын тахир дутуу, одой иргэдийн дунд мэргэжлийн баримжаа олгох,зөвлөгөө өгөх, мэдээлээр хангах сургалт зохион байгуулан 35 иргэнийг хамруулсан байна. Зуунмод суманд 50-аас дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаснаас 13 аж ахуйн нэгжид тахир дутуу 42 иргэн хөдөлмөр эрхлэж байна.

## 2. Микро түвшиний буюу орон гэргүй иргэд болон нэн ядуу өрхийн гишүүдийн дунд бүлгийн ярилцлага хийх замаар анкетын судалгаа хийсэн нэгдсэн дүн

2002 оны эцсийн байдлаар Төв аймгийн хэмжээнд 22677 өрхийн 96176 хүн ам бүртгэлтэй байгаа бөгөөд түүний дотор 2666 ядуу өрхийн 11534 хүн хүнд нөхцөлд амьдарч байна. Дээрхи нийт ядуу өрхийн дотор амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу 1894 өрхийн 9114 хүн онцгой хүнд нөхцөлд амьдарч байгаа бөгөөд тэдгээрийн 70 гаруй хувь нь нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдсан байна. Аймгийн хэмжээний 27 сумын дотор нэн ядуу өрхийн хүн амын тоогоор дараах сумууд дээгүүрт орж байна.

Үүнд:

1. Зуунмод 492 өрхийн 2131 хүн
2. Эрдэнэсант 212 өрхийн 891 хүн
3. Угтаал 110 өрхийн 540 хүн
4. Лүн 57 өрхийн 221 хүн
5. Заамар 60 өрхийн 312 хүн
6. Баянчандмань 69 өрхийн 329 хүн
7. Аргалант 54 өрхийн 266 хүн тус тус орж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Нэн ядуу өрхийн анкетын судалгаанд Зуунмод, Лүн, Эрдэнэсант, Аргалант, Жаргалант, Борнуур, Баянчандмань сумуудын 26 баг, тэдгээрийн дотор онцгой хүнд нөхцөлд амьдарч байгаа, нэн ядуу 50 гаруй өрхийн 100 гаруй иргэд хамрагджээ.

- Зуунмод сумын Номт, Нацагдорж, Баруун Зуунмод, Баянхошуу, Зүүндэлгэр багийн 15 өрх хамрагдсны дотор огт мөнгөн орлого байхгүй, шил лааз зэргийг цуглуулж , айлд зарагдаж амьдардаг 7 өрхийн 40 хүн, өөрийн гэсэн орон гэргүй , айлын хашаа, гэрт амьдардаг 5 өрхийн 26 хүн, байнгын хэвтэрт тал цус харвасан, мэдрэл муутай өвчтөнтэй 4 өрх, эдгээр өрхүүдийн дотор амьдралын гачигдлаас шалтгаалан сургууль завсардсан 6 хүүхэд байна.
- Нэн ядуу өрхийн судалгаанд хамрагдсан хөдөөгийн 6 сумын нийт 40 өрхийн дотор огт мөнгөн орлого байхгүй 14 өрх, өөрийн гэсэн орон гэргүй /сумын төвийн ашиглалтгүй,эвдэрхий халуун усны байр г.м байшингийн буланд толгой хоргоддог/ 20 өрх, байнгын сахиуртай хэвтэрт байдаг өвчтөнтэй 24 өрх, түүний дотор амьдарлын гачигдлаас шалтгаалан сургууль завсардсан 16 хүүхэд , эдгээр хүүхдүүдийн ихэнх нь суурь өвчтэй, тэжээлийн дутагдал болон тархины саажилт,сэтгэл мэдрэлийн зэрэг ямар нэгэн өвчинтэй байна.
- Эдгээр судалгаанд хамрагдсан өрхүүдийн 60 гаруй хувь нь ямар нэгэн шалтгаанаар / нас залуу, хөдөлмөр эрхлэх чадвартай, г.м/ нийгмийн халамж үйлчилгээнд хамрагддаггүй бөгөөд зөвхөн нэг удаагийн гурил будаа, хувцас зэргийн тусламж авч байсан боловч тогтмол мөнгөн орлого байхгүй учраас амьдралын ямар ч баталгаа байхгүй байна.

**3. Дүгнэлт санал:**

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн явцад аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны дундаж түвшин буурч ядуурал эрс нэмэгдэх болсон . Тухайлбал: Хөдөө суманд үйлдвэрлэл уналтанд орсноор ажилгүйдэл ихэссэн нь 1 хүнд ноогдох орлогын хэмжээг эрс бууруулсан .

1. Судалгаанд хамрагдсан өрхийн хөдөлмөрийн насанд хүрсэн гишүүдийн 70 гаруй хувь нь ажилгүй учраас ямар ч мөнгөн орлого байхгүй, 50 гаруй хувь нь өөрийн гэсэн орон гэргүй , айлын хашаа, зуны байшинг сахиж амьдардаг, байнгын сахиуртай хэвтрийн өвчтөнтэй, зарим өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүд зөвхөн халамжийн эсвэл группийн,тэтгэврийн мөнгөөр амьдардаг учраас хүнсний болон ахуйн наад захын хэрэглээгээ хангаж чаддаггүй, байнгын өлөн зэлмэн амьдардаг байна.

2. Ажилгүйдлээс үүдэн хүмүүс сэтгэлийн хямралд орох, замбараагүй архидах, мөрийтэй тоглох, байнгын өр ширэнд баригдах,, наад захын хэрэгцээт зүйлсээр гачигдах, гэр бүлд хүчирхийлэл дарамт үүсэх зэрэг нийгмийн дотор сөрөг үзэгдлүүд нэмэгдэх үндэс нь болж байна.
Тухайлбал судалгаанд хамрагдсан өрхүүдийн 80 гаруй хувь нь цахилгаан, дулаан, хог, усны мөнгөө төлж чаддаггүй учраас олон жилийн өр үүссэн, цахилгааныг голдуу хулгайгаар хэрэглэдэг, зарим өрхийн их дээд сургуульд сурдаг, сурлага сайтай хүүхдүүд нь ихэвчлэн 1,2-р курсээс мөнгөний гачигдлаас болоод гарсан , өөрсдөө цааш сурах сонирхолтой авьяастай боловч эцэг эх нь явуулж чаддаггүй байна

UIH.MN СУДАЛГААНЫ САН

3. Хөдөө орон нутагт ядуурлыг бууруулах чиглэлээр олон төрлийн хөтөлбөр төслүүд хэрэгждэг боловч түүний үр дүн бодит байдал дээр төдий л харагдахгүй, цар хүрээ нь хязгаарлагдмал, зөвхөн өнөө маргаашийг аргацаасан шинжтэй, ядуурлаас аврах гол арга нь болж чадахгүй байна.

4. Эмзэг бүлгийн иргэдийн эрх зүйн мэдлэг сул, мэдээлэлгүй, эрхээ хамгаалах чадвар доройгоос нийгмийн халамж үйлчилгээний гадна хоцрох нь цөөнгүй байна. Иймд оюун санааны ядуурал гэсэн шинэ хэлбэрч бий болсон байна.

5. Нөгөө талаар зээл тусламжийг зөвхөн ядуу иргэдэд олгож хандуулж ирсэн тэднийг бэлэнчлэх сэтгэлгээнд сургах, зөвхөн авах сэтгэлгээтэй болгон тэдний амьралын идэвхитэй хэв шинжийг алдагдуулахад хүрсэн байна.

/ Судалгааны анкетын асуулга 36 ш хавсаргав, /

**Цаашид авах арга хэмжээ**

- Нэн ядуу иргэдийн амьжиргааг дээшлүүлэх гол арга бол мэргэжлийн баримжаатай болгож ажлын байраар хангах замаар албан бус салбарт тогтмол ажлын байрыг нэмэгдүүлэх
- Орон нутгийн Засаг захиргаанаас орлогын тэгш бус хуваарилалтыг арилгахад чиглэгдсэн бодлого авч хэрэгжүүлэх ,
- Нийтийг хамарсан ажлын жижиг төслүүд болон чиглэсэн зорилготой зээлийн хөтөлбөрүүдээр дамжуулан ядууст хүрч ажиллах
- Орон нутгийн засаг захиргаанд болон хувийн секторт тулгуурлан жижиг хэмжээний төслүүдийг хэрэгжүүлэх, өрхөөр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх санхүүгийн болон бусад талын дэмжлэг үзүүлэх, илүү олон хүнд зээл авах боломжийг олгох зорилгоор энэ чиглэлээр мэргэшсэн санхүүгийн байгууллагыг үүсгэн байгуулах
- Сум бүр ИТХ-ын дэргэд нэн ядуу өрхийн хүүхдүүдийг нь их дээд сургуульд үнэ төлбөргүй сургах, дотуур байраар хангах, хичээлийн хэрэгсэл, хувцас, хоол хүнсээр шаардлагатай үед хангах **тусгай сантай болох**
- Боловсрол,эрүүл мэндийн салбарт төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ялангуяа ядуу амьдралтай өрхийн гишүүд ЕБС, бүх шатны боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүртэх боломжтой болох
- Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмолжуулах, Хүний эрхийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Тайлан гаргасан Судалгааны багийн нарийн бичгийн дарга
Аймгийн хүний эрхийн мэргэжилтэн
С.Энхжаргал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## *Хөвсгөл аймгийн нэн ядуу иргэдийн байдал*

## */Судалгааны тайлан/*

*Хөвсгөл аймаг нь улсын нийслэлээс 701 км алслагдсан, 23 засаг захиргааны нэгж, нэг тосгонтой, аймгийн төв Мөрөн сум.*

*Тус аймагт 2001 оны хүн амын тооллогоор 117914 хүн ам тоологдсон. Үүнээс бага орлоготой хүн ам 13081, ядуу хүн ам 23234, нэн ядуу хүн ам 24238. Нийт 29570 өрхтэйгээс бага орлоготой өрх 3918, ядуу өрх 6366, нэн ядуу өрх 6012 байгаа бөгөөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 3750 байгаагаас бага орлоготой өрх 1180, ядуу өрх 1300, нэн ядуу өрх 1268 байна.*

*Огт малгүй өрх 6089 байгаа бөгөөд нэн ядуу хүмүүсийн 248 нь оюуны хомсдолтой, 34 нь хараагүй, 192 нь хэлгүй, дүлий, биеийн бусад эрхтний гажигтай 513, хэвтрийн өвчтэй 40, бүтэн өнчин хүүхэд 272, хагас өнчин хүүхэд 1850, хог түүдэг хүүхэд 14 байна.*

*Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны хүн ам 59163, үүнээс хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам 10695 байна.*

*Ядуурал эрчимтэй өсч байгаагийн нэг шалтгаан нь аймгийн төвийн хэмжээнд аваад үзэхэд төсвийн байгууллагууд, тоотой хэдэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг эс тооцвол үйлдвэр муу хөгжсөнтэй холбоотой юм. Үйлдвэрлэл хөгжих нөхцөл тун хомс яагаад гэвэл аймгийн хэмжээнд дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй, нэн ялангуяа эрчим хүчний хомсдол ихтэй холбоотой байна. Тус аймгийн хувьд сүүлийн жилүүдэд ган зудад их хэмжээгээр нэрвэгдэж, малгүй өрх айл олон болж, үүнээс үүдэн аймгийн төвд амьжиргааны эрхээр шилжин ирснээр аймгийн төвийн ядуу өрх, иргэдийн тоог албан ёсоор нэмэгдүүлж байна.*

*Нэн ядуу иргэдийг хэн бүрдүүлж байна вэ? гэвэл:*

- *Ажилгүй*
- *Тахир дутуу*
- *Өндөр настан*
- *Олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд*
- *Малаа ган зуданд үхүүлж, амьжиргааны эх үүсвэргүй болсон иргэд бүрдүүлж байна.*

*Судалгааны явцад ажиглагдсан нэг зүйл гэвэл нэн ядуу гэгдэж байгаа иргэд нийгмийн халамжинд хамрагдах боломж хомс учир нь нийгмийн халамжийн сангаас нийгмийн халамжийн өндөр настан, нэн ядуу амьдралтай 45 настай эх,*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

50 настай эрэг гэсэн хоёр нөхцлөөр тэтгэмж олгогддогоос хамааралтай юм байна. Мөн иргэдэд хууль эрх зүйн мэдлэг боловсрол олгох нь маш чухал санагдлаа.

Судалгаанд авч явахад ажиглагдсан бас нэг зүйл нь нэн ядуу өрхүүдийн тэргүүлэгч нар өөрөөр хэлбэл нөхрүүд нь гэрийн эзэгтэйгээс илүү амьдралын төлөө тэмцэх ёстой байтал энэ байдалдаа буугаад өгчихсөн байдалтай байсан бөгөөд тэр гэр бүлийг, үр хүүхдүүдээ тэжээх ачааг эмэгтэйчүүд, эхнэрүүд нь үүрдэг, тийм ч утгаараа судалгаанд оролцсон хүмүүсийн 80% нь эмэгтэйчүүд байлаа.

Аймгийн хэмжээнд 35-аас дээш насны хүмүүсийг ажилд огт авахгүй байгаа тухай судалгаанд оролцож байгаа хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй бүх хүмүүс хэлж байлаа.

Залуу, дунд насны нэн ядуучуудыг үндсэндээ үнэхээр амьдрахын төлөө зүтгэж байгаа, юухан хээхэн хийж амьдрах гэж тэмцэж яваа ажилч, залхуу буюу амьдрах эвээ олохгүй хулгай хийж, архинд орсон гэсэн хоёр хэсэгт хувааж болохоор байна.

Тэд өнөө маргаашийг аргацаах буяны буюу өглөгийн нэг удаагийн 5-10,0 мянган төгрөг, нэг шуудай гурил мэтийнхээ оронд төрөөс биднийг ажлын байраар хангах эсвэл зээлийн хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг хангах талаар дэмжлэг үзүүлээсэй гэсэн бодолтой байдаг юм байна.

Судалгааны асуулгын 45-47-асуулгуудад судалгаанд оролцогчид хариулахдаа: Ажилтай болох, ажилтай л болвол амьдралаа өөд нь татаад амьдарч чадна. Төрөөс болон бусад буяны байгууллагуудаас бидэнд өнөөдөр нэг шуудай гурил будаа өгөх байдлаар биш энэ зарцуулж байгаа хөрөнгөө биднийг ажлын байртай болгоход зориулаад биднийг ажлын байртай, ажилтай болгоод л өгвөл хамгийн тохирсон дэмжлэг гэж үзнэ гэж хариулцгааж байв.

Нярай хүүхдийн асаргааны мөнгө тэр хүүхдийн сүү, тэжээлд зориулагдах бус 4-8 гишүүнтэй өрхийн амьжиргааны эх үүсвэр болж байгаа тохиолдол маш олон тохиолдож байна.

Нэн ядуу хүн бүр нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа нь хэнд ч ойлгомжтой бөгөөд нэн ядуу хүмүүс гэдэг маань нийгмийн нэгэн давхрага болсон нь харагдаж байлаа. Эдгээр хүмүүст ажил олдох магадлал байхгүй /яагаад гэвэл нэн ядуу хүмүүсийн ихэнх хувийг 35-аас дээш насны хүмүүс эзэлж байна / хувиараа хөдөлмөр эрхлэх хөрөнгийн боломж байхгүй /санаа байвч

UIH.MN
СЭДЭЛ ААНЫ САН

бэл бэнчин нь хүрэхгүй/, санхүүгийн зээл /зээлийн барьцаанд тавих хөрөнгөгүй/ авах огт боломжгүй хүмүүс учраас эдгээр хүмүүс энэ байдлаасаа гарах боломжгүй учраас өнөөдөр эцэг эх нь нэн ядуу, маргааш үр хүүхэд нь мөн л нэн ядуучуудын өвхрагыг бүрдүүлж энэ нь цааш даамжирсаар байх болов уу гэсэн бодол төрж байлаа.

Нэн ядуу өрхийн нэг хүүхэд их, дээд сургуульд суралцах сургалтын төлбөрөө төрөөс буцалтгүй төлөх нөхцөлд хамрагдаад сургуульд сурах боломжтой ч зөвхөн сургалтын төлбөрөөс гадна түүнд амьдрах байр, идэх хүнс, өмсөх хувцас, ном дэвтрийн мөнгө гээд нэн ядуу хүнд бол дааж давашгүй ачаа учир хүүхдээ сургуульд сургах тухай бодохын ч аргагүй хэмээн тэд ярьцгааж байна. Нэн ядуу хүүхэд бүрэн бус дунд, эсвэл бүрэн дунд боловсрол олвол л БОЛОВСРОЛТОЙ ХҮН болж байгаа нь тэр. Тийм хүнд ажил олдох нь ховор мөн л нөгөө ядуучуудын арми нэмэгдэж байна гэсэн үг юм.

Судалгаанд хамрагдсан хүмүүсээс огт гэр оронгүй хүн цөөн бөгөөд тэдний хөрөнгө гэвэл хашаа, гэр, /цөөн хэд нь зуны байшинтай/ байдаг. Энэ нь банк, санхүүгийн байгууллагын хувьд бол хөрөнгө огт биш учраас хувиараа хөдөлмөр эрхлэхэд хэрэгцээтэй хөрөнгийнх барьцаа болж чаддагүй гэж судалгаанд хамрагдагдсад ярьж байв.

2001 онд Хөвсгөл аймгийн Нийгмийн Халамжийн Сан нь улсын төвлөрсөн төсвөөс 769298,8 мянган төгрөгийн санхүүжилт авч 24 сумын нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээнд зарцуулсан байна.

Аймгийн Нийгмийн халамжийн сангаас 2000 онд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжинд нийт 9401хүнд 626665.5 төгрөг үүнээс олон хүүхэдтэй 2594 эхэд 60367,5, ахмад настан 1355 хүнд 421251 төгрөгийн хөнгөлөлт, тахир дутуу 318 иргэнд 16144,6 төгрөгийн хөнгөлөлт, бүтэн өнчин 22 хүүхдэд 1311,6 төгрөг, 2001 онд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжинд нийт 10485 хүнд 699342,0 төгрөг үүнээс олон хүүхэдтэй 993 эхэд 26429,4 төгрөгийн тэтгэмж, ахмад настан 1864 хүнд 45063,2 төгрөгийн хөнгөлөлт, тахир дутуу 319 иргэнд 13561,8 төгрөгийн хөнгөлөлт, бүтэн өнчин 18 хүүхдэд 2349,0 төгрөгийн тэтгэмжийг тус тус олгожээ. Нийгмийн халамжийн тэтгэврийн 72,3 хувийг төрлөхийн бөгөөд 16 нас хүрээгүй байхдаа өвчилсөн иргэд эзэлдэг тул ЭХМК-ийн хурлаар цуцлагдах хувь нь бага, мөн нэмж орох хандлага их байдаг. Мөн нийгмийн даатгалын шимтгэлд хамрагдаагүй, ажилгүй хүмүүс олон байгаатай холбогдож, Нийгмийн халамжийн тэжээгийн тэтгэвэр нэмэгдэж 2001 он гэхэд 104 хүнд тэжээгчийн тэтгэвэр шинээр тогтоогдсон байна. Энэ мэтчилэнгээр

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Нийгмийн халамжийн Тэтгэвэрт хамрагсдын тоо өссөөр 2001 онд шинээр 321 тэтгэвэр тогтоогдож, 178 тэтгэвэр зогссон байна.*

*2002 онд Нэн ядуу амьдралтай өрх толгойлсон 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 нас хүрсэн 10 эмэгтэй хүнд 937,0 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр, байнгын асрамжинд байдаг 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдээ асарч буйн улмаас хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд нэн ядуу амьдралтай өрхийн асран хамгаалагч 104 хүнд амьжиргааны доод түвшингийн 75%тай тэнцэх хэмжээний тусламж олгож, 11829,2 мянган төгрөг зарцуулсан байна. Нэн ядуу амьдралтай өрхийн болон бүтэн өнчин 73 хүүхдэд эх үрсийн баярын үеэр тус бүрт нь 3500 төгрөг, бүгд 225,5 мянган төгрөгийн үнэ бүхий бэлэг, харж хандах ах дүүгүй өрх толгойлсон 3 эхэд гэр оронтой болгоход нь зориулж халамжийн сангаас 1200,0 мянган төгрөг, 300 хүүхдийг цэцэрлэгт хамруулж, хоолны мөнгийг халамжийн сангаас төлөхөд 2976,2 мянган төгрөг зарцуулжээ.*

*Нэн ядуу иргэнд үзүүлэх халамжийн үйлчилгээнд 519 хүнийг хамруулж 3707,2 мянган төгрөг зарцуулсан байна*

*Аймгийн Хөдөлмөр зохицуулалтын албанаас 2000-2002 онд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нийгмийн эмзэг бүлгийн 170 иргэдэд мэргэжлийн баримжаа олгох, амьдрах ухаанд сургах сургалт зохион явуулсан байна. 2001-2002 онд тахир дутуу 7 иргэнийг ажлын байраар хангажээ.*

*2000-2002 онд Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд орлого нэмэгдүүлэх жижиг зээл төсөл /1996-2006/ хэрэгжиж аймгийн 23 сум, 1 тосгоны ядуу бага орлоготой иргэдийн амьдралыг дээшлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилгүй, ядуу 1638 хүн төсөлд хамрагдаж ажлын байртай болсон. Нийт ядуу өрхийн 2,4%, нийт ядуу хүн амынг 2,5% нь ядуурлаас гарсан байна. Үүнд нийт Дэлхийн банк, НҮБ-ын ХХ-ийн газраас 51,4 сая төгрөгийн санхүүжилт зарцуулжээ.*

*Мөн Олон улсын Хөдөөгийн Хөгжлийг дэмжих сангийн Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслийн хүрээнд 2000 онд тус аймгийн 11 сумын 364 өрхөд 13539 толгой мал буюу 233704,9 мянган төгрөгийн , 16 сумын 473 өрхөд 8810,5 мянган төгрийн хүнсний ногоо тариалах зээл, 2001 онд 20 сумын 578 өрхөд 19077 толгой мал буюу 352099,5 мянган төгрөгийн, 476 өрхөд 8815,0 мянган төгрөгийн хүнсний ногоо тариалах зээл, 2002 онд 23 сумын 757 өрхөд 27007 толгой мал буюу 451257,5 төгрөгийн зээл олгосон байна.*

*Эцэст нь дүгнэж хэлэхэд аймгийн төвд амьдардаг нэн ядуучууд, суманд амьдардаг нэн ядуучуудын хоорондын ялгаа огт байхгүй байлаа.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

***<u>Цагааннуур сум:</u>*** *Аймгийн төвөөс 280 км алслагдсан. Үндэсний цөөнхүүд болох цаатан, дархадууд голлон амьдардаг. Нийт 1325 хүн амтайгаас хөдөлмөрийн насны 824, хөдөлмөр эрхлээгүй 465 хүн байна. Нийт хүн амын 423 нь ядуу, 443 нь нэн ядуу бөгөөд сумын хэмжээнд 299 өрхтэй ба үүний 109 нь ядуу, 94 нь нэн ядуу амьдралтай юм байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх 58 байгаагаас ядуу нь 16, нэн ядуу нь 42 байна. Сумын хэмжээнд огт малгүй өрх 24 байна.*

*Сумын нэн ядуу иргэдийн 6 нь оюуны хомсдолтой, 2 нь хараагүй, 4 нь хэлгүй дүлий, 6 нь биеийн бусад эрхтний гажигтай, 4 нь бүтэн өнчин, 33 нь хагас өнчин гэсэн судалгаа гарсан байна.*

*2001 онд Нийгмийн халамжийн сангаас 8699,0 мянган төгрөгийн санхүүжилт авч 17 хүнд 1668,9 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 3 хүнд 246,3 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 9 хүнд 852,6 мянган төгрөг, 4 хүнд 450,0 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр, бүрэн хараагүй 1 хүнд 120,0 мянган төгрөг, 42 амаржсан эхэд 2481,2 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 2998,2 мянган төгрөгийг 62 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 31 хүнд 859,0 мянгөн төгрөгийн халамж, тэтгэмж олгожээ.*

*2002 онд 9585,3 мянган төгрөгийн санхүүжилт авч 23 хүнд 2489,6 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 4 хүнд 333,2 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 13 хүнд 1390,4 мянган төгрөг, 5 хүнд 560,0 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр, бүрэн хараагүй 1 хүнд 126,0 мянган төгрөг, 61 амаржсан эхэд 3019,5 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 2271,2 мянган төгрөгийг 50 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 27 хүнд 605,5 мянгөн төгрөгийн халамж, нэн ядуу ахмадын халамжинд 12 хүнд 18,0 мян.төгрөг, нэн ядуу тахир дутуугийн халамжийг 30 хүнд 228,0 мян.төгрөг, нэн ядуу хүүхдийн 20,0 мян.төгрөгийн халамжийг 1 хүүхдэд тус тус олгожээ.*

*Олон улсын Хөдөөгийн хөгжлийн сангийн Хөдөөд ядуурлыг бууруулах төслийн шугамаар 2002 онд тус сумын 14 өрхөд 6899,0 мянган төгрөгийн үнэ бүхий 402 толгой малын зээл олгогджээ.*

*Тус сумын нэн ядуу иргэдийн ихэнх нь цаатанууд буюу тайгад амьдардаг бөгөөд цаг агаарын байдлаас болоод тэдэнд хүрч байдалтай нь танилцаж чадсангүй. Сумын төв дээр амьдардаг цөөн тооны хүмүүстэй уулзахад бүгд амьжиргааны эх үүсвэргүй бөгөөд хүнсний гол бүтээгдэхүүн нь загас болдог хэмээн ярьцгааж байлаа. Нэг хэсэг нь ах дүү, айл хөршийнхнөөсөө гуйлга гуйх*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*байдлаар үр хүүхдээ тэжээдэг, зарим нь өвөө юм уу эмээгийнхээ тэтгэвэрээр амьдралаа залгуулдаг нийтлэг үзэгдэл энд ч мөн адил байлаа.*

***Улаан Уул сум:*** *Аймгийн төвөөс 170 км алслагдсан. Хүн амын олонхийг дархадууд эзэлдэг. 3534 хүн амтай, үүний 1609 нь ядуу, 444 нь нэн ядуу амьдралтай ба нийт 329 өрхтэй бөгөөд 390 нь ядуу, 103 нь нэн ядуу ангилалд хамаардаг байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 97 үүнээс 33 нь нэн ядуу амьдралтай ажээ. Сумын хэмжээнд огт малгүй өрх 14 байна.*

*Нэн ядуу хүмүүсээс 11 нь оюуны хомсдолтой, 2 нь хараагүй, 4 нь хэлгүй, дүлий, 5 нь биеийн бусад эрхтний гажигтай, хэвтрийн өвчтэй 1, бүтэн өнчин 5, хагас өнчин 32 хүүхэд байна.*

*Нийт хүн амын 1692 нь хөдөлмөрийн насны, үүний 372 нь хөдөлмөр эрхэлдэггүй байна.*

*2001 онд Нийгмийн халамжийн сангаас 27513,0 мянган төгрөгийн санхүүжилт авч 53 хүнд 6833,3 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр олгож үүнээс хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 15 хүнд 1800,0 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 25 хүнд 3473,3 мянган төгрөг, 7 хүнд 840,0 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр, нэн ядуу амьдралтай 45 нас хүрсэн эхэд 120,0 мянган төгрөг, 200 амаржсан эхэд 9768,12 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 8754,0 мянган төгрөгийг 95 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 52 хүнд 1323,0 мянган төгрөгийн халамж, тэтгэмж олгожээ.*

*2002 онд Нийгмийн халамжийн сангаас 31924,0 мянган төгрөгийн санхүүжилт авч 53 хүнд 5931,4 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр олгож үүнээс хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 15 хүнд 1259,0 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 18 хүнд 2282,4 мянган төгрөг, 14 хүнд 1754,0 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр, нэн ядуу амьдралтай 45 нас хүрсэн эхэд 60,,0 мянган төгрөг, 231 амаржсан эхэд 11483,7 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 10006,2 мянган төгрөгийг 185 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 62 хүнд 1589,0 мянган төгрөг нэн ядуу 1 ахмадад 50,0 мянган төгрөгийн халамж, тэтгэмж олгожээ.*

*Олон улсын Хөдөөгийн хөгжлийн сангийн Хөдөөд ядуурлыг бууруулах төсөлд 1999 оноос хамрагдаж байгаа бөгөөд энэ шугамаар 1999 онд тус сумын 26 өрхөд 13586,0 мянган төгрөгийн үнэ бүхий 702 толгой мал, 2000 онд 29 өрхөд 16791,0 төгрөгийн үнэтэй 976 толгой мал, 2001 онд 34 өрхөд 17345,0 мянган*

*төгрөгийн 687 толгой малын зээл, 2002 онд 20 өрхөд 316,7 мянган төгрөгийн хүнсний ногооны зээл тус тус олгогджээ.*

***Төмөрбулаг сум:*** *Аймгийн төвөөс 60 км зайтай.* *4213 хүн амтай, үүний 717 нь ядуу, 1196 нь нэн ядуу амьдралтай ба нийт 1077 өрхтэй бөгөөд 201 нь ядуу, 278 нь нэн ядуу ангилалд хамаардаг байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 111 үүнээс 31 нь нэн ядуу амьдралтай ажээ.*

*Сумын хэмжээнд огт малгүй өрх 39 байна.*

*Нэн ядуу хүмүүсээс 3 нь хараагүй, 10 нь хэлгүй, дүлий, хэвтрийн өвчтэй 1, бүтэн өнчин 25, хагас өнчин 82 хүүхэд байна.*

*Нийт хүн амын 2224 нь хөдөлмөрийн насны, үүний 176 нь хөдөлмөр эрхэлдэггүй байна.*

*2001 онд Нийгмийн халамжийн сангаас 24383,2 мянган төгрөгийн санхүүжилт авч 82 хүнд 9362,6 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр олгож үүнээс хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 28 хүнд 3360,0 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 25 хүнд 2730,6 мянган төгрөг, 23 хүнд 2552,0 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр, нэн ядуу амьдралтай 45 нас хүрсэн эхэд 120,0 мянган төгрөг, 138 амаржсан эхэд 8702,5 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 4057,4 мянган төгрөгийг 119 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 35 хүнд 751,1 мянган төгрөг, нэн ядуу 11 хүнд 89,6 мянган төгрөгийн халамж, тэтгэмж олгожээ.*

*2002 онд Нийгмийн халамжийн сангаас 31756,4 мянган төгрөгийн санхүүжилт авч 97 хүнд 10285,8 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр олгож үүнээс хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 12 хүнд 1512,0 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 56 хүнд 5428,0 мянган төгрөг, 26 хүнд 2967,8 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр 191 амаржсан эхэд 9468,0 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 8644,7 мянган төгрөгийг 80 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 34 хүнд 1228,0 мянган төгрөг, нэн ядуу 41 хүнд 314,5 мянган төгрөгийн халамж, тэтгэмж олгожээ.*

*Олон улсын Хөдөөгийн хөгжлийн сангийн Хөдөөд ядуурлыг бууруулах төслийн хүрээнд 2000 онд 32 өрхөд 19605,0 төгрөгийн үнэтэй 1188 толгой мал, 35 өрхөд 6239,4 мянган төгрөгийн хүнсний ногооны зээл, 2001 онд 29 өрхөд 18950,0 мянган төгрөгийн 1158 толгой мал, 50 өрхөд 652,2 мянган төгрөгийн*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*хүнсний ногооны зээл, 2002 онд 40 өрхөд 24655,0 мянган төгрөгийн 1724 толгой мал, 15 өрхөд 171,9 мянган төгрөгийн хүнсний ногооны зээл тус тус олгогджээ.*

***Мөрөн сум:*** *Аймгийн төв Мөрөн сум нь аймаг засаг захиргааны төв бөгөөд 25402 хүн амтай, үүний 8222 нь ядуу, 8918 нь нэн ядуу амьдралтай ба нийт 6301 өрхтэй бөгөөд 2167 нь ядуу, 2347 нь нэн ядуу ангилалд хамаардаг байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 1254 үүнээс 650 нь нэн ядуу амьдралтай ажээ. Нэн ядуу хүмүүсээс оюуны хомсдолтой 13, хараагүй 9, хэлгүй дүлий 19, биеийн бусад эрхтний гажигтай 330, хэвтрийн өвчтэй 4, бүтэн өнчин хүүхэд 51, хагас өнчин хүүхэд 386 байна. Хөдөлмөрийн насны 13426 хүн байгаагаас 4460 нь хөдөлмөр эрхэлдэггүй байна.*

*2001 онд Нийгмийн халамжийн сангаас 177028,3 мянган төгрөгийн санхүүжилт авч 510 хүнд 58148,3 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр олгож үүнээс хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 73 хүнд 7759,0 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 306 хүнд 36030,3 мянган төгрөг, 75 хүнд 8322,0 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр, нэн ядуу амьдралтай 45 нас хүрсэн эх, 50 нас хүрсэн эцэгт 133,6 мянган төгрөг, 54 амаржсан эхэд 3449,1 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 5317,8 мянган төгрөгийг 100 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 10 хүнд 279,0 мянган төгрөг, нэн ядуу 6 хүнд 53,4 мянган төгрөгийн халамж, тэтгэмж олгожээ.*

*2002 онд Нийгмийн халамжийн сангаас 223352,8 мянган төгрөгийн санхүүжилт авч 549 хүнд 61770.1 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр олгож үүнээс хөдөлмөрийн чадвараа 70% алдсан 60 хүнд 6488,6 мянган төгрөг, 16 хүрээгүй өвчилсөн 345 хүнд 38959,3 мянган төгрөг, 83 хүнд 9356,6 мянган төгрөгийн тэжээгчийн тэтгэвэр, нэн ядуу амьдралтай 45 нас хүрсэн эх, 50 нас хүрсэн эцэгт 203,3 мянган төгрөг, 128 амаржсан эхэд 6336,0 мянган төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 4536,1 мянган төгрөгийг 90 хүнд, олон хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 9 хүнд 400,5 мянган төгрөг, нэн ядуу 30 хүнд 420,5 мянган төгрөгийн халамж, тэтгэмж олгожээ.*

*Олон улсын Хөдөөгийн хөгжлийн сангийн Хөдөөд ядуурлыг бууруулах төслийн хүрээнд 2000 онд 60 өрхөд 789,7 мянган төгрөгийн хүнсний ногооны зээл, 2001 онд 26 өрхөд 16991,0 төгрөгийн үнэтэй 928 толгой мал, 50 өрхөд 1481,6 мянган төгрөгийн хүнсний ногооны зээл, 2002 онд 34 өрхөд 20681,5 мянган төгрөгийн 1272 толгой мал, 48 өрхөд 1179,6 мянган төгрөгийн хүнсний ногооны зээл тус тус олгогджээ.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ХӨВСГӨЛ АЙМГААС ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ КОЛЛЕЖИД СУРАЛЦАЖ БАЙГАА СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙГ ТӨРӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗЭЭЛ, БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИНД ХАМРАГДАХ СУРАЛЦАГЧДЫН СУДАЛГАА / 2001-2002, 2002-2003 оны хичээлийн жилээр /**

2002,09,23 Мөрөн

| № | Сумын нэр | 2001-2002 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ: МУ-ын ЗГ-ын 158-р тогтоолын нөхцөлд хамрагдсан суралцагчид | | | БҮГД | МУ-ын ЗГ-ын 96-р тогтоолын нөхцөлд хамрагдсан суралцагчид | | БҮГД | 158 ба 96-р тогтоолын нөхцөлд хамрагдсан бүгд | Төрийн албан хаагчийн гэр бүлээс / МУЗГ-ын 2000 оны 201-р тогтоолоор / | БҮГД | 2002-2003 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ / шинээр материал бүрдүүлсэн /: МУ-ын ЗГ-ын 158-р тогтоолын нөхцөлд хамрагдсан суралцагчид | | | БҮГД | МУ-ын ЗГ-ын 96-р тогтоолын нөхцөлд хамрагдсан суралцагчид | | БҮГД | 158 ба 96-р тогтоолын нөхцөлд хамрагдсан бүгд | Төрийн албан хаагчийн гэр бүлээс / МУЗГ-ын 2000 оны 201-р тогтоолоор / | БҮГД |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Малчин | Ядуу | 3-аас дээш хүүхэд нь суралцаж | | Зээл | Буцалтгүй | | | | | Малчин | Ядуу | 3-аас дээш хүүхэд нь суралцаж | | Зээл | Буцалтгүй | | | | |
| 1 | Алаг-Эрдэнэ | | | | 0 | | | 0 | 0 | 6 | 6 | 4 | 1 | | 5 | | | 0 | 5 | 11 | 16 |
| 2 | Арбулаг | | 1 | | 1 | | | 0 | 1 | 14 | 15 | 4 | | 1 | 5 | | | 0 | 5 | 12 | 17 |
| 3 | Баянзүрх | 4 | 2 | | 6 | | | 0 | 6 | 7 | 13 | 2 | 2 | | 4 | 3 | | 3 | 7 | 7 | 14 |
| 4 | Бүрэнтогтох | 3 | 7 | | 10 | 1 | | 0 | 10 | 16 | 26 | 4 | 5 | 1 | 10 | 5 | | 0 | 10 | 20 | 30 |
| 5 | Галт | 2 | 1 | | 3 | 1 | | 1 | 4 | 17 | 21 | 9 | 1 | | 10 | 1 | | 1 | 11 | 15 | 26 |
| 6 | Жаргалант | 2 | | | 2 | | | 0 | 2 | 16 | 18 | 15 | 5 | | 20 | | | 0 | 20 | 18 | 38 |
| 7 | Их-Уул | 4 | | | 4 | 3 | | 3 | 7 | 14 | 21 | 8 | 2 | | 10 | 1 | | 1 | 11 | 14 | 25 |
| 8 | Мөрөн | 6 | 40 | 8 | 54 | 31 | 3 | 34 | 88 | 257 | 345 | 14 | 146 | 5 | 165 | 38 | 5 | 43 | 208 | 287 | 495 |
| 9 | Рашаант | 1 | | | 1 | | | 0 | 1 | 16 | 17 | 9 | 3 | | 12 | 1 | | 1 | 13 | 19 | 32 |
| 10 | Рэнчинлхүмбэ | 2 | 3 | 1 | 6 | 8 | | 8 | 14 | 15 | 29 | 3 | 3 | | 6 | 2 | | 2 | 8 | 12 | 20 |
| 11 | Тариалан | 8 | 9 | 3 | 20 | 8 | | 8 | 28 | 44 | 72 | 21 | 11 | 2 | 34 | 3 | 2 | 5 | 39 | 45 | 84 |
| 12 | Тосонцэнгэл | 2 | 3 | | 5 | 1 | | 1 | 6 | 22 | 28 | 10 | 11 | | 21 | 4 | 2 | 6 | 27 | 19 | 46 |
| 13 | Төмөрбулаг | 2 | | | 2 | 1 | 1 | 2 | 4 | 15 | 19 | 6 | | | 6 | 2 | | 2 | 8 | 14 | 22 |
| 14 | Түнэл | 3 | | | 3 | | 1 | 1 | 4 | 9 | 13 | 7 | 4 | | 11 | | | 0 | 11 | 10 | 21 |
| 15 | Улаан-уул | | | | 0 | | | 0 | 0 | 15 | 15 | 3 | 1 | | 4 | | | 0 | 4 | 14 | 18 |
| 16 | Ханх | | | | 0 | 2 | 1 | 3 | 3 | 11 | 14 | | 2 | | 2 | 1 | | 1 | 3 | 15 | 18 |
| 17 | Хатгал | 2 | 8 | | 10 | 3 | 1 | 4 | 14 | 18 | 32 | 1 | 8 | | 9 | 3 | 1 | 4 | 13 | 14 | 27 |
| 18 | Цагааннуур | | | | 0 | | | 0 | 0 | 6 | 6 | 1 | | | 1 | | | 0 | 1 | 7 | 8 |
| 19 | Цагаан-Уул | 3 | 1 | | 4 | 2 | | 2 | 6 | 23 | 29 | 17 | 8 | | 25 | 2 | | 2 | 27 | 25 | 52 |
| 20 | Цагаан-Үүр | | 1 | | 1 | 1 | | 1 | 2 | 19 | 21 | 3 | 3 | | 6 | 1 | | 1 | 7 | 13 | 20 |
| 21 | Цэцэрлэг | | 3 | 1 | 4 | 2 | | 2 | 6 | 17 | 23 | 16 | 3 | | 19 | 2 | | 2 | 21 | 14 | 35 |
| 22 | Чандмань-Өндөр | 2 | | | 2 | 1 | | 1 | 3 | 15 | 18 | 6 | 3 | | 9 | 1 | 1 | 2 | 11 | 14 | 25 |
| 23 | Шинэ-Идэр | | 2 | | 2 | 2 | | 2 | 4 | 23 | 27 | 9 | 7 | | 16 | | | 0 | 16 | 24 | 40 |
| 24 | Эрдэнэбулган | | | | 0 | | | 0 | 0 | 13 | 13 | 5 | 2 | | 7 | | | 0 | 7 | 15 | 22 |
| | **БҮГД** | 46 | 81 | 13 | 140 | 67 | 7 | 74 | 214 | 628 | 842 | 177 | 231 | 9 | 417 | 70 | 11 | 81 | 498 | 658 | 1156 |

Хэнтий аймаг

# Нэн ядуу иргэдийн төлөв байдал

2003 он

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдал

1. Статистик тоо баримт
2. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас хийж буй ажлаас
3. Анкетийн судалгааны дүн
4. НХҮ-ий тайлангаас
5. ЯБҮХ-ийн хэрэгжилтийн тайлан

### Нэн ядуу өрхийн тоо

| Д/д | Сумдын нэр | Өрхийн тоо | Өрхийн хүн амын тоо |
|---|---|---|---|
| 1 | Биндэр | 227 | 1051 |
| 2 | Батширээт | 116 | 52 |
| 3 | Баян-Адрага | 53 | 274 |
| 4 | Батноров | 75 | 369 |
| 5 | Бэрх | 79 | 402 |
| 6 | Норовлин | 194 | 950 |
| 7 | Дархан | 91 | 479 |
| 8 | Бор-Өндөр | 44 | 239 |
| 9 | Баян-овоо | 83 | 367 |
| 10 | Цэнхэрмандал | 73 | 325 |
| 11 | Дэлгэрхаан | 148 | 753 |
| 12 | Баянхутаг | 130 | 566 |
| 13 | Галшар | 117 | 510 |
| 14 | Баянманх | 63 | 324 |
| 15 | Жаргалтхаан | 123 | 627 |
| 16 | Мөрөн | 174 | 762 |
| 17 | Өмнөдэлгэр | 201 | 937 |
| 18 | Хурх | 56 | 281 |
| 19 | Дадал | 42 | 233 |
| 20 | Өлзийт | 177 | 865 |
| 21 | Хэрлэн | 868 | 3939 |
| | Аймгийн дүн | 3143 | 14774 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

### *Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт*

| Дугаар | | Гүйцэтгэх ажил | Гүйцэтгэл | Шалгуур үзүүлэлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөтөлбөрийн заалтын | Төлөвлөгөөний заалтын | | | 0-25 12.5 | 25-60 37.5 | 50-75 62.5 | 75-100 87.5 | 100 |
| 1.4.1 | 95. | Орон гэргүй, нэн ядуу хүмүүст зориулсан, орон сууцны нийтийн байр барих, жижиг 4 ханатай гэрээр хангах, төсөл хандив, хүмүүнлэгийн байгууллагын туслалцааг энэ ажилд чиглүүлэх | Аймгийн хэмжээнд 2002 оны байдлаар нийт өрхөд гэр, орон сууц олгосноос Монгол улсын Засгийн газар 5 гэр, УИХ-ын гишүүн Д.Арвин 10 гэр, АЗД 10 гэр, НХҮС-ас 13 гэр " Дэлхийн зөн" ОУБ-аас 9 гэр олголоо | | | | | 100 |
| 1.4.7 | 117 | Ядуу иргэдийг ажил эрхлэх боломжоор хангах, амьжиргааны баталгаажих түвшингээс дээгүүр орлоготой эрхийн ахуй амьдралыг дээшлүүлэх, халамж үйлчилгээний хамруулах ажлын дэс дараатай зохион байгуулах | Ядуу иргэдийг ажил эрхлүүлэх зорилгоор өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төсөлд зохих шалгуураар хамруулж байна.Уг ажилд хүнсний ногоо тариалах, оёдол ноосны чиглэлээр түр ажлын байраар хангах асуудал хэрэгжиж байна. | | | 62.5 | 87.5 | |
| 1.4.9 | 125 | Хүмүүнлэгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж тэдний үйл ажиллагааг уялдуулах нийгмийн халамжийн арга хэмжээнд тэднийг аль болох өргөн хүрээтэй татан оролцуулах | Ядуу иргэд болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх , өрхийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс " Дэлхийн зөн байгууллагатай хамтран хүнсний ногоо тариалах , оёдол хатгамал хийх арга технологид нийт 50 хүнийг хамруулж асрамжийн газрын хүүхдүүдэд болон нэн ядуу зарим өрхүүдэд 500-1000 кг хүнсний ногоо олгожээ. | | | | | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Аймгийн Засаг даргын нөөц сангаас 2001 онд 1.431 мянган төгрөг, 2002 онд 784.565 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг нэн ядуу , орлогогүй , гачигдалтай иргэдэд олгожээ.

Баян-Овоо сум :

Ядуу болон нэн ядуу өрхийн судалгаа явуулж "Өрхийн амьжиргааны чадавхийг сайжруулах болон ядуурал ажилгүйдлийг бууруулах хөтөлбөрүүдийг тус тус баталжээ.

ӨАЧДЗ-ийн хурлаар нэн ядуу ба ядуу өрхийн орлогогүй 11 өрхөд 200.0 мянган төгрөгийг 6 сарын хугацаагаар олгоод байна. Сумын засаг даргын захирамжаар 3 иргэнд буцалтгүй тусламж олгожээ.

Бор-Өндөр хот:

Хотын ядуу иргэдийн судалгааг нарийвчилж гаргажээ. Ядуу өрхийн хөдөлмөрийн насны , хөдөлмөрийн чадвартай 50 гаруй иргэдийг ажлын байраар хангажээ. Хөдөлмөр эрхлэлтийн албатай хамтарч мэргэжил шаардагдахгүй нийтийг хамарсан ажлын байраар хангаж байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжинд хамрагдаагүй 20 орчим хүнийг хамруулжээ. Ядуу өрхийн 20 гаруй эхчүүдэд 300.0 гаруй мянган төгрөгийг 1 удаагийн мөнгөн тусламж, орон гэргүй өрхийн 8 хүнийг орон гэртэй болгожээ.

Хэрлэн сум:

10 гаруй мянган хүн амтай . Нэн ядуу өрх 1854. нэн ядуу тахир дутуу иргэдэд
2001 онд 1368.0 мян.төгрөг
2002 онд 1411,5 мян төгрөгийн буцалтгүй тусламжиийг
сумын Засаг даргын нөөц сангаас зарцуулжээ.

Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон эмэгтэйчүүдийн амьдрал ахуйд туслах зорилгоор 22 өрхөд 250 гаруй мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж, хөдөлмөр эрхлээгүй 140 гаруй хүнийг хот тохижилт, цэвэрлэгээнд түр хамруулж 2.7 сая төгрөгийн ажлын хөлс олгосон.

Нэн ядуу өрхийн 32, бүтэн ба хагас өнчин 16, бага орлоготой ахмад өндөр настан 60, нийт 110 оюутныг төрийн сангийн зээлээр сургаж байна. 2001 онд нэн ядуу болон орлогогүй 62 хүнд иргэний үнэмлэх авахад зориулж 155.0 мянган төгрөг сумын Тамгын газраас зарцуулжээ.

Дэлхийн зөн ОУБ-тай хамтран 4-р сургууль дээр сургууль завсардсан хүүхдийн 2 бүлэг хичээллэж байна. Мөн 3-р цэцэрлэг дээр нэн ядуу өрхийн 30 хүүхдийн 1 бүлгийг ажиллуулж байна.

UILMN
СУДАЛГААНЫ САН

Тандалтын судалгааны дүнгээс: Энэхүү судалгаанд 90 хүн хамрагдсан

- Эр 32
- Эм 57

Боловсролын байдлаар нь ангилавал

Дээд- 0

Тусгай дунд - 6

Бүрэн дунд - 13

Бүрэн бус дунд - 39

Бага - 21

Боловсролгүй - 14

Хөдөлмөр эрхэлдэг - 12

Хөдөлмөр эрхэлдэггүй - 76

Орлого олдог 1 хүнтэй өрх - 33

2 хүнтэй өрх - 23

3 хүнтэй өрх - 2

Өөрт тохиолдож байгаа бэрхшээлийг арилгахын тулд төр захиргаанд хандана гэж судалгаанд оролцогсод 100% хариулсан байна.

Нэн ядуу байдлаас гарахад хамгийн чухал нөлөөтэй хүчин зүйл бол хөдөлмөр эрхлэлт, ажлын байр гэж 100% хариулжээ.

Өрхүүдээр явж ярилцлага хийх явцад хөдөлмөрийн чадвартай , эрхэлсэн ажилгүй залуучууд маш олон байлаа.

Ярилцлагаас:

- Яагаад ажилгүй байгаа юм бэ ? гэж асуухад
- Ажил олдохгүй байна.
- Ажилд оръёо гэж төрийн байгууллага, албан тушаалтанд санал хүсэлтээ илэрхийлж байсан уу? Хэнд хандаж байсан бэ?
- Үгүй . Уул нь багийн дарга мэдэж байгаа
- Тэгээд ямар орлогоор амьдарч байна вэ?
- Яахав дээ ах дүү хамаатан садан тусладаг , хаая хүмүүст туслаад хөлсөнд нь гэдэс цувдай мэтчилэн авдаг
- Хэдий болтол хүнээр тэжээлгэж, хүний тусламжинд найдах вэ? Цаашид яаж амьдрах бодолтой байна вэ?
- Мэдэхгүй. Ажилтай л болчихвол... Ажил л хиймээр байна. Зээл авч юм хийе гэхээр даан ч хөрөнгийн баталгаагүй гээд зээл өгөхгүй юм гэж уулзсан хүн болгон ярьж байлаа.

Ийнхүү судалгаанаас үзэхэд аймаг орон нутаг төрийн байгууллага, Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагаас нэн ядуу иргэддээ тусламж дэмжлэг үзүүлдэг гэдэг нь тодорхой байна.

Харин нэн ядуу иргэд маань бид ядуу зүдүү амьдарч байгаа болохоор “ Бид авах ёстой, биднийг харж хандах ёстой” гэсэн сэтгэлгээтэй болж хийж бүтээж, хөдөлмөрлөж амьдрана гэсэн сэтгэл дутмаг бэлэнчлэж, биеийн амрыг харж бусдад хувь заяагаа даатгад байна уу даа. Нөгөөтэйгүүр иргэд хөрөнгийн баталгаагүйгээс зээл авч жижиг дунд үйлдвэр болон хувийн аж

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ахуй эрхлэж амьжиргаагаа дээшлүүлэх  нөхцөл муу  мөн үйлдвэр хөгжөөгүй , ажлын байр нэн ховор байна.

**Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний тайлан**

| № | Үйлчилгээний төрөл | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|
| | | Хүн | Дүн | Хүн | Дүн |
| 1 | *Нэн ядуу амьдралтай иргэнд үзүүлсэн халамжийн үйлчилгээ* | 21 | 10728 | 96 | 2566.6 |
| 2 | *Ахмад настанд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээ* | 317 | 1897.6 | 12 | 723.9 |
| 3 | *АБДТД орлоготой бөгөөд олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхэд үзүүлэх* | | | 12 | 2850.0 |
| 4 | *Өнчин хүүхдийг байнга асрамжлах* | | | 1 | 2000.0 |
| | *ДҮН* | 338 | 2970.4 | 122 | 10315.5 |

**Нийгмийн халамжийн тэтгэвэр олголтын тайлан**

| № | Тэтгэврийн төрөл | 2001 | | 2002 | |
|---|---|---|---|---|---|
| | | Хүн | Дүн | Хүн | Дүн |
| 1 | *АБДТД орлоготой 60 настай эр, 55 настай эмэгтэй өндөр настан* | 136 | 12601.0 | 101 | 13174.1 |
| 2 | *Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсантахир дутуу* | 192 | 20751.0 | 236 | 25831.3 |
| 3 | *Төрөлхийн тахир дутуу , 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон* | 770 | 79511.0 | 845 | 98826.0 |
| 4 | *Тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд* | 240 | 25612.5 | 292 | 33949.0 |
| 5 | *Бүрэн хараагүй, хэлгүй, дүлий, болон одой хүн* | 41 | 4820.0 | 42 | 5305.7 |
| 6 | *Иргэний журамт үүргээ биелүүлж яваад хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болсон хүн* | | | | |
| 7 | *Иргэний журамт үүргээ биелүүлж нас барсан иргэний гэр бүлийн х/чадваргүй гишүүд* | 16 | 2078.7 | | |
| 8 | *АБДТД орлоготой өрх толгойлсон 4-өөс дээш хүүхэдтэй эх, эцэг* | 9 | 983.5 | 18 | 1520.0 |
| | *Дүн* | 1404 | 146357.7 | 1534 | 178606.1 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

### Хэнтий аймгийн хэмжээнд ЯБҮХ-ийн хүрээнд хэрэгжүүлсэн төслүүд

Хэнтий аймгийн хүн амын 38.6% нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой. үүнээс 49.2% нь нэн ядуу байна. ЯБҮХ тус аймагт 1996-2000 оны хугацаанд хэрэгжиж 21 суманд нийт 253.4 сая төгрөгийн санхүүжилттэй 322 төсөл хэрэгжсэн.

Уг төслүүдэд нийт 2776 хүн оролцож 51113 хүн ашиг хүртсэн байна. Иймхүү ЯБҮХ-ийн хүрээнд нэн ядуу иргэдийг хамруулж тэдэнд 50 сая 600 мянган төгрөгийн зээл олгосноос 39 сая 822150 төгрөг эргэн төлөгдөж зээлийн эргэн төлөлт 78.6%-тай байна.

| *Д/д* | *Сангийн нэр* | *Төслийн тоо* | *Төслийн санхүүжилт* | *Төсөлд оролцсон хүмүүс* | | | | *Ашиг хүртэг сэд* |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | *Нийт* | *Эм* | *ӨТЭ* | *ТД* | |
| 1 | ЭБОББС | 144 | 38000000 | 435 | 251 | 46 | 4 | 1563 |
| 2 | ЭХС | 54 | 16030000 | 165 | 159 | 20 | 3 | 529 |
| 3 | ОНХС | 103 | 195111500 | 1673 | 435 | 30 | | 46497 |
| 4 | ТДИ-ийг дэмжих | 1 | 5923000 | 73 | 46 | 20 | 73 | 170 |
| 5 | НЯИТС | | 12100000 | 403 | 218 | 86 | 35 | 2247 |
| 6 | ТББ-ыг дэмжих | 1 | 998000 | 27 | 27 | 6 | | 107 |
| | Дүн | 303 | 268162500 | 2776 | 1136 | 208 | 115 | 51113 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН